

**ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ 2022 ОНЫ 03 ДУГААР САРЫН 11-НИЙ  
ӨДРИЙН 01 ДҮГЭЭР ТОГТООЛООР БАЙГУУЛАГДСАН “МОНГОЛ УЛСЫН  
ХӨГЖЛИЙН БАНКНААС САНХҮҮЖҮҮЛСЭН ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨРИЙН  
ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ ТАВЬЖ, ШАЛГАЛТ ХИЙСЭН ТАЛААРХ ХОЛБОГДОХ  
ЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГУУДЫН ТАЙЛАН, МЭДЭЭЛЭЛТЭЙ ТАНИЛЦАХ, ХУУЛЬ  
ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ ТАВИХ ЗОРИЛГОТой ЕРӨНХИЙ  
ХЯНАЛТЫН СОНСГОЛ”-ЫН 2022 ОНЫ 03 ДУГААР САРЫН 29-НИЙ ӨДӨР  
/МЯГМАР ГАРАГ/-ИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

**Ерөнхий хяналтын сонсголын сэдэв:** “Монгол Улсын Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж, шалгалт хийсэн талаарх холбогдох эрх бүхий байгууллагуудын тайлан, мэдээлэлтэй танилцах.”

**Хаана, хэзээ:** Ерөнхий хяналтын сонсгол 2022 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн 9.00 цагт Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд зохион байгуулагдсан.

**Оролцогчид:** Нийтийн сонсголын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.5-д заасны дагуу Улсын Их Хурлын гишүүдийн ирц бүрдэж, сонсголыг Улсын Их Хурлын гишүүн, Сонсгол даргалагч Жадамбын Бат-Эрдэнэ нээж, сонсгол зохион байгуулах болсон үндэслэл, сонсголын зорилго, оролцогчдын ирц, сонсголын дэг, дараалал, сонсголд оролцогчдын эрх, үүргийг танилцуулснаар эхэллээ.

Ерөнхий хяналтын сонсголд Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны гишүүд, ажлын хэсгийн ахлагч болон гишүүд оролцсоноос гадна Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Сангийн яам, Хууль зүй, дотоод хэргийн яам, Эдийн засаг, хөгжлийн яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Барилга, хот байгуулалтын яам, Үндэсний Аудитын газар, Санхүүгийн зохицуулах хороо, Татварын ерөнхий газар, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Гаалийн ерөнхий газар, Монгол Улсын Ерөнхий прокурорын газар, Авлигатай тэмцэх газар, Цагдаагийн ерөнхий газар, Барилгын хөгжлийн төв, Монголбанк, Хөгжлийн банк зэрэг холбогдох төрийн байгууллагын удирдах албан тушаалтан, Улсын Их Хурал дахь Ардын намын бүлгийн ажлын алба, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн ажлын алба, Монгол Ардын Нам, Хөдөлмөрийн Үндэсний Нам зэрэг улс төрийн намын төлөөлөл бүхий 11 оролцогч, Монголын Үндэсний Худалдаа аж үйлдвэрийн танхим, Монголын банкны холбоо, Монголын мэргэшсэн үнэлгээчдийн институт, Монгол-Брэнд холбоо, Авлигалтай тэмцэх газрын дэргэдэх Олон нийтийн зөвлөл, “Ард түмний штаб”, Компанийн засаглалын Үндэсний зөвлөл, Монголын хуульчдын холбоо зэрэг төрийн бус байгууллагын төлөөлөл бүхий 12 оролцогч, “НВЦ” ХХК, “Монполимет групп”-ийн “Монцемент Билдинг Материалс” ХХК, “Прайсоутерхаускуперс” ХХК, “Эрэл” групп, “Хөтөлийн цемент шохой” ХК, “Вестерн Холд” ХХК, “Монгол драй милк” ХХК, “Инжир” ХХК, “Кью Эс Си” ХХК, “Ганхүдэр Орд” ХХК, “Алтан Дорнод Монгол” ХХК, “Бэрэн групп” ХХК зэрэг аж ахуйн нэгжийн төлөөлөл бүхий 15 оролцогч, Монгол Контент ХХК, ТВ-8 телевиз, Харах өнцөг студи, Монгол ТВ, “Улаан бал” нэвтрүүлэг, ТВ24 телевиз, Зариг.мн, UBN.mn, ERENNews.mn, FACETV.mn, Dardas.mn, Цахиур.мн зэрэг хэвлэл мэдээллийн байгууллагын хэвлэл мэдээллийн төлөөлөл бүхий 21 оролцогч болон иргэдийн 14 төлөөлөл бүхий нийт 170 гаруй оролцогчид оролцлоо.

Ерөнхий хяналтын сонсголын ажиглагчаар Монголын хуульчдын холбооны гишүүн, хуульч Ч.Отгонбаатар, Г.Давааням, “Монполимет” группын “Монцемент

Билдинг Материалс” ХХК-ийн Худалдан авалтын хэлтсийн менежер, хуульч Д.Дэлгэр, ХҮН-ын Удирдах зөвлөлийн дарга Б.Найдалаа нар ажиллалаа.

### **Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн Ж.Бат-Эрдэнэ:**

Улсын Их Хурлаас зохион байгуулж байгаа Ерөнхий хяналтын сонсголд оролцож байгаа та бүхэнд энэ өдрийн амар амгаланг айлтган мэндчилж байна. Нийтийн сонсголын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.7 дахь хэсэгт зааснаар нийт Байнгын хорооны гишүүдийн гуравны нэгээс доошгүй ирсэн тохиолдолд ирц бүрдэх ёстой. Өнөөдөр сонсголд оролцогчдын ирц бүрдсэн тул сонсголын үйл ажиллагааг эхлүүлж байна. Байнгын хорооны ирцийг би та бүхэнд танилцуулъя. Дамбын Батлут гишүүн, Баагаагийн Баттөмөр гишүүн ирсэн байна. Жадамбын Бат-Эрдэнэ, Хүрэлбаатарын Булгантуяа, Хассуурийн Ганхуяг, Тогмидын Доржханд, Мөнхөөгийн Оюунчимэг, Чимэдийн Хүрэлбаатар, Содномын Чинзориг, Баттөмөрийн Энхбаяр гэсэн Байнгын хорооны гишүүд ирсэн байна. За үүнээс гадна Б.Бат-Эрдэнэ, Д.Тогтохсүрэн, С.Одонтуяа, Г.Мөнхцэцэг, Б.Пүрэвдорж, Н.Алтанхуяг гэсэн Улсын Их Хурлын гишүүд хүрэлцэн ирсэн байна. Мөн Улсын Их Хурлын дэд дарга Т.Аюурсайхан ирсэн байна.

Ингээд сонсголын үйл ажиллагааг эхлүүлж байна. За өнөөдрийн энэ сонсголд Улсын Их Хурлын гишүүдээс гадна холбогдох төрийн байгууллагуудын төлөөлөл, төрийн бус байгууллага, иргэд, хуулийн этгээд, хэвлэл мэдээллийн төлөөллүүд ирсэн. Нийт 120 гаруй оролцогч энэхүү сонсголд оролцож байна.

Ингээд журмынхаа дагуу та бүхэнд сонсголын зорилго, дэгийг танилцуулъя. Улсын Их Хурлын 2022 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн чуулганаар Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ, Ч.Хүрэлбаатар, Д.Ганбат, Б.Баттөмөр, Б.Пүрэвдорж, Б.Энх-Амгалан нарын гишүүд Хөгжлийн банкны асуудлаар тодорхой саналуудыг гаргаж, энэ асуудлыг Улсын Их Хурлын хүрээнд татаж авч ярилцах, хэлэлцэх зайлшгүй шаардлагатай гэсэн саналыг анх гаргасан. Үүний дагуу Улсын Их Хурлын даргын захирамж гарсан. Энэ захирамж 2022 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 20 дугаар захирамж гарсан. “Монгол Улсын Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж, шалгалт хийсэн талаарх Монгол Улсын Засгийн Газар, Монголбанк болон аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжтэй танилцаж, үр дүнг Улсын Их Хуралд танилцуулах үүрэг бүхий” ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөрөөр ахлуулан, ажлын хэсгийн гишүүдэд Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ, Ц.Даваасүрэн, Б.Пүрэвдорж, С.Чинзориг нарын бүрэлдэхүүнтэй ийм ажлын хэсгийг байгуулсан.

Мөн Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн дагуу Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр Ш.Адьшаа, Ж.Бат-Эрдэнэ, Ц.Давасүрэн, Ж.Мөнхбат, Ц.Сэргэлэн, Г.Тэмүүлэн, Н.Учрал, Д.Цогтбаатар нарын гишүүдээс Улсын Их Хурлын дарга Г.Занданшатарт тодорхой саналыг хүргүүлсэн. Энэ саналдаа хяналтын сонсголыг хийе гэсэн саналыг гаргасан. Тэгээд энэ саналын дагуу Эдийн засгийн байнгын хорооноос тодорхой шийдвэр гарч өнөөдрийн сонсголыг хийж байгаа юм.

Журмын дагуу тодорхой дэгийг та бүхэндээ танилцуулах ёстой. Дэгийг та бүхэнд танилцуулъя. Энд зайлшгүй сонсголд оролцогчдын эрх, үүргийг танилцуулж байж дэг, журмаа гаргаж энэ сонсгол явах ёстой юм байна. За ингээд сонсголд оролцогчдын эрхийг та бүхэнд танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 120 дугаар зүйл, Нийтийн сонсголын тухай хуулийн 15 дугаар зүйлд заасан дэгийг та бүхэнд танилцуулъя. Энэ хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэгт сонсогч, сонсголд оролцогч дараах эрх эдэлнэ гэж, 15.1.1 дэх заалтад хууль болон холбогдох хуульд заасан үндэслэл, журмын дагуу асуултад хариулах, тайлбар, санал хэлэх, оролцогчдын эрхийг заасан байна. Мөн 15.1.2 дахь заалтад сонсголын тэмдэглэл, гарсан шийдвэртэй танилцах, өөрийн хэлсэн санал, тайлбарыг хянах ийм эрхийг эдэлж байна. За мөн 15.1.3 дахь заалтад сонсгол зохион байгуулагч болон даргалагчаас тэнцвэртэй, хүндэтгэлтэй хандахыг шаардах эрхтэй, 15.1.4 дэх заалтад холбогдох хууль тогтоомжид заасан эрх эдлэнэ гэж заасан. Хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсэгт сонсголд оролцогч дараах үүргийг хүлээнэ гэж, 15.2.1 дэх заалтад сонсгол зохион байгуулагчийн дуудсанаар сонсголд хүрэлцэн ирэх, сонсголын дэг сахих, сонсгол зохион байгуулагч болон сонсголд даргалагчийн хууль ёсны шаардлагыг биелүүлэх, 15.2.4 дэх заалтад сонсголд үнэн зөв мэдүүлэх, бодитой дүгнэлт өгөх, 15.2.5 дахь заалтад холбогдох бусад хууль тогтоомжид заасан үүрэг хүлээх, 15.3 дахь хэсэгт сонсголд оролцогч нь сонсголын явцад бусдыг ялгаварлан гадуурхах, доромжлох, яриаг нь таслах, сонсгол даргалагчийн зөвшөөрөлгүйгээр үг хэлэх, хүч хэрэглэх зэрэг зохисгүй үйлдэл гаргахыг хориглоно гэж тус тус заасан байна.

Сонсголд оролцогчдыг танилцуулъя. Өнөөдөр 120 гаруй сонсогч, оролцогчид оролцож байна. Нэн тэргүүнд сонсголын 4 ажиглагч оролцож байна. Ч.Отгонбаатар, Г.Давааням Монголын Хуульчдын Холбооны гишүүн, хуульч, Д.Дэлгэр “Монполимент” группийн “Монцемент Билдинг Материалс” ХХК худалдан авалтын хэлтсийн менежер, Б.Найдлаа ХҮН-ын удирдах зөвлөлийн дарга гэсэн ийм 4 хүн оролцож байна.

Хэвлэл мэдээллийн алба, хэвлэл мэдээллийн байгууллагуудаас 21 байгууллага оролцож байна. Телевиз, радио, бусад сайтуудаас 21 байгууллага саналаа өгч энэ сонсголд оролцож байна. Сонсголд оролцогчдоос төрийн байгууллагууд ер нь сонсголыг төрийн байгууллага, албан тушаалтан төрийн үйл ажиллагаанд иргэдийг оролцуулах, иргэдийн мэдэх эрхийг хангах үүднээс энэхүү сонсголыг явуулдаг. За тэр үүднээс өнөөдөр төрийн байгууллагаас Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Дэд дарга У.Бямбасүрэн болон Засгийн газрын бусад хүмүүс оролцож байна. За яамдуудаас Сангийн яам, Барилга хот байгуулалтын яам, Хууль зүй, дотоод хэргийн яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Эдийн засаг, хөгжлийн яам гэх мэтчилэн яамдууд оролцож байна. За агентлагуудаас Үндэсний аудитын газар, Санхүүгийн зохицуулах хороо, Татварын ерөнхий газар, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Гаалийн ерөнхий газар, Улсын Ерөнхий прокурорын орлогч Төрийн хууль цаазын шадар зөвлөх, Нийслэлийн прокурорын газрын Ерөнхий прокурор Хууль цаазын зөвлөх, Барилгын хөгжлийн төв гэх мэтчилэн төрийн байгууллага, агентлагууд оролцож байна. Мөн Монголбанк оролцож байгаа, Хөгжлийн банк бүрэн бүрэлдэхүүнээрээ оролцож байна. За 11 улс төрийн намын төлөөлөл оролцож байна.

Төрийн бус байгууллагын төлөөллөөс Монголын Худалдаа Аж Үйлдвэрийн танхимын Ерөнхийлөгч бусад хүмүүстэйгээ оролцож байна. Мөн Монголын банкуудын холбооны хууль эрх зүйн хамтын ажиллагаа хариуцсан менежер, Монголын мэргэшсэн үнэлгээний институтийн тэргүүн, удирдах зөвлөлийн дарга, Монголын мэргэшсэн үнэлгээний институтийн гүйцэтгэх захирал, удирдах зөвлөлийн гишүүд, Монгол Брэнд холбооны тэргүүн, Авлигатай тэмцэх газрын дэргэдэх Олон нийтийн зөвлөлийн гишүүд, Ард түмний штабын тэргүүн, гишүүн,

Монголын компанийн засаглалын үндэсний зөвлөлийнхөн, Монголын хуульчдын холбооныхон гэх мэт төлөөллүүд оролцож байна. За компанийн төлөөллүүдээс 15 компанийн төлөөлөл, иргэдээс нийт 14 иргэн оролцож байгаа. За тэгээд дохионы хэлмэрч Б.Саранчимэг, Б.Мядаг гэсэн ийм хүмүүс оролцож байна.

Ингээд та бүхэнд дэгийг танилцуулъя. За энэхүү сонсголд 5 мэдээлэл сонсъё гэж урьж оролцуулсан байгаа. Нэгдүгээрт, Монгол Улсын Хөгжлийн банкнаас санхүүжүүлэх төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн байдалд хяналт тавьж, шалгалт хийсэн Улсын Их Хурлын ажлын хэсгийн тайлан мэдээллийг сонсоно, Б.Баттөмөр гишүүн тайлан, мэдээлэл өгнө. Хоёрдугаарт, Монгол Улсын Засгийн газраас Хөгжлийн банканд хийсэн хяналт шалгалтын талаарх тайлан мэдээлэл. Гуравдугаарт, Монголбанкнаас Хөгжлийн банканд хийсэн хяналт шалгалтын талаарх тайлан мэдээлэл. Дөрөвдүгээрт, Төрийн аудитын байгууллагаас Хөгжлийн банканд хийсэн хяналт шалгалтын тайлан танилцуулга. Тавдугаарт, Монгол Улсын Хөгжлийн банкны өнөөгийн байдал, санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүн, тулгамдаж буй асуудлын талаарх тайлан танилцуулгыг Хөгжлийн банкнаас танилцуулгыг хийнэ.

Бид мэдээллийг тэнцвэртэй байлгах, бүрэн дүүрэн мэдээллийг авах үүднээс аж ахуйн нэгжүүдийг оролцуулж байгаа. Аж ахуйн нэгжүүдээс 4 аж ахуйн нэгж хүсэлт гаргасан. Хүсэлт гаргагчид энд ирчихсэн байгаа, хүсэлтийг сонсгол болохоос хоёр хоногийн өмнө албан ёсоор бичгээр мэдээлэх, хүсэлт гаргах ёстой. За ингээд 4 байгууллага гаргасан та бүхэнд танилцуулъя. “Монполимет групп”-ийн “Монцемент Билдинг Материалс” ХХК, “Вестерн Холд” ХХК, “Эрэл групп” ХХК, “Монгол драй милк” ХХК гэсэн дөрвөн компанийн мэдээллийг сонсъё. Мэдээллийг хуулийн дагуу 10 хүртэл минутад танилцуулна.

За үүний дараа Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, хариулт авна. Хуулийн дагуу хорин минутын дотор асуулт асууж, хариулт авна. За хэдэн ч асуулт, хариулт 20 минутдаа багтааж авч болно. Үүний дараагаар Ерөнхий хяналтын сонсголыг олон нийтэд хүргэж, хэвлэл мэдээллийн байгууллагуудын мэдээлэх эрхийг хангах үүднээс хэвлэл мэдээллийн байгууллагуудад асуулт асуух боломжийг олгож байгаа. Яг үнэндээ Хяналт шалгалтын хууль, за бусад хуулиудад асуух асуулт бас хязгаартай байж байгаа. Тэгээд ер нь энэ сонсголыг олон нийтэд мэдээллийг бүрэн дүүрэн хүргэх тэнцвэртэй байдлыг бий болгох, тэнцвэртэй мэдээллийг хүргэх, за иргэдийн мэдэх эрхийг хангах, төрийн үйл ажиллагаанд оролцох эрхийг хангах үүднээс бол энэ сонсгол явж байгаа үүднээсээ бид энэ хэвлэл мэдээллийнхнийг бүрэн дүүрэн бас асуулт асуух боломжийг нь хангаж байгаа юм.

Дөрөвдүгээрт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн дагуу оролцогчид бас 5 хүртэл минутад үг хэлэх ийм боломжийг олгож байгаа. Тавдугаарт, Улсын Их Хурлын гишүүд хамгийн сүүлд 5 хүртэл минутад саналаа хэлэх ийм боломжийг хуулийн дагуу өгнө. Ингээд илтгэл, тайлан мэдээллүүдийг эхлүүлье. Хэлэлцэх асуудалтай холбоотой санал байна уу? Б.Энхбаяр гишүүний микрофоныг нэгээрэй.

#### **УИХ-ын гишүүн Б.Энхбаяр:**

За гишүүддээ өглөөний амгаланг айлтгая. Хэлэлцэх асуудалтай холбоотой хоёр асуулт байна. Нэгдүгээрт, бид Хяналт шалгалтын тухай хуулийг Улсын Их Хурлаас гаргасан. Энэ бол ард түмний төлөөлөгчдийн хамгийн дээд байгууллага болох Улсын Их Хурлын хяналт шалгалтын хамгийн дээд хэлбэр, үүнийг бид

хуульчилсан байгаа. Энэ бол Үндсэн хуульд 2019 онд орсон өөрчлөлтийн дагуу хийгдэж байгаа. За үүний хамгийн анхны Ерөнхий хяналтын сонсгол болох гэж байгаа юм. Тэр утгаараа бид энэ Ерөнхий хяналтын сонсголыг яг энэ агуулга, зорилготой нь сайн холбож авч үзэх ёстой. Энэ дотор, Хяналт шалгалтын хуульд зааснаар Улсын Их Хурлын гишүүд асуулт асууна, хариулт авна гэж байгаа. Энэ бол Улсын Их Хурлын гишүүн хувь хүнийхээ хувьд асууж байгаа хэрэг биш. Ард түмний төлөөлөгчийн хувьд асууж байгаа, хариулж байгаа этгээд Улсын Их Хурлын гишүүнээр дамжуулж ард түмэнд хариултаа өгч байгаа. Энэ бол Улсын Их Хурлын хяналтын гол утгаа. Би хэвлэл мэдээллийн байгууллагынхныг асуулт асуух ёсгүй гэж хэлж байгаа юм биш. Энэ хяналтын сонсголд, хуульд асуулт асууна гэж байхгүй байгаа шүү. Коридорт асууж болно. Олон нийтээс асууж болно. Улсын Их Хурал буюу энэ парламентын хяналт бол яг одоо тэр зарчмынхаа дагуу явах ёстой. Та бүхэн тэр Америкийн сенатыг харж байгаа биз дээ. Сенатад гишүүд нь гишүүд асуулт асуухаар асуултад нь хариулж байгаа байхгүй юу. Тэнд худлаа ярих ёсгүй. Худлаа яривал тэр хүн хуулийн хариуцлага хүлээдэг. Ийм онцлогтой байдаг байхгүй юу. Үр дагавар нь. Тийм учраас энэ хуулиа хэвшүүлэх тал дээр анхаараач ээ. Ер нь яахав бүгдээрээ асууж болно. Би асуух ёсгүй гэж байгаа юм биш. Бүгдээрээ асууж болно. Тэгэхээр ямар ч ялгаагүй болдог юм, парламентын утга байхгүй, парламент чинь коридорт гараад л явчихаж байна гэсэн үг. Тэгэхээр энэ өөрөө парламент буюу тэр одоо ард түмнийг төлөөлөх дээд байгууллагын энэ үнэлэмж хяналтынх нь утгыг нь сулруулдаг юм. Тийм учраас ийм ялгаатай хууль гаргасан, хуулиа барих ёстой гэдэг нэг ийм санал байна.

Хоёрдугаарт, би энэ сонсголыг хийх асуудлыг тогтооход 14 хоногийн өмнө хариуцлагатай, ажил хэрэгч байх талаасаа хэд хэдэн хүмүүсийг байлгаасай гэж хүссэн. Нэгдүгээрт, энд орлогч нарыг байлгахгүй ээ, байгууллагын дарга нар өөрсдөө ирэх хэрэгтэй. Жишээлбэл, Монголбанкны тайланг Монголбанкны дэд Ерөнхийлөгч өгнө гэсэн байна. Ерөнхийлөгчийг нь авчир! Лхагвасүрэн Ерөнхийлөгч өөрөө тавь! Үндэсний аудитын тайланг гуравдугаар газрын захирал нь тавина гэж байна. Үгүй ээ, Монгол Улсын ерөнхий аудитор өөрөө ир! Улсын Их Хурлаас томилгоо авсан энэ хүмүүсийг байлгамаар байна. Дараа нь хуулийн байгууллагын дарга нар хаана байна. Монгол Улсын Ерөнхий прокурор, Авлигатай тэмцэх газар, Цагдаагийн ерөнхий газрын дарга нарыг байлгамаар байна. Асуулт байна, хэнээс асуух юм? Дөрөвдүгээрт, энэ банкны дампууруулсан гэж байгаа, найдваргүй зээл гэж байгаа асуудал бол гол гол зээлдэгч болох хэдхэн компани, банктай холбогдож байгаа. Хөгжлийн банк нь үндсэндээ Худалдаа хөгжлийн банкны охин компани хэлбэртэй болсныг бүгд мэдсэн. Тийм учраас Худалдаа хөгжлийн банк, Голомт банкны захирлуудыг байлгамаар байна. Тэгэхгүй бол энэ дөрвөн компаниас юуг нь асуудаг юм. За дараа нь энэ Хөгжлийн банканд хариуцлагатай алба хашиж байсан хамаарал бүхий этгээдүүдээс асуух асуулт байна. Жишээ нь энэ Сод-Эрдэнэ гэж хүн байна, манай төрийн өндөр албан тушаалтны хамаарал бүхий хүн, Зээлийн газрын захирал байсан гэдэг. Монголбанкны одоо Дэд ерөнхийлөгч хийж байгаа Дөлгөөн байна. Мөн л зээлийн газрын захирал байсан. Энэ хүмүүсээс асуух асуулт байна. Энэ хүмүүсийг байлгамаар байна.

### **Сонсгол даргалагч, УИХ-н гишүүн Ж.Бат-Эрдэнэ:**

Б.Энхбаяр гишүүний санал гэх үү дээ. Нэгдүгээрт, Хяналт шалгалтын тухай хууль, Нийтийн сонсголын тухай хуулиудад хориглосон заалт бол байхгүй ээ. Хоёрдугаарт, энэ сонсгол ард нийтэд мэдээлэл өгөх, мэдэх эрхийг олгох, төрийн үйл ажиллагаанд оролцох боломжийг ард нийтэд олгох ийм зорилттой хууль юм. Хоёулаа одоо хуулиар нэг мэтгэлцээд яах вэ. Сонсголыг тодорхой асуудлаар, олон

нийтийн дунд гарсан асуудлаар сонсголыг хийх ёстой гэсэн ийм хуулийн заалт байгаа юм. Тэгэхээр өнөөдөр нийтийн хэмжээнд нийгмийг шуугиулсан гэх юм уу, тодорхой хэмжээнд алдаа дутагдал гарсан Хөгжлийн банктэй холбоотой энэ асуудлаар тодорхой төрийн байгууллага, албан тушаалтан, бусад иргэд, аж ахуйн нэгжүүдээс бид нар мэдээллийг авах үүрэгтэй, эрхтэй. Тэр утгаараа энэ сонсгол өнөөдөр хийгдэж байгаа. Сонсголоос ямар нэгэн тодорхой шийдвэр гарахгүй. Сонсголоос гарсан тайланг холбогдох Байнгын хороонд өгнө. Байнгын хороон дээр хэлэлцээд цаашаагаа Улсын Их Хурал зайлшгүй шаардлагатай гэвэл асуудал болгож дэвшүүлж Улсын Их Хуралд оруулах ийм л зүйл. Энэ бол хэлэлцүүлэг биш шүү, сонсгол юм шүү. Хоёрдугаарт, тантай санал нийлж байгаа зүйл бол өчигдөр баахан дарга нар надаас чөлөө авлаа, яасан ч их ажилтай, яасан ч их зовлон гачигдалтай дарга нар байдаг юм. Өнөөдөр бас Монгол Улсын Ерөнхийлөгчөөс санаачилсан Ногоон хөгжил гэсэн хэлэлцүүлэгт зарим нэг нь оролцож байх шиг байна. Тэгэхдээ дуудаарай, Засгийн газрынхан бас хүмүүсээ дуудаад оруул. Одоо оролцуулахыг урьж байна аа. Одоо ямар ч байсан хэлэлцүүлэг, мэдээлэл явж байх хооронд энэ хүмүүсээ ирүүлье ээ. За Т.Доржханд гишүүн.

### **УИХ-ын гишүүн Т.Доржханд:**

Та бүхэнд өглөөний мэнд хүргэе ээ. Тэгэхлээр ард түмний хувьд, иргэдийн хувьд, мөн олон нийт, намуудын хувьд маш их хүлээсэн ийм сонсгол гэж ойлгож байгаа. Тэгэхлээр үр дүнтэй баймаар байна. Үр дүнтэй байхын тулд эндээс бас үр дүн гаргахаар тодорхой мэдээлэл өгөх хүмүүсийг оруулах нь зүйтэй. Хоёр сарын өмнө бид нар их сүртэй хэлэлцүүлэг хийсэн. Хоёр сэтгүүлчээ зогсоож байгаад маш сайн хэлэлцүүлэг хийсэн. Гэхдээ үр дүн нь хаана байгаа юм? Одоо үр дүнгээ эндээс нэхэх ёстой. Тийм болохоор холбогдох эрх бүхий албан тушаалтнуудыг одоо дууд аа. Монгол Улсын парламент өнөөдөр шийдвэр гаргадаг дээд байгууллага нь юм бол дуудах хэрэгтэй. Хэнийг дуудах ёстой юм бэ гэхээр, эрх барьж байгаа намын дарга Л.Оюун-Эрдэнийг дууд. Эрх барьж байгаа намын Ерөнхий нарийн бичгийн дарга Амарбаясгаланг дууд. Яагаад гэвэл, нэгдүгээрт, камерын өмнө, иргэдийнхээ өмнө амлалт өгсөн шүү. Хоёрдугаарт, Ардчилсан намын удирдлага нь аль талд байна вэ тэд нарыг дууд. Яагаад гэвэл Ардын нам, Ардчилсан нам засаглаж байх үед энэ хулгай гарсан. Тухайн үеийн засаг барьж байсан Ерөнхий сайдуудыг дууд. Гуравдугаарт, Б.Энхбаяр гишүүнтэй санал нэг байна аа. Хуулийн байгууллагын удирдлагуудыг дууд. Өнөөдөр Авлигатай тэмцэх газрын дарга, Ерөнхий прокурор хоёр нь энд сууж байх ёстой. Дуудах хэрэгтэй, юун орлогч дарга. Тийм болохоор яаралтай дуудах хэрэгтэй. Бүтэн өдрийн хэлэлцүүлэг байх шиг байна. Нэмээд энэ хамгийн их зээл авсан нөхдүүдийг дуудаач, юун энэ 4 компани вэ? Саналаар нь хүлээж авсан юм аа гэж байсан. Энэ бол ойлгомжгүй байна, тодорхой биш байна. Хамгийн их зээл авсан тэр сахал Эрдэнэбилэг гэдэг нөхрийг дууд. Хамгийн их зээл авсан Халтмаагийн Баттулгыг дуудах хэрэгтэй шүү дээ. За хамгийн их зээл гаргасан Ерөнхий сайд нь энд бас сууж байх шиг байна. Дараагийн Ерөнхий сайдууд нь бас байж байх шиг байна. Фортуна Батбаяр гэдэг хүнийг дууд. Ийм байдлаар асуудлаа яримаар байна аа. Тэгээд эндээс үр дүнтэй гарах ёстой шүү, зүгээр нэг хэвлэлийнхнийг дуудаж оруулж ирээд зарим нэг төлөөллийг дуудаж оруулаад хий гаргах байдлаар явна гэвэл болохгүй ээ. Тэгэхлээр ийм саналтай байна, үүнийг яаралтай ажил хэрэг болгож өгнө үү, баярлалаа.

### **Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн Ж.Бат-Эрдэнэ:**

Нийтийн сонсголын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1 дэх заалтад “Нийтийн сонсгол гэж хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актыг тогтоох,

төрийн байгууллага, нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд хяналт тавих, түүнчлэн хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актын хэрэгжилтийг үнэлэх, нийтийн эрх ашгийг хөндсөн асуудлаар шийдвэр гаргахын өмнө төрийн байгууллага, албан тушаалтан, иргэд, хуулийн этгээд, мэргэжлийн шинжээчээс санал сонсох, мэдээлэл авах үйл ажиллагааг нийтийн сонсгол гэнэ” гэжээ. Өнөөдөр хийж байгаа энэ үйл ажиллагаа маань нийтийн сонсгол шүү. Энэ ямар нэг шүүх хурал биш шүү. Тийм болохоор та бүхэн хуулийнхаа дагуу, тэр тусмаа хууль тогтоогчид та бүхэн маань энийг бас нэг хараач ээ. За саналуудаас Цагдаагийн ерөнхий газрын даргыг урьж байна, Тамгын газрынхаа дуудаарай. Авлигатай тэмцэх газрын даргыг бас дуудъя, Тамгын газрынхан дуудаарай. Шүүх байгууллага биш болохоор бусад байгууллагууд нь хэрэггүй байх гэж бодож байна. Мөн Монголбанкны Ерөнхийлөгчийг дууд. Ерөнхий прокурор, Цагдаагийн газрын дарга нараа дуудъя.

За ингээд үйл ажиллагаа эхлэх үү? Одоо хурлаа эхлүүлчихээд илтгэлүүдээ сонсчихоод, мэдээллээ сонсчихоод, тэгээд саналаа хэлчих ээ. Сая энд горимын саналууд хэлсэн байгаа. За Н.Алтанхуяг гишүүн, горимын саналыг бол хүлээж авах ёстой байх аа.

### **УИХ-ын гишүүн Н.Алтанхуяг:**

УИХ-ын гишүүн Б.Энхбаяр, УИХ-ын гишүүн Т.Доржханд гишүүдийн саналтай санал нэг байна. Дээр нь хэвлэл мэдээллийнхэн нэг юм хийнэ гээд намайг урьсан би очихгүй гэсэн юм. Энэ бол шоу хийдэг сэдэв биш. Энэ бол үнэхээр одоо Монгол Улсын парламент гэж байдаг юм бол энийг үнэхээр энэ Хөгжлийн банк байгуулагдсанаас эхлээд юу болсныг ярих гэж байгаа юм бол парламентынхаа танхимд хариуцлагатай хүмүүс нь, хариуцаж байсан хүмүүс нь сууж ярих ёстой. Олон нийт тэрнийг харах ёстой. Тэр эртээд та нарын хийж байгаа юмыг харахад шоу хийж байна лээ. Одоо миний өмнө ийм материалууд байгаа, одоо энийг л ярих гээд байх шиг байна. Энэ аудитын 2012-2017 оны аудитын дүгнэлт дандаа баримт түшиж ярих ёстой. 2015 онд гаргасан 2014 он хүртэлх аудитын дүгнэлт, 2016 онд Б.Энхбаяр гишүүнээр ахлуулсан ажлын хэсгийн санал, дүгнэлт, манай Засгийн газрын үед гарч байсан шийдвэрүүд, бусад шийдвэрүүд, хууль хэрхэн яаж өөрчлөгдсөн бүх юм, Чингис бондын Хөгжлийн банкны эх үүсвэр болон түүгээр санхүүжүүлж байгаа төслүүдийн танилцуулга. Ингээд шууд Ерөнхий сайд хамаардаггүй юм Хөгжлийн банкныг. Тэгэхдээ би хариуцлагатайгаар оролцъё гэж ирж байгаа юм. Тэгэхээр манай УИХ-ын гишүүн Сү.Батболд сайд байгаа шүү дээ, Ерөнхий сайд тэр хүн бас байлцаж байх хэрэгтэй. Ерөнхий сайд нь шууд хариуцдаггүй шүү! Ер нь Сангийн сайд нар нь байж байх хэрэгтэй. Хаянхярваа гэдэг Сангийн сайдын үеэс эхэлж энэ Монголд анх 600 сая ам.долларын Евро бонд боссон юм. Бүгдээрээ Чингис бонд гэж ганцхан бондны тухай мэддэг болохоос биш юм чинь эндээс эхэлсэн юм. Тэгэхээр хэрвээ юм ярих гэж байгаа бол учир утгатай ярь. Тэгээд тэр хэвлэл мэдээллийнхэн энэ дээр асуух шаардлага байхгүй. УИХ-ын гишүүд юмаа асууж эхлээд ойлголтоо нэгтгэмээр байна. Энэ олон түмэнд зөв юм хэлмээр байна. Шоу хийж байна лээ шүү дээ. Тэгээд нэг хоёр нөхөр мөргөлдөөд дуусаа биз дээ. Ингэж одоо энэ шоу хийж, ард түмний цаг үрж, бид нарын цагийг үрж бас яах гээд байгаа юм. Би энийг чинь бүгдийг нь тэр нөгөө самбар дээрээ ярихын тулд бүгдийг нь уншчихсан. Одоо тэгээд үд хүртэл энийг дахиад сонсох юм байна л даа. Тэгээд хэнээс юу асуух юм? Хариуцаж байсан хүмүүс гэдэг чинь үе үеийн Сангийн сайд, одоо тэр УИХ-ын гишүүн Ж.Эрдэнэбат байгаа шүү дээ. Бас хариуцаж байсан тэр үеийн нэг Ерөнхий сайд. Яагаад Ерөнхий сайд байсан хүмүүс нь орж ирээд сууж болохгүй байгаа юм? Яагаад Сангийн сайд байсан хүмүүс нь орж

ирээд сууж болохгүй байгаа юм? Манай үед Эдийн засгийн яам хариуцаж байсан Эдийн засгийн яамныхан, сайд байсан хүн нь яагаад орж ирэн сууж болохгүй байгаа юм. Үе үеийн банкных нь захирал, ТУЗ-ийн гишүүд яагаад байхад болохгүй гэж? Ийм бүрэлдэхүүнтэй л ярих ёстой шүү дээ. Хууль хяналт ч болоогүй. Хууль хяналт болоогүй шүү. Та нар эхлээд энэнийхээ учрыг ол. Би ил тод ярилцлагын төлөө байна. Баахан амьтан дүүргээд, гудамжинд ярьдаг хүмүүс нь орж ирээд бид нартай юм яриад байх ямар учир утга байгаа юм. Тэгвэл би УИХ-ын гишүүн гэж энд суухын хэрэг юу байгаа юм. Харин хэдүүлээ өнөөдөр энэ дээр нэг жаахан нухацтай ярьчихаад бүрэлдэхүүнээ нэг жаахан аятайхан зөв болгож авах талаар ярьчихмаар. Би бол ингэж байгаа юм. Нэг удаагийн шоугаар энэ асуудал шийдэгдэхгүй ээ. Улсын Их Хурлынхаа Түр хороог байгуулъя, Улсын Их Хурлын хяналт шалгалтын хуулийн дагуу, Түр хороон дээр ажиллагаагаа явуулъя. Тэр нь олон нийтэд дандаа ил тод яваг. Би бол ийм горимын саналтай байгаа. Ийм ийм хүмүүсийг оролцуулах ёстой. Тэгэхгүй бол яах юм бэ? Энэ дотор байгаа хүмүүс чинь ихэнх нь энэ асуудлыг яаж явсныг мэдэхгүй. Ийм л саналаар хийвэл Ж.Бат-Эрдэнэ дарга аа та хуульд тийм юм байхгүй гээд байдаг, энэ шоу болно шүү би шууд хэлчихье. Одоо үд хүртэл та нар үд хүртэл унтаж үхрийн дуугаар сэрнэ гэдэг чинь амаа ангайлгаад баахан юм сонсоно. Тэгээд үдээс хойш УИХ-ын гишүүд популизм хийж хэдэн юм асууна. Хойноос нь хэвлэл мэдээллийнхэн дахиад л нөгөө ярьсан сэдвээ ярина. Ямар учир утга байгаа юм бэ? Энэ Монгол Улс цаашаа хөгжихөд бид нар ямар юм дээр алдаж, ямар алдаа оноо гарчихав, ямар хулгай дээрэм болж, энийг яаж засах вэ? Банк нь яаж ажиллаж байв, яаж шийдвэр гаргаж байв, засаг нь яаж ажиллаж байв, ингэж ярих гэж байгаа шүү дээ. Тэгээд тэр холбогдох хүмүүс баймаар байна шүү дээ. Би бол ийм л саналтай байна. Тэгэхгүй бол энд суухын учир утга байхгүй. Дахиад эрт дээрийнх шиг шоу хийгээд дуусгана. Тэгээд хэвлэл мэдээллээр яадаг юм. Та хорин нэгэн байгууллага сонгосон гэж байна. Хэн сонгосон юм. Дандаа захиалгатай байна лээ шүү дээ. Захиалгатай мөнгө төлж баахан юм хийж байна шүү дээ. Тусдаа баахан хаягууд нээчихсэн. Ингэж бол Монголыг удирдахгүй шүү! Энэ ард түмнийг ингэж тархийг нь угаах байдлаар ингэхгүй. Харин тэр үнэхээр хулгай, дээрэм, хийчхээд байгаа хүмүүсээ олоод тогтоогоод, тэгээд яриад хөөрөөд хийх ёстой. Энэ хэзээ билээ, 49%-иар Улсын Их Хурал дээр нэг хэлэлцүүлэг болсон шүү дээ.

### **Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн Ж.Бат-Эрдэнэ:**

За Ш.Адъяаа гишүүнийг авъя, Ч.Хүрэлбаатар гишүүнийг авъя. За УИХ-ын гишүүн Ш.Адъяаа гишүүний микрофон.

### **УИХ-ын гишүүн Ш.Адъяаа:**

За энэ сонсголын ач холбогдлыг бид ингэж бууруулж болохгүй л дээ. Нэгэнт энэ сонсгол хийнэ гээд энэ нийтийн сонсгол хийж байгаа юм бол энд оролцогчдын эрхийг тэгш хангаж өгөх ёстой. Зөвхөн Улсын Их Хурлын гишүүд энд ярина гэдэг энэ юм бол бас хязгаарлалттай ойлголт байх гэж ойлгож байна. Энд оролцож байгаа бүх хүн санал бодлоо ярилцаж, нийгмийн төлөөлөл болсон хэвлэл мэдээллийнхний үгийг нь хэлүүлье. Энэ хэвлэл мэдээлэл, бусад оролцогчдын үгийг хэлж, үзэл бодол тэр баримтыг нь сонсохгүй юм бол бид зүгээр Улсын Их Хурлынхаа танхим дотор орж УИХ-ын гишүүд ярилцъя. Тийм учраас одоо УИХ-ын гишүүн Б.Энхбаяр, УИХ-ын гишүүн Т.Доржханд, УИХ-ын гишүүн Н.Алтанхуяг гишүүдийн саналыг дэмжиж байгаа. Түүнээс гадна энэ Хөгжлийн банкны хамгийн их чанаргүй, өр үүсгэсэн 1.8 их наяд төгрөгийн өр төлбөр бол энэ Төрийн өмчит компаниуд байгаа шүү дээ. Энэ Төрийн өмчит компаниудын удирдлагуудыг энд оролцуулъя. Тэр Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар гэж Монголын Төрийн өмчийг хариуцдаг байгууллагыг



оруулж ирэх ёстой. Бид нар энд Аж ахуйн нэгжүүд л гээд байгаа болохоос биш тэр АСЕМ гээд 250 тэрбум төгрөгийн зардал гаргасан гэж байгаа. 1.8 их наяд төгрөгийн Төрийн өмчийн компаниудын өр зээл байгаа шүү дээ. Энийг хэн хариуцах юм? Эд нар юунд зарцуулсан юм? Ямар үр дүн байдгийг нь бид яагаад сонсож болдоггүй юм? Хэдэн аж ахуйн нэгжүүд, хэдэн хэвлэл мэдээллийнхэн. Энэ шоуны шинж чанартай болж байна шүү. Тийм учраас энэ Төрийн өмчит компаниудын удирдлагуудыг заавал оруулах ёстой. Хамгийн их өр төлбөр, өр үүсгэсэн Төрийн өмчит компаниудын удирдлагуудыг энд заавал авч оролцуулъя гэсэн горимын саналыг гаргаж байна.

### **Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн Ж.Бат-Эрдэнэ:**

За УИХ-ын гишүүн Ч.Хүрэлбаатар. УИХ-ын гишүүн Ч.Хүрэлбаатар гишүүний микрофоныг нээе.

### **УИХ-ын гишүүн Ч.Хүрэлбаатар:**

За та бүгдэд энэ өглөөний мэнд хүргэе. За ерөнхий сонсголынхоо ажлыг эхлүүлмээр байна. Буруу зориултаар зээл олгож байсан, завхралын үүд тавьж байсан хүмүүс орж ирчихээд саад болоод байх шаардлага байхгүй шүү дээ. Ажлаа явуулмаар байна. Харин тэр орлогч, газрын захирал нарыг болиулаад тэр байгууллагын дарга нар нь өөрсдөө тавиг. Хэрвээ дарга нь ирэхгүй бол тэрийг сонсоод ч хэрэггүй. Тэгээд урагшаагаа явмаар байна. Нийгэмд бүх хүмүүсд энэ Хөгжлийн банкны талаар янз бүрийн мэдээлэл оччихсон байгаа. Үнэн бодит байдлыг ялгаж салгах ажил би өнөөдөр хийгдээсэй гэж үзэж байгаа юм. Хэн нэг нь гарч ирж өөрсдийгөө өмөөрөөд байх ч шаардлага байхгүй. Хэн нэгэн рүүгээ бас буруутгаад дайраад байх ч шаардлага байхгүй болов уу гэж бодож байна. Тэгэхээр Ж.Бат-Эрдэнэ дарга аа, та одоо ажлаа эхлүүлэе. Хэвлэлийнхэн асууг л дээ. Өнөөгийн нийгэмд энэ болохгүй байгаа зүйлүүдийг нь хэвлэлийнхэн гаргасан шүү дээ. Өмнө нь бид нар сөрөг хүчин байхад тэр 2015 онд энэ Хөгжлийн банкны тухай асуудлыг яриад эргүүлээд бид нар өөрсдөө шалгуулаад дууссан шүү дээ. Хэвлэлээр балбуулаад, одоо ч Хаан банкн дээр тийм юм болж байгаа. Энэ эздүүд нь тийм юм хийж байгаа, мөнгөнд дуртай сэтгүүлчид хөлс мөнгөөр гүйж очиж мэдэгдэл хийдэг хүмүүсүүдийг татаад оруулчихсан. Тэр үйл явдал яг давтагдаж байгаа. Тийм учраас одоо тэр хэвлэлийнхэн ч асууг, гишүүд нь ч асууг. Гишүүд хангалттай байна. Тэгэхээр энэ юмаа яриад жаахан урагшаа явмаар байна. Ж.Бат-Эрдэнэ дарга аа тал талаас гомдлыг нь сонсоод байвал өнөөдөр хурлаа ч эхэлж чадахгүй. Энэ төлөвлөсөн ёсоороо та ажлаа хийгээд явсан нь дээр байх. Харин тэр байгууллагын дарга нарыг бүгдийг нь дуудчих хэрэгтэй. Хүмүүсийн өргөдлийг нь аваад явуулна биз ажил хийж чадахгүй байгаа юм бол.

### **Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн Ж.Бат-Эрдэнэ:**

За хэвлэлийнхэн дэгтэй холбоотой горимын саналуудыг сонслоо, сонсох ёстой. Сонслоо. За цаашаагаа үйл ажиллагаагаа эхлүүлэе. Ер нь бол төр уламжлалт чанартай шүү дээ. Ямар ч байгууллагын дарга байсан урьд өмнөх даргынхаа хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, төрийн залгамж халаа гэж байдаг. Тэр утгаараа урьд өмнөх сайд гэхээсээ урьд өмнөх дараа дараагийн сайд, тэр тусмаа Засгийн газрын хэмжээнд бүх хяналт шалгалтыг нэгтгээд өнөөдөр оруулж ирж байгаа гэж ойлгож байгаа. Монголбанкны захирал урьд өмнө байсан захирлаас үл хамаараад өнөөдөр танилцуулгаа нэгтгээд оруулж ирж байгаа. Хөгжлийн банкныхан энэ хэмжээнд нь анх байгуулагдсанаас эхлээд хуулийн дагуу бүх хийсэн

ажлуудаа өнөөдөр нэгтгээд орж ирж байгаа. Тийм үүрэг даалгавруудыг өгсөн. Тийм болохоор өнөөдөр энэ заавал одоо тухайн үед байсан хүмүүсийг авчрах шаардлагагүй байх гэж бодож байна. Хоёрдугаарт, хэвлэл мэдээллийнхний үгийг нь хэлүүлье. Бид яах гэж сонсгол хийж байгаа юм. Ард иргэдэд мэдээллийг өгөх, түрүүн би хэллээ шүү дээ. Төрийн үйл ажиллагаанд оролцох эрхийг, мэдэх эрхийг бид нар хангаж байгаа шүү дээ. Тэр утгаараа оролцуулаад явчихъя, тэгээд хууль зөрчсөн гэвэл намайг одоо юунд өгнө биз дээ. За ингээд хэлэлцүүлгээ эхэлье, сонсголоо эхэлье.

Ямар заалт байгаа билээ, нээрээ тийм заалт байгаа шүү. Түрүүнд миний дурдсан Цагдаагийн ерөнхий газрын дарга, Авлигатай тэмцэх газрын дарга, Монголбанкны Ерөнхийлөгч, Аудитын газрын Ерөнхий аудитор, Ерөнхий прокурор өөр хэн байгаа билээ. Ийм хүмүүсийг Тамгын газрынхан дуудаарай. Төрийн албаны тухай хуульд зааснаар дуудсан үед ирээгүй бол зохих арга хэмжээ авна гэсэн тийм заалт байдаг байхаа. За Хөгжлийн банкны захирлыг дуудъя. За ингээд хэлэлцүүлгээ эхэлье. Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.3-д байгаа юм биш үү. Эрхэлж байгаа албан тушаалын хувьд сонсголд оролцох үүрэг хүлээсэн төрийн албан хаагч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр сонсголд оролцох тайлбар өгөхөөс татгалзсан бол Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.17-д заасан Нийтийн сонсголыг зохион байгуулах, сонсголд оролцох дүрэм, журам, тогтоомжийг зөрчсөн гэж үзнэ ээ гэсэн байна шүү. За ингээд сонсголоо эхэлье. Эхний сонсгол Монгол Улсын Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн талаарх Улсын Их Хурлаас байгуулсан ажлын хэсгийн танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга Баагаагийн Баттөмөр танилцуулна. Гишүүний микрофоныг өгье.

### **УИХ-ын гишүүн, ажлын хэсгийн ахлагч Б.Баттөмөр:**

Та бүгдийн амар амгаланг эрж мэндчилье ээ. Улсын Их Хурлын даргын 2022 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 20 дугаар захирамжаар Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж, шалгалт хийх талаарх Монгол Улсын Засгийн газар, Монголбанк, Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжтэй танилцаж, Улсын Их Хуралд танилцуулах үүрэг бүхий ажлын хэсэг 02 дугаар сарын 08-аас 03 дугаар сарын 29-нийг хүртэлх хугацаанд хяналт шалгалтыг хийж гүйцэтгэлээ. Хөгжлийн банкны тухай шалгасан сэдвүүдийг одоо танилцуулъя. Хөгжлийн банкны тухай өмнө нь хийсэн хяналт шалгалт, Улсын Их Хурлын ажлын хэсэг газар дээр нь хийсэн шалгалт, зээл олголт, чанар, зориулалт, Хөгжлийн банкны санхүүгийн байдал, шүүхээр шийдвэрлэсэн явц, Монгол Улсын Хөгжлийн банканд хийсэн хяналт шалгалтын ажлын үр дүнгийн талаарх дүгнэлт, цаашид авах арга хэмжээ гэсэн ийм сэдвийн хүрээнд ярина аа. Энэ ажлын хэсгийн нэг онцлог нь газар дээр нь очиж бүх төслүүдийг үзсэн. Төслийн барьцаа хөрөнгүүдийг газар дээр нь үзсэн. 10 аймаг, 23 сум болон Улаанбаатар хотын 9 дүүрэг, багуудад ажилласан. Ингэхдээ 61 зээлдэгчийн 754 нэр төрөл, 3089 ширхэг, 3.5 их наяд төгрөгийн зээл олгох ийм үнэлгээ бүхий барьцаа хөрөнгөд магадлагаа хийсэн. Энэ одоо урьд хийгдэж байсан шалгалтуудаас онцлог нь энд байгаа.

Энд 9 баг ажилласан. Монголын одоо энэ төсөл хэрэгжиж байгаа бүх аймаг, сумуудад очиж ажиллан. Энэ зураг дээр тодорхой гарч байгаа. За Хөгжлийн банк 2011-2012 онд одоо байгуулахаар шийдсэн. Хөгжлийн банкны тухай хууль батлагдсан. Гадаад удирдлагын баг одоо энэ үед томилсон байдаг. Солонгосын удирдлагын багийг явуулж монголын удирдлагын багийг томилсон. За 2016-2017

онд Хөгжлийн банкны тухай хуулийн шинэчлэл хийгдсэн. Одоо 2 охин компани “Ди Би Эм Ассет Менежмент” ХХК, “Ди Би Эм Лизинг” ХХК гэсэн ийм 2 охин компанийг байгуулсан. За 2020-2021 онд Сангийн яамны харьяанд шилжсэн. За удирдлагын баг нь солигдсон. 2021 оноос хойш дүрэм нь шинэчлэгдээд ингээд ажиллаж явна аа.

Өнөөдөр Төрийн банкны удирдлагын бүтэц байгаа. Төлөөлөн Удирдах зөвлөл гэж байна, Гүйцэтгэх захирал, Тэргүүн дэд захирал, Бизнес, хөгжил хариуцсан дэд захирал, Үйл ажиллагаа хариуцсан дэд захирал, Захиргаа, удирдлага хариуцсан дэд захирал гэсэн 4 дэд захиралтай, нэг гүйцэтгэх захирал зуун арваадхан хүнтэй, нөгөө зуун ямаанд жаран ухна гэдэг шиг ийм их өндөр цалинтай, ийм баг өнөөдөр энд ажиллаж байна. Энийг хариуцаж байгаа хүмүүс нь үнэхээр туйлын хариуцлагагүй хандсан гэж ингэж үзэж байгаа. Хийж байгаа ажилдаа тохирсон баг ажиллах ёстой. Ийм учраас энэ бүтэц зохион байгуулалт нь буруу ажиллаж ирсэн, өнөөдөр ч одоо буруу байна гэдгийг хэлж байна.

2011 онд Хөгжлийн банкны тухай хуулийг баталсан. 2010 оны 07 дугаар сарын 20-ны өдөр Хөгжлийн банкныг байгуулахаар шийдвэрлэсэн байдаг. 07 дугаар сарын 20-ны өдрийн 195 дугаар тогтоолоор. Өнөөдөр үйл ажиллагаанд мөрдөж байгаа 8 хууль байна. Монгол Улсын Хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан 80 дүрэм, журам байна. Монголбанкнаас баталсан 2 журам байна аа. Ингээд үндсэндээ 90 журам, 4 хууль өнөөдөр энд Хөгжлийн банканд үйлчилж байна аа гэдгийг хэлэхийг хүсэж байна.

За өмнө нь 10 удаа хяналт шалгалтын ажил хийгдсэн. Эдгээрийн 6 нь бие даасан, 4 нь хамтарсан хэлбэртэй байсан. За энэ Хөгжлийн банканд хийсэн шалгалтуудын материалыг үзэхээр үнэхээр их чухал чухал асуудлуудыг үнэхээр доголдолтой байгаа, засаж хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийг авахаар энэ баримт бичиг, дүгнэлтэд заасан байдаг боловч харамсалтай нь энэ мөрөөр ямар ч арга хэмжээ авагдаагүй. Өнөөдрийн энэ асуудлууд хуримтлагдах үндсэн шалтгаан болбол хийсэн шалгалтын мөрөөр хийх ажлуудыг хийгээгүйгээс болсон гэж. Энд 2015 онд Аудитын газар, Улсын Их Хурлын даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг, 2016 онд Засгийн газар хамтарсан шалгалт хийсэн. 2017 онд Үндэсний аудитын газар, 2018 онд Монголбанк бие дааж хийсэн. 2019 онд Үндэсний аудитын газар, 2021 онд Монголбанк хийсэн.

За энэ шалгалтын дүнгүүдийг аваад үзэхээр хамгийн их зээл олголт, эрсдлийн удирдлагатай холбоотой 15 удаагийн ийм зөвлөмжүүдийг өгсөн байдаг. Активыг ангилах, активийн эрсдлийн санд 6 удаа, ТУЗ-ийн үйл ажиллагаа, зохистой засаглалыг 5 удаа, бараа, үйлчилгээ, ажил үйлчилгээ худалдаж авах гээд ингээд 17 зөвлөмжийг өгсөн байдаг. За энэ хэрэгжилт нь туйлын хангалтгүй явж ирсэн. Хөрөнгийн үнэлгээчдийн зүгээс магадласан барьцаа хөрөнгийн үнэлгээ нь 59 зээлдэгчийн 754 нэр төрлийн 3.4 их наяд төгрөгийн зээл олгох ийм үнэлгээ, 3089 ширхэг барьцаа хөрөнгөд магадлан хамрагдсан. Хөгжлийн банкны зээл олгох үед 3 их наяд 481 тэрбум төгрөг байсан. Монгол Улсын Хөгжлийн банк 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдөр 2 их наяд 97 тэрбум болгож бууруулсан байгаа. Барьцаа хөрөнгийг сая үнэлсэн байдлаар бол 2 их наяд 347 тэрбум болгож Хөгжлийн банкны 2021 оны 12 сарын 31-ний үнэлгээг нэмэгдүүлж ингэж үнэлсэн ийм дүн гарч байна.

Ирээдүйд бий болох бүртгэлтэй барьцаа хөрөнгийг хэлье. За энд олгосон 1 их наяд 69 тэрбум төгрөг, магадалсан үнэлгээгээр 667 тэрбум төгрөг, эрсдэл тооцсон үнэлгээгээр 399 тэрбум төгрөг болж буурсан үзүүлэлт харагдаж байна. Энэ

ирээдүйд бий болох бүртгэлтэй барьцаа хөрөнгийн үнэлгээ газар дээр нь хийсэн шалгалтаар одоо яаж байгаа. Энэ болбол үндсэндээ 36 компани байгаа. 36 компанийн нийт дүн бол 1 их наяд 69 тэрбум 49 сая гэсэн ийм дүн гарч ирж байгаа. Ирээдүйд бий болох 36 компани. За энэ ямар компаниуд байна вэ гэвэл “Болоршүр” ХХК, “Бэрэн групп” ХХК, “Вестерн майнинг” ХХК, “Вестерн Холд” ХХК гээд 36 компани энд байж байгаа.

Санхүүжүүлсэн зээл бол санхүүжүүлсэн шууд зээл, дамжуулан олгох зээл, улсын төсвийн багц гэсэн 3032 төсөл байгаа. 7.4 их наяд төгрөг байгаа. За нийт 3.2 их наяд төгрөгийн 101 төсөл, 1.6 их наяд төгрөгийн 2540 төсөл байгаа. 391 төсөл 2.5 их наяд төгрөг. Ингээд нийт дүнгээрээ 7.4 их наяд төгрөгийн зээлийг Хөгжлийн банк байгуулагдсан цагаасаа хойш олгосон байгаа юм. За дамжуулан зээл олгосон дүн улсын төсвийн багцаас 2 их наяд 540 тэрбум төгрөгийн 391 төсөл төслийн орлогоос төлөгдөх нөхцөлтэй Хөгжлийн банкнаас шууд олгосон зээл нь 3 их наяд 275 тэрбум, төсвийн орлогоос төлөгдөх нөхцөлтэй Хөгжлийн банкнаас дамжуулан олгосон зээл нь 1 их наяд 646 тэрбум. Ингээд нийт дүнгээрээ болбол 7 их наяд 462 тэрбум төгрөг гэдэг ийм тоо ийм 3 сувгаар хийгдсэн байгаа юм аа. За энэ санхүүжүүлсэн зүй нь болбол нийт арга хэмжээ нь 355 байгаа. За нийт санхүүжүүлсэн дүн нь 2 их наяд 540 тэрбум төгрөг гэсэн ийм тоо байна.

За энэ хүлээж байгаарай. Н.Алтанхуяг гуай таны тухай энэ дээр одоо тодорхой гарна. Зээлд тавигдах шаардлагыг хангаагүй төслийн жагсаалт гэж байгаа. Нэгдүгээрт нь бол хангаагүй жагсаалтуудын тайлбар нь одоо энд явж байна, “ТОСК”-той холбоотой хөдөлгөөнт цогцолборууд байгаа. Мөн “Эрдэнэс монгол” ХХК-тай холбоотой шаардлага хангаагүй. За энд үндсэндээ нэлээн олон компаниуд энд гарч ирж байгаа. Шаардлага хангаагүй зээлдэгчийн тоо 10.1.1-ийг зөрчсөн “ТОСК” нэг байна, 10.1.2-ыг зөрчсөн хоёр байна, “ТОСК” нэгийн 10.1.3-ыг зөрчсөн хоёр байна, хоёр компани байна гэх мэтээр энэ дүнгүүд нь ингэж гарч ирж байгаа юм. За 10.1.3-ыг зөрчсөн Хөгжлийн банкнаас дараах шаардлагыг хангасан төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлсэн. За энд Хөгжлийн банкны тухай хуулийн 10.1.2-ыг зөрчсөн 7; 10.1.3-ыг зөрчсөн 12; 10.1.4-ийг зөрчсөн 5; 10.1.5-ыг зөрчсөн 8; Хөгжлийн банкны тухай хуулийн 10.1.6-г зөрчсөн 15 гэсэн ийм компаниуд энд байна.

Ашиглалтад тавигдах дараах шаардлагыг хангаагүй байгааг харуулж байна.  
Үүнд:

1. нарийвчлан зохицуулаагүй;
2. тодорхой бус;
3. байгууллагын санхүүжилтийн зээлээс ялгарахгүй;
4. Монгол Улсын Хөгжлийн банкнаас олгосон зээлүүдийн дундаж хүү арилжааны банкнаас олгож байгаа зээлийн дундаж хүүгээс 4.1 орчим хувиар бага байгаа боловч дундаж хугацаа нь 5.1 жил байгаа нь экспортыг дэмжсэн эдийн засгийн өсөлтөд нөлөө үзүүлэхээс илүү урт хугацаатай зээл олгож байгаа;
5. Хугацааг бодитойгоор тооцоогүй;
6. Санхүүжилтээр төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлээгүй.

Эндээс ер нь хөгжлийн зээл гэдэг юу гэдгийг бид нар их тодорхойгоор гаргаж, тавьж аж ахуй нэгжүүддээ олгох ийм юм бодохгүй бол энэ Хөгжлийн банкны зээл бол хөгжлийн банкны зээл биш, энэ хөгжлийн зээл юм аа гэдгийг энд хэлэх гэж байгаа юм.

За тавдугаарт нь, хугацааг бодитойгоор тооцоолдоггүй, зургаадугаарт нь санхүүжилттэй төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлээгүй гэсэн ийм шаардлагууд одоо хангагдахгүй байна аа гэсэн зүйлийг одоо хэлье ээ. 2012-2022 он хүртэл Хөгжлийн банкнаас олгосон зээлийг энд харуулж байна. За тэр Ким Жан Жин гэсэн солонгос захирлын үед “Хөтөл”, “ТОСК”-ийн зээлүүд олгогдсон. Б.Шинэбаатар ТУЗ-ын даргатай, Н.Мөнхбат гүйцэтгэх захиралтай үед “Эрэл групп” ХХК, “Кью Эс Си” ХХК, “ТОСК”, “Бэрэн групп” ХХК, “МАК Цемент” ХХК, “Монполимет” групп гээд компаниудад зээл олгосон. ТУЗ-ын Б.Даажамба, М.Баярмагнай, Б.Батбаяр гүйцэтгэх захирлын үед “НВЦ” ХХК, “Монгол драй милк” ХХК, Г.Амартүвшингийн үед 6 зээл, Н.Мөнхсүхийн үед 2 зээл, Ж.Ганбат, Б.Сүх-Очирын үед одоо ажиллаж байгаа энэ үед нь зээл олгогдоогүй ийм байдалтай байна.

Энэ зээлдэгчид хугацаа хэтэрсэн зээлээр нэг жил хүртэл хугацаатай 11 зээл байна. Аж ахуйн нэгжүүдийнх нь нэр нь тэнд харагдаж байна. Хоёрдугаарт нь, 1-2 жил хүртэл хэтэрчихсэн явж байгаа 12 зээл, 2-3 жил хэтэрсэн 16 зээл, 3-аас дээш жил хэтэрсэн 20 зээл, хугацаа нь хэтрээгүй байгаа 12 зээл байна. Энэ дээр одоо яг энэ зээлүүдийн одоо ямар аж ахуйн нэгж байгааг нь энд харуулсан байгаа. Цаг бага байгаа, надыг 20 минутад багтаж итгэл тавь гэсэн учраас хурдхан хурдхан явуулаад байж магадгүй. Бас харуулахын тулд ингээд жаахан хараад явъя. Цаг жаахан сунжирч магадгүй байна Ж.Бат-Эрдэнэ дарга аа.

Газар дээр нь хийсэн шалгалтаар нийт шалгалтын боловсруулах үйлдвэрт 1.4 их наяд төгрөгийн 25 зээл байна. Барилгад 11 зээл, 837 тэрбум төгрөг байна. Уул уурхайн олборлолтонд 13 зээл, 381 тэрбум төгрөг гэх мэтээр. Ингээд үндсэндээ 8 салбарт ийм зээлүүдийг олгосон байна. Нийт зээлийн 41 хувь нь ам.доллараар, 17 зээл 1.3 их наяд төгрөг. Монгол төгрөгөөр 41 хувь нь 38 зээл, 1.1 их наяд төгрөг. За еврогоор 12 хувь нь байгаа, 4 зээл 374 тэрбум төгрөг. Японы иенээр 5 хувь нь байна, 10 зээл 141 тэрбум төгрөг. Хятадын юаниар 1 хувь. Зээлийн бүтцийг ингээд аваад үзэхэд ийм бүтэцтэй байна. Зээлийн үлдэгдлийг ингээд аваад үзэхээр 40 зээл байгаа. Энэний 1.8 их наяд төгрөг байгаа. Хэвийн зээл нь 1 их наяд 166 тэрбум төгрөг байгаа. 17 зээл байгаа. За 4 зээл байгаа. Энэ анхаарал хандуулах 204 тэрбум төгрөг байгаа. Зээлийн бүтцийн хувьд үлдэгдлийн хувьд ийм байдалтай байна.

Зээлийн зориулалтын дагуу ашигласан 28 зээлдэгч 43 хувь байна. Зориулалтын бус ашигласан 37 зээлдэгч 57 хувь нь байна. Зориулалтын бус 37 зээлдэгчийн 19 нь бүрэн бус, зориулалт нь нотлогдоогүй 18 байна. Сангийн яам, Хөгжлийн банкнаас ирүүлсэн материалд 20 зээлдэгч 508 тэрбум төгрөгийг зориулалтын бусаар зарцуулсан тооцоо байсан ч газар дээр нь үзсэн шалгалтаар 37 зээлдэгч болж өссөн. Зээлийн зориулалтын дагуу ашигласан “Говь”, “Дархан минж”, “Дорнод эрчим хүч” гэх мэт 28 компани байна. Зориулалт нь бүрэн бус төслийн нэг хэсгийг төсөлдөө зарцуулсан, нэг хэсгийг төсөлдөө зарцуулаагүй “Бармон”, “Болор шүр”, “МБҮ Трейд”, “Изинис-Эйр Вэйз”, “Имперал Гоулд Майнинг”, “Инжир”, “Монгол драй милк”, “Мондулаан”, “Монгол эм Импекс”, “Монгол кашмер” гэх мэт 19 компани байна. Зориулалт нь нотлогдоогүй “Бэрэн групп”, “Газ импорт”, “Дэд бүтэц Инженеринг”, “Инжир”, “Зэст өндөр”, “Монгема” зэрэг 18 компани байна.

Зээлийн ангиллын хувьд “Дулааны станц”, “МАК”, “Моннис Майнинг”, “Дорнын цас”, “Вестерн холд”, “Дархан минж”, “Зорчигч тээвэр-3”, “МИАТ”, “Газрын тос боловруулах үйлдвэр” гэх мэт хэвийн зээлдэгч 17 компани байна. “Эрдэнэс монгол”, “Эрчим хүч”, “Ган хүдэр”, “Монголын эм импекс” гэх мэт чанаргүй зээлийн ангилалд хамаарсан 44 зээлдэгч байна. “Хөтөл”, “Бэрэн групп”-ийн 2 төсөл, “Эрэл групп”, “Монполимет”, “Петролеум продакшн” гээд 12 компани байна.

Зээлийн эргэн төлөлт хэвийн 28 компани байна. Шалгалтын явцад “Хаан банк”, “Ди Би Эм Лизинг”, “Цэцэнс Майнинг Энд Энержи”, “Дорнын цас”, “Дархан минж”, “МИАТ”, “Пи Си Вай”, “Эйч Энд Эйч Ремикон”, “НВЦ” компаниуд нийт 99 тэрбум төгрөг төлсөн. “Вояжер Минерал Ресурс”, “Худалдаа хөгжлийн банк”, “Голомт банк”, “Сод монгол”, “Макс Рөүд” гэсэн 5 компани нийт 27 тэрбум төгрөгийн зээлээ төлж дууссан байна. Шалгалтын хугацаанд 126 тэрбум төгрөгийн эргэн төлөлт хийгджээ. Өчигдрийн байдлаар хэдэн компани зээлийн төлөлт хийсэн тухай Хөгжлийн банкны тайлан дээр тодорхой гарах байх.

“ТЭЦ-4”, “Дорнод бүсийн эрчим хүч”, “Газрын тос боловсруулах үйлдвэр”, “Говь”, “МИАТ”, “Зорчигч тээвэр”, “МАК цемент”, “Монполимет” гэсэн 862 тэрбум төгрөгийн 8 төсөл амжилттай хэрэгжсэн.

2021 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 66 зээлдэгчийн эрсдлийн сангийн зарцуулалт 583 тэрбум төгрөгийн эрсдлийн сантай байна. Монголбанкны хийсэн шалгалтын ангиллаар тооцвол 1 их наяд 348 тэрбум төгрөг, арилжааны банкны актив ангилах журмаар тооцвол 1 их наяд 774 тэрбум төгрөг байхаар байгаа боловч өнөөдрийн байдлаар Хөгжлийн банкны эрсдлийн сан 1 их наяд 348 тэрбум төгрөг байна. Монголбанкны нэмж байгуулах эрсдлийн сангийн хэмжээ 765.8 тэрбум төгрөг, бодитой байсан нь бол 583 тэрбум төгрөг, эрсдлийн сангийн зардал нь 1 их наяд 348.9 тэрбум төгрөг байна.

Нийт мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг харвал харилцах дансны үлдэгдэл нь Монголбанканд 300 тэрбум төгрөг, арилжааны банканд 32 тэрбум төгрөг байна. Хугацаатай хадгаламжийн үлдэгдэл Жи Пи Морган, Чингис Хаан банканд 394 тэрбум төгрөг, Чингис хаан банканд 25 тэрбум төгрөг байна. Үнэт цаас хэлбэр оруулсан Монгол Улсын Хөгжлийн банкны бонд 11 тэрбум төгрөг байна. Энержи ресурсд 19 тэрбум төгрөг, Эрдэнэс таван толгойд 146 тэрбум төгрөг үнэт цаасны хэлбэрээр оруулсан байна. Хараат болон хамтын хяналттай охин компаниудад оруулсан хөрөнгө оруулалт нь “МИК” 46 тэрбум төгрөг, “Үндэсний экспортын даатгал”-д 5 тэрбум төгрөг, “Ди Би Эм Лизинг”-д 100 тэрбум төгрөг, “Ди Би Эм менежмент” 10 тэрбум төгрөг тус тус байна.

Хөгжлийн банкны зээл дэх талуудын анх олгосон үеийн болон одоогийн ханшийн зөрүүний алдагдалд компаниуд 467.8 тэрбум төгрөг, Хөгжлийн банк 214.4 тэрбум төгрөг хүлээгээд байгаа юм. Ингээд нийт алдагдал 682.2 тэрбум төгрөгийг Монгол Улс валютын ханшнаас алдчихсан байна. Монгол Улс валютынхаа ханшийг одоо барьж чадахгүй, монгол төгрөгийн үнэ цэнийг хадгалж чадахгүйгээс өнөөдөр ийм алдагдалд орж байна гэдгийг хэлье.

Хүүгийн байдлыг харвал төгрөгийн хүү бол 7-12 хувь, ам.долларынх 7.7-8 хувь, иен 6.7-7 хувь, евро 4.4-7 хувь байна. Энэ доод талын нь улаан зураас эх үүсвэрийн хүү, дээд шар зураас нь олгож байгаа хүүний хэмжээ юм. Зохистой харьцааны хувьд нийт одоо Хөгжлийн банкны 2019.12.31-ээс нийт төлбөр болон эзэмшигчийн өмчийн дүн нь 4 их наяд байна. Монголбанкны 2021.12.31-ний байдлаар 3 их наяд 280 тэрбум, тохируулгын хэмжээ нь 765.7 тэрбум төгрөг байна. Зохистой харилцааны 6 үзүүлэлтийн 3 нь хангаж, 3 нь хангахгүй байна.

Хөгжлийн банк зээл олгох үеийн үйл ажиллагааны журамд нэмэлт өөрчлөлт оруулж, үнэлгээг тогтоох журам хийсэн. Байгууллагын үндсэн үйл ажиллагааны барьцаатай холбоотой тоо баримтууд энд байна. Улаанаар нь найдваргүй болсон

зээлүүд, бусад өнгөөр нь найдвартай болон анхаарал хандуулах зээлүүд мөн харагдаж байна. Барьцаа хөрөнгөөр төлөгдөх боломжтой, барьцаа хөрөнгө нь зээлийн үлдэгдлээс их 29 компани, анхаарал хандуулах барьцаа хөрөнгийн зээлийн үлдэгдлээс бага 30 компани, өндөр эрсдэлтэй барьцаа хөрөнгөгүй 11 компани байна.

Нийт 2 их наяд 557 тэрбум төгрөгийн хөрөнгийг Японы банкнууд, Олон улсын, Хятадын хөгжлийн банк, Оросын банкнууд гэх мэт 14 эх үүсвэрээс татан төвлөрүүлсэн байна.

Хамгийн тулгамдсан асуудал бол 2023 оны 10 сард Евро бондын 1.6 их наяд буюу 500 сая ам.доллартой тэнцэх хэмжээний мөнгө, 2023 оны 12 сард Самурай 752 тэрбум төгрөг, Хятадын хөгжлийн банкны 63 тэрбум төгрөгийг тус тус төлнө. Энэ Монгол Улсын хувьд тулгамдсан асуудал болоод байна.

Шүүхээр шийдвэрлүүлэхээр шүүхэд хандсан 16 зээлдэгчээс 749 тэрбум төгрөгийг, давж заалдах шатны шүүхэд 37.5 тэрбум төгрөг, дээд шүүхэд 6 зээлдэгчийн 373.6 тэрбум төгрөг байна. Шүүхээр шийдвэрлүүлсэн 23 зээлийн 1 их наяд 160 тэрбум төгрөгийн зээлийг төлүүлэхээр ажиллаж байна. Шүүхийн шийдвэр гарсан “Чингис хаан банк”, “ТОСК”, “Энсада инстэрн” гэсэн 3 аж ахуйн нэгжийн 58.7 тэрбум төгрөгийг төлүүлэх ажил хийгдэж байна. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажил дээр 5 зээлдэгчийн 19.6 тэрбум төгрөгийг гаргуулахаар ажиллаж байна. Шүүхээр шийдвэрлүүлэхээр Хөгжлийн банкны захирлуудын тавьсан асуудлууд байна. Батбаяр захирлын үед 1, Амартүвшингийн үед 4 гэх мэт. Цаг бага байгаа учраас шүүхээр шийдвэрлүүлэхийг ингээд харуулаад харуулаад явчихъя гэж бодож байна. Анхан шатны шүүх хурал 11 удаа хойшилсон тохиолдол байна. Анхан шатны шүүхийн шийдвэр гарсан хугацаа хамгийн их нь 33 сар байна. Шүүхийн шатанд шийдвэр гүйцэтгэхэд зарцуулсан хугацаа хамгийн их нь 69 сар байна. Шүүхэд нэхэмжлэл гаргаснаар банкны шууд хүлээж авч буй алдагдал нь 4.4 хувь байна. Нэхэмжлэл шаардлагаас хэрэгсэхгүй болгосон дүн нь 26.3 хувь байгаа юм.

Хяналт шалгалтын ажлын үр дүнгийн талаар: 2022 оны 03 дугаар сарын 28-ны байдлаар 126 тэрбум төгрөгийн төлөлт хийгдсэн байгаа. Үйл ажиллагаа нь хүндэрсэн томоохон зээлийн үлдэгдэлтэй “Хөтөл”, “Кью Эс Си” гэсэн 2 компанийн ажиллагаанд анхаарал хандуулахад одоо төрийн мэдэлд авахаар шийдвэр гаргах түвшинд ажиллаж байна. Зээлийн дүн хэвийн, хувийн хэвшлийн нийт зээлийн 26.3 хувийг эзэлж байна. Ажлын хэсгээс Засгийн газарт чиглэл өгч, Монгол Улсын Хөгжлийн банкны удирдлагууд одоо солигдсон. Ажлын хэсэг бүрэлдэхүүнээ өргөжүүлж, мэргэжлийн байгууллагууд, хөндлөнгийн шинжээч барьцаа хөрөнгө, баталгаа, зээлийн зориулалттай газар дээр нь шалгуулж, барьцаа хөрөнгийн үнэлгээ, барьцаа хөрөнгө, мэдээллийг зээлийн харилцаа, зээлийг зориулалтын болон зориулалтын бус ашиглаж байгааг тодорхойлсон. Ажлын хэсэг удаа дараа уулзалтуудыг хийсэн. Монгол Улсын Хөгжлийн банкны үйл ажиллагааг сайжруулахтай холбогдсон 5 чиглэлийг анхаарах асуудал, санал зөвлөмжийн судалгаа, хяналт шалгалтын үйл ажиллагаанд үндэслэн боловсруулж гаргасан. Ард иргэдээс нийтийн сонсгол явуулах саналын дагуу Улсын Их Хурлын холбогдох хууль, тогтоомж, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу нээлттэй сонсгол хийх ажлыг зохион байгуулж байна. Боломжтой зээлийн бүтцэд өөрчлөлт оруулах, барьцаа хөрөнгийг нэмэгдүүлэх, зориулалт бусаар ашигласан, зээлүүдийг хууль хяналтын байгууллагууд өгөх саналыг гаргаж байна. Эрх зүйн хувьд 85 дүрэм журам, 8 хууль мөрдөж, Монголбанкнаас гаргасан 2 журам одоо хэрэгжиж байна.

2019 оноос өмнөх хугацаанд нарийвчилсан зохицуулалтгүй шаардлага сул байсан нь банкны үйл ажиллагаа доголдоход нөлөөлсөн гэж ингэж үзэж байгаа.

Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуульд заасан ТУЗ-ийн гишүүний Засгийн газар нээлттэй сонгон шалгаруулалтаар 3 жилийн хугацаагаар 1 удаа томилж, компанийн тухай хуульд заасан үндэслэлээр чөлөөлдөг гэвч ТУЗ, гүйцэтгэх удирдлага тогтворгүй ажиллаж ирсэн, компанийн менежмент сул байх, мэргэжлийн чадамж дутагдах зэрэг үндсэн шалтгаан болсон байна. Удирдлагын багийн тогтворгүй байдал банкны хүний нөөцийн тогтворгүй байдал чадамжид нөлөөлсөн гэж үзэж байгаа.

Зээл олголтын хувьд Монгол Улсын Хөгжлийн банкны 10.1 дэх заалтад заасан зээлийн бодлого болон Хөгжлийн банкнаас санхүүжих төсөл, хөтөлбөрт тавих шаардлагыг бүрэн хангуулж олгогдоогүй байна. Зээл олгох, тавих шаардлагуудыг л зөрчиж олгосон зээлүүдийн дийлэнх нь чанаргүй зээлийн ангилалд бүртгэгдсэн байна. Зориулалтын хувьд үзэхэд зориулалтын дагуу зээлийг олгож байгаагүй байна. Энэ нь чанаргүй ангилалд бүртгэгдэх үндсэн шалтгаан болж байгаа гэдгийг энд хэлье. Санхүүгийн хувьд бол ийм байдалтай байна.

2022 оны 01 дүгээр сарын 31-ний байдлаар 3.2 их наяд төгрөг банкнаас нийт зээлийн үлдэгдэлд байгуулсан зээлийн эрсдлийн сангийн хэмжээ 585 тэрбум төгрөгт хүрсэн. Нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн харьцаа 55.3 хувь буюу 1.8 их наяд төгрөгөөр тооцоологдсон, тохируулгыг хийснээр хуримтлагдсан алдагдал 1 их наяд төгрөгт хүрч чанаргүй зээлийн ангиллыг бууруулсан тохиолдолд Хөгжлийн банкны олон улсын зах зээлээс татан төвлөрүүлсэн эх үүсвэр хугацаанаасаа өмнө дуудагдах эрсдэл үүсэхээр байна. Монголбанкны 2021 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар тогтоосон улсын байцаагчийн актыг үндэслэн өөрийн хөрөнгө эрсдлээ чиглэсэн активын харьцаа 2021 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар тооцож үзэхэд 1.9 хувь байгаа нь Монголбанкны тогтоосон зохистой харьцааг хангахгүй байх эрсдлийг дагуулж байна.

Барьцаа хөрөнгийн хувьд зээлийн барьцаа хөрөнгийг мэргэшсэн үнэлгээчин биш банкны эдийн засаг үнэлж байгаа нь Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн 15.1.1 дэх заалттай зөрчилдөж, барьцаа хөрөнгийн үнэ цэнэ, бодит байдалтай нийцэхгүй байх, үнэ цэнийн бууралтад орох, зээлийн өрийг барьцааны талаар хангах боломжгүй болгож байна.

Хөгжлийн банканд 2015-2021 онд 10 удаагийн хяналт шалгалт хийсэн боловч тус банктай холбоотой зөрчил, дутагдал арилахгүй хэвээр байна. Улсын Их Хурал, Засгийн газраас Хөгжлийн банканд тавих шаардлагыг чангаруулж чанаржуулах, хяналт шалгалтын хүрээнд тогтмол зөвлөмжийг хэрэгжүүлж хангуулах, хяналт шалгалтыг тогтмол эрчимтэй авах шаардлагатай болоод байна.

Эрх зүйн хувьд бид нар ажиллах хугацаандаа Улсын Их Хурлаас шүүхийн бус журмаар өр барагдуулах үйл ажиллагааг зохицуулах хуулийн төслийг өчигдөр өргөн барьсан. Монгол Улсын Засгийн газраас төлбөрийн чадваргүйдлын тухай хуулийг өргөн барихаар ажиллаж байна. Хөгжлийн банкны тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзсэн.

Гэрээний дагуу цааш авч хэрэгжүүлэх арга хэмжээгээ товчхон ярьчихъя. Гэрээний дагуу эргэж төлөгдөх боломжтой зээлүүд нь 707.8 тэрбум төгрөг байна. “МАК цемент”, “Говь”, “Строй инвест”, “Цэцэнс Майнинг”, “Энержи ресурс”, “Вестерн



Холд”, “Дархан минж”, “Монполимет” гэсэн 8 компани шууд гэрээний дагуу эргээд төлчих боломжтой гэж үзэж байгаа. Засгийн газрын түвшинд шийдвэрлэх шаардлагатай 13 зээл байна. Энэ нь бүгд ТӨК-ууд бөгөөд Засгийн газар шийдвэрлэх шаардлагатай байна. Нийт зээлийн дүн 1 их наяд 54 тэрбум төгрөг байна. Шүүхэд шилжүүлэх барьцаа хөрөнгийн дутагдалтай компани 21, зээлийн дүн нь 1 их наяд 15 тэрбум төгрөг байна. Барьцаа хөрөнгө нь хүрэлцээтэй шүүхэд шилжүүлэх 9 компанийн зээлийн дүн 76.8 тэрбум байна. Авлигатай тэмцэх газарт шилжүүлэх 36 зээл байгаа.

Хэвлэл мэдээллийн хэрэгслээр гарсан улс төрчдийн улс төрийн нөлөө хамаарлын тухайд хэдэн зүйл хэлье гэж бодож байгаа юм. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, ажлын хэсэг шууд хүний гэм буруутайг тогтоох эрх зүйн боломж байхгүй, бодит байдал дээр нь компанийн бодит өнөөдрийн байдлыг үнэлж гаргахыг хичээсэн. Х.Баттулга Монгол Улсын Ерөнхийлөгч асан “Хөтөл” компани, “ТОСК шинэ яармаг”-тай холбоотой, Н.Алтанхуяг Улсын Их Хурлын гишүүн “Кью Эс Си” компанид давуу эрх олгосон, “Дарханы төмөрлөгийн үйлдвэр”-ийн хувьчлал дээр. Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт “Вестерн Холд” компанид холбогдох “Ховдын цементийн үйлдвэр”, энэ төсөл нь их сайн хэрэгжиж байгаа төсөл юм. Үүнийг газар дээр нь үзсэн хүмүүсийн хувьд ярьсан. Энэ төслийн хувьд гүйцэтгэл нь 70 орчим хувьтай байгаа юм байна лээ. Амартүвшин, Ганхуяг, Дамдинням нарын хувьд “Вертекс майнинг” ХХК-тай холбоотой асуудал хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр гарсан байгаа. Энэ гурван хүний хувьд ийм байдалтай байгаа. Билэгт Улсын Их Хурлын гишүүн асан “Ачлал трейд” ХХК, “Монлаа” ХХК-тай холбоотой асуудлууд байгаа. А.Сүхбат Улсын Их Хурлын гишүүн асан “Түгээмэл түмэн хишиг” ХХК, Шаравдорж Улсын Их Хурлын гишүүн асан “Шанх майнинг” ХХК, Ундармаа Улсын Их Хурлын гишүүн асан “Капитал банк”, “Монгол эм импекс концерн”, Гарамжав Улсын Их Хурлын гишүүн асан “Монполимет”, Хүрэлбаатар үндэсний аудитын газар дарга асан “Эрд хул” ХХК, Лхамсүрэн Зам тээврийн хөгжлийн дэд сайд асан “Мондулаан” ХХК, Номтойбаяр Улсын Их Хурлын гишүүн асан “МАК цемент”, Пүрэв сангийн дэд сайд асан “Энсада инстерн” ХХК, Элдэв-Очир Улсын Их Хурлын гишүүн асан “Изинис эйрвэйз” ХХК, Хурц Тагнуулын ерөнхий газрын дарга асан “Изинис эйрвэйз” ХХК, Батбаяр Эдийн засгийн хөгжлийн сайд Хөгжлийн банк, Энх-Амгалан Улсын Их Хурлын гишүүн “Монгема” ХХК-тай тус тус холбоотой. Энэ дээр нэмэгдээд “Сэлэнгийн Герефорд” гэж компани 4.1 тэрбум төгрөгийн зээл авсан, 326 сая төгрөг буцааж төлсөн. Зээлийн үлдэгдэл нь 5.5 тэрбум байгаа энэ компани болон эзэн нь олдохгүй байгаа. Үүнийг Авлигатай тэмцэх газар өгч шалгуулах нь зүйтэй гэж бодож байна. Хотол түмэн гэж компани 2 компани болчихоод байгаа. 2018 онд 11.5 тэрбум төгрөгийн зээл аваад 3 сая төгрөг төлсөн. Одоо 17.1 тэрбум төгрөг төлөх дутуу. Одоо 22 компанитай холбогдсон энэ улс төрчдийн хувьд бол Авлигатай тэмцэх газар өгч шалгуулж үнэн зөвөө тогтоолгох нь зүйтэй гэж үзсэн юм. Анхаарал хандуулсанд баярлалаа.

### **Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн Ж.Бат-Эрдэнэ:**

Монгол Улсын Засгийн газар, Монголбанк болон аудитын тайлан, дүгнэлт зөвлөмжтэй танилцаж дүнг Улсын Их Хуралд танилцуулах үүрэг бүхий ажлын хэсгийн ахлагч Баттөмөр сая танилцуулаа. Тэгэхээр Улсын Их Хуралд энэ дүнгээ танилцуулна аа. Хоёрдугаар тайлан мэдээлэл Монгол Улсын Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрийн байдалд хяналт шалгалт хийсэн талаар Монгол Улсын Засгийн газрын танилцуулгыг Сангийн сайд Б.Жавхлан танилцуулна. Жавхлан сайдын микрофон.

### **УИХ-ын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан:**

Нээлттэй энэ сонсголд оролцож байгаа бүгдэд өглөөний мэнд ээ. Монгол Улсын Засгийн газраас Хөгжлийн банканд 2016, 2019 онд 2 удаа иж бүрэн шалгалт хийсэн байдаг юм. Шалгалт тус бүрээр нэлээдгүй ажлууд хийгдсэн. Багцалж хэлэх юм бол 2016 оны шалгалтын дараа 16 дүгнэлт, 90 зөвлөмж гарсан. 2019 оны шалгалтын дараа 3 дүгнэлт, 62 зөрчил, 37 зөвлөмж гарсан байдаг. 2016 оны шалгалтын дараа гарсан зөвлөмжүүдээс хамгийн том, одоо хийгдсэн ажил бол Хөгжлийн банканд томоохон хуулийн өөрчлөлтүүд хийгдсэн. Энэ хуулийн өөрчлөлтийн дараа гол өөрчлөлт нь мэргэжлийн төв институц болох Монголбанк Хөгжлийн банканд хяналт шалгалтын үйл ажиллагаа хийдэг болсон, шалгуур үзүүлэлтүүдийг тавьдаг болсон. Өмнө нь мэргэжлийн байгууллага шалгадаггүй, Засгийн газрын харьяаны аудитын институцүүд нь, өөрөөр хэлбэл Засгийн газрын байгууллага Засгийн газрынхаа байгууллагыг шалгадаг байсан. 2019 оны шалгалтын дараа энэ чанаргүй зээлүүд анх удаа гараад байгаа зүйл биш. 2019 онд шалгалтаар одоогийн Ерөнхий сайд тухайн үед ЗГХЭГ-ын дарга байхдаа ахалж шалгалт хийсэн. Нэлээдгүй чанаргүй зээлүүдийг хуулийн байгууллагад шалгуулахаар шалгалтын мөрөөр шилжүүлсэн байгаа. Энэ процесс өнөөдрийг хүртэл идэвхтэй явж байгаа. Шалгалт тус бүрээр гарсан энэ зөвлөмж зөрчлүүдийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг газрын захирал Сүх-Очир танилцуулна. Орж ирээгүй юм уу?

### **Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн Ж.Бат-Эрдэнэ:**

Жавхлан сайд танилцуулах гэж байна уу?

### **УИХ-ын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан:**

За тэгье дээ. Манайхан орж ирээгүй, оруулаагүй юм шиг байна. 2016 онд хийсэн шалгалтын мөрөөр ийм дүгнэлтүүд гарсан юм. Хараат бус бие даасан байдлыг нь нэмэгдүүлэх, засаглалыг нь сайжруулах, дүрэм журмуудад холбогдох өөрчлөлтүүдийг хийх, үйл ажиллагааны цар хүрээг нь нэмэгдүүлэх, хяналтын тогтолцоог сайжруулах гээд. Энэ нь хамгийн гол шалгалтын мөрөөр хийгдсэн зүйл. Өөрөөр хэлбэл Хөгжлийн банканд шалгалт хийдэг байсан институц маань өөрөө хууль, эрх зүйн хувьд зохимжгүй байна, тийм учраас хөндлөнгийн банкны системийн төв одоо мэргэжлийн хяналтын байгууллага Монголбанкаар шалгуулдаг болъёо гээд. Ингээд 2016 оноос хойш Төв банк байнга хяналт тавьдаг болсон. Хяналтын систем нь одоо сайжирсан гэж үзэж байгаа юм. Мөн 2016 он хүртэл бид их сайн мэднэ. Хөгжлийн банкаар дамжиж Монгол Улс 2-3 төсөвтэй явж ирсэн гээд тухайн үед маш их энэ яригддаг байсан. Ийм зөрчилтэй асуудлыг нэг тийш нь болгох. Улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй зээлийг төсөвт авсан, арилжааны нөхцөлтэй зээлүүдийг Хөгжлийн банканд нь үлдээсэн. Төсвөөс санхүүжүүлэх ёстой төсөл, хөтөлбөрүүдийг Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэнтэй холбогдуулж 1 их наяд төгрөгийг төсвөөс Хөгжлийн банк хооронд зохицуулалт хийж байсан. Ингэж төсвийг төсөв рүү нь, Хөгжлийн банканд очих ёстой эх үүсвэрийг нь Хөгжлийн банканд өгч, Хөгжлийн банкны дүрмийн сан одоо 1 их наяд төгрөгөөр нэмэгдэж төлбөрийн чадвар нь мөн энэ хэмжээгээр балансын хамт сайжирсан байгаа. Мөн хуримтлагдсан алдагдлыг нь бууруулсан. Өөрөөр хэлбэл цаашид Хөгжлийн банкийг хэвийн үйл ажиллагаанд нь оруулах энэ хэмжээний нааштай өөрчлөлтүүд гарсан

байгаа юм. 2016 оны шалгалтын дараа юу өөрчлөгдсөн бэ гэвэл засаглалын хувьд энэ хоёр энд харагдаж байгаа, ийм байдлаар өөрчлөгдсөн байна.

Хяналт шалгалтын тогтолцоо нь Үндэсний аудитын газар, Олон улсын хөндлөнгийн санхүүгийн аудит гээд ер нь жил болгон хийдэг Олон улсын зээлжих зэрэглэл тогтоодог байгууллагаас дотоод аудитын алба гээд 3 институц, субъект шалгалт хийдэг байсан бол шалгалтын дараа 3 институц нэмэгдэж орж ирсэн байгаа юм. Энэ бол хуулийн өөрчлөлтөөр нэмэгдэж орж ирсэн процесс болсон гэсэн үг. Хамгийн том өөрчлөлт нь түрүүнд дурдсан Монголбанк, Засгийн газар мэдээж өөрөө бас шалгалтаа бүрэн хэмжээгээр хийдэг болсон. Дотоод хяналт 2 салсан байгаа. Дотоод аудитын алба, мөн нэмэгдээд дотоод хяналт шалгалтын нэгж гэж өдөр тутмын үйл ажиллагаа явуулж шууд Засгийн газарт тайлагнадаг тогтолцоотой болсон гэсэн үг.

2019 онд хийсэн шалгалтын мөрөөр Засгийн газрын тогтоол гарсан байдаг. Үйл ажиллагааны журмын хэрэгжилт, эх үүсвэрийн зохицуулалтын төсөл, хөтөлбөрийн явцын талаар, санхүү төсвөө нягтлан бодох бүртгэл, мөнгөний баримтын бүрдлүүдийн талаар чиглэл өгсөн тогтоол гарсан. Мөн дараагийн гарсан гол тогтоол маань 169 дүгээр тогтоол байгаа. Хуулийн төсөл боловсруулж өргөн барихад бэлэн болгох, зөрчилтэй зээлдэгчийг хуулийн байгууллагад шилжүүлэх гээд дахин тодруулж хэлье. Одоогоор хуулийн байгууллагад оччихоод байгаа 30-аад зээлтэй холбоотой ажил шалгалтаас хойш эхэлсэн байгаа байгаа юм. Өнөөдрийг хүртэл ингээд эрчимтэй явж, өнөөдөр бид энэ зааланд цуглаж энэ асуудлуудыг одоо ярилцах болж байгаа. Шалгалтын дүнг олон нийтэд нээлттэй ид тод мэдээлэх гэсэн тогтоол гарсан боловч энэ шалгалт чинь нууцын зэрэглэлтэй явж байгаад саяхан нууцын зэрэглэлээс шалгалтын материалыг гаргасан байгаа. Бага, хэт бага хүүтэй зээлийг олгох ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг бүрэн бүрэлдэхүүнээр нь өөрчлөх, Олон улсын менежментийн баг ажиллуулах гэж. Тухайн үедээ ийм шийдвэрүүд гарч байсан боловч харамсалтай нь Олон улсын менежментийн баг ажиллуулах энэ заалт хэрэгжээгүй. ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг өөрчлөх заалт ч мөн бүрэн хэрэгжээгүй ээ.

Энэ шалгалтаар 37 зөвлөмж, 3 дүгнэлт, 62 зөрчлийн акт тогтоогдсон байдаг юм. Шалгалтын хэрэгжилтийг 7 багц арга хэмжээнд хуваасан. Өгөгдсөн үүрэг даалгавар нь Хөгжлийн банкны эрх зүйн орчныг боловсронгуй болгох, дотооддоо мөрддөг дүрэм, журамд нарийвчилсан зохицуулалтуудыг тусгах. Дараах журмуудыг шалгалтын мөрөөр үйл ажиллагаандаа мөрдөж эхэлсэн. Монголбанк Монгол Улсын Хөгжлийн банкны зээлийн бодлогыг өөрчилсөн зээлийн үйл ажиллагааны журам, зөрчилтэй зээлд зээлдэгчид авах арга хэмжээний төлөвлөгөө, зээлийн судалгаа шинжилгээ хийх аргачлал, мөнгөн хадгаламж байршуулах үйл ажиллагааны журам гээд ялангуяа зөрчилтэй холбоотой, цаашид энэ зөрчлүүдээ дахин гаргахгүй байх эрсдлийг бууруулах зорилгоор эдгээр шинээр журам зохицуулалтуудыг хийж өгсөн байгаа. 2019 оны шалгалтын мөрөөр өгсөн үүрэг даалгавар, авч хэрэгжүүлэх арга хэмжээ гээд Чингис самурай, Евро бонд болон бусад эх үүсвэрээс 2012-2016 онд санхүүжилт авсан зөрчилтэй зээлдэгчийг хуулийн байгууллагаар шалгуулах процесс ингээд явж байгаа, өнөөдрийг хүртэл нийт 959.2 тэрбум төгрөгийн 29 чанаргүй зээлийг төлүүлэхээр шүүхэд нэхэмжлэл гаргасан.

Шүүхийн шийдвэр гарсан зээлүүд нь “Кью Эс Си”, “ТОСК”, “Энсада инстерна”, “Ган хүдэр орд”, “Дэд бүтэц инженеринг”, “Монлаа”, “Эрд хул”, “Болор шүр” гэсэн найман компани байгаа юм. Мөн энэ шалгалтаар өгөгдсөн үүрэг даалгавар, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ үргэлжилнэ. Арилжааны банкны санхүүжүүлэх

боломжтой төсөлд бага хүүтэй зээл олгож байгааг зогсоож томоохон төсөл, хөтөлбөрүүдийг санхүүжүүлж байх гэсний дагуу Монгол Улсын Хөгжлийн банкны зээлийн бодлогын шинэчлэлийн хүрээнд 20 тэрбум төгрөгөөс дээш үнийн дүнтэй зээлийн хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэх зохицуулалтыг тусгасан. Өөрөөр хэлбэл 20 тэрбум төгрөг хүртэлх бага хэмжээтэй зээлийг Хөгжлийн банкаар явуулахгүй байх арга хэмжээ, статустай болсон гэсэн үг.

ТУЗ-ийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах гэсний дагуу Хөгжлийн банкны ТУЗ-ийг компанийн тухай хуулийн зохицуулалтын хүрээнд шинээр зохион байгуулж ТУЗ-ийн хараат бус 4 гишүүнийг олон нийтээс нээлттэй сонгон шалгаруулалтаар сонгосон. Засгийн газраас Хөгжлийн банканд хийсэн хяналт шалгалтын мэдээллийг олон нийтэд ил тод мэдээлэх мэдээллийг ил тод байлгах байдлын тухай журам баталсан. Зээлдэгчийн мэдээлэл болон Засгийн газраас хийсэн хяналт шалгалтын тайланг ил тод нээлттэй болгож олон нийтэд танилцах боломжтой болсон.

Төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэхдээ эцсийн зээлдэгчийг зөв тодорхойлж гэрээг байгуулах, эрсдлийг бууруулах, үүргийн гүйцэтгэлийг хангуулах энэний дагуу зээлийн үйл ажиллагааны журамд зээл хүсэгчийн хамаарал бүхий этгээдийн мэдээллийг тогтоох талаар өөрчлөлт оруулсан. Зээлийн барьцаа хөрөнгийн үнэлгээг тогтоох журмыг баталж, уг журамд барьцаа хөрөнгө нь тавигдах шалгуур, шаардлагыг хангахыг тусгасан.

Хөгжлийн банкны ТУЗ-өөс гүйцэтгэх удирдлага тавих, хяналтыг сайжруулах, гүйцэтгэх удирдлагад хариуцлага тооцох, банкны менежментийг Олон улсын туршлагатай багт хариуцуулах талаар холбогдох арга хэмжээг авах үүргийн дагуу 2020 оны 04 дүгээр сараас Сангийн яам тус банкны хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлж эхэлсэн. Үүнээс хойш энэ хүрээнд ТУЗ-ийг шинээр томилж, ТУЗ-ийн харьяаны дотоод аудитыг өргөжүүлж, бүтэц зохион байгуулалтыг шинэчилж, чадавхжуулах талаар холбогдох арга хэмжээг авч ажиллаж байна. Мөн муу зээлдэгчдийг шүүх болон хуулийн байгууллагад шилжүүлэх процесс ялангуяа Сангийн яаманд шилжиж ирснээс хойш нэлээдгүй идэвхжиж, өнөөдөр нийт бараг бүх чанаргүй зээлдэгч нарыг шүүхийн байгууллагад өгч шүүхийн процесс явж байна. Өнөөдөр үүнтэй холбоотойгоор бид одоо сонсгол хийгээд сууж байна гэж харж байгаа юм.

Сангийн яаманд Засгийн газрын хувьцаа эзэмшигчид төлөөлөх эрх шилжиж ирснээс хойш авсан арга хэмжээ нийтдээ зээлийн багц 3.2 их наяд байна 74 зээлийн. Хуулийн байгууллагад нийтдээ 46 зээл буюу 1.7 их наядын зээлийн гэрээг шилжүүлсэн байна. Шүүхийн шатны явцад анхан шатандаа 10 зээл магадлах шатандаа 1 зээл, хяналт шалгалтын шатандаа 6 зээл, шийдвэр гүйцэтгэлийн буюу эцсийн шатандаа 8 зээл байна. Бусад хуулийн байгууллагад Авлигатай тэмцэх газар 10, Эрүүгийн цагдаагийн газар 10, Дүүргийн цагдаагийн газар 2 зээл шилжүүлсэн байна. Шалгалттай холбоотой товч мэдээллийг хугацаандаа танилцуулж дууслаа баярлалаа.

**Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн Ж.Бат-Эрдэнэ:** За баярлалаа. Дараагийн тайлан мэдээлэл Монгол Улсын Хөгжлийн банкнаас хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийн байдалд хяналт шалгалт хийсэн талаарх Монголбанкны танилцуулгыг Монголбанкны дэд ерөнхийлөгч Г.Энхтайван танилцуулна. Монголбанкны Ерөнхийлөгч ирээгүй байна уу? За Энхтайван, одоо хүрээд ирэх байх. Дараагийнхыг нь сонсож байя тэгвэл.

Монгол Улсын Хөгжлийн банкны үйл ажиллагаа, зээл олголтын үр дүн, эргэн төлөлтийн байдалд хийсэн Аудитын шалгалт. Танилцуулгыг Үндэсний аудитын газрын гуравдугаар газрын захирал Д.Энхболд танилцуулна. Аудитын газрын дарга сая над руу ярьсан Сэлэнгэд явж байгаа юм байна. Томилолтоор явж байгаа юм байна.

Аудитын гуравдугаар газрын захирал Энхболд байна. Засгийн газар, Улсын Их Хурлын дэргэдэх байгууллагууд, сая гишүүдийн хэлж байгаа дээр анхаараад хариуцлагаас мултарч, хариуцлагаас хойш суух юм бол алба хаших хэрэг байхгүй шүү. Дэд дарга чинь байгаа юм уу? 37 дугаар микрофон.

### **Монгол Улсын Ерөнхий аудиторовын орлогч Г.Эрдэнэцэцэг:**

Монгол Улсын Ерөнхий аудитор Занданбат дарга Сэлэнгэ аймагт томилолтоор явж байгаа. Аудит хариуцсан хоёр орлогчтой, аудит хариуцсан орлогч, мэдээлэл технологи хариуцсан орлогч гээд миний бие мэдээлэл технологи, харилцаа хамтын ажиллагаа хариуцсан орлогч байна.

Хариуцсан газрын дарга маань илүү дэлгэрэнгүй яриад асуулт хариултад миний бие хариулаад явъя аа гэж бодож байна. Аудит хариуцсан орлогч бас өвчтэй байгаа.

### **ҮАГ-ын Аудитын гуравдугаар газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд:**

Та бүхний энэ өдрийн амгаланг айлтгая. Үндэсний аудитын газраас 2014, 2015, 2019 онуудад Хөгжлийн банкны үйл ажиллагаатай холбоотой гүйцэтгэлийн аудитыг хийсэн байгаа. 2019 онд аудитыг гүйцэтгэхдээ Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2017, 2018 онд аудит хийх тогтоолыг гаргаад энэ үндэслэлээр, мөн Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооноос ирүүлсэн албан бичиг зэргийг үндэслэн гүйцэтгэлийн аудитыг гүйцэтгэсэн. Гүйцэтгэлийн аудитын хамарсан хүрээний хувьд Хөгжлийн банкны 2012-2017 оны үйл ажиллагаа, 2012-2018 оны зээлийн үйл ажиллагааг хамруулан гүйцэтгэлийн аудитыг гүйцэтгэсэн. Тухайн аудитыг гүйцэтгэхэд Монлаа, Эгийн голын усан цахилгаан станц, Монгол Улсын Хөгжлийн банкны олон нийтэд мэдээлэл түгээхтэй холбоотой асуудлуудаарх баримт бичгүүд холбогдох хууль хяналтын байгууллагад шилжүүлэгдсэн байсан учраас аудитаар энэ асуудлыг хязгаарлаж, бусад үйл ажиллагаанд аудитын үйл ажиллагааг хамруулсан. Аудитаар дараах 4 зорилтыг хэрэгжүүлэхээр зорилт тавьсан. Үүнд: Монгол Улсын Хөгжлийн банкны зорилго, зорилт, бүтэц зохион байгуулалт, үйл ажиллагаа хууль тогтоомжийн дагуу үр нөлөөтэй явагдаж байна уу, татан төвлөрүүлсэн хөрөнгийг үр ашигтай, эрсдэлгүй удирдаж байна уу, зээл олголтын үйл ажиллагаа үр дүнтэй хууль, журмын дагуу явагдсан уу, банкны үйл ажиллагаанд хяналтын үр нөлөөтэй тогтолцоо үйлчилж байна уу гэсэн 4 асуудлын хүрээнд 2019 онд аудитыг хийж гүйцэтгэсэн.

Нэгдүгээр зорилтын хүрээнд хууль, эрх зүйн хүрээнд үйл ажиллагаа явагдаж байна уу гэдэг чиглэл дээр эрх зүйн зохицуулалт хангалтгүй, эрсдлийн удирдлагын тогтолцоо бүрэн бүрдээгүй, банкны бүтэц зохион байгуулалтын байгуулах, үйл ажиллагаатай бүрэн уялдааг үзсэн ерөнхий дүгнэлтийг хийгээд энэ хүрээнд ерөнхий дүгнэлтийг хийх болсон дараах илрүүлэлтүүдийг аудитаар хийсэн. Үүнд: Эрх зүйн зохицуулалт хангалтгүй, эрсдлийн удирдлагын тогтолцоо бүрэн бүрдээгүй байсан гэж үзсэн. Тухайн үед өрийн удирдлагын тогтолцоо болон өрийн асуудлууд

Гадаадын зээл тусламжийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Валютын зохицуулалтын тухай хууль зэрэг олон эрх зүйн бичиг баримтуудаар нэгдсэн бус салангид байдлаар зохицуулагдаж байсан. Дээрээс нь 2015 анх улсын Өрийн удирдлагын тухай хууль батлагдсан байгаа. Мөн Монгол Улсын Хөгжлийн банкны хэрэгжүүлэх зорилго, зорилттой холбоотой асуудлыг улсын хөгжлийн бодлогын ерөнхий урт хугацааны болон дунд хугацааны бодлогуудтай хэрхэн уялдуулах чиглэлийн эрх зүйн зохицуулалтууд хангалтгүй байсан зэрэг нь суурь хүчин зүйл болсон гэж үзсэн.

Дараагийн асуудал бол банкны захиргааны нэгжийн орон тоо банкны үйл ажиллагаатай бүрэн уялдаагүй байна гэж тухайн үед дүгнэсэн байна. Энэ нь ямар учиртай вэ гэхээр тухайн үеийн гүйцэтгэх захирлын ажлын албаны дэргэд зээлийн эрсдлийн удирдлагын асуудал хариуцсан нэгжийг давхардуулан ажлыг нь гүйцэтгүүлж байсан. Зээлийн өрийн стратеги болон өрийн удирдлага, эрсдлийн шинжилгээ, эрсдлийг үнэлэх зэрэг асуудлуудыг хариуцах газар, хэлтэс, нэгжийн чиг үүрэг хангалтгүй түвшинд байсан. 2016 он хүртэл зээлийг олгох үйл ажиллагаа идэвхтэй явуулсан ч 2016 оноос банкны цар хүрээ харьцангуй хумигдаж ирсэн байхад банкны дэмжих үйлчилгээ болон захиргааны чиглэлийн ийм бүтэц нь 2019 оныг хүртэл өргөжсөөр байсан учраас үйл ажиллагаа нь бүтэцтэйгээ харилцан уялдахгүй байна гэдэг дүгнэлтийг гаргасан. Арвилан хэмнэлттэй холбоотой ажиллах зарчмыг хангаагүй үр ашиггүй зарцуулалтыг хийж байна гэж дүгнэсэн. Гадаад томилолтын асуудал, орон тоо, бүтцийн асуудал, цалингийн асуудал, дээрээс нь маш их хэмжээний зар сурталчилгааны ажлыг хамгийн багадаа жилд 720 тэрбум, ихдээ 1.2 их наяд төгрөгийг зөвхөн банкны үйл ажиллагааны олон нийтэд түгээх үйл ажиллагаанд зарцуулсан байсан. Мөн үйл ажиллагаанд хамааралгүй зардлуудыг Засгийн газрын өгсөн чиглэлийн дагуу зарцуулж явсан зэрэг нь тухайн банкны үйл ажиллагаа арвилан, хэмнэлттэй ажиллах зарчмыг хангаагүй, үр ашиг, үр нөлөөтэй байдал хангагдаагүй гэдэг дүгнэлтийг хийхэд хүргэсэн.

Мөн тухайн үед худалдан авах ажиллагаанд мөрдөж байгаа журмын зохицуулалт хангалтгүй, арвилан хэмнэлтгүй худалдан авалт хийх нөхцөлийг бүрдүүлсэн байгаа учраас тухайн банкны зүгээс хэрэгжүүлж байгаа худалдан авах ажиллагаатай холбоотой эрх зүйн зохицуулалтыг болиулж Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах хуулийг мөрдөх нь зүйтэй юм гэдэг чиглэлийг өгсөн. Худалдан авах ажиллагаатай холбоотой хэд хэдэн зөрчлүүд илэрсэн. Жишээлбэл банкны байрыг худалдан авахад 20-иод тэрбум төгрөгийг шууд худалдан авалтын гэрээгээр авсан. Гэтэл адилхан хотын А зэрэглэлийн бүсэд Монгол Улсын Их сургуулийн номын сангийн 6 давхар барилгын 15 мянган квм барилгыг 14 тэрбум төгрөгөөр босгосон байхад Хөгжлийн банкны барилгыг хорин хэдэн тэрбумаар авсан асуудал нь шууд гэрээгээр хийгдэж, ашиг сонирхлын зөрчил орсон байж болзошгүй гэдэг үндэслэлээр 10.2 тэрбум төгрөгтэй холбоотой асуудлыг хууль хяналтын байгууллагад шилжүүлж ажилласан тухайн үед.

Энэ зорилтын хүрээнд Монгол Улсын Их Хуралд хоёр асуудлыг толилуулсан зөвлөмжөөрөө, нэгдүгээрт Монгол Улсын Хөгжлийн банкны зээл олгох үйл ажиллагааг улсын хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичгүүдтэй уялдуулах эрх зүйн орчныг бүрдүүлэхэд анхаараач ээ гэдэг асуудлыг хөндсөн. Зээлийн зорилгыг урт хугацааны бодлоготой уялдуулах санхүүжилтийн эх үүсвэр нь Монгол Улсын Хөгжлийн банкны эх үүсвэртэй уялдуулах тал дээр хангалтгүй байсан. Үүнийг хэрхэн эрх зүйн зохицуулалтаар оруулах нь тодорхойгүй байсан учраас Улсын Их Хурлын анхааралд энэ асуудлыг толилуулсан байгаа. Мөн банкны тухайн үед мөрдөгдөж байгаа худалдан авах ажиллагааны журам нь хангалтгүй байсан учраас

дээр эрх зүйн зохицуулалт дээр нь анхаараач ээ гэдэг асуудлыг Улсын Их Хуралд танилцуулж байсан. Засгийн газрын Хэрэг эрхлэх газар болон Хөгжлийн банк ТУЗ-д банкны үйл ажиллагааны төсвийг арвилан хэмнэлттэй, үр ашигтай зарцуулахад анхаарах гэдэг зөвлөмжийг өгсөн. 12.2 тэрбум төгрөгтэй холбоотой асуудлыг хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн.

Хоёр дахь зорилтын хүрээнд тооцоо судалгаагүйгээр эх үүсвэр татаж, мөнгөн хөрөнгийн удирдлагыг зохисгүй хэрэгжүүлснээс их хэмжээний алдагдал хүлээсэн байна гэдэг асуудал аудитаар тухайн үед гарч байсан. Үүнтэй холбоотой нэгдүгээрт бэлтгэл ажлыг бүрэн хангаагүйгээр, бонд гаргасан, зарим бондын эх үүсвэр татах үйл ажиллагааны зардал өндөр байгаа нь бодит хүү нэмэгдэхэд хүргэсэн байна. 2012-2015 онд мөнгөн хөрөнгийн удирдлагыг зохистой хэрэгжүүлээгүйгээс их хэмжээний орлого олох боломжийг алдаж 102 тэрбум төгрөгийн ханшийн алдагдал хүлээсэн.

Арилжааны банкнуудад зарим хадгаламжийг Монголбанкны хүү, эх үүсвэрийн хүүгийн түвшнээс бага хүүтэйгээр байршуулснаас 14 тэрбум төгрөг, 0.9 сая ам.долларын орлого олох боломжийг алдсан байгаа нь тооцоо судалгаа хангалтгүйгээр, өөрөөр хэлбэл ямар төсөл, үйл ажиллагаанд ямар хөрөнгийг татан төвлөрүүлэх гэж байгаа нь тодорхойгүй байдлаар эх үүсвэрийг бүрдүүлж, зарцуулж байгаа асуудлыг цэгцтэй болго гэдэг чиглэлээр, банканд бол активын оновчтой удирдлага хэрэгжүүлэх замаар гадаад валютын ханшийн алдагдлыг бууруулах эрсдлийг хянан удирдаж ажиллах шаардлагатай байна гэдэг дүгнэлтийг өгсөн.

Аудитын гурав дахь зорилтын хүрээнд 7 асуудлыг аудитын илрүүлэлт болгож гаргаж тавьсан. Үүнд: Төслийн үр дүнг үнэлэх шалгуур үзүүлэлт иж бүрэн бус, зээл олголтод, мөрдөгдөж байгаа дүрэм, журмын зохицуулалт хангалтгүй байна гэдэг дүгнэлтийг хийсэн. Зарим зээл зорилго, зорилтод нийцээгүй, Улсын Их Хурлаас батлаагүй хөтөлбөрүүдэд арилжааны банкнуудаар дамжуулан зээл олгосон, өөрөөр хэлбэл Монгол Улсын Хөгжлийн банкаар ямар зорилготой төсөл, хөтөлбөрүүдэд зээл олгох нь тогтоогдсон байсан. Зээлийн зорилт хангагдаагүй, мөн банкны зээлийн зорилтоос зориулалт бусаар ашигласан зэрэг зөрчлүүд гарсан. Аудитын тайланг дэлгэрэнгүй байдлаар нийтэд тавьсан байгаа учраас та бүхэн холбогдох жишээнүүдийг тэндээс шууд татаад үзэх боломжтой байгаа. Мөн зарим зээлийн ашиглалт муу, эргэн төлөлт хангалтгүй хугацаа хэтэрч байгаа нь төслийн үнэлгээ хангалтгүй хийгдсэнтэй холбоотой зэрэг 7 асуудлыг гаргаж тавьж дараах зөвлөмжүүдийг өгсөн. Үүнд: зээлийн үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа журмуудыг шинэчлэн боловсруулж, мөрдүүлэх шаардлагатай байна. Хөгжлийн банкнаас олгох төсөл, хөтөлбөрийн санхүүжилт, хэрэгжилт, үр дүнд үндэсний эдийн засагт үзүүлж буй нөлөөллийг бодитой үнэлж дүгнэх, хяналтын тогтолцооны үйлчлэлийг сайжруулах шаардлагатай байна, ашиглалт муу, эргэн төлөгчид хангалтгүй ангилал буурсан, төслүүдийн хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулах шаардлага байна гэдэг чиглэлээр холбогдох байгууллагуудад нь зөвлөмжөө өгч ажилласан.

Дөрөв дэх аудитын зорилтын хүрээнд банкны үйл ажиллагаанд тавих дотоод хяналтын тогтолцоо 2014 он хүртэл хангалтгүй байсан. Мөн 2012 он хүртэл дотоод аудитуудыг томилоогүй, дотоод аудитуудыг байн байн сольдог, сэлгэдэг ойр ойрхон. Тогтолцооны үр нөлөөнд энэ байдал нөлөөлж байна. Засгийн газар болон Хөгжлийн банк өөрөө өөртөө хяналт тавих тогтолцоо бүрдсэн, хөндлөнгийн хяналтын тогтолцоо хангалтгүй байна гэдэг чиглэлийг өгч ажилласан.

2017 оны Хөгжлийн банкны тухай хуулиар Монголбанк болон Засгийн газраас тавих хяналт орж ирсэн боловч хуулиар энэ нь тодорхой хэмжээний хязгаарлалттай хяналт байсан учраас хангалтгүй гэсэн дүгнэлтийг аудитаас өгч банкны үйл ажиллагаанд тавигдах зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг оновчтой, иж бүрэн зохистой түвшинд тогтоон мөрдүүлж хяналт тавьж ажиллах шаардлагатай байна гэдэг дүгнэлтүүдийг өгсөн.

Аудитын зөвлөмжүүдэд үндэслээд дараах 28 зээлдэгчтэй холбоотой асуудлаар албан шаардлага хүргүүлж ажилласан. Албан шаардлагын хэрэгжилтийг Үндэсний аудитын газарт ирүүлсэн. Энэ 28 байгууллагаас одоогийн байдлаар 6 зээлдэгч эргэн төлөлтийг хийсэн, бусад 22 зээлдэгч зөрчил дутагдлыг бүрэн гүйцэд арилгаагүй хэвээр байна. Мөн Улсын Их Хурлын ажлын хэсэг болон Засгийн газрын ажлын хэсгийн дүгнэлтэд энэ талаар дурдагдсан. Хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудлаар Улсын ерөнхий прокурорын газраас 2022 оны 02 дугаар сард Үндэсний аудитын газарт тус асуудал ямар түвшинд явж байгаа талаар мэдээлэл албан бичгээр ирүүлсэн байгаа. Үүнийг та бүхэн асуудал бүрээр дэлгэц дээр харж байна. Үүнээс хоёр асуудалд гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцсон боловч хөөн хэлэлцэх хугацаа дууссан үндэслэлээр эрүүгийн хариуцлагаас чөлөөлсөн. Нэг асуудалд хэрэг бүртгэлийн хэрэг нээхээс татгалзсан, гурван асуудалд хэрэг нээж шалгуулж байгаа тухай хариу ирүүлсэн байна.

Албан шаардлагын хэрэгжилтийн байдлаар 28 зээлдэгчийн 569.8 тэрбум төгрөгийн эргэн төлөлтийг төлүүлэх, эргэн төлөвлөлтийн эрсдэлд орсон 237.8 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй 3 зээлд анхаарч зээлийг хугацаанд нь төлүүлэх, эрсдлийг бууруулах талаар арга хэмжээ авч ажиллахыг даалгасан. Энэ асуудлаар 6 зээлдэгч зээлээ хаасан. 22 зээлдэгчийн 919.4 тэрбум төгрөг зөрчлийн дүн нь болсон. Эргэн төлөлтийн эрсдэлд орсон 3 зээлийн 242.5 тэрбум төгрөг болж бодитой үр дүн гараагүй байна гэж аудитаар үзсэн. Иймээс Хөгжлийн банканд хийсэн аудитын удаа дараагийн зөвлөмж, албан шаардлагын биелэлт хангалтгүй байгаа учраас 2022 онд Үндэсний аудитын газраас Хөгжлийн банкны 2019 оноос хойших үйл ажиллагаа, өмнөх жилүүдийн эргэн төлөлтийн байдалд дахин аудит хийхээр 2022 оны 06 сараас аудитыг эхлүүлэхээр төлөвлөгөөг батлаад бэлтгэл ажлыг хангаад ажиллаж байна. Анхаарал тавьсан та бүхэнд баярлалаа.

### **Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн Ж.Бат-Эрдэнэ:**

Монголбанкны Ерөнхийлөгч ирсэн үү? Монголбанкныхан хаана байна? Ирсэн үү? Хаана байгаа юм? 39 номерын микрофон өг. Семинар нь хаана болж байгаа юм? Ордон дотор болж байгаа юм биш үү? Ордон дотор бол та нар очоод дуудаадаг даа. Олоод ирлээ.

Цагдаагийн Ерөнхий газрын дарга Ж.Болд, Авлигатай тэмцэх газрын дарга З.Дашдаваа, Монгол Улсын Ерөнхий прокурор Б.Жаргалсайхан нар ирсэн байгаа шүү.

Дараагийн тайлан мэдээлэл, Монгол Улсын Хөгжлийн банкны үйл ажиллагаа, өнөөгийн байдал, санхүүжилт, төсөл, хөтөлбөрийн явц, үр дүн, тулгамдаж буй асуудлын талаарх тайлан танилцуулгыг Хөгжлийн банкны гүйцэтгэх захирал Н.Мандуул танилцуулна. 21 номер байна. Мандуул захирлын микрофон.

### **Хөгжлийн банкны гүйцэтгэх захирал Н.Мандуул:**



Бүгдэд нь энэ өдрийн мэнд хүргэе. Өмнөх илтгэлүүдтэй давхцуулахгүй үүднээс аль болохоор товч болон нэмэлт мэдээлэл өгөх талаар хичээе. Дэлгэцэн дээр та бүхэнд харуулж байна. Миний илтгэл дөрвөн хэсэгтэй.

Нэгдүгээрт, та бүхэн мэдэж байгаа 2022 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр Хөгжлийн банк мэдээллийн ил тод байдлын журмаа шинэчлэн баталсан тул хэвлэлийн бага хурал хийж, Хөгжлийн банкны энэ чанаргүй зээлийн мэдээллүүдийг олон нийтэд ил болгосон. Түүнээс хойших өнөөг хүртэлх 2 сарын хугацаанд гарсан үр дүнгийн талаар танилцуулъя.

Хоёрдугаарт, Хөгжлийн банкны өнөөгийн нөхцөл байдал, өнгөрсөн хугацаанд гарсан алдаа, түүнээсээ авах сургамж болон цаашдаа манай менежментийн зүгээс авах арга хэмжээний саналыг танилцуулъя.

Нэгдүгээрт хэлэхэд, Хөгжлийн банкны хувьд 01 дүгээр сарын 20-ны өдрөөс хойш Төрийн сангийн 4 валютын дансыг Монголбанк дээр нээсэн байгаа. Түүнээс хойш өнөөдрийн байдлаар 33 зээлдэгчээс 132.2 тэрбум төгрөгийн эргэн төлөлт хийгдсэн. Үүнийг ангиллаар нь задалбал 22.1 тэрбум нь хэвийн, 53.5 нь анхаарал хандуулах, 33 тэрбум нь чанаргүй, 27.6 тэрбум төгрөг нь бүрэн төлөгдөж хаагдсан зээл байна. Нийтдээ хэвийн зээлээс 9 зээл эргэн төлөлт хийгдсэн нь анхаарал хандуулах 6, чанаргүйгээс 13 зээлдэгчийн зээл төлөлт хийгдсэн. Бүрэн төлөгдөж хаагдсан нийт 5 зээлдэгч байна. Та бүхэн бас энэ хүснэгтээс харж байгаа байх.

Өнөөг хүртэл Хөгжлийн банк ямархуу байдалтай явж ирэв гэдгийг энэ бүлэгт танилцуулъя. Хөгжлийн банкны пассив гэж ярьдаг өр төлбөрийн хувьд анх 2011 оноос хойш 2013-2015 онд өндөр өсөлттэй жилүүд байсан. Өмнө нь Сангийн сайдын илтгэлд танилцуулагдсан Чингис бондыг улсын төсөв рүү шилжүүлсэн тэр үйл ажиллагаанаас болоод пассив тал маань нэлээд буурч 4 их наяд төгрөгт хүрсэн. Түүний дараа 2017 онд Евро бонд буюу 580 сая ам.долларын бондын эргэн төлөлт хийгдэж пассив тал маань 2.7 их наяд төгрөг рүү буусан байгаа. Ингээд түүнээс хойш тогтмол 3 их наяд төгрөг орчим байна. Өмнө нь Засгийн газрын баталгаатай эх үүсвэр 90 орчим хувийг эзэлдэг байсан бол өнөөгийн байдлаар 24 хувь байгаа. Ганц зээлийн эх үүсвэр, тэр нь бидний хэлж заншсанаар Самурай бондын эх үүсвэр байгаа.

Зээлийн багцын хувьд танилцуулъя. 2011 оноос хойш үйл ажиллагаа эхлээд зээлийн багцын өндөр өсөлттэй жилүүд 2015 он хүртэл үргэлжилсэн байна. Энэ хугацаанд чанаргүй зээлийн хэмжээг Хөгжлийн банк өөрийнхөө дотоод дүрэм журмаар тооцож явж ирсэн. Тэгээд Хөгжлийн банкны тухай хууль эрх зүйн орчин өөрчлөгдөж 2017 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа өнөөгийн хууль батлагдсан. Үүнээс хойш Монголбанкны дүрэм журмыг баримтлан чанаргүй зээлийн хэмжээг тооцдог болсон байгаа. Гэхдээ 2018 онд Монголбанкнаас акт тавьсан байдаг. Нийт чанаргүй зээлийн хэмжээ чинь 417 тэрбум байх байсан, манай банкнаас тохируулгыг нь хийгээгүй явсан юм байна. Ингэж явсаар байгаад 2020 онд чанаргүй активыг 884 тэрбум төгрөг гэж тооцоо хийж тайлагнасан байдаг юм байна. Монголбанкны 2021 оны шалгалтаар нийт чанаргүй зээл маань 1.8 их наяд буюу 57 хувьд хүрсэн байна. Ингээд харахаар манай нийт зээл 3.2 их наяд байгаа. Үүний 57 хувь буюу 1.8 их наяд нь чанаргүй зээл. Анхаарал хандуулах 200 тэрбум төгрөгийн зээл байна. Монголбанкнаас нэмээд 784 тэрбум төгрөгийн Эрсдлийн сан байгуул гэсэн шаардлага тавьсан. Тэгсэн тохиолдолд өөрийн хөрөнгө маань 200 тэрбум төгрөг рүү буурч Монголбанкны өөрийн хөрөнгийн хүрэлцээний шаардлагыг хангах нөхцөлгүй болох тийм байдалд хүрээд байна.

Хөгжлийн банкны зээлийн багцын чанарын 1.8 их наяд төгрөгийн чанаргүй зээл маань яг хэдий хэдийд гарав аа гэдгийг бас энэ хүснэгтээр харуулсан байна. 2012 онд 305 тэрбум, 2013 онд 169 тэрбум, 2014 онд 446 тэрбум, 2015 онд 289 тэрбум, 2016 онд 25 тэрбум, 2017 онд 393 тэрбум төгрөг байна. 2018 онд 143 тэрбум, 2019 онд 22 тэрбум төгрөг байна. Оноор нь гаргасан графикийн хувьд бол энэ байна.

Хөгжлийн банкны хувьд нийтдээ 9 төлөөлөн удирдах зөвлөл, 9 гүйцэтгэх захиралтай энэ хугацаанд ажилласан байна. Өөрөөр хэлбэл нэг жил орчим хугацаанд удирдлагууд ажилласан гэсэн үг. 1.8 их наяд төгрөгийн чанаргүй зээл нийт 4 гүйцэтгэх захирлын ажлаа хийж байх үед шийдвэр нь гарсан байдаг. Ким Жан Жин гээд Солонгос захирал, Н.Мөнхбат, Б.Батбаяр, Г.Амартүвшин гэсэн ийм 4 захирлыг ажиллаж байхад зээлүүд гарсан. Зээлүүдийнх нь нэрс энэ хүснэгт дээр харагдаж байна. 1.8 их наядын зээл гүйцэтгэх захирлуудаараа хуваагдах юм бол Ким Жан Жин захирлын үед 305 тэрбум төгрөг, Мөнхбат захирлын үед 931 тэрбум төгрөг, Батбаяр захирлын үед 536 тэрбум төгрөг, Г.Амартүвшин захирлын үед 22 тэрбум төгрөгийн чанаргүй зээл тус тус гарчээ.

Түүнчлэн бид төлөөлөн удирдах зөвлөлийнх нь гаргасан шийдвэрээр бүлэглэн харуулж байна. Энд Б.Батбаяр даргын үед 305 тэрбум, Б.Шинэбаатар даргын үед 931 тэрбум, Б.Даажамба даргын үед 420 тэрбум М.Баярмагнай даргын үед 138 тэрбум, нийтдээ 1.8 их наяд төгрөгийн зээл байна. Эдгээрийг шугамаар харуулах юм бол нэг иймэрхүү үр дүнтэй байна.

Тэгэхээр бид цаашдаа яах ёстой юм бэ? Өмнөх алдаа дутагдал яах вэ, ингээд маш олон шалгалтууд ордог, үүнээс бүлэглээд ер нь цаашдаа яах ёстой юм бэ гэдэг дээр менежментийн саналаа танилцуулъя. Нэгдүгээрт, Хөгжлийн банк ил тод байдлын хувьд маш санаачилгатай, өөр түвшинд ажиллах ёстой. Засгийн газар, Үндэсний аудитын гэх мэт энэ олон шалгалтууд хэрэгжихгүй байгаа нь Хөгжлийн банкны үйл ажиллагаа ил тод биш байсантай холбоотой гэж бодож байна. Тэгэхээр төслийн судалгааны явц, олголт, зарцуулалт, гүйцэтгэлийг бол ил тод байлгах нь зүйтэй. Түүнчлэн хяналт шалгалтаар хийгдсэн тайлан, дүгнэлт болон түүний хэрэгжилтүүдийг нийтэд ил тод байлгах нь зүйтэй гэсэн саналтай байна.

Шийдвэр гаргалтын тухайд, Хөгжлийн банкны хувьд эрх зүйн орчны хувьд 2011-2016 он хүртэл, 2017 оноос өнөөг хүртэл гэсэн хоёр хуулийн хүрээнд ажиллаж байсан. Өмнөх хууль дээр бол Улсын Их Хурал болон Засгийн газрын шийдвэрээр Хөгжлийн банк шууд зээл олгодог байсан. 2017 оноос Хөгжлийн банк өөрөө шийдэж төсөл, хөтөлбөрөө санхүүжүүлдэг ийм эрх зүйн орчинд ажиллаж ирсэн байна. Бидний санал бол цаашдаа Хөгжлийн банкнаас санхүүжүүлэх төсөл, хөтөлбөрийг Улсын Их Хурал, Засгийн газар заавал баталж байх ёстой. Харин Хөгжлийн банкны хувьд төслийн үр ашгийн судалгааг хийгээд бие даан шийдвэр гаргах нь зүйтэй гэсэн саналтай байгаа. Түүнчлэн бас нэг чухал зүйл бол бид зөвхөн төсөл нь сайн, муу гэдэг талаар яриад байдаг. Тэгвэл төсөл хэрэгжүүлэгч дээр магадлан шинжилгээ хийж байх ёстой нь гэж үзэж байгаа. Жишээ нь, барилгын компани ажиллуулдаг хүн гэнэт махны бизнес хийдэг ч юм уу, тиймэрхүү кэйсүүд манай зээл дээр муу зээл болж бүртгэгдсэн тийм зүйл бас ажиглагдаж байна.

Санхүүжилтийн процессын талаар бид маш олон зээлдэгч нартай уулзалт зохион байгуулж, санал бодлыг нь сонссон. Шийдвэр гарчхаад байхад зээл олголт удааширдаг, түүнээс болж бизнес эрсдэлд ордог гэсэн зүйлийг хэлж байсан. Тэгэхээр бид судалгаа хийгээд юу гэж дүгнэсэн бэ гэхээр тухайн төслийн явц болон

хэрэгжилттэй нь уялдуулж зээлийн санхүүжилтийг олгох ёстой байжээ. Энэ дээр бас дутуу дулимаг ажилласан байна гэж үзэж байна.

Түүнчлэн хяналт муу тавьсанаар зөвхөн төсөл санхүүжүүлэх ёстой байсныг тухайн компани өөр үйл ажиллагаанд зарцуулах боломжийг банкны зүгээс олгосон байна. Зарим үед шийдвэр гарсны дараа нэг дор тухайн төслийн санхүүжилтийг бүтнээр нь олгоод түүнийхээ араас гүйцэтгэлийг нь хянах гэж оролддог иймэрхүү алдаа дутагдал байжээ гэж дүгнэсэн.

Үйл ажиллагааны хувьд бол төслийн санхүүжилтийг сонгодог утгаар нь хэрэгжүүлж чадаагүй гэж үзэж байна. Түүнчлэн банкны хувьд ялангуяа зах зээлийн зарим эрсдэл валютын ханш зэрэг дээр зээлдэгч нарт илүү уян хатан нөхцөлтэй анхнаас нь нөхцөлүүдээ сайн тохирч зээлээ олгох ёстой байсан байна гэсэн бодолтой байгаа. Тэгэхээр энэ хүрээнд төслийг бойжуулах гэдэг зүйл дээр банкны хувьд тэг цэгээс нь эхлэн ажиллах ёстой юм байна.

Мөн төгрөгийн орлоготой зээлдэгчийг валютын ханшийн эрсдэлээс нь хамгаалахад Монголбанк, Сангийн яам зэрэг банк санхүүгийн байгууллагуудтай хамтран ажиллах тийм механизмыг бий болгох ёстой гэж үзэж байгаа.

Засаглалын хувьд нэг зүйл байна. Хөгжлийн банкны тухай хуулиар төлөөлөн удирдах зөвлөл нь гүйцэтгэх удирдлагад хяналт тавьдаг, бодлого стратегийг баталдаг. Мөн зээлийн шийдвэрийг гаргаад байгаа. Тэгэхээр дүрмийн өөрчлөлтөөр 0.6 хувиас их буюу тэр чинь одоо хэрвээ манай өөрийн хөрөнгө 1 их наяд гэж үзвэл 6 тэрбумаас дээших ямарваа нэгэн шийдвэрийг ТУЗ гаргадаг. Энэ нь ТУЗ дээр маш их хариуцлагын ачаалал үүрүүлдэг. ТУЗ болон гүйцэтгэх удирдлагын хариуцлагын зааг ялгаа бас дутуу дулимаг байсан байна гэж үзэж байгаа.

Хэрвээ Хөгжлийн банк үнэхээр ингээд улс оронд хэрэгтэй төслөө санхүүжүүлье гэвэл одоо бидэнд маш энгийн матриц харагдаж байна энэ дээр. Зориулалтын бус зориулалтын дагуу зарцуулсан эсэх, төсөл хэрэгжээгүй, төсөл нь хэрэгжсэн гэдэг иймэрхүү байдлаар матрицыг гаргаад үзвэл одоогийн байдлаар зээлүүдээ хуваарилалт хийгээд харж байна. Тэгэхээр хэрвээ зориулалтын дагуу зарцуулагдаад төсөл нь хэрэгжсэн бол Хөгжлийн банкны зорилтот төсөл, хөтөлбөр мөн байсан байна. Харин зориулалтын дагуу зарцуулагдаад төсөл нь хэрэгжээгүй бол энэ нь зах зээлийн эрсдэлд орсон, магадгүй төсөл хэрэгжүүлэгчийн бизнесийн ур чадвар дутагдсан зэрэг шалтгаанаас үүдэлтэй байх магадлалтай. Харин төсөл нь хэрэгжсэн боловч зориулалтын бус зарцуулалттай байсан бол мөнгө угаах гэмт хэргийн шинж чанартай зүйлс бас яригдах нь зүйтэй болов уу гэж үзэж байна. Мэдээж төсөл нь хэрэгжээгүй зориулалтын бусаар зарцуулсан бол авлига, албан тушаалын хэрэг рүү явж орох байх.

Бид зээлийн багцдаа анализ хийгээд үзэхээр 1.8 их наяд төгрөг дээр нэмээд цаашдаа 400 тэрбум төгрөгийн зээлийн багцад арга хэмжээ авах шаардлагатай гэж үзэж байгаа. Тэгэхээр нийтдээ 2.2 их наяд төгрөгийн багц дээр бид ямар нэгэн байдлаар арга хэмжээ энэ ондоо багтаж авч байж банк маань эрүүл саруул ажиллах нөхцөл нь бүрдэнэ гэж үзэж байна. 2.2 их наядын бараг гуравны нэг орчим нь буюу 762 тэрбум төгрөг нь төсвийн шинж чанартайгаар өмнөх онуудад төрийн өмчит аж ахуйн нэгжүүдэд олгосон зээлийн багц байгаа. 496 бараг ойролцоогоор 500 орчим тэрбум төгрөг нь “Хөтөл” ХХК болон “Кью Эс Си” ХХК-ийн авсан зээл байна. Бусад 986 тэрбум төгрөг нь бол хувийн хэвшил, бизнесийн зээлүүд байгаа.

Дотор нь задлаад харвал 762 тэрбум төгрөгийг төрийн өмчит байгууллагууд авсан. Эдгээр нь “Монголын газрын тос”, “Эрдэнэс Монгол”, “ТОСК”-н 300 орчим тэрбум, “Эгийн голын усан цахилгааны станц”-ын ТЭЗҮ, мөн “Таван толгой” цахилгаан станцын ТЭЗҮ санхүүжүүлсэн. Ингээд нийтдээ 762 тэрбум төгрөг ямар нэгэн байдлаар банкны хувьд эргэн төлөгдөх боломжгүй болчихсон байж байна. “Хөтөл”, “Кью Эс Си” ХХК бол ойлгомжтой. Бусад зээлүүдийн хувьд нийт 38 зээл байна.

Энэ улаанаар тэмдэглэснийг шүүхэд нэхэмжлэл гаргасан болон шүүхэд нэхэмжлэл гаргахаар бэлдэж байгаа зээлүүд гэж ойлгож болно. Зарим зээлүүд дээр мэдээж шийдвэр гарсан боловч Шүүхийн шийдвэрийн ерөнхий газар дээр цаг хугацаа алдаж байгаа асуудлууд байгаа. Тэгэхээр төсвийн шинж чанартай, өмнөх онуудад олгогдсон энэ 760 гаруй тэрбум төгрөгийн багцыг Засгийн газарт шилжүүлж үр ашигтай зардал мөн эсэхийг нь Засаг дээр шийдэх нь зүйтэй гэж бидний зүгээс санал болгож байна. Хөтөлийн цемент шохойн үйлдвэрийн хувьд бол шүүх, прокурорын байгууллагууд хувьчлалыг нь цуцлах шийдвэр гаргасан гэх мэтчилэн шийдээд байна. Ингээд ажиллагаанууд хийгдээд төлөгдсөн тохиолдолд манай чанаргүй зээл нэлээн буюу 28 хувиар буурчих юм. Бид II, III, IV улиралд нийтдээ 986 тэрбумынхаа талаас дээш орчмыг нь төлүүлэхээр ажиллаж байна. Ингэсэн тохиолдолд 2022 оны эцэс гэхэд чанаргүй зээлийн хувийг 12 хувиас доош оруулах боломжтой. Ингэж чадвал банкны хувьд цаашдаа ЭКСИМ банкны чиг үүргийг хэрэгжүүлээд явах нөхцөл бололцоо нь бий болно гэж үзэж байна. За баярлалаа.

#### **Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн Ж.Бат-Эрдэнэ:**

Дараагийн илтгэл, танилцуулга Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн.

#### **Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн:**

Сайн байцгаана уу? Өнөөдрийн амар амгаланг эрж мэндчилье. Бүс нутгийн ногоон санхүүжилтийн Олон улсын хуралдаанд зэрэг явж байгаа учраас түрүүн орж ирж амжсангүй. За тэгээд би Монгол Улсын Хөгжлийн банканд Монголбанкнаас хэрэгжүүлсэн хяналт шалгалтын үйл ажиллагаатай холбоотой товч танилцуулгыг та бүхэнд хүргэе.

Эхлээд Монголбанкны зүгээс Хөгжлийн банканд хууль эрх зүйн ямар үндэслэлээр шалгалт хийдэг юм бэ, Шалгалт ямар хүрээг хамардаг, хийсэн шалгалтын үр дүнг хэн тайлагнадаг вэ, Шалгалтын үр дүнд ямар арга хэмжээ авч хэрэгжүүлдэг вэ гэдэг талаар танилцуулга хийе.

Хэдийгээр Хөгжлийн банк 2011 онд байгуулагдсан ч Хөгжлийн банкны тухай хуульд 2017 оны 02 дугаар сарын 10-ны өдөр УИХ-аас өөрчлөлт оруулснаар Монголбанк тодорхой хэмжээгээр хянаж шалгадаг эрхтэй болсон. Энэ хуулийн хүрээнд Хөгжлийн банк маань банк гэдэг статустай болсон. 2017 оны 11 дүгээр сарын 03-ны өдөр Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар төрийн өмчит төрөлжсөн банкны гэрчилгээг авсан. Хэдийгээр 2011 оноос хойш үйл ажиллагаа явуулсан ч гэсэн 2017 оноос эхлээд банк гэдэг гэрчилгээтэйгээр үйл ажиллагаа явуулах хуулийн этгээд болсон байгаа. Ингээд Хөгжлийн банкны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д заасан төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэх, төлбөр тооцоо хийх, баталгаа, батлан даалт гаргах, үнэт цаас гаргах, санхүүгийн хэрэгсэл худалдах, худалдан авах, хадгалах, зээл авах, гадаад валют худалдах, худалдан авах, хадгалуулах, компанийн хувьцаа эзэмших, хөрөнгө оруулалтын санд хөрөнгө

оруулалт хийх, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор зөвлөх үйлчилгээ үзүүлэх, экспорт импортын санхүүжилт хийх, төлбөрийн чадварыг сайжруулах, ашигтай ажиллагааг нэмэгдүүлэх зорилгоор богино, дунд хугацаатай санхүүгийн эх үүсвэр татан төвлөрүүлэх зэрэг ийм үйл ажиллагааны эрхийг авсан байгаа.

2017 оны 02 дугаар сард батлагдсан хуулийн 25 дугаар зүйлийн 25.1-д Хөгжлийн банкны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам, активыг ангилах, активын эрсдлийн сан байгуулах, зарцуулах журмыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний саналыг харгалзан Монголбанк батална гэсэн тул Монголбанкны Ерөнхийлөгчийн 2017 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн тушаалаар Хөгжлийн банкны активыг ангилах, активын эрсдлийн сан байгуулах, зарцуулах журмыг, 2017 оны 05 дугаар сарын 30-ны өдөр Хөгжлийн банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журмыг Монголбанк тус тус баталаад байгаа. Энэ баталсан журмынхаа дагуу Монголбанк дангаараа Хөгжлийн банканд 2018 онд хэсэгчилсэн шалгалт, 2021 онд мөн хэсэгчилсэн шалгалтыг хийсэн.

2018 онд хийсэн шалгалтын талаар танилцуулъя. Тухайн үед макро эдийн засаг, санхүүгийн үзүүлэлт ямар байсан талаар та бүхэнд эхлээд танилцуулъя. Энэ үед жилийн инфляц 7.7 хувьтай, Дотоодын нийт бүтээгдэхүүн 15 их наяд төгрөг, гадаад валютын улсын нөөц 2.9 тэрбум ам.доллар, гадаад валюттай харьцах төгрөгийн ханш 2461 төгрөг, тухайн үеийн Монголбанкны бодлогын хүү 10 хувь, нийт банкны системийн актив хөрөнгө 27 их наяд буюу дотоодын нийт бүтээгдэхүүнээс илүү хувьтай байсан. Тухайн үеийн улсын төсвийн орлого нь 8 их наяд, зарлага нь 9.9 их наяд, тэнцэл нь 1.9 их наядын алдагдалтай, төлбөрийн тэнцэл өөрөө ашигтай ийм макро эдийн засгийн орчинд Хөгжлийн банк үйл ажиллагаагаа явуулж байсан санхүүгийн тайланг үзүүлье. Тухайн үеийн Монголбанкны шалгалтаар 07 дугаар сарын 20-ны өдрийн байдлаар нийт банкны мөнгөн хөрөнгөнд 767 тэрбум төгрөг, оруулсан хөрөнгө нь 209 тэрбум, зээл нь 2.2 их наяд төгрөг. Тухайн үеийн 2.2 их наядын зээлд тодорхой хэмжээний чанаргүй болсон, зээлд эрсдлийн сан нь 237 тэрбум төгрөгөөр байгуулагдсан. Нийт зээл нь 2.4 их наяд, тэрний 237 тэрбум төгрөгийн зээл нь чанаргүй буюу тодорхой эрсдлийн сан байгуулаад цэвэр зээл нь 2.2 их наяд байсан. Бусад мөнгөн хөрөнгө нь 353 тэрбум төгрөг, үндсэн хөрөнгө нь 27 тэрбум, нийт банкны өр, нийт хөрөнгө нь 3.5 их наяд төгрөгийн ийм хөрөнгөтэй банканд Монголбанк шалгалт хийсэн. Шалгалтыг хэсэгчилсэн байдлаар хийгээд дөрвөн зээлийг нарийвчлан шалгасан байгаа. Бусад зээл нь бол яг хугацаандаа явж байсан. Дөрвөн зээл дээр бол доголдол гарсан байсан учраас чанаргүй зээлд орсон байна уу, зээлийн хуваарийн дагуу явж байна уу гэдгээр нь хэсэгчилсэн маягаар шалгасан. Хэсэгчлэн шалгалт хийхэд нийт 80 тэрбум төгрөгийн чанарын ангиллыг бууруулсан. Тэгээд нийт эрсдлийн санг нь 237-оос 80-аар нэмээд 318 тэрбум төгрөг болгож энэ шалгалтын акт материалыг тухайн үеийн банкны ТУЗ, гүйцэтгэх удирдлагад нь хүргүүлсэн.

Ерөнхийдөө яагаад одоо энэ 2018 онд ингэж шалгалт хийгдсэн юм бэ гэвэл хэдийгээр 2011 онд Хөгжлийн банк байгуулагдаад бүх л төсөл, хөтөлбөрийг Засгийн газар болон УИХ-аар батлаад олгодог байсан ч энд бол Төв банкны оролцоо ерөөсөө байгаагүй. Энэ үед банк гэдэг гэрчилгээг ч аваагүй байсан. Ингээд 2017 онд хуульд өөрчлөлт оруулснаар Монголбанк банк гэдэг гэрчилгээг нь олгоод хяналт тавих хэмжээнд аваачсан. Тэгэхдээ бусад арилжааны банканд тавьдаг хяналт шалгалтын хүрээнд биш Засгийн газрын санхүү эрхэлсэн сайдын гаргасан зөвлөмж, санаачилгаар Монголбанк тэр активын ангиллын журам, зохистой харьцааны

журмыг нь батлаад тэр хүрээндээ л шалгалтаа хийдэг ийм зохицуулалттайгаар өнөөдрийг хүртэл явж ирж байгаа. Тухайн үед хийсэн шалгалтаар бусад зүйлүүдийн харьцааны үзүүлэлтүүдийг яг өөрийнхөө баталсан журмаар үзэх юм өөрийн хөрөнгө эрсдэлээр жигнэсэн активын харьцаа бол 9-өөс их байх ёстой гэдэг ийм зохицуулалттай. Тухайн үед банкнаас 34 хувийн харьцаа хангаж байна гэж ирүүлсэн. Монголбанкны шалгалтаар сая миний хэлсэн эрсдлийн сан байгуулаад явах юм бол энэ нь 32 хувь болж буурсан. Гэхдээ нөгөө журам дээр байгаа 9-өөс их байх гэдэг харьцаагаа хангаж байгаа учраас зохистой харьцааг хангаж байна гэж тухайн үед үзсэн. Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцааг зуун хувиас илүү байх ёстой. Харилцагчийн бэлэн мөнгөнийх нь бэлэн байгаа байдал, төлбөрийн чадвараа гүйцэтгэж байгаа байдал нь зуун хувь байх ёстой гэдэг харьцааны үзүүлэлт байдаг. Тухайн үед банкнаас ирүүлсэн харьцаа бол 161 байсан. Монголбанкны хяналт шалгалтаар энэ дээр бол зөрчил дутагдал байгаагүй гэдгээрээ 161 гэдгийг нь баталгаажуулж гарсан. Тэр утгаараа энэ үзүүлэлт дээр бол зохистой харьцаагаа хангаж байсан. За зээл баталгаа, зээлтэй адилтгах актив хөрөнгийн нийт дүн нь өөрийн хөрөнгөөс хөрөнгийн өөрийн хөрөнгөөс 30 дахин нэмэгдүүлснээс хэтрэхгүй байх ёстой гэдэг хязгаар байдаг. Үүнээс хэтрэх юм бол банканд эрсдэлтэй зүйл болж байна гэдэг дохио өгдөг. Энэ утгаараа тухайн үед банкнаас манайд ирүүлсэн санхүүгийн тайлангаар 12.4 дахин их байна гэж ирсэн. Энэ нь 30 дахин их байхаасаа бол 50 хувиар доогуур үзүүлэлт гэсэн үг. Тухайн үед Монголбанкны хийсэн шалгалтаар 11.7 дахин их байна гээд тодорхой хэмжээгээр буурсан байгаа. Яагаад гэвэл тэр зээлтэй адилтгах хөрөнгүүдийн чанар алдагдсан гэдгээрээ. Өөр нэг үзүүлэлт бол нийт том зээлдэгчид олгосон зээл, зээлтэй адилтган тооцдог хөрөнгө, баталгаа, батлан даалтын нийлбэр дүн нь нийт зээл зээлтэй адилхан актив баталгаа, батлан даалтынхаа нийлбэр дүнгийн 80 хувиас хэтрэхгүй байх ёстой гэдэг ийм дээд хязгаар тогтоосон шалгуур үзүүлэлт байдаг. Банкнаас бол 9.2 хувь байна, хэтрээгүй гэсэн байдлаар ирүүлсэн. Монголбанкны шалгалтаар энэ нь баталгаажсан байгаа. 2018 онд хийсэн иргэдийн шалгалтаар банкны ерөнхий үзүүлэлт зохистой харьцаагаа хангаж байна гэсэн ийм материал гарсан байдаг. Тухайн үед хийсэн, нөгөө миний түрүүчийн хэлж байсан 4 чанаргүй зээлтэй холбоотойгоор Монголбанкнаас акт тогтоож, банканд нь мэдэгдэл хүргүүлсэн байдаг.

Нэгдүгээрт, зээл олголт түүнд тавих хяналт, аудитлагдсан санхүүгийн тайланг зээлдэгчээс авдаггүй нь Хөгжлийн банкны активыг ангилах, активын эрсдлийн сан байгуулж зохицуулах журмын 2.1.6 дахь заалтыг зөрчсөн байна. Тийм учраас тус банкны зээлийн бодлогын 4.2.2-т зааснаар зээлдэгч нь шүүхийн шийдвэрийн өргүй байх гэсэн боловч шүүхийн лавлагаагаар 267.2 сая төгрөгийн өртэй зээлдэгчид зээл олгосон байна гэдгээрээ акт тавигдсан байдаг. Мөн зээл олголтод хяналт тавих аудитлагдсан санхүүгийн тайланг зээлдэгчээс авдаггүй нь Хөгжлийн банкны активыг ангилах акт яг л түрүүчийн заалттай адилхнаар. Ийм байдлаар банканд мөрдөгдөх журмаа биелүүлээгүй байна. Зээлтэй этгээдийн материалыг нь шалгалгүйгээр зээл олгосон байгаа учраас энэнд нь хугацаатай үүрэг өгсөн. Зээлийг үе шаттай хэсэгчлэн төлүүлэх арга хэмжээг авах, зээл эргэн төлөгдөх эх үүсвэр хангалтгүй, дахиад зээл олгосон байгаа нь өөрөөр хэлбэл зээлтэй компанид зээл олгосон байгаа нь нэлээн олон эрсдэлийг банканд үүсгэж байгаа учраас энэ дээр хатуу арга хэмжээ авч ажиллахыг Монголбанкнаас мэдэгдсэн байгаа. Мөн зээлийн тусгайлсан болон бүлгийн эрсдлийн сан байгуулах дотоод аргачлалыг батлаагүй, журмаар зохицуулагдаагүй байна шүү гэдэг зөвлөгөө өгсөн. Яагаад гэвэл энэ банк нь өөрөө дөнгөж 2017 оноос эхлээд яг банкны статустай болсон. Эдний зохистой харьцаа гэдэг Монголбанкнаас тавьж байгаа шалгуур үзүүлэлтийг хийдэг болсон учраас банкнуудад хийгддэг тэр эрсдлийн сан

байгуулдаг, том банкуудад зориулсан бүлгийн сан гэж бас байдаг. Энэ сантай холбоотой дүрэм, журмыг бий болгож мөрдүүлнэ гэдэг шаардлагыг бас хүргүүлсэн. Мөн Хөгжлийн банкны тухайн үеийн ТУЗ, гүйцэтгэх удирдлагад Монголбанкнаас авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээг мөрдөж ажиллуулахыг үүрэг болгосон. Ерөнхийдөө бол 8 үүрэг даалгавар өгсөн байдаг. Та бүхэнд энэ мэдээллээс тодорхой харагдах байх аа.

Дараагийн хэсэгчилсэн ээлжит шалгалтыг 2021 оны 07 дугаар сард оруулсан. Монголбанкнаас хяналт шалгалт хийхэд яг тэр 07 сарынх нь материалыг үздэггүй. Түүнээс өмнөх нэг бүтэн жилийн юм уу 2 жилийн үйл ажиллагаатай холбоотой материалыг бүгдийг нь авч шалгадаг практик байдаг. Үүний дагуу шалгадаг. Энэ талаар товч танилцуулга хийхэд тухайн үеийн макро эдийн засгийн үзүүлэлтүүд ийм байсан. Инфляц 7.4 хувь, Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүн 19 их наяд төгрөг, гадаад валютын нөөц 4.5 тэрбум ам.доллар, гадаад валюттай харьцах төгрөгийн ханш 2849 төгрөг, бодлогын хүү 6 хувь, банкны системийн нийт актив хөрөнгө 39 их наяд төгрөг байсан. Ийм макро эдийн засгийн орчинд Хөгжлийн банкны үйл ажиллагаа ямаршуу байна гэдгээр шалгалт хийгдсэн. Шалгалт хийгдэхээс өмнө одоо бид яг 07 дугаар сарын 31-ний санхүүгийн тайланг нь авч үзээд ороход нийт хөрөнгө нь 4 их наяд төгрөгт хүрсэн байсан. Энэ 4 их наядын 724 тэрбум төгрөг нь мөнгөн хөрөнгө, 217 тэрбум төгрөг бол хувьцаа буюу хөрөнгө оруулалтад хийсэн хөрөнгө. Нийт зээл нь 2.8 их наяд төгрөг. Та бүхэн миний түрүүчийн 2018 онд хийсэн шалгалт, гурван жилийн дараа хийсэн шалгалт хоёрын хооронд зээл 404 тэрбум төгрөгөөр л өссөн байгааг харж байгаа байх. Харьцуулж үзэх юм бол 2.8 их наяд төгрөгийнхөө зээлд 581 тэрбум төгрөгөөр зээлийн эрсдлийн сан байгуулчихсан, бусад хөрөнгө нь 627 тэрбум төгрөг. Мөн санхүүгийн арилжаа хэлбэрээр 210 тэрбум төгрөгөөр санхүүгийн үүсмэл хэрэгсэлд хөрөнгө оруулчихсан. Үндсэн хөрөнгө нь 25 тэрбум ийм банканд дээр шалгалт орсон. Тухайн хийсэн шалгалтаар банкны 40 зээл дээр зээлийн хуваарь зөрчигдсэн байсан. Зээлийн хүү хугацаандаа төлөгдөөгүй, зээлийн үндсэн өрийн төлбөр хуваарьт хугацаандаа төлөгдөөгүй гэдэг зүйлээр мөн Монголбанкныхаа активын ангиллын журмын дагуу тухайн зээлүүдийг эрсдэлээр нь ангилаад ангиллыг нь бууруулсан. Ангилал бууруулаад 755 тэрбум төгрөгийн эрсдлийн сан байгуулж нийт эрсдлийн санг 1 их наяд 337 тэрбумд хүргэх ийм л акт тогтоогдсон байгаа. Ингэхлээр тухайн банкны зээлүүд нь эрсдэлгүй, мөнгөн ашиг болон орлого, өөрийн хөрөнгөөр эрсдлийн сан байгуулаад ирэхлээр тухайн банкны зохистой харьцааны үзүүлэлтүүд бүгд зөрчигдөж эхэлж байгаа.

Би зохистой харьцааны үзүүлэлтүүд яаж зөрчигдөөд, юу болсон бэ гэдгийг та бүхэнд танилцуулъя. Өөрийн хөрөнгийн хэрэгслээр жигнэсэн активын харьцаа 9 хувиас илүү байх ёстой. Банк бол тухайн үедээ 34 хувь байна гэсэн тайлантай байсан бол Монголбанкны хяналт шалгалтаар 1.9 хувь болж буурсан. Өөрийн хөрөнгө нь 1 их наяд төгрөг байсан бол одоо ингээд 755 тэрбум төгрөгөөр хөрөнгийн сан байгуулчихаар 235 тэрбум болж өөрийн хөрөнгө нь буурч байгаа юм. Тэгэхлээр энэ нь юу хэлж байна вэ гэхлээр харьцаа хөрөнгө ингээд алдагдаад явчихаж байгаа юм. Энэ 9 хувиасаа доошоо ороод зохистой харьцаагаа хангахгүй байна гэсэн дүгнэлтийг Монголбанкны хянан шалгагч нар хийсэн. Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа 161-161 хэвээрээ байсан, яагаад гэвэл тодорхой хэмжээний хөрвөх чадвартай активаар 724 тэрбум төгрөгийн мөнгөн хөрөнгөтэй байсан гэдгээрээ банк маань хэвийн хангаж байгаа үзүүлэлт гарсан. Зээл баталгаа, зээлтэй адилхан актив хөрөнгийн нийт үнэ нь өөрийн хөрөнгөөс 30 дахин үржүүлснээс хэтрэхгүй байх ёстой гэдгээрээ 1.8 их наяд төгрөгийн мөнгө нь банкны өөрийнх нь тайлан байсан бол одоо бидний өөрийн хөрөнгийг нь багасгаад гаргаад ирэхлээр

энэ маань 14.9 дахин гэдэг тоо гарч ирж байгаа юм. Тэгэхдээ 30 дахин гэдгээсээ хэтрээгүй байгаа. Энэ нь өөрөө би түрүүн хэлээд байгаа, ерөөсөө 2018 оноос 2021 оны хооронд 3 жилийн хугацаанд зээл нь өөрөө 400 тэрбум төгрөгөөр л өссөн. Гэхдээ урьд нь олгогдсон зээлүүдийн чанар алдагдсан учраас ингээд харьцааны үзүүлэлт нь чанар талдаа алдагдаад явж байгаа. Харин хязгаар тавьсан заалтууд дээр бол өөрөө хангагдсан хэвээрээ байгаа. За тэгээд нийт том зээлдэгчдэд олгосон зээл, зээлтэй адилтгах тооцох хөрөнгө баталгаа, батлан даалтын нийлбэр дүн нь нийт зээл, зээлтэй адилтгах баталгаа, батлан даалттай нийлбэр дүнгийн 80 хувиас хэтрэхгүй гэдгээрээ энэ бол өөрөө нөгөө төвлөрөл хэлээд байгаа юм. Том том зээлдэгч нарт их олгосон байна уу, бага, дунджаар олгосон байна уу гэдгийг нь харьцуулдаг үзүүлэлт. Энэ нь 79.5 буюу нөгөө 80 хувийнхаа хязгаар луу ойртож очиж байна гэдэг маань Хөгжлийн банкнаас олгосон нийт зээл, баталгаа, батлан даалтууд маань нэлээн төвлөрөл өндөртэй байна гэснийг харуулсан үзүүлэлт байгаа. 79.5 гэдэг маань 80 хувь дотроо байгаа учраас зохистой харьцаагаа хангаж байгаа юм. Тэгэхлээр Монголбанкнаас тавьж байгаа зохистой харьцааны шалгуур үзүүлэлт хангах журмаар нэг л заалт дээр хангаагүй, бусад гурван заалт дээр нь бол хангасан гэсэн ийм шалгалтын тайлан гарсан байгаа. Шалгалттай холбоотойгоор Монголбанкнаас хянан шалгагчийн зөрчил тогтоосон актыг тавьсан. Энэ дагуу мэдэгдлийг хүргүүлсэн. Үүнийг уншаад танилцуулъя.

Нэгдүгээрт, зээлийн эрсдлийн санг 755.7 тэрбум төгрөгөөр нэмж байгуулах тохируулгын гүйлгээг хийсэн нөхцөлд тус банкны өөрийн хөрөнгө, эрсдэлтэй жигнэсэн активын харьцаа 1.9 хувь болон буурч Монголбанкны Ерөнхийлөгчийн Хөгжлийн банкны үйл ажиллагаа, зохистой харьцааны шалгуур үзүүлэлтэд болон үйл ажиллагааны хязгаарлалт тогтоох, түүнд хяналт тавих журмын 2.2 дахь заалтад заасан өөрийн хөрөнгийн хүрэлцээний зохистой харьцааг 7.1 нэгж хувиар хангахгүй болсон байна. Мөн Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайдын хамтарсан 2017 оны тушаалаар батлагдсан нягтлан бодох бүртгэлийн багц материалын 4.3-ын "г"-ийн 6 дахь заалт болон Хөгжлийн банкны активын ангилал, эрсдлийн сан байгуулах, зарцуулах журамд заасны дагуу тооцож шалгах өдрөөр 2021 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 1.7 их наяд төгрөгийн зээлийн өр, үлдэгдэл бүхий 40 зээлдэгчийн зээлд 755.7 тэрбум төгрөгийн зээлийн эрсдлийн санг нэмж байгуулах улсын байцаагчийн мэдэгдлийг хүргүүлсэн байна. Үүнийхээ дагуу Монголбанк ямар үйл ажиллагаа хийх ёстой вэ гэдэг дээр зөвлөмж хүргүүлсэн.

Нэгдүгээрт, Хөгжлийн банкны зорилго, зорилт стратегид нийцсэн үүрэг хариуцлага хүлээх эрсдлийн талаар тодорхой тусгасан. Банкны зохистой засаглалын бодлогыг боловсруулж баталж, тэрэндээ хяналт тавьж ажиллах шаардлагатай байна. Банк үйл ажиллагаатай холбоотой аливаа асуудлыг мэргэжлийн түвшинд, сонирхлын зөрчилгүй, хараат бус байдлаар шийдвэрлэх чадвартай ТУЗ-ын гишүүдийг томилох шаардлагатай байна. Хувьцаа эзэмшигчид нь ТУЗ-ын гишүүдтэй гэрээ байгуулах, ТУЗ-аас гүйцэтгэх удирдлагын ажлын гүйцэтгэл, гэрээний үр дүнг үнэлж, дүгнэлт өгөх, гүйцэтгэх удирдлагын ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн баталж, эрх мэдэл, хяналтын заагийг оновчтой тогтооход анхаарч ажиллах шаардлагатай байна. Зээлийн үйл ажиллагаатай холбоотойгоор Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1-д заасан Хөгжлийн банкнаас санхүүжүүлэх төсөл, хөтөлбөрт тавигдах шаардлагыг хангасан эсэхийг үнэлэх, дүгнэлт өгөх, тодорхой шалгуур, аргачлал, зааврыг шинэчилж мөрдөх зайлшгүй шаардлагатай байна. Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн 10.2-т заасан шаардлагыг хангасан төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэх, санхүүжүүлэхдээ гадаад, дотоодын банк санхүүгийн байгууллага, хөрөнгө оруулагчидтай хамтран санхүүжүүлэх заалтыг хангасан эсэхийг үнэлэх,



дүгнэлт өгөх, тодорхой шалгуур, аргачлал, зааврыг шинэчилж мөрдөх зайлшгүй шаардлагатай байна. Зээлийн эрсдлийн удирдлага, дотоод аудит, тогтолцоог сайжруулах, зээл чанаргүйдэхээс сэргийлэх арга хэмжээг урьдчилан авч байх, зээлийн бодлого, холбогдох журмыг үйл ажиллагаандаа бүх шатанд нь мөрдөж ажиллах шаардлагатай байна. Зээлийн үйл ажиллагаатай холбоотой энэ зөвлөмжийн хүрээнд чанаргүй зээлийг төлүүлэх талаар шүүх, хууль хяналтын байгууллагад тухай бүр нь хандаж ажиллах, банкнаас авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээг эрчимжүүлэх, барьцаа хөрөнгөгүй зээлүүдийг барьцаажуулах, барьцаа хөрөнгө хангалтгүй зээлүүдэд нэмж хөрөнгө барьцаалах шаардлагатай байна. Мөн ханшийн эрсдэлтэй холбоотой тодорхой зөвлөмжүүдийг өгсөн байгаа. Гадаад валютын эх үүсвэрээр гадаад валютаар орлого олдог зээлдэгчийн хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлдэг байх. Энэ нь өөрөө бидний яриад байгаа орлого нь төгрөгөөр байдаг аж ахуйн нэгжид валютын зээл олгох зохицуулалт эрсдэлтэй юм байна шүү гэдэг талаараа тодорхой зааж өгсөн байгаа. Мөн Хөгжлийн банкны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4, 8.1.6-д заасан үйл ажиллагааны дагуу валютын ханшийн эрсдэлийг оновчтой удирдах хяналтын тогтолцоог бий болгох зайлшгүй шаардлагатай байна гэсэн ийм зөвлөмжийг өгсөн байгаа. Эцэст нь актив, пассивын хугацааны зөрүүний шинжилгээг тогтмол хийж хяналт тавьж ажиллах, банкны хүлээн зөвшөөрөх эрсдлийн хэм хэмжээний түвшинд урт хугацааны төлбөрийн чадварын үзүүлэлтийг актив, пассивын хугацааны зөрүүний шинжилгээтэй уялдуулж байх шаардлагатай гэсэн ийм шаардлага өгсөн байгаа. Хянан шалгагч улсын байцаагч хяналт тавиад ийм зөвлөгөө өгч бүгд мэргэжлийн үгээр байдаг учраас та бүхэнд дандаа ингээд мэргэжлийн үгээр хэллээ. Үүнийг та бүхэнд жаахан ойлгомжтой болохын тулд мэдээж гаднаас эх үүсвэр авсан бол тэр нь 3 жилийн хугацаатай байвал 5 жилийн хугацаатай бол өгч болохгүй. Яагаад гэвэл 3 жилийн дараа буцаад дуудагдах учраас энэ хугацаанд нь таарсан байх ёстой. Гаднаас валютаар эх үүсвэр авчирсан бол төгрөгөөр орлого олдог аж ахуйн нэгжид өгч болохгүй. Яагаад гэвэл ханшны зөрүү үүсэх юм бол ханшийн зөрүүний алдагдал зээлдэгч дээрээ ч хохиролтой, банкандаа ч эрсдэлтэй болно. Анхаарал тавьсанд баярлалаа.

### **Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн Ж.Бат-Эрдэнэ:**

За баярлалаа. Монгол Улсын Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих эрх бүхий байгууллагуудын дүгнэлт, саналыг сонслоо. Одоо Хөгжлийн банкнаас санхүүжилт авсан зарим нэгэн компаниуд, өөрөөр хэлбэл оролцогчдын тайлбар хэлэх боломж, бололцоог олгож байна. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль, Нийтийн сонсгол зохион байгуулах журамд зааснаар тодорхой асуудлаар санал хэлэх, тайлбар дүгнэлт гаргах, төрийн байгууллага, албан тушаалтан, хуулийн этгээд, иргэн болон шинжээч, ажиглагч нь сонсгол болохоос ажлын 2-оос доошгүй өдрийн өмнө Байнгын хороо, Дэд хороонд саналаа хүргүүлнэ гэсэн. Ингээд дөрвөн компанийн саналууд ирсэн. Эхнээс нь тайлбар танилцуулгыг нь сонсьё. Ингээд хамгийн эхлээд “Монполимет” группийн “Монцемент Билдинг материалс” ХХК-ийн захирал Ц.Халиун 10 минутад багтааж тайлангаа танилцуулна уу.

**“Монполимет” группийн “Монцемент Билдинг материалс” ХХК-ийн захирал Ц.Халиун:**

Сайн байцгаана уу? Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрүүдээс сайн төсөл, цаг хугацаандаа хэрэгжсэн төслийн төлөөлөл болгоод “Монцемент Билдинг материалс” компанийг

төлөөлөөд захирал Ц.Халиун миний би энэ арга хэмжээнд оролцож байна. Надад 10 минут байгаа учраас маш товчхон танилцуулъя. Ерөнхийдөө энэ Хөгжлийн банкны асуудлаас хойш Монцемент төслийн талаар буруу зөрүү мэдээллүүд нийгэмд нэлээд их явлаа. Тиймээс тодорхой мэдээлэл хийх нь зөв гэж үзэж байна.

Нэгдүгээрт, энэ үйлдвэрийн төсөл 2005 оноос хойш ерөнхийдөө төслийн судалгааны түвшинд явж эхэлсэн. Төслийн судалгааны ажилд гэхэд 10 гаруй жилийг зарцуулсан байдаг. Цогц үйлдвэрийн төсөл маань эхлээд Дорноговь аймгийн Өргөн суманд цемент болон чулуунцарын үйлдвэрлэл бүхий Монцемент цогц үйлдвэр, мөн энэ орон нутагт Монгол Улсын анхны хаягдал халуун хийнээс эрчим хүч үйлдвэрлэх WHR гэдэг анхны шинэ технологийг манай хамт олон нэвтрүүлсэн. Ингэснээр төвийн эрчим хүчнээс авах эрчим хүчний ачааллыг 30-40 хувиар бууруулах, өөрөөсөө эрчим хүчийг үйлдвэрлэх ийм технологийн шийдлийг гаргасан байгаа. Мөн энэхүү технологиор Европын сэрэн босголт хөгжлийн банкны олон улсын 200 гаруй төслүүдээс тогтвортой хөгжлийн шагналыг 2017 онд Монцемент төсөл анх удаа Монгол Улсаас авч байсан.

Гуравдугаарт, мэдээж хэрэг хэрэглэгчдээ ойртох үүднээс Улаанбаатар хот дахь Монцемент үйлдвэрийг барьж байгуулсан. Үйлдвэрүүд маань ISO-90012015 стандартыг хэрэгжүүлсэн. Мөн лабораториуд маань магадлан итгэмжлэгдсэн, орчин үеийн технологи бүхий ийм үйлдвэрүүд байгаа. Оролцогч үндэсний болон олон улсын байгууллагууд гэвэл “Лафарж” групп гэж байдаг. Дэлхий дээр цемент үйлдвэрлэлээрээ ноёлдог энэ групптэй хамтарч эдний технологи, мөн судалгаа шинжилгээнд бол Маккензи Аткинс даблү эс пи гэх мэт эдгээр байгууллагуудтай хамтарч ажилласан. Төсөл анх эхэлж байхад бид ийм талбайд очиж байсан бол өнөөдрийн байдлаар үйлдвэр маань бүрэн боссон ийм дүр зурагтай байгаа. Мэдээж хэрэг төсөл хэрэгжүүлэхэд манай Монгол Улсын дэд бүтцийн хүртээмж хүндрэлтэй. Бид нар эхлээд хамт олныхоо тав тухыг бий болгох зорилгоор шинэ хороолол, спорт цогцолбор, фитнес гэх мэт цогцолборыг барьж байгуулсан. Говийн бүс нутагт төсөл хэрэгжүүлэхэд усан хангамж маш чухал байдаг. Иймд шинээр усны ордыг илрүүлэх, цаашлаад Өргөн сумын ард иргэдийг цэвэр усан хангамжаар хангах энэ ажлыг бид хийсэн. Эрчим хүчний 110 кВ-ын дэд станцыг барьж байгуулах, мөн 53.3 километр агаарын шугамыг бас барьж байгуулах гээд энэхүү станц нь Өргөн сум болон Эрдэнэ сум гээд ойр хавийнхаа орон нутгийг эрчим хүчээр хангах бүрэн хүчин чадалтай дэд станц болсон. Манай Монгол Улс төмөр замын хүртээмж ялангуяа хөдлөх бүрэлдэхүүн хүртээмжтэй бус байдаг. Ийм учраас яалт ч үгүй хувийн хэвшил өөрөө хөрөнгөө гаргаад төмөр замд хөрөнгө оруулалт хийх шаардлага заавал тулгардаг. Төслийн хүрээнд орон нутгуудад бүтээн байгуулсан эдгээр дэд бүтцүүдэд 49.5 тэрбум төгрөгийг зарцуулсан байдаг.

Үйл ажиллагаа 2016 оноос хойш зах зээлд нэвтэрч эхэлсэн. Энэ 5 жилийн хугацаанд улсын болон орон нутгийн төсөвт 53 тэрбум төгрөгийн татварыг төвлөрүүлсэн. Мөн энэ үйлдвэрийг дагаж жижиг, дунд үйлдвэрлэл маш ихээр хөгжиж байгаа. Манайх 200 гаруй ханган нийлүүлэгч байгууллагуудтай хамтарч ажилладаг. Эдгээрийн үйл ажиллагааны орлогод 243 тэрбум төгрөгийн орлогыг оруулжээ. Нийгмийн хариуцлагын хүрээнд, тогтвортой хөгжлийн бодлогынхоо хүрээнд маш олон бүтээн байгуулалтыг сум, орон нутагт хийсэн. Эдгээрээс хамгийн том бүтээн байгуулалт нь усан хангамжийг шийдэх зорилгоор Өргөн сумын орон сууц руу 11.2 километр урттай цэвэр усны шугам хоолойг өөрсдийн хөрөнгөөр барьж байгуулсан. Энэ хугацаанд зөвхөн Өргөн сумынхаа хөгжил дэвшилд нийт 24.2 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг хийсэн байна. Дорноговь аймагт мөн 2

цементийн үйлдвэр байдаг учраас энэ аймгийн өрсөлдөх чадвар бусад аймгуудтай харьцуулахад тэргүүлэх байранд ордог.

Хөгжлийн банкны тухайд бол Хөгжлийн банкны тухай хуулийн 10.1.1 гээд заалт байгаа. Энэ дээр дурдсан бүх шалгуурыг Монцемент төсөл 100 хувь хангаж байсан. Монгол Улсын урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогод нийцсэн үү гэвэл нийцсэн. Мөн Хөгжлийн банкны импортыг орлох бүтээгдэхүүн үйлдвэрлэл рүү чиглэх гэсэн гол зорилготой нийцсэн үү гэвэл нийцсэн. Техник эдийн засгийн үндэслэл байсан уу, байгаль орчинд үзүүлэх нийгэм эдийн засгийн үр нөлөө судлагдсан уу гэх мэт шалгууруудыг бол Монцемент төсөл хангасан. Монгол Улсын Засгийн газар 2014 оны 05 дугаар сарын 26-ны өдөр 164 дүгээр тогтоолыг баталж энэ тогтоолын дагуу 65 сая ам.доллартай тэнцэх төгрөгийг энэ Монцемент төсөлд олгох гэж Хөгжлийн банканд даалгасан байдаг. Мөн Үндэсний аюулгүй байдлын зөвлөмжид нийт төслийн хөрөнгө оруулалтын 20 хүртэлх хувийн хөрөнгө оруулалтыг Хөгжлийн банк олгож болно гэсэн байдаг. Энэ шалгууруудыг Монцемент төсөл хангасан байдаг.

Тухайн үеийн ханшаар буюу үүрэг үүсэх үеийн ханш гэж ярьдаг. Энэ үеийн ханшаар нийт 126.6 тэрбум төгрөгийн санхүүжилтийг авсан. Өнөөдрийн байдлаар энэ дэлгэц дээр харагдаж байна. Нийт 24 удаагийн төлөлтөөр 143.1 тэрбум төгрөгийн эргэн төлөлтийг хийсэн байгаа. Мөн энэ дээр харьцуулалт харуулахыг хичээсэн. Тухайн үеийн ханшаар 126.6 тэрбум төгрөг, зээлийн хүү 44.6, нийт төлбөр маань 171.2 тэрбум төгрөг байсан бол одоогийн буюу өнөөдрийн ханшийн огцом өсөлтөөс шалтгаалан нийт зээл маань одоо 235.5 тэрбум төгрөг болж байгаа. Эндээс үүсэж байгаа ханшийн хохирол бол 70 тэрбум төгрөг болж байна. Өнөөдрийн бид нарын зээлийн гэрээн дээр ам.долларын хүү 7.85 хувь байгаа. Үүнийг өнөөдрийн төгрөгийн ханш руу хөрвүүлэх юм бол 16.25 хувь буюу бусад арилжааны банктай дүйцэхүйц хэмжээний хүү бодогдож байна.

2019 он хүртэл Монцемент төсөл цаг хугацаанаасаа түрүүлж зээлийнхээ эргэн төлөлтийг хийх сайн зээлдэгч гэсэн төлөвтэй. Тухайн үед маш олон ажлын хэсгүүд энэ Хөгжлийн банкны зээлийг шалгасан байдаг. Үүгээр ч гэсэн Монцемент төслийг шалгуур хангасан, сайн хэрэгжиж байгаа, сайн төсөл байна гэсэн олон дүгнэлтүүд гарсан байдаг. Яалт ч үгүй 2020, 2021 онуудад Цар тахлын нөхцөл байдал нөлөөлсөн. Цар тахлын жилүүдэд Форсмажор, Хардшип<sup>1</sup> гээд энэ хоёр сертификатуудыг манай Худалдаа аж үйлдвэрийн танхимаас олгодог юм байна лээ. Цар тахлын энэ хүндрэлийг ямар ч аж ахуйн нэгж, хэн ч ер нь таамаглах боломжгүй байсан. Ийм нөхцөл байдал үүссэн үү гэдгийг Худалдаа аж үйлдвэрийн танхимаас судлаад эдгээр сертификатыг олгосон байдаг. Мөн ханшийн хохиролд орж байна уу гэдгийг энэ Хардшип буюу хүнд нөхцөл байдлын гэрчилгээгээр бас тогтоосон байдаг. Цар тахлаас болоод зөвхөн манай үйлдвэр дээр л гэхэд 213 хоногийн үйл ажиллагааны тасалдал бий болсон байдаг. 4 удаагийн хөл хорио тогтоосон. Ажиллах хүчний маань 80-90 хувь нь КОВИД-оор 1-2 удаа өвдсөн. Зарим үнэхээр чадвартай инженер, техникийнхээ ажилчдыг бид зуурдаар энэ өвчнөөр алдсан. Маш их хүндрэлүүд тулгарсан бидний хувьд. Энэ нөхцөл байдалд бидний хувьд хамгийн нэгдүгээр зорилго бол ерөөсөө энэ хамт олныхоо цалинг ямар ч байсан хоцроохгүй, ажлын байраа тогтвортой авч үлдэх зорилго байсан. Хамт олныхоо

---

<sup>1</sup> Force majeure /Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйл/ болон Hardship /Хүнд нөхцөл байдал/-ын гэрчилгээ

эрүүл мэндэд анхаарч ажиллахад орон нутагт эм, эмнэлгийн хүрэлцээ маш муу байсан. Бид нар өөрсдөө кемпдээ ор дэлгээд хүмүүсээ эмчилж байсан. Өргөн сумын эмч нартай хамтраад ажилласан. Энд бас маш их зардал гарч байсан. 2014, 2018, 2021 онуудад хэн ч тооцоолох боломжгүй гаднын хүчин зүйлсүүд бидэнд маш их тулгарсан. Жишээ нь одоо ханш 1800 төгрөг дээр байхад бид нар зээл авсан бол өнөөдрийн байдлаар 2924 төгрөг болоод 57 хувиар өсчихсөн ханшийн өсөлттэй. Эрчим хүчний тариф.

Үйлдвэрлэлийн хамгийн чухал түүхий эд бол нүүрс байдаг. Сайн чанарын нүүрс байснаараа сайн чанарын цемент үйлдвэрлэх нөхцөл бололцоо нь бүрддэг. Ийм сайн чанарын нүүрс бол өнөөдөр манай Монгол Улсад Таван толгойн нүүрс л байгаа, 6000 килокалораас дээш. Энэ нүүрсийг өнөөдөр бид нар 155 хувийн өсөлт буюу Таван толгойгоос Дорноговь руу үйлдвэрийнхээ талбай дээр 1100 километр зай тээвэрлэхэд 166 мянган төгрөгөөр өнөөдөр талбай дээрээ хүлээж авч байна. Төмөр замын тариф. Түлш бол та бүхэн бүгдээрээ мэдэж байгаа, 1450 байсан бол өнөөдөр дизель түлш 3045 буюу 114 хувийн өсөлттэй байна.

### **Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн Ж.Бат-Эрдэнэ:**

Баярлалаа. Дараагийн компани “Вестерн Холд” ХХК гүйцэтгэх захирал С.Балжинням, цагтаа багтая, 10 минутад багтаая. В индэр.

### **“Вестерн Холд” ХХК-ийн Төслийн удирдагч С.Жавхланбаатар:**

Та бүгдэд энэ өдрийн мэндийг хүргэе ээ. “Ховд Эко цемент” төслийн удирдагч С.Жавхланбаатар би цагтаа багтаад цөөхөн хэдхэн үг хэлээд төслийн явцын талаарх танилцуулга, бодит бичлэгийг та бүхэнд тавьж үзүүлнэ ээ. “Ховд Эко цемент” төсөл нь баруун таван аймгийг барилгын гол түүхий эд болох цементээр хангах, алслагдмал баруун хязгаарт Монгол Улсын төрийн бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор, бүс нутгийнхаа хөгжлийг хэрэгжүүлэх зорилгоор хэрэгжүүлж байгаа, түүхэндээ бараг хэмжээгээрээ ч тэр, хөрөнгө оруулалтаараа ч тэр хамгийн анхны ийм төсөл байгаа. Нийт хөрөнгө оруулалтынхаа 40 хувийг Хөгжлийн банкнаас зээлсэн, үлдэгдэл 60 хувийг хувийн хэвшил өөрөө гаргаж байгаа ийм төсөл байгаа юм. Түрүүчийн илтгэлүүд дээр гарсан зээлийн эргэн төлөлт хэвийн ангилалд төсөл яг ид хэрэгжих шатандаа сүүлийн 3 жил хэрэгжиж байгаа. Хэдийгээр цар тахалтай хүнд нөхцөл байдалтай байгаа ч бид нэг ч өдөр төслийн бүтээн байгуулалтыг зогсоогоогүй явж байгаа. Энэ ондоо багтаан үйлдвэрийг ашиглалтад оруулахаар зорьж байна.

Ингээд танилцуулгыг та бүхэнд явуулъя. Гарахгүй юм байна шүү дээ. Техникийн сааталтай байх шиг байна. Ямар ч бичлэг гарахгүй байна. Тэгвэл танилцуулгаа товчхон хурдан явчихъя.

Байршлын хувьд “Ховд Эко цемент” төсөл маань Ховд аймгийн төвөөс 18 км-т байршиж байгаа. Шохойн чулууныхаа орд 2 км-ийн зайд байршиж байгаа. Шохойн чулууны ордын нөөц эхний геологийн судалгаагаар 30 сая тонны нөөцөөр батлагдсан байгаа. Бусад цементийн олон төрлийн түүхий эд байж байгаа. Бүгд баруун бүс нутагтаа байгаа гэдгээрээ онцлог байгаа. Гөлтгөнө, төмрийн хүдэр, нүүрс, занарын орд гэх мэт.

Төслийн давуу талуудыг товчхон дурдъя. Төслийн энэ бол төрийн бодлогоор хэрэгжиж байгаа гэдгийг бас бид нар үзүүлье ээ. 2012 оноос эхэлж хэрэгжсэн

төслийн ач холбогдлыг дурдах юм бол баруун таван аймагт цементийг өнөөгийн Улаанбаатарын үнэ ханшид аваачих ийм зорилт, үндсэн зорилго нь байгаа юм. Таван аймгийн зах зээлийн бодит суурь хүчин чадал дээр суурилагдсан. Анх бол 2012 онд батлагдсан баруун бүс нутгийн төрийн бодлогод нийцүүлэх гэж эхэлсэн байдаг. Энэ төслийг Засгийн газраас хоёр ч удаа дэмжсэн, баруун бүсэд цементийн үйлдвэрийг байгуулъя гэдэг ийм шийдвэр гарсан байдаг. Засгийн газрын 2016-2020, 2020-2024 оны мөрийн хөтөлбөрт тусгагдсан ийм төсөл байгаа юм. Төслийн ач холбогдлыг түрүүн би бас эхлээд хэлсэн байгаа. Улаанбаатарын үнээр цементийн үнийг баруун аймагт барья. Ингэснээр орон сууцжуулах хөтөлбөр бусад барилгын томоохон төслүүдэд гол түлхцийг нь манай төсөл дамжуулж хүргэнэ. Дараагийн ач холбогдол шууд 250-300 ажлын байрыг бий болгоно. Мөн дам дамаар 3000 иргэн, аж ахуйн нэгжийг төсөл маань дэмжих юм. Малчид жижиг дунд үйлдвэрлэгчид, тээвэрчид гэх мэт.

Хөдөө орон нутагт инженер техникийн ажилчид маш дутмаг байна. Энэ дээр манай төсөл яг өөрөө бодит, энэ хүндрэлийг амсаж байгаа. Энэ хүрээндээ бас төсөл хэрэгжүүлэх шатандаа Ховд болон баруун бүс нутагт байгаа МСҮТ болон бусад техникийн коллежуудтай хамтран сургалтын хөтөлбөр бэлтгэж ажиллаж байгаа. Цаашид бас бусад ач холбогдлууд нэлээн бий. Төвлөрлийг сааруулах тээврийн зардлыг хэмнэх, шатахууны зардлыг хэмнэх, зам ашиглалтыг сайжруулах гэх мэт. Зорилтот зах зээл баруун таван аймаг, энэ техник эдийн засгийн үндэслэл дээрээ суурилсан байж байгаа. Бусад мэдээж томоохон төслүүдийг дэмжиж ажиллана. Одоогоор баруун таван аймагт яригдаж байгаа нэг том төсөл Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц байгаа.

Зээл авах процессыг товчхон дурдъя. 2014 онд энэ төсөл маань техник эдийн засгийн үндэслэл нь батлагдсан. Байгаль орчны нарийвчилсан үнэлгээ 2017 онд хийгдсэн. 2017 онд мөн төслийн нарийвчилсан үнэлгээ, эрсдлийн үнэлгээ хийгдсэн байдаг. 2017 оны 05 дугаар сарын 09-өөс эхлэн Монгол Улсын Хөгжлийн банканд ТЭЗҮ-ээ хүргүүлж зээл авч хамтран хэрэгжүүлбэ ээ гэдэг саналаа тавиад, ингээд 2017 оны 06 дугаар сард үйлдвэрийн төсөвт өртгийг өгөөд зураг төслөө батлуулж өгөөд 09 сард, 2018 оны 11 дүгээр сард сүүлийн бичиг баримт буюу төслийн ТЭЗҮ-г магадлалаар оруулсан бичиг баримтаа өгөөд 2018 оны 11 дүгээр сард зээлийн гэрээг байгуулсан байдаг. Ингээд жилийн дараа буюу 2019 оны 09 дүгээр сард эхний санхүүжилтээ аваад өнөөг хүртэл ингээд төсөл хэрэгжээд явж байна. Барьцаа үнэлгээний асуудал байгаа. Барьцаа үнэлгээ нийт зах зээлийн үнэлгээгээрээ 161.3 тэрбум барьцаа үнэлгээг Хөгжлийн банканд өгсөн. Үүнийг Хөгжлийн банк маань 80 тэрбумаар эрсдэл тооцож барьцаалсан байж байгаа.

Төсөл хэрэгжих шатны зарим үйл явцыг харуулж байна. 2019 оны 05 дугаар сард шав тавьсан, тухайн үеийн Монгол Улсын Ерөнхий сайд, одоогийн Ерөнхийлөгч очсон. Төсөлтэй, бас төр Засгийн дээд өндөр шатны албан тушаалтнууд очиж хэд хэдэн удаа танилцсан байгаа. Улсын Их Хурлын Дарга, Шадар сайд, Барилга хот байгуулалтын сайд гэх мэт.

Өнөөдрийн байдлаар төслийн гүйцэтгэлийн хэмжээг бас ангилал бүрээр нарийвчилж гаргасан байж байгаа. Ер нь барилгын ажил маань 95 хувьтай тоног төхөөрөмжийн угсралт маань 30 хувьтай төсөл маань нийт өнөөдрийн байдлаар 73 хувийн гүйцэтгэлтэй явж байгаа. Мэдээж бэрхшээлийг бид нар ярих ёстой, онцлох ёстой гэж бодож байна. Хил гааль хаалттай байснаас шалтгаалаад төслийн өртөг маань нэмэгдсэн. Нарийн тохиргоо хийдэг гаднын мэргэжилтнүүд байж байгаа, эд нар маань бас одоо болтол орж ирэх асуудалтай байж байгаа. Дээр нь нийтдээ

Монголын зах зээлд, ялангуяа энэ том төслийг хэрэгжүүлэхэд нарийн мэргэжлийн инженер болон өдөр тутмын барилгын ажлыг гүйцэтгэх угсралтын ажлыг гүйцэтгэх ажиллах хүчний хомстолтой бас бид нар нэлээд тулгарсан. Анхаарал хандуулсанд баярлалаа.

### **Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн Ж.Бат-Эрдэнэ:**

Дараагийн компанийн мэдээллийг сонсьё. “Эрэл групп” ХХК-ийг үүсгэн байгуулагч Б.Эрдэнэбат. 16 дугаар микрофоныг өгөөрэй. Б индрийн микрофоныг өг дөө.

### **“Эрэл групп” ХХК-ийн үүсгэн байгуулагч Б.Эрдэнэбат:**

Өнөөдөр нээлттэй сонсох үйл ажиллагаанд ирсэн бүх хүмүүст өнөөдрийн мэндийг хүргэе ээ. Ингээд би “Эрэл” компанийн байшин үйлдвэрлэх комбинатын төслийг товч танилцуулъя. “Эрэл” компани бол дотроо бол 13 ийм аж ахуйн нэгжтэй, ихэнх нь дэд бүтцийн салбарт, барилгын материалын үйлдвэрлэлийн үйл ажиллагаа эрхэлдэг. Үүн дотроосоо байшин, үйлдвэр комбинатыг орчин үеийн европын технологид шилжүүлсэн. Уг үйлдвэр нь Европын холбооны 28 улсын “Прогресс” гэдэг группийн тэргүүлэх орчин үеийн технологи байгаа. Дэлхийн энэ хөгжилтэй ийм олон оронд энэ үйлдвэрээр ард түмнээ үл хөдлөх хөрөнгө, үндсэн хөрөнгөөр ингэж хангаж байгаа юм. Эко ногоон үйлдвэрлэл.

Ингээд он цагийн дарааллаар нь би та бүхэнд Улсын Их Хурлын тогтоол, Засгийн газар, Үндэсний аюулгүй байдлын энэ тогтоолуудыг холбогдуулж ярина. Улсын Их Хурлын 2010 оны 36 дугаар тогтоолоор бол шинэ бүтээн байгуулалт, дунд хугацааны зорилт хөтөлбөрөөр уг төслийг Улсын Их Хурлын бондын зөвлөлөөр орж албан ёсны зөвшөөрөл өгсөн. Дараад нь 2012 оны 12 дугаар сарын Үнэсний аюулгүйн зөвлөлийн зөвлөмжөөр төслийн арга хэмжээнд гуравны нэгийг нь зарцуулна, гуравны хоёрыг нь бол өөрсдөө Олон улсаас олохоор ингэж зөвлөмжөөр шийдвэрлэсэн. Үүний дагуу бид Олон улсаас Европын Комерц банкнаас германы нэг нь Олон улсын хөрөнгө оруулалтын банкнаас 9 сая ам.долларын зээлийг олж ирсэн. Хөгжлийн банкнаасаа, Чингис бондын эх үүсвэрээс бол 14 сая ам.доллар тухайн үеийн ханшаар 20 тэрбум төгрөгийн зээлийг авсан. Уг төслийг бид хугацаанд нь өнөөдөр ашиглалтад оруулах төлөвлөлтөө тавьсан. 2016 оны 254 дүгээр тогтоол хэрэгжээгүйгээс болоод нэг жилийн хугацаа алдсан байгаа. Гэхдээ бид энэ хөрөнгийн эх үүсвэрийг бол өөрсдөө олоод уг ажлыг хийж дуусгасан. 2013 оны 04 дүгээр сард хөгжлийн төлөө түншлэл, нийгмийн хариуцлагатай хөрөнгө оруулалтад урьсан. Энэ урилгыг бол бүрэн дүүрэн дэмжсэн. Ингээд 2013 оны 05 дугаар сард 180 дугаар тогтоол гарсан. 180 дугаар тогтоолоор 14 сая ам.доллартой тэнцэх төгрөгийн зээлийн шийдвэр гарч, 2013 оны 06 дугаар сардаа Барилга хөгжлийн яамнаас бол Хөгжлийн банканд захиалгын бөгөөд худалдан авалтын баталгаа гаргасан. Үүний дагуу 2013 оны 08 дугаар сард 14 сая ам.долларын зээлийг авсан. Уг үйлдвэр нь нэг, хоёр захиалагчтай ч юм уу хувийн захиалгаар явдаг биш хот тосгон дагуул хотыг иж бүрнээр нь барьдаг учраас энэ бол гарцаагүй өнөөдөр төрийн дэмжлэг төрийн захиалга бол чухлаа. Тухайн үед 184 мянган өрх өнөөдөр бол 220 мянган өрх гэж байгаа. Гэр хорооллын агаар, хөрсний бохирдлыг бууруулах, гэр хорооллыг дахин төлөвлөх, Олон улсад хүлээсэн уур амьсгалын өөрчлөлтөөр Монгол Улсын хүлээсэн үүргийг биелүүлэх ийм стратегийн ач холбогдолтой Засгийн газрын ийм төслөө.

Уг төсөл ашиглалтад 2017 онд орсон. 2017 оны 12 дугаар сарын 15-нд ашиглалтад ороод тус төсөл өнөөдөр хүртэл дөрөв дэх жилдээ үйл ажиллагаа нь бараг зогсолтын байдалтай байгаа. Энэ нь юу юугаар холбогдсон бэ гэхээр Засгийн газрын 121, Засгийн газрын 2019 оны 202 дугаар тогтоол хэрэгжээгүйгээс үүдээд төлбөрийн хүнд нөхцөл байдал үүссэн юм. Тэгээд уг үйлдвэртээ бол манай төр Засгийн өндөрлөгүүд очиж танилцсан. Энэ дээр бол манай барилгын сайд Х.Баделхан сайд, манай Хөгжлийн банкны захирал Н.Батбаяр нар очиж нээлтийн үйл ажиллагаанд оролцсон. Дараа нь Монгол Улсын Ерөнхийлөгч, Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүх. Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Л.Оюун-Эрдэнэ, Монгол Улсын Нийслэл хотын иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга С.Амарсайхан нар очиж үйл ажиллагаатай танилцсан. Энэнээс хойш бид энэ байшин үйлдвэрлэх кабинетаар юу хийж болох вэ гэж, амины орон сууц, дээр нь нийтийн орон сууц, цэцэрлэг, сургууль соёл, олон нийтийн барилгыг яаж барьж явуулах вэ гэдэг загварын байруудыг бариулсан дэлгэцэн дээр та бүхэнд энд харуулж байна. Ингээд бид ногоон гэрчилгээ Олон улсын хэмжээнд бол А зэрэглэлийн, Б зэрэглэлийн эрчим хүчний хэмнэлттэй ийм ногоон гэрчилгээнүүдийг авсан. Амины орон сууцыг бол өнөөдөр долоо хоногийн дотор иж бүрэн барьж дуусгаж байгаа. Тэр саяын нийтийн орон сууцыг бол 2019 онд ашиглалтад оруулсан. Борлуулалтын өртөг нь нэг метр квадрат нь нэг сая хоёр зуун мянган төгрөгөөр тухайн үедээ үнэлж гаргасан. Бид цайз захын 712 айлын энэ GIZ-тэй холбогдоод хотын захиргаа, нийслэлийн орон сууцны корпорацтай нийлээд эхний ээлжийн 20 айлыг ашиглалтад оруулсан, 2021 онд буюу өнгөрсөн онд. Энэний нэг метр квадратын борлуулалтын үнэ нэг сая зургаан зуун мянган төгрөгтэй тэнцсэн. Энэ бол бас харьцангуй хямд давуу олон талуудтай. Энэ бол эрчим хүчний хэмнэлттэй, галд тэсвэртэй, газар хөдлөлтөд тэсвэртэй, жилийн дөрвөн улиралд өвөл зунгүй үйл ажиллагаа явуулдаг, хүнээс хамаарах алдаа байхгүй ийм олон сайхан давуу талтай.

Энэ үйлдвэрийг хугацаа алдалгүйгээр бид гэр хорооллын дахин төлөвлөлтийг орчин үеийн хот тосон болгож энэ хорт хий, агаарын бохирдлоос гарах ёстой гэсэн бодол, байр суурьтай байдаг. Энэ дээр хэрэглэсэн гол шийдвэрүүдийг хэлье. Улсын Их Хурал, Засгийн газар, Үндэсний аюулгүй байдлын. Эхнийх нь бол өнөөдөр “Эрэл” компани хэрэгжүүлсэн. Тэр аюулгүйн зөвлөмжийн гуравны хоёрыг бол бид Олон улсаас хөрөнгөө босгосон. Дараагийнх нь тэр юу барилгын яамнаас Хөгжлийн банканд гаргаж өгсөн баталгаа байгаа. Жил болгон 150 мянган метр квадрат соёл, олон нийтийн барилга, 5000 айлын амины орон сууцыг тухайн үйлдвэр захиалж зах зээлийн ханшаар худалдаж авна гэсэн ийм баталгааг үндэслэж Хөгжлийн банк 2013 оны 08 дугаар сард зээлийн хорооныхоо хурлаар 14 сая ам.долларын зээлийг Чингис бондоос бидэнд олгосон. Ингээд дараад нь 2016 оны 121 дүгээр тогтоолыг бас хэрэгжүүлсэн. 2020 он гэхэд бол өвөл зунгүй ажиллуулах орчин үеийн технологитой үйлдвэр ашиглалтад оруулахаар Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан. Түүнийгээ хэрэгжүүлсэн. 2019 оны 202 дугаар тогтоолоор 2019 оноос эхлээд жил болгон 2500 айлын орон сууцыг барихаар “Эрэл групп”-д Засгийн газрын үйл ажиллагааны дөрвөн жилийн мөрийн хөтөлбөрт суусан. Энэ өнөөдөр Ковидтой холбогдуулаад олон улсын давагдашгүй хүчин зүйлээс болоод Монгол Улс санхүү эдийн Засгийн гүн хямралд орсон учраас энэ бас тухайн үеийн Засгийн газрын тогтоол бол хэрэгжээгүй. Үүнтэй холбогдоод өнөөдөр Хөгжлийн банканд төлөгдөх эргэн төлөлт хугацаа алдсан. Уг зээл өнөөдөр найдваргүй зээлийн ангилалд хугацаагаараа орчхоод байгаа. Уул нь энэ найдвартай зээл, стратегийн ач холбогдолтой хамгийн чухал зээл. Дэлхийн олон улсад хэрэглэгдэх хамгийн орчин үеийн технологийг Монгол хүний оюун ухаанаар өнөөдөр Монгол Улсынхаа цаг уурт нутагшуулж газар хөдлөлтийн долоогоос есөн бал, дээр нь хасах тавин градуст эрчим хүчний алдагдалгүй ийм

байрыг, хот тосгоныг жил болгон 150 мянган метр квадрат ашигтай ийм талбай бүхий орон сууцыг ашиглалтад оруулна. Хуучин бид социалист системийн үед мэднэ шүү дээ, тийм ээ, энэ 3, 4 дүгээр хороолол, сургуультай цэцэрлэгтэй, нийтийн орон сууц, амины орон сууцтай 13, 14, 15 бүгдийг нь барьж байгуулсан ийм сайхан түүхтэй уул нь үйлдвэр. Өнөөдөр хамгийн орчин үеийн, технологид шилжээд, бид бүхэн үүнийгээр гэр хорооллын дахин төлөвлөлтөд саяын энэ шар ангилалд шилжсэн энэ Олон улсын Ковид болон хилийн хорио энэ цэрийн асуудал, дэглэм чөлөөлөгдсөнтэй холбогдуулаад бид цаашид хамтран ажиллах үүнийг үр өгөөжийг нь бол гэр хорооллынхондоо маш түргэн хүргэх ийм зорилтыг дэвшүүлж байгаа юм.

Ингээд бид энэ төслийг цааш нь амжилттай хэрэгжүүлэх талаар та бүхэнд өөрийнхөө дараагийнхаа саналыг товчхон хэлчихье. Хугацаа бага байгаа учраас. Байшин үйлдвэрлэх кабинет үйлдвэрийн санхүүгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 275 тэрбум төгрөгийн хөрөнгөтэй, үүнээс бид Хөгжлийн банкнаас 141.7 өнөөдрийн хаалтын ханшаар, тухайн үеийн ханшаар бол үндсэн зээл 70 тэрбум төгрөгийн зээлтэй. Энэ ханшийн алдагдалтайгаа нийлээд бол 141 болчихоод байгаа. Ингээд 141 тэрбумын зээлээсээ бид тэр юун дээр он оноор нь та бүхэнд товчхон харуулъя. Тэрэн дээр тухайн үеийн ханшаараа 107.3 тэрбум хүү алдангитайгаа нийлээд, өнөөдрийн хаалтын ханшаар бол 141.7 тэрбум. Үүнээсээ бид 60-70 тэрбум төгрөгийг нь Олон улсын хөрөнгө оруулагч стратегийн хөрөнгө оруулагчийг олоод үндсэн зээлээсээ шууд хаая гэж ийм саналыг дэвшүүлж байгаа юм. Тэгээд зээлийнхээ үлдэгдэл дээр төр хувийн хэвшлийн түншлэл болоод цаашдаа Засгийн газартайгаа хамтраад гэр хорооллыг өвөл зунгүй барилгажуулъя. Ингээд Засгийн газар 30 хувьтай, “Эрэл” компани 45 хувьтай, Олон улсын санхүүгийн хөрөнгө оруулалтын компани 25 хувьтай байхаар ингэж бид төлөвлөж байна. Ингээд бид эхлэлийн баланс бол ямар ч өр байхгүй. Байшин үйлдвэрлэх ХХК болоод үйл ажиллагаагаа явуулна. Тэгээд Хөгжлийн банкны үндсэн зээлийн 65 тэрбум төгрөгийг өнөөдөр хаана. Тэгээд төрийн оролцоотой байгаа учраас бид ипотекийн зээлээр худалдан авагч, гэр хорооллын өрхийн орлогод нийцсэн ийм орон сууц, эко барилгыг бүрэн барилгажуулах ийм боломжтой. Стратегийн хөрөнгө оруулагч Олон улсад туршлагатай, санхүүгийн үйл ажиллагаа явуулах компани байгаа. Ингээд эзэмшлийн бүтцийн талаараа та бүхэнд бас би товчхон энэ дээр ингээд харуулъя. Засгийн газар бол 30 хувь, “Эрэл” компани 45 хувь, түрүүний хэлдэг стратегийн хөрөнгө оруулагч нь 25 хувь байхаар энэ байшин үйлдвэрлэх кабинет ХХК гэсэн. Ийм төр, хувийн хэвшлийн түншлэлийн компани байна.

### **Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн Ж.Бат-Эрдэнэ:**

Баярлалаа. Дараагийн мэдээллийг “Монгол драй милк” ХХК Х.Батбаасан. Б индэр, Б индэр микрофоныг өгөөрэй.

### **“Монгол драй милк” ХХК Х.Батбаасан:**

Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе ээ. “Монгол драй милк” ХХК буюу “Монгол хуурай сүү” төслийг болон Хөгжлийн банкнаас авсан 14.9 сая ам.долларын зээл, үүний эцсийн барьцаалуулагч болон батлан даагчийг төлөөлж Хадбаасан овогтой Батбаасан би энд танилцуулахаар ирсэн байна. Юуны өмнө нэг юм хэлэхэд төслийн товч танилцуулга болон дэлгэрэнгүй персентацийг та бүхэнд ямар ч байсан би авчраад тараачихсан байгаа. Тэгэхээр энэндээ тааруулаад ярина гэхээр цаг хугацаа маань амжихгүй учраас би гол гол юмнуудаа товчлоод ярьчихъя. Та бүхэн бас энэ танилцуулга аваагүй хүмүүс энэ төслийнхөө юуг харчихна биз дээ.



Монгол орны гол эдийн засгийн нэг хөшүүрэг мал аж ахуй гэдгийг та бид бүгдээрээ сайн мэдэж байгаа. Үүнээс сүү, сүүн бүтээгдэхүүнийг эргэлтэд оруулах малчдын гар дээр байгаа сүүг эргэлтэд оруулж экспорт, импортыг орлох. Монгол улс гэхэд л жилдээ 70-80 орчим сая ам.долларын сүү болон сүүн бүтээгдэхүүн гаднаас импортлон оруулж ирдэг. Үүнийг бид нар дотооддоо хийж малчдын гар дээрээс сүүн бүтээгдэхүүнийг авч тэрийгээ хуурай сүү болгох зорилготой. Ерөнхийдөө товчхондоо бол иймэрхүү төсөл байгаа. Төслийн хүрээнд бид нар нийтдээ төслийн хөрөнгө оруулалт маань 34.5 сая ам.доллар гэж анх тооцоологдож байсан. Энэ төсөл маань өөрөө 2014, 2015, 2016 онд судалгаагаа хийж байсан төсөл байгаа. Хөгжлийн банк дээр болохоороо 2017 оны 06 дугаар сараас эхлээд зээлээ аваад тэгээд 2017 ондоо нийтдээ 14.9 сая ам.долларын зээл авсан ийм төсөл байгаа. Хөгжлийн банканд дээр анх батлагдсанаараа бол 29 сая ам.доллар боловч яг олгогдсон зээл нь бол 14.9 сая ам.доллар байгаа.

Энд нэг юмыг бас хэлэх нь зүйтэй байх. Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030 гээд 2016 оны тогтоол, төрөөс хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого гээд 2015 оны тогтоол, Монгол мал үндэсний хөтөлбөр гээд 2010 оны тогтоол, Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай тогтоол, Хүнсний аюулгүй байдлын тухай тогтоол, Мах сүүний анхдугаар аян гээд 2016 оны 12 дугаар сард батлагдсан тогтоол, Эрчимжсэн мал аж ахуйн үндэсний хөтөлбөр гээд тогтоол энэ бүх тогтоолын хүрээнд “Монгол драй милк” компани маань Монгол Улсын алслагдсан аймаг, сум нутагт 60 ширхэг хуурай сүүний үйлдвэр барихаар Хөгжлийн банкнаас 14.9 сая ам.долларын зээлийг үндсэндээ 2017 ондоо багтааж авсан. Уг зээлийг авснаас хойш одоогийн байдлаар бодит байдлыг л би хэлье. Одоогийн байдлаар нийтдээ 7 үйлдвэр ашиглалтад орчихсон байгаа. Хөвсгөл, Хэнтий, Дорнод, Говь-Алтай гэх аймаг болон сумдад 7 үйлдвэр ашиглалтад орчихсон байгаа. 23 үйлдвэр нь Улаанбаатар хотод, “Туушин” гаалийн баталгаат бүс болон “Монгол драй милк” компанийн өөрийнх нь складанд иж бүрнээрээ хадгалагдаад байж байна. 30 ширхэг үйлдвэр нь Хятад ард улсын Эрээн хотод Эрээний гаалийн баталгаат агуулахад өнөөдрийг хүртэл тодорхойгүй шалтгаанаар ингээд складын төлбөр төлөөд байж байна. Энийг би яагаад хэлж байгаа юм гэхээр ямар ч байсан энэ төслийн зориулалтын 60 ширхэг тоног төхөөрөмжийг бол үйлдвэрлээд захиалаад авчихсан. Энэ чинь өөрөө япон технологийн Хятад ард улсад үйлдвэрлэсэн малын шингэн сүүг хуурайшуулах зориулалттай ийм байгаа. Өдөрт нэг үйлдвэр маань өдөрт 1500 литр шингэн сүү боловсруулах хүчин чадалтай. Тэгэхээр бид бүхэн мэдэж л байгаа төв суурин газраас алслагдсан аймаг, сумд маань үндсэндээ 200-300 километр дотор л малчид сүүгээ тушаах боломжтой. Тэрнээс цаашаа буюу тэр 500, 600, эсвэл 1000 хүртэл километрийн малчид маань сүүгээ эргэлтэд оруулж чаддаггүй ээ. Энийг та бид бүгдээрээ мэдэж байгаа. Тэгэхээр бид нарын энэ төслийн гол зорилго юу вэ гэхээр тэр 1000 километрийн цаана алслагдсан байгаа аймаг, сумдын малчдад тэр аймаг дээр нь байдаг юм уу, сум дээр нь байдаг юм уу, энэ үйлдвэрээ барьж ашиглалтад оруулаад, тэгээд малчдын гар дээрээс бэлэн мөнгөөр сүүг нь худалдаж аваад тэрийгээ өдөрт 1500 литр сүү нэг үйлдвэр боловсруулна, нийтдээ 60 үйлдвэр боловсруулаад явах юм бол энэ гаднаас авдаг 70-80 сая ам.долларын валютын урсгалыг дотооддоо үлдээх, мөн гадагшаа бас бид нар энэ хэмжээний сүү гаргаж болох юм байна гэдэг судалгаан дээрээс энэ төслийг хэрэгжүүлж эхэлсэн юм.

Тэгээд үйлдвэрийн ерөнхий юуг би та бүхэнд сая хэлчихлээ. Ерөнхийдөө бол 7 үйлдвэр ашиглалтад ороод бэлэн болчихсон боловч өнөөдрийн байдлаар бас нэг тодорхойгүй шалтгаанаар буюу “Монгол драй милк” компани маань өөрөө 2017 онд зээл авсан боловч 2019 онд Хөгжлийн банк маань муу зээлдэгч гэдэг ангилал руу

оруулаад зээлээ эргүүлэн татсан. Энэнээс хойш өнөөдрийг хүртэл ингээд хууль хяналтын байгууллагад шалгагдаж байгаа. Тийм учраас бас тодорхой хэмжээний хөрөнгүүдийг хөдөлгөж чадахгүй, ингээд барьцаа хөрөнгүүдийг болон энэ сүүний төслүүдийг бүгдийг нь ингээд битүүмжлэгдсэн байдалтай байгаа. Ер нь бол яах вэ би энэ дээр юуг хэлэх гэхээр энэ слайд дээр гарч л байна л даа. Нийтдээ хэдэн аймаг, хэдэн сумд хийсэн гэдэг мэдээллүүд нь Хөвсгөл аймгийн Их уул суманд болон Хөвсгөл аймгийн Галт сум, Хэнтий аймгийн Баянхутаг сум, Булган аймгийн Хутаг-Өндөр сум, Говь-Алтай аймгийн Эрдэнэ сум, Дорнод аймгийн Баяндун сум, Дорнод аймгийн Баян-Уул сумдад үйлдвэрүүд ашиглалтад орсон. Та бүхэнд тараасан энэ товчхон танилцуулгын урд талын QR код дээр угаасаа видео мэдээллүүд нь байгаа шүү. Та бүхэн тэр QR кодыг уншуулаад мэдээ, мэдээллийг аваарай. Хугацаа бага байгаа учраас би энэ дээр бас нэг юмыг онцолж хэлэх нь зүйтэй болов уу гэж бодож байна. Уг зээлийг авахад эцсийн барьцаа хөрөнгийг гаргасан барьцаалуулагч буюу батлан даагчийн зүгээс Хөгжлийн банктай 2019 оноос хойш өнөөдрийг хүртэл тодорхой хэмжээний уулзалтуудыг хийсэн. 2019 онд иргэний журмаар шүүхэд өгөхөд нь бид нар бас очоод тэнд хүлээн зөвшөөрөөд барьцаалуулагч нь энэ зээлийг төлье гэдгийг хүлээн зөвшөөрсөн байгаа. Өнөөдрийг хүртэл бас энэ дээр Хөгжлийн банкны шинэ захирлууд маань нэлээн ажил хэрэг болгоод бид нартай дараа дараагийн уулзалтуудыг хийж байгаа учраас энэ дээр их талархууштай байна. 2022 оны 12 дугаар сардаа багтаад “Алтай групп” компани болон түүний нэгдэл охин компаниуд энэ төсөлтэй холбоотой зээлийг 100 хувь төлж барагдуулахаар банктай уулзаж тохиролцож төлж барагдуулна гэдгээ энэ дашрамд бас давхар хэлье. Энийг бол эцсийн барьцаалуулагч буюу Бат-Эрдэнэ гэдэг хүний зүгээс заавал хэлээрэй гэж надад дамжуулсан юм байгаа юм. Баярлалаа.

#### **Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн Ж.Бат-Эрдэнэ:**

Баярлалаа. Ингээд Монгол Улсын Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтдээ хяналт тавьж шалгалт хийх талаар эрх бүхий байгууллагуудын тайлан, мэдээллийг сонслоо. Дээрээс нь бас энэ санхүүжилтэд хамрагдсан саналаа өгч танилцуулга хийе гэсэн 4 компани бичгээ өгсөн байгаа. Энэ 4 компанийн танилцуулгыг сонслоо. Ингээд хөтөлбөрийн дагуу 12.30-13.30 хүртэл завсарлага байгаа. Үдийн цайны завсарлага байгаа. Тэгэхээр өнөөдөр ингээд завсарлаад 13.30 цагт дараагийнхаа хурлаа эхэлье ээ. Энэ миний саяын дуудсан эрх бүхий байгууллагууд, төрийн байгууллагууд, албан тушаалтнууд, яамдын төлөөллүүд агентлагийн төлөөллүүдээс асуулт асууна шүү. 13.30 цагт хүрч ирээд эхний асуулт шууд Улсын Их Хурлын гишүүдийн асуултууд байна. Тийм болохоор энэ эрх бүхий байгууллагууд 13.30 цаг гэхэд бэлэн байна шүү. Баруун жигүүрийн 4 давхарт хоолны газар байгаа. Тэнд хоол идэх ийм боломж бололцоо байгаа.

**Ерөнхий хяналтын сонсголын үдээс хойших хуралдаан 13.30 цагт үргэлжлэв.**

#### **Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн Ж.Бат-Эрдэнэ:**

Энэ төрийн байгууллагынхан орж ирээрэй, Засгийн газар, Засгийн газрын төлөөлөл, Монголбанк, Хөгжлийн банк өшөө юу байгаа билээ. Аудитынхан, Монголбанкны төлөөлөл, яам, агентлагууд, зохион байгуулагчид, хүмүүсээ дуудаарай. Энэ төрийн байгууллагууд, яам агентлагуудын дарга нарыг дуудаарай Монголбанкныхаа хаана байна, Хөгжлийн банкныхан байна уу? Хөгжлийн банкныхан, ажлын хэсгийнхэн, Засгийн газрын Хэрэг эрхлэхийнхэн. Ингээд үдээс хойших хуралдаанаа эхэлье ээ. Хуралдаан дэгийн дагуу Улсын Их Хурлын гишүүд

асуулт асууж, хариулт авна. Ингээд асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Кнопоо дарчихъя, санал өгөх клопоо. Ц.Даваасүрэн гишүүнээр, хэн бэ? Амжсан уу? Ц.Цэрэнпунцаг гишүүнээр тасаллаа. Орохгүй байна? Д.Батлут гишүүний нэр орохгүй байна. Д.Батлут гишүүний нэрийг нэмээрэй. Ингээд Д.Батлут гишүүнээр тасаллаа. С.Одонтуяа гишүүн асуулт асууя. Улсын Их Хурлын гишүүд журмынхаа дагуу 20 минутад багтааж асуулт асууж, хариулт авна шүү. Тийм 20 минутад.

**УИХ-ын гишүүн С.Одонтуяа:**

5 минут юм биш үү, үгүй юу? Нэг гишүүн 5 юм уу?

**Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн Ж.Бат-Эрдэнэ:**

Асуулт асууж, хариулт авах нь нэг гишүүн 20 минутад, тэгэхлээр 20 минутад багтаад хэдэн ч асуулт асууж хэдэн ч хариулт авч болно гэсэн үг.

**УИХ-ын гишүүн С.Одонтуяа:**

Энэ Хөгжлийн банкны асуудал бас нэлээд өндөр түвшинд бид бас бүгд л ярилцаж байна. Би зүгээр нэг зүйлийг эхнээс нь жоохон санаа зовж эхэлж байна. Энэ юу вэ гэхээр би бас Цагаатгалын комиссыг удирдан зохион байгуулах комиссын даргаар ажиллаж байгаа. Өнгөрсөн зуунд явсан хэлмэгдүүлэлтийн асуудал хүртэл дуусаагүй байгаа юм. Тэгэхээр би энүүгээр юу хэлэх гээд байна гэхээр бид бүх асуудалд маш нухацтай хандах шаардлагатай. Тэрнээс биш хавтгайруулаад л бүгдийг нь залилагчид бүгдийг нь луйварчид гэсэн маягаар бас хандаж болохгүй. Энд шүүх, мөн холбогдох байгууллагууд, ажлын хэсгүүд бүгд маш анхааралтай, хариуцлагатай ажиллах ёстой байна. Надад 5 асуулт байна. Нэгдүгээрт, энэ маш олон ажлын хэсгүүд гарсан байгаа. Хамгийн анх бол тэр Хууль зүйн дэд сайд Б.Энхбаяраар ахлуулсан ажлын хэсгээс өгсүүлээд л цаана нь ингээд олон ажлын хэсгүүд гарсан. Энэ шалгалтуудыг бүгдийг нь нууцын зэрэглэлээс гаргаж чадсан уу? Надад бодоход зарим нь бол нууцын зэрэглэлээс гараагүй юм шиг материалууд харагдаад байна. Жишээлэхэд, сая Монголбанкны 2021 оны шалгалтын дүнг маш товчхон ярьсан. Гэтэл 2020 оны Монголбанкны яг Хөгжлийн банкн дээр хийсэн ажлын хэсгийн дүгнэлтийг авч үзмээр байна. Энэ бол маш чухал. Манай мэргэжлийн хүмүүс хийж байсан нь чухал юу байсан. Гэхдээ энэ дүгнэлт надад бол олдохгүй байна. Тэгэхээр энэ дээр бол би бас хардалт төрж байна. Энийг нууцын зэрэглэлээс гаргаад энийг бас Улсын Их Хурлын гишүүдэд ирүүлээч ээ гээд хэлмээр байна. Хоёрдугаарт, 2017 онд Улсын Их Хурлаар Хөгжлийн банкны тухай хууль өөрчлөгдсөн. Энэ хууль өөрчлөгдсөнөөр хяналтгүй гарах бүх эх үүсвэр чинь тавигдсан юм биш үү, ингэж үзэж болох уу? Яагаад гэхээр энэнээс хойших зээлүүд болохоор дандаа барьцаагүй, дутуу дүгнэлттэй, зориулалтын бусаар зарцуулагдсан ийм зүйлүүд гараад байгаа юм. Бид нар чинь гадаадаас мөнгө босгохдоо Засгийн газрын баталгаатайгаар баталгаа гаргаж мөнгө босгож байгаа гэтэл зарцуулалт дээр нь хэтэрхий хариуцлагагүй хандаж байгаа байхгүй юу. Нэг хэдэн улс төрийн томилгоогоор очсон хүмүүс. Тэгээд тэр ТУЗ-ийн гишүүд, захирал нь өөрөө мэдээд ингээд ямар ч барьцаа хөрөнгөгүй ирээдүйд олох орлого ч гэнэ үү ийм зүйлүүдээр гаргачихсан байж байгаа. Тэгэхээр энэ бол өөрөө маш ноцтой асуудалд хүргэчихсэн байгаа. Тийм учраас энэ хүмүүст ер нь хариуцлага тооцсон зүйл байдаг юм уу? Би бараг зээл авсан хүмүүсийг буруутгамааргүй байна. Өнөөдөр зээл бол бага хүүтэй зээл олдоно гэдэг бол өөрөө маш хэцүү асуудал шүү дээ. Олон жилийн хүч хөдөлмөр шингэж байж олон жил төслөө хийж байж нэг үйлдвэр завод барьж байж ингээд нэг зээл олдог. Гэтэл зээл олгож байгаа хүмүүс дээр л хариуцлага яримаар

байна. Энэ хүмүүс яг юуг үндэслэж өгсөн юм, ямар нөлөөнд автаж өгсөн юм? Тэгээд энэ хүмүүс өнөөдөр ямар хариуцлага хүлээсэн юм гэдэг энэ зүйл дээр тодорхой хариулт авмаар байна. Ажлын хэсэг энэ дээр гаргаж тодорхой дүгнэлтүүдэд хүрч чадсан уу гэдгийг асуумаар байна.

Дээрээс нь энэ өнөөдөр энэ зээл өгчихсөн байгаа ТУЗ-д байсан, гүйцэтгэх захирал байсан хүмүүс чинь бүгд өнөөдөр улс төрийн өндөр албан тушаал үргэлжлүүлээд л хашаад явж байгаа шүү дээ. Тэгэхээр энэ хүмүүсийг ингэж өөгшүүлээд ингээд яваад байж болж байна уу, үгүй юу? 2016 он хүртэл бол Хөгжлийн банк бол Монгол Улсын шилдэг аж ахуйн нэгжээр шалгарч байсан. Тэгээд 2016 оноос хойш яагаад ингээд ийм хурдан гэнэт доройтолд орчихов оо гэдгийг асуумаар байна. Мөн энэ Хөгжлийн банкны ТУЗ-д арилжааны банкны удирдлагууд суудаг юм байна. Энэ шийдвэрийг ер нь хэн гаргадаг юм. Энэ чинь эрх ашгийн зөрчил мөн үү, биш үү гээд ийм зүйлүүдийг асуумаар байна. Ер нь сая би энэ тэр Сангийн сайдын, Монголбанкны Ерөнхийлөгч нар нар дандаа л зөвлөмж өгсөн, 20 удаагийн, 9 удаагийн зөвлөмж өгсөн, ингэсэн буруу байсан, алдаа дутагдал гээд байгаа юм. Үгүй ээ, бид нар чинь нэг л Монгол Улсад байж байгаа шүү дээ. Аль хаа байсан Америкаас хүн зөвлөмж өгөөд байгаа юм биш. Энэ зөвлөмжийг яагаад хэрэгжүүлээд энэ Хөгжлийн банкны ажлыг ийм найдваргүй банк болгочих асуудлыг нь явцын дунд шийдэж болоогүй юм уу? Ямар их зөвлөмж гаргаад л байсан юм, гаргаад л байсан юм. Тэгээд үр дүн яагаад гараагүй юм бэ гэдгийг асуумаар байна. Дээрээс нь энэ 2017 оны ажлын хэсгийн дүгнэлт гараха д 17 аж ахуйн нэгж зөрчилтэй байсан. Өөрөөр хэлбэл эргэлзээтэй байсан.

**Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн Ж.Бат-Эрдэнэ:**

20 минутдаа бас хариултаа авах юм шүү дээ.

**УИХ-ын гишүүн С.Одонтуяа:**

Ойлголоо. Тэгэхээр энэ 17 аж ахуйн нэгжээс 11 нь Төрийн өмчит аж ахуйн нэгж байсан. Тэгээд тэр үед яагаад энэ Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдээ цэгцлээд хувьчлахыг нь хувьчлаад зээлийг нь төлүүлэхийг нь төлүүлэх арга хэрэгсэл бодоогүй юм бэ? Ялангуяа энд нэг анхаарал татаж байгаа, санаа зовоож байгаа компани бол газрын тосны үйлдвэр байгаа. Жилийн 10 хувийн хүүтэй авч байсан, одоо хэд болсон бэ? Тэгэхээр энэ яг газар дээр нь юм яг хийгээд бүтээчихсэн юм байгаа юм уу? Хэдэн зуун тэрбум зээл аваад л байдаг, Энэтхэгийн Засгийн газраас өчнөөн их наядыг авчихсан. Тэгээд энэ газар дээр нь боссон юм байна уу? Энэ чинь бас нэг Хөгжлийн банкиг эргээд мухардалд оруулах нэг зүйл болох гээд байна шүү. Тэгэхээр энэ бизнесийн хувийн хэвшил рүүгээ их дайрахаасаа илүүтэй Төрийн өмчит аж ахуйн нэгжүүд чинь хамаг зээлийг чинь идчихсэн байна. Энэ чинь зээлээ төлнө гэдэг чинь дахиад л улсын төсвөөс аягүй бол татаас авна, улсын төсвөөс мөнгө нь гарна гэсэн асуудал шүү дээ. Энэ дээр хариулт авмаар байна.

**Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн Ж.Бат-Эрдэнэ:**

Ажлын хэсэг хариулах уу? Б.Баттөмөр гишүүний микрофон.

**УИХ-ын гишүүн, ажлын хэсгийн ахлагч Б.Баттөмөр:**

С.Одонтуяа гишүүний тэр хэлмэгдүүлэлт дахиад явах вий дээ гэдэгтээ бол би санал нэг байна. Хэлмэгдүүлж энийг ямар нэгэн байдлаар ийм гэмт хэрэг хийчихсэн,

энэ зээл авчихсан гэсэн юм биш. Энэ бол хэвлэл мэдээллийн хэрэгслээр явж байгаа. Энэ асуултад тэр бол хууль хяналтын байгууллагад нь очоод үнэн зөвөө тогтоолгох нь зүйтэй гэсэн ийм зөвлөмжийг л өгч байгаа юм. Түүнээс биш ингээд нотолчихсон, бидэнд ийм нотлох эрх, үүрэг ч байхгүй шүү дээ. Бидэнд тийм ээ. Тийм учраас энэ хууль хяналтын байгууллагын удирдлагууд байна. Тийм учраас энэ дээр анхааралтай хандаад, үнэхээр гэм буруугүй бол тэрийг нь тогтоогоод нийгэмд энэ хүн гэм буруугүй байна гэдгийг нь тогтоохгүй бол нилдээ төрийн өндөр албан тушаалтнууд энэ Хөгжлийн банкиг идээд дуудсан юм шиг л явж байна. Тийм учраас холбогдож байгаа хүмүүсийн нэгийг нь ч үлдээлгүйгээр энд тавихыг хичээсэн юм.

Шалгалтыг бүгдийг нь нууцаас гаргасан уу гэж. Хамгийн сүүлд Улсын Их Хурлын дарга Монголбанкны энэ шалгалтын материалыг улсын нууцаас гарга гэсэн үүрэг даалгаврыг өгсөн. Энийг би гаргачихсан байх гэж бодож байна. Б.Энхбаяр гишүүнээр ахлуулсан ажлын хэсэг 2016 онд хийсэн шалгалтыг бол Засгийн газар гаргачихсан байгаа. Нууцад байгаа энэ хоёр материал байгаа бусад нь нууц биш байгаа. Аудитын материал 2016 онд, 2019 онд Засгийн газраас шалгасан шалгалтын дүн энэ тэр нийтэд ил байж байгаа. Энд ингэж хариулт өгье өө гэж.

2017 оны Хөгжлийн банкны хууль зориулалт бус зарцуулагдах энэ эх суурийг тавьсан уу гэж асууж байна. Энэ хуульд юу вэ гэхээр Улсын Их Хурал, Засгийн газар тэр санхүүжүүлэх төсөл, хөтөлбөрийг жагсаалтыг гаргана гэсэн ийм зүйл хуульд байсан. Энэ 2017 оны хуулийн шинэчлэлээр энийг жагсаалт гаргахгүй гээд гаргачихсан. Энэ үеэс эхлээд бас хяналтгүй зарцуулагдах ийм юмнууд тавигдсан байхыг үгүйсгэхгүй байна. Ер нь Монгол Улсын хэмжээний Монгол Улсын эрх ашигт нийцсэн том төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэхэд Засгийн газрын шийдвэргүйгээр, Улсын Их Хурлын шийдвэргүйгээр Хөгжлийн банк дангаараа санхүүжүүлээд явах ийм потенциал боловсон хүчний чадавх, ийм зүйл Хөгжлийн банканд бол байхгүй. Өнөөдрийн байдлаар одоо ч байхгүй байгаа. Тийм учраас энэ томоохон төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлж энэ чиглэлийг бүр үгүй ядахдаа Улсын Их Хурал биш юм гэхэд Засгийн газраас өгч байх нь зүйтэй юм гэсэн ийм хариултыг бол хэлье.

Ингээд хариуцлага тооцсон уу гэж. Энэ асуугдах ёстой асуулт. Энэ 2016 онд хийсэн шалгалт, 2019 онд хийсэн шалгалтууд, тэгээд Монголбанкнаас 2021 онд шалгасан, тэгээд аудитаас гаргасан шалгалт энд ерөөсөө нэг ч хүнтэй хариуцлага тооцоогүй. Тэгээд 2016 онд тэр Б.Энхбаяраар ахлуулсан ажлын хэсгийн үеэс эхлээд түүн дээр гарсан тэр зөрчил дутагдлуудыг тухайн үед нь тасалж зогсоогоод тухайн үед нь хариуцлага тооцоод ингээд явсан бол дараа дараагийн үед нь сургамж болох байсан. Дараа дараа ийм алдаа дутагдал гарахгүй байх, ийм нөхцөл бүрдэх байсан юм. Харамсалтай нь ерөөсөө нэг ч хүнтэй хариуцлага тооцоогүй. 2016 онд шилдэг аж ахуйн нэгжээр шалгарч байсан гэж байгаа, 2017 оноос эхлээд юу болчхов оо гэж. 2012, 2013, 2014, 2015 онуудад олгосон зээл нь төлөгдөхгүй болоод, тэгээд 2017 оноос эхлээд үндсэндээ энэ банк маань төлбөрийн чадваргүй болох, томоохон төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэх боломжгүй болох, энэ хариуцлагагүй юмны эх үүсвэр энэ үеэс тавигдаад ингээд явсан юм гэдгийг хэлэхийг хүсэж байна. Энэ Хөгжлийн банкиг явцын дунд яагаад засаж чадаагүй вэ гэж. Би сая хариулчихлаа. Энд бол үнэхээр хүмүүсийг, төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх захирлуудыг нь л солиод байсан. Энэ чинь 5-6 гүйцэтгэх захирал бол солигдчихсон байдаг, бас 4-5 ТУЗ-ийн, дарга нар нь сольчихсон байдаг, ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг нь сольсон байна. Солиод солиод ямар ч ахиц гараагүй. Яг л байдгаараа. Тийм учраас бол хүнтэй хариуцлага тооцсонгүй. Ерөөсөө энэ аливаа ажлын хувь заяа бол хүнтэй холбоотой. Монголчууд бид ерөөсөө хүнтэйгээ ажилладаггүй, өөр юмнаас алдаа дутагдлаа хайгаад байдаг, Хөгжлийн банкны хувьд ерөөсөө алдаа дутагдлын гол эх

сурвалж хаана байна вэ гэвэл хүнтэй л холбоотой. Тэнд ажиллаж байсан хүнтэй холбоотой С.Одонтуяа гишүүнтэй санал нэг байна. Тэр өгч байгаа банкандаа биш, тийм нөгөө авч байгаа аж ахуйн нэгждээ биш банкандаа байна гэж. Ямар ч аж ахуйн нэгж хямд эх үүсвэртэй, хүүг авахыг хүснэ, ямар ч аж ахуйн нэгж. Тэрийг олгож байгаа тэр хүмүүс нь хариуцлагагүй байна шүү дээ. Ирээдүйд олох орлогоо барьцаална гээд иргэний хуулийн 134 дүгээр зүйлд ирээдүйд олох орлогоо барьцаалж болно гэсэн заалт байдаг. Тэр заалтыг үндэслээд л ингээд аваад явчихсан. Төлбөрийн чадваргүй компаниудад олгосон байдаг. Энэ болгоныг л тухайн үед нь ялгаж салгаад зөв аж ахуйн нэгжид нь олгоод явсан бол ийм зөрчил дутагдал бол гарахгүй байсан. Энэ Төрийн өмчийг яг яагаад өөрчлөн байгууллахгүй байгаан бол гэж энэ Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар гэж байдаг. Тэр дарга нь ирсэн байх ёстой. Тэр хүн энд хариулбал илүү хариулах байх. Тийм учраас харин Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийг цаашид авч явах. Мөн л ялгаа байхгүй Монголд Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдэд гарч байгаа алдаа дутагдал юутай холбоотой, бас л хүнтэй холбоотой. Монгол Улсад энэ боловсон хүчний хямрал болчихсон байна шүү дээ. Янз бүрийн улсууд томилогддог очоод ажлаа хийж чаддаггүй, туршлагагүй. Залуу хүмүүс бол томилогдож байгаа нь сайн байна. Залуу хүмүүс эрчтэй, хүчтэй, сайн байгаа байх. Гадаад хэл мэдэж байгаа нь бол сайн байгаа байх. Монгол Улсын ажил Монгол хэлээр явагдана шүү дээ. Ийм ийм зүйлүүд дээр бид нар анхаармаар байгаа юм цаашдаа.

### **Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн Ж.Бат-Эрдэнэ:**

Нэмэлт хариулт өгөх үү. Ц.Даваасүрэн гишүүн, Ц.Даваасүрэн гишүүний микрофоныг нээе.

### **УИХ-ын гишүүн Ц.Даваасүрэн:**

Төрийн өмчийн холбогдолтой зээлүүд дээр бас тодотгож байгаа байх. Би ганц хоёр юмыг бас хэлчихье гэж бодож байгаа юм. Жишээлбэл, “МИАТ”-ын төсөл байна. Би энийг буруутгахгүй байгаа юм. Далайд гарцгүй орон. Ингээд хүндэрчихсэн байгаа үед энэ онгоцоор л бүх ачаа бараагаа татаж авч байна шүү дээ. Тэгээд өөрөө хөрөнгө оруулалт хийж чадахгүй, “МИАТ”-ын үнийг бас барьчихаж байгаа тийм ээ, тэгэхээр энд бол ямар ч арга байхгүй юм. Тэр “Эрдэс монгол”-д авсан нөгөө нүүрсний тээврийн зам байгаа юм. Тэрэнгээр мэдээж энэ нүүрсний экспортыг тээвэрлэх, бас улсын компаниуд, хувийн компаниуд гэдэг агуулгаар тэрийг шийдсэн байх гэж ингэж бодож байгаа юм. Тэр “Төмөртэй ордын төмөр зам”-ын асуудлыг яагаад тэгсэн юм бүү мэд. Тэр үеийн Ерөнхий сайд одоо энд байгаа хариулах байх. Тэрний тэр их мөнгийг төлсөн. Төлсөн мөртөөлөө нөгөө Худалдаа хөгжлийн банк чинь буцааж төлөөгүй байгаа байхгүй юу. Улсаас бол төлсөн. Станцууд байгаа юм. Станцууд бол яагаад тэгсэн гээд гэхээр жил бүр Монгол Улсын эрчим хүч, дулааны хэрэглээ 60-90 мегабайт таван зуун килокалор дулаан байдаг юм уу ингээд өсдөг өө. Нэг айл шинээр гэр бүл боллоо гэхэд тэр айл чинь жишээлбэл гэрэлтэй чийдэнтэй байх ёстой, хөргөгчтэй, пийшинтэй гээд л ингээд, компаниуд шинээр ашиглалтад ороход тэрнээс илүү цахилгааны хэрэглээ үүсэж байгаа юм. Энэ хэрэглээ 60-80 мегабайт жилд үүсэж байгаа байхгүй юу. Энийг л хаах гэж эрчим хүчний салбаруудад энэ зээлүүдийг авсан байгаа. Би бол Сономпэлийг харин энэ дээр бол сайн ажилласан гэж боддог юм. Амгалангийн дулааны станц байна. Энэ байхгүй байсан бол өнөөдөр энэ шинэ барилга байгууламжууд ашиглалтад орохгүй. Яагаад гэвэл дулаангүй болчихно шүү дээ. Мөн ТЭЦ-4 дээр мань хүн 100 мегавайтын нэг блок хийсэн байгаа. Зөв. ТЭЦ-3 дээр 50 мегабайтын нэг блок хийсэн байгаа, зөв. Тэгж байж жилийн эрчим хүчний хэрэглээг хааж байгаа юм. Ирэх жил

юу болох вэ? Энэ зогссон. Шинэ эх үүсвэр хийхээ больсон. Ирэх жилээс эхлээд шинэ барилга байгууламжууд ашиглалтад ороход хүндрэлтэй болно. Оройн цагаар айлуудын тогийг тасалдаг болно. Яагаад гэвэл жил бүрийн өсөж байгаа энэ 60-80 мегабайтын хэрэглээг бид нар шинэ эх үүсвэрээр хаах ёстой. Хоёр жилийн хэрэглээг хаахын тулд ТЭЦ-3-ын хэмжээний станц барих ёстой байхгүй юу. Тэгэхдээ барихгүй байна шүү дээ. ТЭЦ-4 дээр өнгөрсөн жил 4 генератын хүчин чадлыг нэмж байж 90 мегавайтын хүчин чадал гаргасан. Тэрний хүчинд өнгөрсөн жилийн өвөл энэ өвлийн өвөл давж байгаа байхгүй юу. Нөгөө шинэ хэрэглээг. Айл, компаниуд шинээр гарч байгаа. Энэ бүгд гэрэлтэй чийдэнтэй, цахилгаантай тоног төхөөрөмжтэй байгаа учраас тэр яах вэ, тог хэрэглэнэ. Компани, айлууд дулаан хэрэглэнэ. Тэгэхээр энийг чинь заавал шинээр нэмж хаах ёстой байдаг. Гэтэл сүүлийн жил бол шинээр баригдсан юм байхгүй болчихоод байгаа юм. Одоо бол харин батарей хуримтлуурын нэг станц орох байх. Энэ нэг 50 мегабайтыг хаах байх. Энэ 50 мегабайт хаагдахаар бол ирэх жил нэг 30 мегабайтын дутагдалд орно. Оросын холбооны улсаас 340 мегавайтыг авах боломжтой бол энэ жил 280 хүрсэн байгаа. Цаана нь 75 мегабайтын нөөц байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ ирэх өвлөөс эхлээд бид нар эрчим хүч дулааныхаа хэрэглээг хааж чадахгүй болно оо. Шинэ эх үүсвэр барихгүй байгаа учраас. Энийг хөрөнгө оруулалт хийж чадахгүй байгаа учраас тэр ВЭБ банк, гаднын банкнуудаас, Хятадын хөгжлийн банк энэ тэрээс зээл авч эрчим хүчний салбарт энэ станцуудыг Амгалан, ТЭЦ-3, ТЭЦ-4 дээр хоёр удаа гэсэн энэ юмнуудыг бол хийсэн. Энэ бол зайлшгүй хийгдэх ёстой зүйлүүд байсан юм байна лээ. Харин тэр “Эгийн гол”-ынх байна, “Таван толгой”-н гээд төслүүд байна. Энэ бол арай өндөр зардлаар тэнд авч байгаа төслийн ажилтнууд Олон улсын төсөл дээр ажиллаж байгаа хүний цалингаар ажилладаг. Тэгээд 20-30 тэрбумыг тэнд ингээд шийдвэрлэчихсэн. Н.Алтанхуяг сайд байгаа учраас энэ дээр бас хариулах байлгүй. Ийм юм болсон юм байна лээ. Тэгээд тэр зээлүүд нь бол Хөгжлийн банкн дээр байдаг, тэр хоёр зээл. Тэрийг төлөхөд их төвөгтэй, станцууд бол төлчихнө. Станцууд яагаад төлж чадахгүй вэ гэвэл үнийн асуудал байгаа байхгүй юу. Хэрвээ зээл төлөх үнээр ингээд нэмчих юм бол станцууд төлж л орхино шүү дээ. Зээл авчихсан юм чинь станцаа өргөтгөчихсөн юм чинь. Гэтэл үнээ нэмэхээр яах вэ. Нөгөө дулааны өснө. Нөгөө эрчим хүчний үнэ өснө. Тэгэхээр хэрэглэгч дээр тохогдох гээд байгаа шүү дээ. Хэрэглэгч дээр тохохгүй байя гэх юм бол энэ зээлийг улсын төсвөөс хөрөнгө оруулж энэ өргөтгөлүүдийг хийх. Гаднын зээлийг төлөх. Энэ чинь бүгдээрээ гаднын зээл. Хятадын хөгжлийн банк, Оросын ВЭБ банкны зээл. Ийм зээлүүдээр санхүүжүүлсэн эрчим хүчний өргөтгөлүүд бол байгаа. Тэр хоёр төслийн хувьд жоохон хүндрэлтэй болчихсон юм байна лээ. Төслийн нэгжийг санхүүжүүлсэн анхны тохиолдол гарсан юм байна лээ, зээлээр.

**Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн Ж.Бат-Эрдэнэ:**

Б.Баттөмөр гишүүний микрофон.

**УИХ-ын гишүүн, ажлын хэсгийн ахлагч Б.Баттөмөр:**

Газрын тос боловсруулах үйлдвэрийн тухай ярьж байна л даа. Тэгэхээр энэ бол бас үнэхээр анхаарал татсан ийм төсөл байгаа. Монгол Улсад газрын тосоо боловсруулаад нефть бүтээгдэхүүн, бензин, дизелийн түлш гаргана гэдэг үнэхээр ач холбогдолтой төсөл. Гэхдээ харамсалтай нь бол өнөөдөр яг тэр хэмжээнд тийм хүлээлтийг биелүүлэх хэмжээнд хийж чадаж байна уу гэвэл тийм хэмжээнд орж чадахгүй байгаа. Энэ дээр Монголын төрөөс бол анхаарах шаардлагатай. Энэ төслийг хамгийн гол юм бол тэр нөгөө түүхий эдээ хаанаас авах вэ гэдэг асуудал өнөөдөр шийдэгдээгүй. 400-500 километрийн газраас Тамсагаас татна гэж байгаа

юм. Тэр бидний хувьд, эдийн засагч миний хувьд ямар ч үр ашиггүй. Монгол Улс нийт олборлож байгаа түүхий тосныхоо 23-хан хувийг л авна шүү дээ. Үлдэж байгаа 77 хувь нь “Петро Чайна Дачин тамсаг” компанийн хятадын талд оногдох түүхий тос байгаа. Тийм учраас тэрийг тэр дэлхийн зах зээлийнх нь үнээр худалдаад, тэр худалдсан мөнгөөрөө энд тэндээс Хятадаас юм уу, Оросоос нь юм уу түүхий тос авах нь илүү ч ашигтай байж магадгүй юм. Ийм дүр зураг харагдаж байгаа. Тийм учраас Монголын төрөөс энэ газрын тос боловсруулах үйлдвэр дээр онцгой анхаарах ийм шаардлагатай юм шиг шалгалтын явц дундаа анзаарагдсан.

### **Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн Ж.Бат-Эрдэнэ:**

Д.Доржханд гишүүн асуулт асууя.

### **УИХ-ын гишүүн Т.Доржханд:**

Баярлалаа. Маш тодорхой хоёр, хоёр минутаар хариулаад явчхаарай гэж хүсье ээ. Тэгээд хуулийн байгууллагуудын удирдлагууд нь байх шиг байна. Дөрвөн төрлийн хариуцлага байна гэж харж байгаа. Нэгдүгээрт, хуулийн хариуцлага. Хоёрдугаарт, улс төрийн хариуцлага. Гуравдугаарт, ёс зүйн хариуцлага. Дөрөвдүгээрт, санхүүгийн хариуцлага гэж.

Тэгэхлээр энэ дөрвөн төрлийн хариуцлага дотроо хуулийн хариуцлага нэг, Авлигатай тэмцэх газрын удирдлага ирсэн байх ёстой байх, байна уу? Улсын Ерөнхий прокурорын газрын Ерөнхий прокурор нь байна уу? байгаа бол асуулт байна. Яг одоогийн байдлаар, өнөөдөр Улсын Их Хурлын гишүүн хийж байгаа болоод өмнө нь хийж байсан ямар гишүүдээс мэдүүлэг авсан бэ? Улсын Ерөнхийлөгч байсан Халтмаагийн Баттулга болон сахал Эрдэнэбилэг гэдэг хүнээс авсан уу? Ямар нэгэн улс төрийн нөлөө, шахалт дарамт байна уу? Та энэ дээр тодорхой хариулмаар байна.

Хоёр дахь нь сүүлийн сарын хугацаанд Хөгжлийн банкны захирлуудыг бүгдийг нь аваачаад тусгаарлачихсан юм билээ, хорьчихсон юм билээ. Гэтэл заримуудыг нь ингээд аваад үлдчихсэн. Тухайлбал, Хөгжлийн банканд нилээн олон жил эрсдлийн удирдлагын газрын захирал хийж байсан хүн бол өнөөдөр Монголбанкны тэргүүн дэд захирал Дөлгөөн гэдэг залуу байна. Тэгээд маш олон хүмүүс над руу ирүүлээд байна, санал. Үгүй ээ, та сөрөг хүчний хүн. Гэтэл энэ чинь харилцан адилгүй шударга бус ийм нөхцөлд байцаалт явуулаад байна шүү дээ. Нэг нь болохлоор ингээд гадуур сайхан байж байдаг. Гэтэл нөгөө хэсгийг нь аваачаад хорьчихдог. Тэгээд сугалах байдлаар ингээд таалагдсан хүмүүстэй байцаалт авдаг таалагдаагүй болохгүй, хамгаалах ёстой хүмүүсээ ингээд аваад үлдээдэг байж болж байгаа юм уу? Энэ дээр тодорхой хариулмаар байна. Нэг улс төрийн хариуцлага. Хоёр сарын өмнө энэ сэтгүүлчидтэй бид нар ярилцлага хийсэн. Заригийн Өнөрөө, Улаан балын Ч.Лодойсамбуу, эд нар бүгдээрээ, гэрчүүд нь энд сууж байгаа ихэнх хүмүүс нь байсан. Маш сайн хэлэлцүүлэг болсон.

Энэ нийгмийн асуудлыг гаргаж ирж тавьсан сэтгүүлч нар сайн ажиллаж байгаа. Тэгэхэд Монгол ардын намын Ерөнхий нарийн бичгийн дарга орсон. Тэрээр манай намын дүрэмд өөрчлөлт орсон, шинэ дүрмийн хувьд бид нар асуудалд холбогдсон хүмүүсийг бүгдийг нь түдгэлзүүлнэ, хууль хяналтын байгууллагаар шийдвэр гаргах юм бол намаасаа чөлөөлнө, улс төрийн дэмжлэг үзүүлэхгүй гэсэн. Бид алга ташиж хүлээж авсан байхаа. Үнэн биз. Санаачилга гаргасан.



Хэрвээ МАН ийм байдлаар хүмүүстэй хариуцлага тооцох юм бол Хөдөлмөрийн Үндэсний намын зүгээс бол тэр хүмүүсийг улс төрд хүлээж авахгүй. Сонгуульд дэвшүүлэхгүй, иргэд нь бие даагаад очих юм бол дэвшүүлэхгүй байдлаар. Ингээд улс төрчдөд хар тамга дарж байгаа энэ хүмүүсийг хулгай хийдэг нөхдүүдийг дахиж энэ Төрийн ордонд оруулахгүй гишгүүлэхгүй байх талаар хамтарч ажиллая гээд гараа барилцаад гарсан. Одоо тэр хаана байна. Монгол Ардын намаас асуумаар байна. Эрх бүхий албан тушаалтан хэн байна? Хэлмээр байна. Ямар хариуцлага байгаа юм бэ? Яг үүнтэй адилхан. Тухайн үед бол бүлгийн дарга, Ардчилсан намын бүлгийн дарга Д.Ганбат ирсэн, өөрөө бараг түдгэлзээд ч гэсэн шалгуулахад бэлэн байна гэж ярьж байсан.

Ардчилсан намын энэ гэмт хэрэгт холбогдсон нөхдүүд хаана байна. Энэ хүмүүстэй яаж хариуцлага тооцох юм бэ? Одоо нэг нь ингээд намын дарга болно гэчихсэн явж байна. Гэтэл “Шинэ яармаг” гэдэг төслийг өөрийнхөө зөвлөхөөр ингээд дамжуулаад авсан нь үнэн шүү дээ. За тэгээд одоо тэр залуугаа таньж мэдэхгүй болчихсон. Одоо ингээд Ардчилсан намын дарга болно гэчихсэн явж байна шүү дээ. Үгүй ээ, Ардчилсан нам нь хариуцлага тооцох юм уу?.

Дандаа энэ хулгайч нарт дээрэлхүүлээд дандаа орой дээрээ залаад яваад байх юм уу? Ийм байдлаар МАН, АН нам хоёр ингээд ажил, ингээд хариуцлага тооцож чадахгүй яваад байх юм бол энэ улс чинь яах юм бэ? Хэн, яаж энийг чинь цэвэрлэх юм бэ? Энэ дээр Ардчилсан намын төлөөлөл нь хэлж өгөөрэй.

Гуравдугаарт, ёс зүйн хариуцлага. Улсын Их Хурал дээр Ёс зүйн байнгын хороо гэж байгаа. Б.Бат-Эрдэнэ гишүүн ээ, Та ёс зүйн ямар хариуцлага хүлээлгэх юм бэ? Одоо ингээд хүмүүсийн нүд рүү харж байгаад шулуун хэлмээр байна.

Дөрөвт нь санхүүгийн хариуцлага байна. Үгүй ээ, хулгай хийсэн нөхдүүдийн мөнгийг улсын төсвөөс төлүүлэх гээд байгаа юм уу? Н.Мандуул захирал аа, би ойлгосонгүй, 762 тэрбум төгрөгийг улсын төсөв, Засгийн газар шийдэх нь зүйтэй гэдгийг. Тэгээд тэр дотор чинь нөгөөдөх нэг “Хөтөл”, нөгөө “Шинэ яармаг”, “Буянт-Ухаа” чинь явж байна шүү дээ. “Эрдэнэс монгол”-ын мөнгө энэ тэр гээд.

Та нарын анхны зорилго чинь ингээд нийгэмд сенсаци үүсэнгүүтээ өөрсдийнхөө балансыг ингээд сайхан цэвэрлээд бид нар асуудал байхгүй шүү, харин энэ асуудал бол байна, хуулийн байгууллага шийд, үгүй бол энийг төрөөс шийдье гэсэн байдлаар ийм төлөвлөгөөгөө та нар хийж байсан юм уу, болохгүй шүү дээ. Хулгай хийсэн нөхдүүдээр мөнгийг нь төлүүлэх ёстой юм байгаа биз дээ. Юун Засгийн газар, татвар төлөгчдийн мөнгөөр төлүүлэх. 762 тэрбум төгрөгийг гаргуулна гэж орж ирж байна шүү. Энэ бол их сэжиг төрүүлж байна. Болохгүй, заавал төлүүлэх учиртай.

За тэгээд эцэст нь гээд хэлэхэд энэ хурал ямар нэгэн үр дүнтэй л байх ёстой. Тэр үр дүн нь юу вэ гэхлээр өнөөдөр энэ хэлэлцүүлгийн үр дүнд бид нар Улсын Их Хурал шинээр батлагдсан хяналт шалгалтын Түр хороог зайлшгүй байгуулах хэрэгтэй, Түр хороог ингэж байж энэ асуудал маань цаашаа явна. Одоогийн байдлаар 16 гишүүн гарын үсэг зурчихсан байгаа шүү, баярлалаа. За тэгээд товчхон товчхон хариулаарай.

## **Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн Ж.Бат-Эрдэнэ:**

Т.Доржханд гишүүний асуултад Улсын ерөнхий прокурор, Авлигатай тэмцэх газрын дарга, нөгөөдөх нь Б.Бат-Эрдэнэ гишүүнээс асуулт асууя. Улсын ерөнхий прокурор хаана байна? микрофон хэд үү? 35 дугаар микрофон.

## **Монгол Улсын Ерөнхий прокурор Б.Жаргалсайхан:**

Сонсголд оролцож бүх хүмүүст энэ өдрийн мэндийг хүргэе. Миний ярих зүйл хоёр минутад багтахгүй бол та бүхэн намайг уучлаарай. Би энд оролцож байгаа учраас эхлээд энд яагаад сууж байгаагаа тайлбарлахаас өөр аргагүй байдалд орж байна, өнөөдрийн нөхцөл байдлыг харахад. Хурал удирдаж байгаа Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ гишүүн албан бичиг ирүүлсэн. Энэ хэлэлцүүлэгт сонсголд прокуророос төлөөлөл оролцуулна уу. Тухайлбал өчигдөр нэг хүн Монгол Улсын Ерөнхий прокурор та өөрөө оролцоно уу гэж албан ёсоор нэр заагаагүй ээ. Бид төлөөлөл оролцуулсан, зүгээр энэ сонсгол хэлэлцэх үед хууль хяналтын байгууллагуудыг та нар байх ёстой гэж дуудаж байгаа бол бид нар хүндэтгэж хүлээн авна, хүндэтгэсэн учраас бид нар ирээд сууж байгаа, суух ч ёстой. Гэхдээ зүгээр тэгж ил ингэж зарлаж албан бичгээр албан ёсны харьцаа үүсгэхэд олон нийтийн мэдээллийн хэрэгслээр байхгүй байгаа мэт, орондоо хүн ирүүлж байгаа мэтээр ийм зохион байгуулалтын арга хэмжээ авч байгааг би ойлгохгүй байна. Үүнийг бодолцох ёстой байх аа. Яагаад гэвэл хуулийн байгууллага, төрийн байгууллагууд хоорондоо зөв ойлголцолтой байх ёстой байх аа гэдэг үүднээс энэ асуудлыг хэлж байгаа юм.

За гол асуудалдаа орьё. Нэлээн олон хүмүүс асуугдсан уу гэж асууж байна. Асуугдаад, мөрдөн байцаалтын ажиллагаа явагдаад. Одоо өнөөдрийн байдлаар хэрэг бүртгэлтийн 29 хэрэг, мөрдөн байцаалтын 12 хэрэг явж байна. Мөрдөн байцаалтын хэрэг гэдэг бол нотлогдоод тодорхой хэмжээгээр Эрүүгийн хуулийн тодорхой зүйл, хэсгээр яллагдагчаар татагдсан хүмүүс мөрдөн байцаалтын ажиллагаа явагддаг. Энэ болбол 12 хэрэг байна. 29 хэрэг нь хэрэг бүртгэлтийн ажиллагаа явагдаж байна. Энэ дээр бол нотлох үйл ажиллагаа явагдаж байна гэсэн үг.

Ялгамжтай огт хандахгүй ээ, ямар ч хүн дээр ялгамжтай хандахгүй. Тухайлбал одоо тодорхой хэдэн хүмүүс яагаад гадуур явж байгаа юм бэ гээд ярьж байх шиг байна. Зүгээр надад ирж байгаа мэдээллээр энэ хүмүүс яллагдагчаар татагдсан гэж байгаа. Би тийм мэдээлэлтэй байгаа. Яллагдагчаар, татахлаар заавал таслан сэргийлэх арга хэмжээ авдаггүй нөхцөл байдлаас шалтгаалж мөрдөгч, хяналт тавьж байгаа прокурор өөрийн хэмжээндээ ямар таслан сэргийлэх арга хэмжээ авах вэ гэдгээ шийддэг. Үүнийг шүүхээр баталгаажуулдаг ийм л хуулийн зохицуулалттай.

Хэд хоногийн өмнө надтай сэтгүүлч нарын төлөөлөгч нар уулзсан. Хохиролтой холбоотой асуудал бас төлөгдөөд явж байгаа. Тэр үед 107 тэрбум төгрөг төлөгдсөн байсан. Өнөөдрийн байдлаар 110 гаруй тэрбум төгрөг мөрдөн байцаалтын ажиллагааны явцад төлөгдөөд байна.

Дараагийн нэг асуудал нь энд улс төрийн нөлөөлөл байхгүй ээ. Улс төрийн нөлөөлөл байх ч ёсгүй. Мөрдөх байгууллага, прокурорын байгууллага хуулийнхаа

дагуу л ажиллаж байна. Ер нь бол мөрдөх байгууллага гэхээр Авлигатай тэмцэх газрын дарга, цагдаагийн дарга, прокурор яг энэ мөрдөн шалгах ажиллагаа явж байгаа үед шууд оролцдоггүй. Энэ бол цэвэр мөрдөж байгаа мөрдөгч, хянаж байгаа прокурор хоёрын харьцаа үүсдэг. Тэр хоёр хүн мөрдөн шалгах ажиллагаа явуулна. Прокурор нь хянана. Энд оролцогч гэдэг хүмүүс л энэ ажиллагаанд гомдол гаргах ийм л хуулийн зохицуулалттай байдаг. За миний хариулт дууслаа.

### **Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн Ж.Бат-Эрдэнэ:**

Б.Жаргалсайхан прокурор, энэ Цагдаагийн газрын дарга, Ерөнхий прокурор, Авлигатай тэмцэх газрын дарга гэсэн гурван даргыг оролцуулъя гэсэн ийм санал энд гарсан шүү. Миний хувьд бол төрд хэдэн жил ажилласны хувьд бол даргын үг дарга, орлогчийн үг бол үг биш, энэ тэр гэсэн нэг тиймэрхүү бодлого бол барьдаггүй ээ. Тэр утгаараа байгууллагын төлөөллийг би урьсан юм шүү. Түүрүүн би хэвлэлийнхэнд ч бас тэгж тайлбарлалаа, энд хурлаас энэ саналууд орж ирсэн учир та бүхнийг нэмэлт одоо дарга нарыг дуудсан юм шүү. За дараагийнх нь Авлигатай тэмцэх газрын дарга хаана байна, хэд үү? 25 дугаар микрофон.

### **Авлигатай тэмцэх газрын дарга З.Дашдаваа:**

За та бүхний энэ өдрийн амгаланг эрье. Т.Доржханд гишүүний асуултад хариулъя аа. Улс төрд нөлөө бүхий хүмүүсийг асууж тодруулж байцаасан уу гэсэн асуулт тавьж байна. Мөрдөн шалгах ажиллагаа хэрэг явагдаж байгаа талаар сая Ерөнхий прокурор танилцууллаа.

Одоогоор бол яг одоо мөрдөн шалгах ажиллагааны хүрээнд Улсын Их Хурлын гишүүд болон дээр нэр дурдсан хүмүүсийг бол байцаагаагүй байна. Сая нэр дурдсан хүнийг бас яллагдагчаар татаад хориогүй байна гэсэн асуудал яригдаж байна. Яллагдагчаар татагдсан явж байгаа мөрдөн шинжлэх ажиллагааны хүрээнд тодорхой. Одоо хэрэг одоо хорих, цагдах үндэслэл байвал бол одоо цагдан хорих, таслан сэргийлэх арга хэмжээ авдаг. Энэ хуулийнхаа дагуу л энэ үйл ажиллагаа явагдаж байна аа. За хариулт дууслаа.

### **Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн Ж.Бат-Эрдэнэ:**

Т.Доржханд гишүүн тодруулах уу? Хариулт авсан уу? Ёс зүйн байнгын хорооны дарга одоо л орж ирж байна даа. Таны асуултыг сонссон уу? Та байсан уу, уучлаарай. Би Б.Бат-Эрдэнэ гээд ийшээ харсан байхгүй болохоор нь л сонсчхоод байсан юм байна. За уучлаарай.

### **УИХ-ын гишүүн Б.Бат-Эрдэнэ:**

Хурал даргалагч та тэгж гөрдөж болохгүй шүү. Би 13 цаг 30 минут гэхэд орж ирээд сууж байсан шүү.

### **Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн Ж.Бат-Эрдэнэ:**

Таны нэрийг биччихээд харсан чинь суудал онгорхой болохоор нь би хэлсэн юм. За уучлаарай.

### **УИХ-ын гишүүн Б.Бат-Эрдэнэ:**

Тэгээд би энэ Төрийн мэдээлэл дээр 03 дугаар сарын 04-ний өдөр та бид хоёрын хамтдаа баталсан Улсын Их Хурлын гишүүний Ёс зүйн дүрэм шинэчилсэн найруулгаар ингээд батлагдаад төрийн хэвлэлд нийтлэгдсэн байгаа. Энэ нийтлэгдсэнээс хойш 10 хоногийн дараа буюу 03 дугаар сарын 14-ний өдрөөс эхлээд энэ дүрэм үйлчилнэ ээ. Бид нар тал талаас нь ярьж байгаад дүрэмд бол нэлээн нарийн зохицуулалтууд хийчихсэн байгаа. Одоо энд яригдаж байгаа төрийн өндөр албан тушаалтнууд энэ зээл, аж ахуйн үйл ажиллагаанд оролцох концесс, зээл, төсөл, тендер цаашлах юм бол төрийн албыг төрлийн алба болгодог ийм томилгоонд нөлөө үзүүлдэг ийм юмыг болбол хааж өгсөн энэ дүрмийн заалтууд байж байгаа. Тэгээд энэ дүрэм болбол 03 дугаар сарын 14-ний өдрөөс хойш хэрэгжээд эхэлнэ. Энэ дүрмийн хүрээнд өргөдөл зохих шаардлага хангасан бол энэ өргөдлийг хүлээж аваад байнгын хороо хэлэлцэнэ.

Тэгэхдээ Улсын Их Хурлын Ёс зүйн байнгын хороо, хуучин ёс зүйн дэд хороо байхад ч гэсэн бас амаргүй шүү дээ. Ирц бүрдүүлдэггүй, хурлын ирцийг бүрдүүлдэггүй, ирц бүрдээд нэг хурал эхлэхээр зэрэг бие биедээ хариуцлага тооцож чаддаггүй, ёс зүйн хариуцлага бол одоо эрүүгийн хариуцлагын бусад хариуцлага биш шүү дээ. Зөвхөн ёс зүйн. Өнөөдөр энэ шинэ дүрмээр сануулна, уучлал гуйхыг үүрэг болгоно. Тодорхой ийм л заалт байгаа. Хариуцлагын заалт энэ хүрээнд авна.

Хэрвээ тухайн гишүүний холбоотой асуудал нь гэмт хэргийн шинжтэй байх юм бол холбогдох хуулийн байгууллагад нь шилжүүлнэ. Өнөөдөр энэ хуулийн байгууллагууд шалгаж байгаа, дахиад шалгуулахаар ажлын хэсгээс явуулж байгаа энэ нэрс, энэ компани, энэ төслүүдтэй холбоотой гишүүдийн асуудал бол тэндээ шийдэгдээд хуулийн хариуцлага, гэмт хэргийн бүрэлдэхүүн байхгүй байна гээд хүрээд ирэх юм бол энэ асуудлыг одоо зохих ном журмынх нь дагуу өргөдөл ирэх юм бол Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороо хэлэлцээд явна гэсэн ийм л зохицуулалттай байгаа. За яах вэ, зүгээр ажлын хэсэгтэй холбоотойгоор би нэг зүйл нэмж хэлэхэд бол бид энэ хэлэлцүүлгийн үеэр ч ярьж байсан. Манай сэтгүүлчид тэнд сууж байна. Энэ оролцогчид одоо энд бас оролцож байгаа. Тэнд бол энэ улс төрийн нөлөө, хамаарлыг нь нэлээн сайн нарийн тогтоож өгнө өө гэдэг ийм л зүйлийг тавьсан.

Энэ Хөгжлийн банк чинь бол одоо эхнээсээ улс орны хөгжлийг тодорхойлох томоохон төслүүдийг санхүүжүүлнэ ээ гэсэн боловч яг одоо харах юм бол эрх мэдэлтэй хүмүүсийн нэг үгээр хэлэх юм бол карманы банк хэлбэрээр байгуулагдаад, энд одоо улс төрийн нөлөөллөөр ингээд хулгай, дээрмийн үйл ажиллагаанууд явагдаад, ингээд л өнөөдөртэй золгочихсон. Ийм л дүр зураг л байгаа шүү дээ. Одоогийн байдлаар 2000 гаран төсөл хэрэгжсэн, ихэнх нь амжилттай хэрэгжсэн. Жижиг төслүүд бол арилжааны банкнуудаар хэрэгжсэн. Энэ хүндэрчхээд байгаа чанаргүй ангилалд орчхоод байгаа 61 төсөлтэй холбоотой асуудлыг л одоо бид нар тойрч яриад байгаа шүү дээ. Ярихаас ч өөрцгүй. Үүний хэмжээ одоо 1.7-1.8 их наяд төгрөг болчхоод, энэ хохирлыг яаж барагдуулах вэ гэдэг юм нь дээр л бид нар үзээд байгаа байхгүй юу. Одоо тэр харилцан хамааралтай, холбоотой юмыг бол ингээд бүгд асуулт асуусан. Үүнийг жишээлэх юм бол харилцан хамаарлынх нь схемийг одоо зузаан гаргачихсан байгаа шүү дээ. Тэгээд энэ дотроос нь шүүрдээд л одоо ажлын хэсэг танилцуулаад байгаа зүйл шүү дээ.

**Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн Ж.Бат-Эрдэнэ:**

Т.Доржханд тодруулах уу? Хөгжлийн банк, 21 дүгээр микрофон.

## **Хөгжлийн банкны гүйцэтгэх захирал Н.Мандуул:**

За гишүүний асуултад хариулъя. Засгийн газарт шилжүүлнэ гэж санал болгож байгаа төслүүдийн хувьд бол бид ямар нэгэн хулгай луйврыг төсвийн мөнгөөс төлүүлье ээ гэсэн ямар ч тийм зүйл байхгүй. Нийтдээ найман зээлдэгчийн зээл байгаад байна. Бидний санал болгож байгаагаар, үүнийг цаашдаа Засгийн газартай хамтраад ажиллах болов уу. Улсын Их Хурлаас бас дэмжээд өгвөл гэсэн тийм хүлээлттэй байгаа. За нэг нэгээр нь яг тодорхой тайлбарлаад явчихъя аа.

Нэгдүгээрт: “Монголын газрын тос боловсруулах” үйлдвэр. Үүнийг Б.Баттөмөр гишүүн сая тодорхой хэлчихлээ. Энэ нь бол тэр газрын тос боловсруулах үйлдвэрийн эргэн тойрны ажилчдын орон сууц, дэд бүтцийн ажил болон Төрийн өмчит компанийн цалинд энэ зардал маань яваад байгаа юм аа. Тэгэхээр бид энэ бол төсвийн шинж чанартай зардал байна аа гэж үзэж байгаа юм.

Хоёрдугаарт: “Эрдэнэс монгол” компанийн хувьд тэр Гашуун Сухайтын авто зам байна. “Эрдэнэс монгол” компанитай нэлээн олон удаагийн уулзалт хийсэн. Бид энэ зээлээ төлүүлэх талаар ажиллаж үзсэн. Компанийн зүгээс ямар ч боломжгүй ээ гэсэн тийм зүйлийг хэлээд байгаа. Тэгэхээр үүнийг зүгээр шууд төсөв рүү шилжүүлэх гэхээсээ илүү ямар нэгэн байдлаар төслийн орлогоос эргэн төлөгдөх нөхцөлтэй болгочихвол бид цааш нь банканд дээрээ аваад үргэлжлүүлээд явж болно.

Гуравдугаарт: “ТОСК-ийн шинэ яармаг” төсөл байгаа. Энэ бол нэлээн ярвигтай. Манай банкнаас Худалдаа хөгжлийн банканд хадгаламж байсныг нь барьцаалаад “ТОСК”-оор дамжуулаад цааш нь шинэ яармаг гэдэг төсөлд зээл болгочихсон юм байна лээ. Бид шүүхдсэн. Дээд шүүх дээрээс шийдвэрээ гаргана. Тэгэхдээ 65 тэрбумыг нь энэ “Шинэ яармаг” гэдэг төслийг хэрэгжүүлэгч компаниас 20 тэрбумыг “ТОСК”-оос манайд төл гэсэн шийдвэр гаргачихаад байгаа юм. Бид үүн дээр бол цааш нь бас үргэлжлүүлээд ажиллана. Тэгэхээр үүнийг нөгөө ангиллынхаа хувьд “ТОСК” гэдэг компанитай гэрээний дагуу явчихсан болохоор энэ ангилалдаа орчихоод байгаа юм. Үүнийг бол бид нар шүүхийн шатаар шийдүүлээд явна аа. Энийг улсын төсөвт шилжүүлнэ гэсэн зөвлөмж байхгүй. Дараагийн Буянт-Ухаа нэг, хоёр.

## **Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн Ж.Бат-Эрдэнэ:**

Т.Доржханд гишүүн тодруулъя.

## **УИХ-ын гишүүн Т.Доржханд:**

Н.Мандуул захирал аа би таныг ингээд нэг бүрчлэн ярь гээгүй шүү дээ. Яагаад 700 хэдэн тэрбум төгрөгийг татвар төлөгчдийн мөнгөөр санхүүжүүлэх гээд байгаа юм. Тов тодорхой жишээ ярьж байна шүү дээ. “Шинэ яармаг” төсөл хэнтэй хамааралтай юм бэ? Монгол Улсын Ерөнхийлөгчийн зөвлөх нь авсан үнэн шүү дээ. Өмнөх Ерөнхийлөгчтэй холбоотой асуудал шүү дээ. Тэрэнтэй холбоотой асуудлаар би түрүүн Ерөнхий прокурор болон АТГ-н даргаас асуулаа мөн үү? Гэтэл та нар энийг ямар зорилгоор ингээд төсвөөс санхүүжүүлэх болоод төсөв рүү явуулах гээд байгаа юм. Наана чинь бол эрх ашгийн зөрчил байна гэж харагдаж байна аа.

Тэгж харагдаж байна. Энэ бол нэгдүгээрт. Хоёрдугаарт нь бол АТГ-ын дарга бол маш богино хариулчих шиг боллоо. Үгүй ээ, яагаад тэр эрх мэдэлтэй хүмүүсийг байцаахгүй байгаа юм бэ? Түрүүн Ерөнхий прокурор болохлоор ямар нэгэн улс төрийн нөлөө байхгүй ээ гээд. Миний асууж байгаа зорилго бол улс төрийн нөлөөлөлгүй байя. Хуулийн байгууллагыг эрх чөлөөтэйгөөр нь хуулийн дагуу үйл ажиллагаа явуулах боломжийг нь олгооч ээ гэсэн байдлаар ярьж байна. Мөн үү? Гэтэл өнөөдрийг хүртэл тэнд нэг хорин хүний нэрс гарлаа шүү дээ. Улсын Их Хурлын гишүүн байсан, байгаа, Засгийн газрын гишүүн гээд. Үгүй ээ, энэ хүмүүсийг чинь өнөөдөр хүртэл дуудаагүй байна гэдэг чинь ямар учиртай юм бэ? Асуумаар байна. Дахиж тодруулмаар байна. Монгол Улсын Ерөнхийлөгч байсан хүн холбогдчихоод байхад яагаад тэр хүнийг байцаадаггүй юм бэ? Монгол Улсын эзэн нь хэн билээ гээд л Ц.Нямдорж гуай асуугаад л байсан.

### **Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн Ж.Бат-Эрдэнэ:**

Минут дууслаа. Н.Алтанхуяг гишүүн асуулт асууя.

### **УИХ-ын гишүүн Н.Алтанхуяг:**

Эхлээд хэдэн асуулт тавьчихъя. Та нар тэмдэглээд авчихаарай. Энэ Аудитын газар 2019 оны 05 дугаар сар гэсэн энэ нэг материалаас би асууж байгаа шүү. Аудитын дарга нь байвал хариулчих. Энэ дотор юу гэж бичсэн байгаа вэ гэхээр бид нар Монголд анх Чингис бонд боссон гэж ойлгоод байдаг. Үгүй 2012 оны 03 дугаар сард Монгол Улс анх удаагаа 600 сая ам.долларын бонд босгосон. Задалбал 580 сая ам.доллар дээр нэмэх нь 20 сая ам.доллар л доо. Ийм бонд босгосон байдаг юм аа. Тэгээд энэ Евро бонд чинь цаанаа 4-5 хувийн хүүтэй босож ирээд энд нөгөө арилжааны банканд дээр байршуулаагүйгээс болоод хүүгийн алдагдал хүлээсэн гэсэн. Энэ аудитын дүгнэлт дотор 17 орчим сая ам.долларын алдагдал хүлээсэн гээд бичсэн байгаа нь энэ үнэн үү? Энийгээ дахиад нэг хэлээдэх. Хоёрдугаарт, Чингис бонд дээр нэг ийм асуудал гардаг юм, Дөрөв аравны хэд тав аравны хэдэн хувийг нь хүүтэй босгож ирээд бас одоо хүүгийн алдагдал хүлээсэн гэдэг юм. Гэтэл энэ аудитын материал дотор бол Монголбанканд байршуулаад сар бүр 5.9 сая ам.долларын хүү авч байсан байна гэсэн. Энэ хоёрыгоо нотлоод ярих уу гэж би хэлж байна.

Тэгээд би нэг зүйлийг бас тодруулж хэлж байгаад асуулт асууя аа. Ер нь би нэг юм ярьсан л даа. Энэ Хөгжлийн банкны асуудлыг манай хэвлэл мэдээллийнхэн босгож ирсэн. Маш их зөв зүйтэй асуудал босгосон. Тэгэхдээ миний үргэлж санаа зовж байгаа юм бол шоу болгоод дуусгав аа л гээд байгаа юм. Тийм учраас энэ бол нэг удаагийн хэлэлцүүлэг, нэг удаагийн сонсголоор бол дуусах асуудал биш Түр хороо байгуулж аваад хэдүүлээ нухацтай ярих ёстой асуудал шүү гэдгийг би дахин хэлье ээ. Энэ Хөгжлийн банкны асуудлыг би жаахан системчлэх гэж оролдсон юм. Та нар сонсоорой дөрвөн үе шаттай авч үзмээр байгаа юм. Хамгийн анхны үе шат нь болбол Хөгжлийн банк байгуулагдаад 20 сая ам.доллар дээр нэмэх нь 580 сая ам.доллар гэдэг чинь 600 сая ам.долларыг босгоод энүүгээр юу хийсэн юм бэ гэж, эхний алхам. Тэгээд мордохын хазгай гэж эхлээд л 17 сая ам.долларын алдагдал хүүгээсээ хүлээгээд л эхэлсэн л дээ. Тэгэхдээ хамаагүй ээ. Энийг та нар ингээд нэгдүгээр үечлэл энэ шүү, энэ үеийг одоо хэн сайн яаж тодруулж чадах вэ гэхээр Ерөнхий сайд нь С.Батболд байсан, Сангийн сайд нь Д.Хаянхярваа байсан, Хөгжлийн банкны захирал нь солонгос хүн байсан нь үнэн.

Дараа нь хоёрдугаар үе шат нь Чингис бонд, Самурай бондын үе шат. Тэр үед Ерөнхий сайд нь Н.Алтанхуяг байсан. Эдийн засгийн сайд нь Н.Батбаяр байсан. Банкных нь захирал болбол солонгос хүн байсан шүү. Намайг Ерөнхий сайд болоод солонгос захирал хөөгөөд явуулчихсан гээд баахан ярихаар нь би, би шууд харьяалдаггүй юм л даа. Тэгээд тийм баймааргүй юм аа гээд одоо холбогдох хүмүүсийг нь дуудаад уулзсан чинь тэр солонгос захирал чинь юу яасан юм байна лээ шүү. Сү.Батболд Ерөнхий сайд байх үед эхлээд Баярцогт, тэр Д.Хаянхярвааг байх үед эхлээд манай Засгийн газартай 10 орчим сар зэрэгцэж ажилласан хүн байна лээ шүү. Тэгээд яасан юм гэхлээр Чингис бонд босгоод, 12 сард боссон бонд, тэгээд 5 сард нь бол манай Хөгжлийн яамнаас ямар санал орж ирсэн юм бэ гэхлээр Засгийн газрын хурал дээр энэ Солонгосууд бол удирдлага хийж чадахгүй юм байна. Тэгэхээр эд нарын энэ удирдлагын гэрээг нь дуусгавар болгоод, зөвлөхийн гэрээ болгоё гэдэг ийм санал оруулж ирснээр 2013 оны 05 дугаар сард Солонгос захирлууд нь чөлөөлөгдсөн. Ийм учиртай. Тэрний дараа 2 сар хэртэй орлогч нь байсан нэг монгол хүн хийж байгаад тэгээд тэр Мөнхбат гэдэг залуу болсон байна лээ. Яагаад болсон гэж яриад байгаа вэ гэхээр бид нар Хөгжлийн банкны захирлыг Засгийн газар тавьдаггүй юм аа. Төлөөлөн удирдах зөвлөл гэж байгуулаад Төлөөлөн удирдах зөвлөлийнхөө хурлаар оруулаад Хөгжлийнхөө банкны захирлыг тавьдаг, тэрнийг санал болгодог хүн нь бол хариуцаж байгаа яам нь. За юмаа эхлээд ойлголцъё гэж би хэлээд байгаа нь энэ. Хоёрдугаар үе шат нь ийм. Өөрөөр хэлбэл 2014 оны 08 дугаар сараас аваад 2014 оны 10 дугаар сарыг дуустал хугацаанд надаас юм асууж тодруулахад бол би Засгийн газрын түвшиндээ бол мэднэ, банкны түвшинд нь бол саяын миний хэлсэн тэр Фортуна Н.Батбаяр, Мөнхбат. За Мөнхбат ч биш л дээ тэр чинь гүйцэтгэх захирал, Шинэбаатар энэ хүмүүсээс тодруулах шаардлагатай.

Би гуравдугаар үе шатыг хэлнэ. Энэ их ноцтой үе шат шүү. Одоо өнөөдрийг хүртэл манай улс яагаад хөгжихгүй байгаа вэ гэхлээр МАН, АН нам гэж хоорондоо солиорсоор байгаад МАНАН-гийнхан, дундуур чинь яг жинхэнэ хулгайч, жинхэнэ луйварчин, жинхэнэ зохион байгуулалттай гэмт хэрэг, мафи маягийн бүтэц нь ажиллаад, тэгээд бид нар хоорондоо хэрэлдээд дуусдаг ийм болчихсон юм. Одоо эргэн санах хэрэгтэй. Гуравдугаар үе шатыг би юу гэж ойлгож байгаа вэ гэхээр 2014 оны 11 дүгээр сарын 05-ны өдөр манай Засгийн газрыг огцруулсны маргаашаас эхлээд тоологдоно. Энэ хаа хүртэл үргэлжлэх вэ гэхээр 2014, 2015 оны 08 дугаар сар байна уу, Ардын нам хэзээ гарлаа, 09 дүгээр сарын үед хүртэл үргэлжилнэ. Үүнийг бол би МАНАН-ийн Засгийн газар гэдэг юм. Ц.Элбэгдорж зохион байгуулалттайгаар Миеэгомбын Энхболд хоёр Н.Алтанхуяг гэдэг хүнийг огцруулаад юу хийсэн бэ гэхээр МАНАН-ийн Засгийн газар байгуулсан. Тэрний Ерөнхий сайд нь Ч.Сайханбилэг. Шадар сайд нь бол одоо Ерөнхийлөгч болчихсон байгаа Х.Хүрэлсүх, Сангийн сайд нь болбол Ж.Эрдэнэбат, нөгөө банкны чинь Хөгжлийн банкны ТУЗ нь бол Шинэбаатар хэвээрээ. Энэ хооронд их янз бүрийн юм хийсэн, энийг нягталж үзээрэй. Би та нарыг сэтгэл санаа гаргаад энийг одоо үнэн зөв шийдье гэж байгаа хүмүүс цугласан гэж үзэж би өөрийнхөө системчлэлийг хэлж байгаа.

Дөрөвдүгээр үе шат бол 2017 онд Хөгжлийн банкны хуулийг өөрчилснөөс эхлэлтэй. Тэрнээс хойших нь та нар нягталж үзээрэй. Яагаад би энийг хэлж байгаа вэ гэхээр 2017 онд Улсын Их Хурлын манайхан ингэдэг юм. 2017 онд хэн Ерөнхий сайд байлаа, тэрний буруу гэдэг. Үгүй 2017 онд Ж.Эрдэнэбат Ерөнхий сайд байсан юм байна лээ. Тэгэхдээ Улсын Их Хурлын 20 гаруй гишүүн манай энэ Сангийн сайд болчихсон Б.Жавхлан нөхрийн бланк дээр Улсын Их Хурлын 20 гаруй гишүүд гарын үсэг зураад Хөгжлийн банкны хуулийг өөрчилсөн. Би тэгэхдээ тэд нарыг

буруутгахгүй байгаа, бодвол сэтгэл санаа нь Хөгжлийн банкнийг сайн ажиллуулъя л гэж бодсон байх. Тэгэхдээ би дахиад асууя. Бичээд авчихаарай. Аудитынх нь 2019 онд энэ Хөгжлийн банкны асуудлаар, ингээд аудит гэхэд ингэж бичсэн. Улсын Их Хурал, Засгийн газар Монгол Улсын Хөгжлийн банкны санхүүжүүлэх төсөл, хөтөлбөрийг тусгайлан батлахгүй гэж байгаагаас хөгжлийн төсөл, хөтөлбөрүүдийг Монгол Улсын Хөгжлийн банкны санхүүжилтээр төлөвлөн хэрэгжүүлэх боломжгүй байна. 2017 оны хуулийн өөрчлөлтөөс хойш юу болсон гэхээр Монгол Улсын хөгжлийн хөтөлбөрүүдийг Хөгжлийн банк санхүүжүүлэх үүрэггүй болсон. Ингэнгүүт нь Г.Дамдиннямын одоо юу гэдэг юм нэг уул уурхайн төсөл, тэрний нэг гэр, байшин барих төсөл гэдгийг санхүүжүүлж эхэлсэн.

Би энийг буруу гэж бодож байгаа. Гэхдээ та нар ухаанаа уралдуулна биз. Эндээс бид нар хэн нэгнийг зүгээр яллаад зогсох биш цаашаагаа яаж энэ юмаа зөв явуулах вэ гэдгээ ярих юм чинь. Миний бодлоор бол нэг ийм дөрвөн үе шаттайгаар үзэх ёстой. Би нэг юм хэлнэ. 2012 онд намайг Ерөнхий сайд байх үед яаж энэ төслүүдийг санхүүжүүлж байсан юм бэ гэхлээр хамгийн эхлээд мэргэжлийн холбоод нь ярьдаг. Манай салбар дээр, Чингис бондоос ийм ийм салбаруудыг ийм ийм төслүүдийг санхүүжүүлмээр байна. Би одоо та нарт маш тодорхой юм хэлье.

Барилгын салбар дээр бол 40, 50 чиглэл гарч ирснээс ерөөсөө дөрөвхөн чиглэл нэгдүгээрт цемент, хоёрдугаарт арматурын төмөр, гуравдугаарт шил, дөрөвдүгээрт барилгын дүүргэгч материал ийм л дөрвөн юмыг дэмжих нь зүйтэй гэж мэргэжлийн холбоод нь гаргаж ирсэн. Энийг салбарын яам нь яаман дээрээ хэлэлцүүлэг хийгээд тэд нар нь дэмжих юм бол Ц.Элбэгдорж Ерөнхийлөгч байсан юм. Арван долоон хүнтэй бондын бодлогын зөвлөл гэж байгуулсан юм. Одоо энэ Ц.Даваасүрэн гишүүн, тэр үед Төсвийн байнгын хорооны дарга орсон, Ерөнхийлөгчөөс П.Цагаан орсон, Улсын Их Хурлын дарга Д.Одхүүг өгсөн. Б.Гарамгайбаатар Эдийн засгийн байнгын хорооны дарга гэж орсон.

Ингээд Улсын Их Хурал, Засгийн газар, Ерөнхийлөгч бүгдээрээ хамтраад хяналт тавина, Нийслэлээс Э.Бат-Үүл орсон. За тэгээд бүтээн байгуулалтын сайд нар ороод ингээд 17 хүний бүрэлдэхүүнтэй энэ дээр ярьж байгаад хэрвээ дэмжсэн тохиолдолд тэрнийг нь Засгийн газар жагсаалт болгоод Хөгжлийн банк руу өгдөг юм. Одоо бид нар нэг их сонин юм яриад байгаа юм. Тэр Засгийн газар тэрнийг заавал санхүүжүүл гэдэг юм өгдөггүй. Бид нар энэ салбарын ийм ийм компаниуд байна, энэ салбарыг дэмжих нь зүйтэй. Цементийг дэмжих нь зүйтэй гэж хэлж байгаа юм. Тэрэн дотор “МАК” компани нь байна уу, хэн нь байна вэ, бүгдийг нь жагсаагаад өгдөг. Хөгжлийн банк яах вэ? Одоо энэ Хөгжлийн банкны нь миний тэр асуудлаас хариулж байгаарай. Засгийн газраас өгсөн бүх компаниудын төслийг санхүүжүүл гэж өгдөггүй. Хөгжлийн банкны тавих шалгуурыг хангаж байгаа, барьцаа хөрөнгөтэй, тэр барьсан хөрөнгөгүй зээл өгчихсэн гэхээр гайхаад байгаа юм. Тэгээд барьцаа хөрөнгөтэй бусад шалгууруудыг хангасан. Тэр банк одоо компанид зээлийг өгнө. Яагаад энэ зээлийг өгөөд байгаа вэ гэхээр үйлдвэрлэлээ дэмжинэ, дэд бүтцээ дэмжинэ. Хөгжлийн бодлого учраас энийг хийж байсан юм. За энэ асуултад бас надад хариулж өгөөрэй.

Дахиад нэг юм байна лээ, 1.4 тэрбум төгрөгийг морожинд өгчихжээ гэж, морожинд өгсөн юм байгаа байх. Тэгэхдээ ингэж өгсөн, 2 тэрбум төгрөг хүртэл хүссэн төслүүдийг ЖДҮ рүү шилжүүлээд. ЖДҮ-ийн санд Чингис бондоос 100 тэрбум төгрөгөөр нэмж өгсөн. За та нар минь тэр хавиар учраа ол, наадах нэг ойр зуурын юм хийх гэж байгаа хүмүүсийнхээ төслийг дэмж. Ингээд ЖДҮ-ийн санд 100 тэрбум төгрөгөөр дэмжсэн. Тэр үед жилийн 7 хувийн хүүтэй өгч байсан зээлийг Хөгжлийн



банкны зээл 5 хувь болсонтой холбогдуулаад ЖДҮ-гийн зээлийг бид нар 5 хувь болгосон. Тэгэхдээ бүх ЖДҮ-гийн зээл тэр үед арилжааны банкаар дамждаг байсан.

За гурав дахь нь 888 төсөл гээд. Одоо үйлдвэрүүдийг дэмжье гэж. Одоо салбар, салбар дээр ноос, ноолуур, сүү, ээрмэл, оёдол гээд зөндөө юм байгаа юм. Тэд нарыг Хөдөө аж ахуйн яам руу нь өгсөн. Тэндээ төслийн нэгжээ байгуулаад яв. Тэгэхдээ танай наад төсөл чинь арилжааны банкаар дамжина шүү. Бид нар дараа нь нэг эмгэнэлтэй түүх харсан шүү дээ. 2017 онд байна уу? Хэдэн онд байна уу? ЖДҮ-гийн зээлийг хүүг нь 3 хувь болгоод арилжааны банк биш яамдууд одоо зээл өгдөг болсон. Эмгэнэл шүү дээ, энэ чинь. За ийм ийм юм болсон шүү. Би энийг нэг хэлэхгүй болбол бид нар ойлголтын зөрөөтэй хүмүүстэй юм ярихад хэцүү байдаг гэж би байнга хэлдэг. Ийм зүйлийг хэлжээ, тэгээд цааш нь хэлье. Өгөх эсэхийг шийднэ. За аюулгүйн зөвлөлийн зөвлөмжид гарсан. Надтай нэг хүн маргаад байна лээ, Аюулгүйн зөвлөлийн зөвлөмж чинь А.Алтанхуягаа хууль биш шүү дээ, биш. Тэгэхдээ Ц.Элбэгдорж Ерөнхийлөгч, М.Энхболд Улсн Их Хурлын дарга, Н.Алтанхуяг Ерөнхий сайд байхад Аюулгүйн зөвлөлийн зөвлөмж гаргаад Чингис бондоос өгч байгаа мөнгөний эрсдлийг, энэ чинь гадагшаа гаргаж төлөх юм чинь яаж багасгах вэ гэж ярьж байгаад төслийн нийт өртгийнх нь гуравны нэгд л өгнө. Гуравны хоёроо өөрөө босгоно. Одоо түрүүн тэр компаниуд ярьж байна лээ. Би гуравны хоёроо өөрөө босгосон юм. За ингэхлээр чинь Номтойбаярын төсөл орж ирдэг юм. Очоод үзэхээр чинь бас нэг юм босчихсон. Гарамжавын төсөл орж ирдэг байхгүй юу. Ингээд би та нарт нэг аксиом хэлье. Чингис бондын үеийн мөнгөнөөс санхүүжүүлсэн төслүүдээс нэг ч төсөл дампуурах ёсгүй. Тултал нь мөнгө өгөөгүй байхгүй юу. Гуравны нэгд нь л мөнгө өгсөн байхгүй юу даа. Гуравны нэгийнхээ баталгааг аваагүй, барьцаагаа аваагүй болбол тэгвэл тэр Хөгжлийн банкныхантайгаа ярь. За би энэ баталгаатайг нь та нарт хэлж өгч байна. Энийг та нар сайн хараарай анхаараарай.

За дахиад нэг асуулт байна. “ТОСК” байна шүү дээ. “Буянт-Ухаа” нэг, хоёр нь ингээд баригдаад 2015 оны үед байна уу, 2016 оны үед орчихсон шүү дээ. Одоо та нар боддоо ямар гээч улс вэ 6 жил өнгөрчхөөд байхад “Буянт-Ухаа” нэг, “Буянт-Ухаа” хоёрын мөнгө нь хайчихсан юм. Надад нэг тодорхой хариулаад өгөөч хайчихсан юм. Байшин нь баригдаад хүмүүс найман хувийн зээлээр ороод дуусчихсан шүү дээ. Тэр мөнгө хайччихсан юм.

Дахиад надад асуулт байна. Би “Бэрэн групп” ХХК гэж байгаа юм. Ер нь тэр нөгөө барилгынхны хэлснээр арматурын төмөр үйлдвэрлэх шаардлагатай байгаа юм л даа. Тэр Эрдэнэтэд билүү нэг юм хийдэг байсан. Тэгээд тэр салбарынхан нь үзээд манай Бэрэн мундаг аа, манай Бэрэн цаашаа явна гэсэн. Ингээд тэр дөрвөн компани арматурын төмөр үйлдвэрлэнэ гэж Засгийн газрын жагсаалтад орсон байдаг юм. Тэрнээс Бэрэн зээл авсан. Гэтэл 2016 онд уу, 2015 онд “Бэрэн групп” ХХК-ийг арматурын үйлдвэрийг ашиглалтад өгөөгүй байхад нь өөрөө хувийн одоо орон сууцны хороолол барина гэхэд нь дахиад Хөгжлийн банкны зээл өгсөн байгаа юм. Энэ ямар учиртай юм, яагаад өмнөх зээл аваагүй байж өгдөг юм.

“ТОСК” дээр би дахиад асуучихъя. “ТОСК”-ийн, “Буянт-Ухаа” нэг, хоёрын мөнгө төлөгдөөгүй байхад яагаад та нар “ТОСК” дээр тэр гурав дахь зээлийг өгдөг юм, дөрөв дэх зээл өгдөг юм. Тэр дөрөв дэх зээл нь нэг тийм, Америкийн нэг цэргийн ямар өмчөө нэг юм ярьсан юм. Тэрийг тодотгоод өгөөрэй, би ойлгохгүй байгаа. Энийг бол би санаатай үйлдлүүд гэж үзэж байгаа юм. Эсвэл хээл хахууль авлигал авсан, өмнөх зээлээ төлөвлөөгүй байж дараачийн зээл өгнө гэдэг бол болохгүй зүйл.

Дахиад би асууя “АСЕМ Вилла”-ийн мөнгө яахаараа Хөгжлийн банкнаас гардаг юм. Энийг бас Хөгжлийн банкныхан хариулаадах. Энэ юу гэсэн үг вэ?

За энэ сая хэн асууж байна лээ. Ц.Даваасүрэн гишүүн, Ц.Даваасүрэн гишүүн тэр “Эгийн гол”, “Таван толгойн” цахилгаан станцыг бол би Ерөнхий сайд байхад нь эхлүүлээд Сономпил мань зүтгээд явуулчихъя гэсэн юм. Ингээд Засгийн газрын тогтоол юу гэж гарсан гэхээр 50 сая хүртэл ам.доллараас эд нарыг санхүүжүүл ээ гэсэн. Хэдийгээ өгөх үү, яах вэ гэдэг бол тэр банкны асуудал, гүйцэтгэлийнхээ хяналтаар хийгээд явдаг. Харамсалтай нь “Эгийн гол” бол нэг цаас гарсан байх. “Таван толгой”-г Энхсайхан хариуцаж ажилласан, босгож чадаагүй, бас болоогүй юмнууд байгаа. Энэний учрыг олох хэрэгтэй. За ийм ийм зүйлийг би та нарт хэлье. Тэгээд төгсгөлд нь нэг юм хэлье. Миний минут арай гүйцээгүй биз дээ.

### **Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн Ж.Бат-Эрдэнэ:**

Таны асуултад хариулах хугацаагаа үлдээсэнгүй шүү дээ та чинь, 20 минут дотроо бол асуултаа асуугаад хариулт авах нь шүү дээ.

### **УИХ-ын гишүүн Н.Алтанхуяг:**

Үгүй ээ. Ингээд л би та нарт хэлээд байгаа шүү дээ. Морин дэл дээгүүр ийм хэдэн их наяд, хэдэн сая, хэдэн тэрбумын зээл ярина гэж юу байх вэ дээ. За одоо чамтай хэрэлдэж байтал бас минут хүрлээ. Би дахиад би хэлчихье. Битгий шоу хий гэж би хэлсэн. Өнөөдрийн энэ Баттөмөрийн энэ танилцуулгаас харах юм болбол энэ бүх одоо дампуурлыг толгойлж байгаа нь нөгөө муу Женко Х.Баттулга, Н.Алтанхуяг хоёр юм байна л даа. Тэгж гаргаж байна шүү дээ. Битгий улс төрж л дөө, та нар яасан сонин юм. Энэ одоо энийг хараа та нар хэвлэл мэдээллийн хэрэгслээр зээлдэгчдийн улс төрийн нөлөө хамаарлын тухайд ийм юм гарч байна гээд солиорчих юм. Ингэж болохгүй. Энэ Улсын Их Хурал, төрийн дээд эрх барих байгууллага, ард түмний төлөөлөгч нар, хэвлэл мэдээллийн хэрэгслээр энэний хооронд хамаарал явж байна гэдгийг энд ингэж ярьдаг юм биш ээ. Би танд хэлчихье “Кью Эс Си” ХХК гэдэг чинь бол, “Кью Эс Си” ХХК гэдэг чинь намайг огцруулж аваад сар хүрэхгүйн дараа тэр 71 сая ам.долларыг чинь өгч төмөр зам бариулна гэж эхэлсэн. Тэрнээс цааш луйврыг нь та нар надаар хэлүүлэлтгүй мэднэ. Эрдэнэтийн 49 хувийн мөнгийг босгож эхэлсэн. Надад энэ “Кью Эс Си” ХХК ямар ч хамаарал байхгүй. Би 49-тэй алалцдаг биз дээ. Та нар мэднэ шүү дээ. МАНАН-ийнхан та нар энэ юмаа л хайж ол. Би та нарт эзнийг чинь зааж өгөөд байна шүү дээ. Ц.Элбэгдорж, Миеэгомбын Энхболд, Ч.Сайханбилэг, Шадар сайд нь У.Хүрэлсүх, Ж.Эрдэнэбат Сангийн сайд нь, Шинэбаатар ТУЗ-ийн дарга нь. Энэнээс илүү яалгах гэсэн юм та нар. “Хөтөл” ХХК, намайг бас “Хөтөл” ХХК-тай холбоосон. “Хөтөл” ХХК чинь бол бид нарын урд талд гарсан зээл, манай Засгийн газар байгуулагдахаас өмнө гарсан зээл. Тэгэхдээ нэг ийм юм байна лээ шүү. Заримдаа Засгийн газрын шийдвэр гаргахгүйгээр зарим шийдвэр ТУЗ-ийн шийдвэр гарсан байна лээ шүү. Ийм юмаа учрыг нь олж нарийн сайн ялгаж нягталж яваарай. За эцсийн эцэст энэ бол ард түмний л хөрөнгө шүү дээ. Бид нар гадагш нь одоо гаргаж төлөх ёстой мөнгө шүү. Тэгэхээр би бас нэг юм хэлж байна, Б.Баттөмөр дарга аа, та тэр гүтгэлгийн шинжтэй юм аа энэ олон нийтэд ингэж хүний нэрийг оруулахаа боль. Би бол Улсын Их Хурал дээр үнэнийг хэлдэг. Үнэнийг хэлсэн хүнд хүн өшөөтэй, үхэр унасан хүнд нохой өшөө шүү дээ гэж үнэн юм байна. Энэ нөхөр мэдээж үнэн юм ярина, түрүүлээд тэр нөхрийг одоо ингээд тэрэнтэй хамааралтай

гээд зарлачих гэж, та нар ядаж намайг 49-тэй хамааралтай гэж зарлаад байх даа яах вэ дээ.

**Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн Ж.Бат-Эрдэнэ:**

Гурван минут үлдлээ хоёр минут гаран Аудитын газар, Хөгжлийн банк хариулъя. Аудитын 37 микрофон.

**Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч Г.Эрдэнэцэцэг:**

За саяын асуултад Үндэсний аудитын газраас хариулъя аа. За аудитын тайлан дүнгээр нотлогдсон уу гэж энэ тайлан дээр гарсан дүн байгаа учраас энэ дээр бас тодорхой хэлье ээ. Эдийн засгийн хөгжлийн яам, Монголбанк, Сангийн яамны 2012 оны 12 дугаар сарын 28-ны өдөр хамтарсан гэрээ байгуулж, энэ Чингис бондын 1.4 тэрбум ам.долларыг одоо Монголбанк дахь Засгийн газрын бондын харилцах дансанд 4.7 хувийн хүүтэйгээр байршуулж Монголбанк, Сангийн яаманд сард 5.9 сая ам.долларын хүү төлж байсан.

За мөн Сангийн яам 2013 онд Чингис бондын эх үүсвэрээс 1.2 тэрбум ам.долларыг Хөгжлийн банканд төгрөгөөр байршуулснаас 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл хугацаанд нийт 761.1 тэрбум төгрөгийн ханшийн алдагдал хүлээсэн гэсэн тооцоо гарсан. Ингээд нийт мөн хэлсэн 17.9 сая ам.долларын үр ашиггүй зардал гарсан гээд түрүүн хэлж байна. Мөн 16 сая ам.долларын орлого олох боломжийг алджээ гэж дүгнэж гаргасан. Энэ нь болохоороо Евро бондын 20 сая ам.долларыг аливаа төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, арилжааны банкнуудад хадгаламж, зээл хэлбэрээр байршуулж зэрэг арга хэмжээ аваагүй бөгөөд энэ нь 2012 оны 06,12 дугаар саруудад хүүгийн зардал тус бүр 0.6 сая ам.доллар, нийтдээ 1.2 сая ам.доллар төлсөн, мөн Евро бондын 580 сая ам.долларыг 2012 оны 09 дүгээр сараас арилжааны банкнуудад хадгаламж хэлбэрээр байршуулах, мөн 2012 оны 10 дугаар сараас зээл олгох зэргээр ашиглаж эхэлсэн бөгөөд энэ ашиглагдаагүй энэ хугацаанд хүүгийн зардалд 16.7 сая ам.доллар төлсөн байна. Ингээд нийт мөн бас энэ асуулт дээр хариулахад. Энэ зарим эх үүсвэрийн нэрлэсэн хүүгийн түвшин бага байгаа хэдий ч одоо бас энэ бонд гаргахтай холбоотой зардлын баталгааны зардал, шимтгэлийн дүн зэрэг гэрээний дагуу тусгагдах зардалд энэ бондын хүүгийн 0.4-өөс тэр 23 орчим хувийг эзэлж бодит хүү өсгөхөд хүргэж байна гэж ингээд дүгнэсэн. Энэ нь Самурай бондын нэрлэсэн 1.52 хувь хэдий ч Японы олон улсын хамтын ажиллагааны банкны баталгааны зардал 5 аравны ...

**Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн Ж.Бат-Эрдэнэ:**

Т.Аюурсайхан гишүүн асуулт асууя.

**УИХ-ын дэд дарга, Улсын Их Хурлын гишүүн Т.Аюурсайхан:**

Өдрийн мэнд хүргэе ээ. Ажлын хэсгийн мэдээлэл цагт баригдаад бас зарим зүйлүүд бүрхэг, орхигдсон, жишээлбэл барьцаа үнэлгээнүүд нэлээн боломжийн харагдаад байсан. Энэ барьцаа үнэлгээг нь хэн хийсэн юм бэ? Хөгжлийн банкны өөрийнх нь хийсэн үнэлгээ юм уу? Ажлын хэсэг хийсэн юм уу? Ажлын хэсэг хийсэн юм болбол ямар шинжээчид ажиллаж, хөрөнгийг яаж үнэлсэн юм? Энэ хөрөнгүүд чинь их эргэлзээтэй шүү дээ. Хэд дахин илүү үнэлээд зээл авчихдаг.

Хоёрдугаарт, энэ Хөгжлийн банк дотор охин компаниуд, ялангуяа “Дэ Би Эм лизинг” ХХК өөрөө Хөгжлийн банкны нэг зээлдэгч маягаар лизингийн компани, охин компанид байгаа нийт зээлийн мэдээлэл нь бүхэл тоо яваад байна. Энэнийх нь задаргаа нь бол ажлын хэсгийн юун дээр байгаа юм байна лээ. Тэгээд энэ бол ажлын хэсгийн мэдээлэл бол нээлттэй явсан. Тэгэхлээр энэ мэдээллээ тэр орон парламент сайт дээрээ нээлттэй тавьчих нь зүйтэй гэж ийм саналтай байна. Тэгээд энэ дээр бол дотор нь энэ тариалан эрхлэлтийг дэмжих сангийн 48.5 тэрбум төгрөг, тэгээд л бусад одоо задаргаанууд нь дандаа бүтнээрээ орчихсон. Тэгээд энэ дотор бас задалж анализ хийх шаардлагатай гэж бодож байна. Тэгээд энэ дээр бол хариулт авахгүй цаг аваад яах вэ? Энэ сайт дээрээ нээлттэй тавьчих нь зүйтэй гэдэг саналтай.

За энэ Хөгжлийн банкны асуудал болбол асуудал мөн.

Нэгдүгээрт, үндсэндээ Хөгжлийн банк өөрөө эрсдлээ удирдах чадваргүй болчихсон.

Хоёрдугаарт, Засгийн газар энэ эрсдлийг нь хариуцахгүй ээ гээд хэлчихсэн байгаа. Өөрөөр хэлбэл энэ өр, төлбөрийг Засгийн газар хийхгүй шүү, татвар төлөгчдийн мөнгөөр хийхгүй шүү гээд хэлчихсэн байгаа.

Тэгээд ирэх жил 800 орчим сая ам.доллар татагдах гээд байдаг. Гаднын эх үүсвэрийн, за 762 тэрбум төгрөг төлөгдөх боломжгүй болчихоод байдаг. Хуулийн байгууллага ажиллаад ажиллаад энэ мөрдөн байцаах ажиллагааны явцад 110 тэрбум төгрөгийн эргэн төлөлт хийлгэсэн. Энэ маш их хүч хөдөлмөр мөн л дөө. Манай хэвлэл мэдээллийн байгууллагууд ажилласан, хуулийн байгууллагууд ажиллаж байна. Гэхдээ энэ чинь энэ том дүн, дотор юу ч болохгүй байна шүү дээ. Тэгээд үр дүн юу болж байна гэх юм бол одоо ингээд Хөгжлийн банк дампуурч байна шүү дээ үндсэндээ, эрсдлээ хариуцах чадваргүй. Засгийн газар эрсдлийг нь хариуцахгүй гэсэн. Тэгээд одоо цаашдаа энэ чинь юу болох вэ гэдэг маш том асуудал үүсэж байгаа биз. Улс оронд Хөгжлийн банк ямар чухал билээ, ямар зорилгоор байгуулагдаж байлаа, ямар хөрөнгө, мөнгө татлаа тэгээд одоо яах вэ гэхээр энэнээс гарах арга зам юу юм бэ гэхээр сая танилцуулагдлаа шүү дээ, Хөгжлийн банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулна, Өр барагдуулах тухай хуулийг санаачилна гээд арга хэмжээ. Энэ чинь ямар нэгэн арга хэмжээ биш шүү дээ. Хөгжлийн банкны тухай хуульд бид нар өөрчлөлт зөндөө л оруулсан. Оруулаад, оруулаад өөрчлөлт оруулж байтал энэ Хөгжлийн банк чинь өөрөө дампуурчихсан байна шүү дээ.

Тэгэхлээр яах вэ гэхээр ерөөсөө л хариуцлага шүү дээ. Бид нар хариуцлагаа ярьж чадахгүй тооцож чадахгүй учраас энэ асуудал чинь ингээд эргээд л яваад байна. Тэгээд хариуцлага хаанаас тооцох вэ гэхлээр толгойноос нь л тооцно шүү дээ. Нөлөө бүхий этгээдүүд, албан тушаалтнууд. Одоо нийгэм, өөрөөр хэлбэл бидний цаана байгаа сонгогчид, хэвлэл мэдээллийн байгууллага, биднээс хууль хяналтын байгууллагын удирдлагуудаас яг үүнийг л шаардаж байна шүү дээ.

Бид нар 2016-2017 онд үүнийг шалгасан шүү дээ иж бүрэн шалгасан, тэгээд тэр үедээ хариуцлага тооцож чадаагүй. Жишээлбэл одоо энэ Н.Алтанхуяг гэдэг хүнийг одоо зохих ёсоор байцаасан юм уу, зохих ёсоор яллагдагчаар татсан юм уу? Энийг нь хийж бол чадаагүй шүү дээ. Тэр Мөнхбат гээд залуу байсан, тэр Шинэбаатар гээд ТУЗ-ийн, дарга билүү эд нар чинь Н.Алтанхуяг даргын үед тавигдсан хүмүүс хэвээрээ л явж байсан юм. За яах вэ, нэр дурдагдаж Шадар сайд У.Хүрэлсүх байсан, дараагийн Засгийн газар гээд 2015 оны 01 дүгээр сар байх аа Засгийн хуралдаанаар би нөгөө Шударга өрсөлдөөний даргын томилгоо орох гээд

оролцож байсан юм. Тэр үед Шадар сайд У.Хүрэлсүх хэлж байсан юм. Н.Алтанхуяг дарга аа. Мөнхбат гэдэг залуу асуудлаа танилцуулаад орж байх үед за залуу минь чи бол энэ янзаараа бол шоронд орно шүү, ийм байдлаар цаашаа явж бол болохгүй шүү гэдгийг бас хэлж байсан. Тэгэхлээр тэр таны сүүл, хойно үлдсэн асуудал бол биш. Тэгээд бид нар одоо үндсэндээ асуудалд бодитой хандах хэрэгтэй. Одоо яах вэ гэхлээр яалт ч үгүй эрх баригчид руу энэ асуудалд хандана, ойлгомжтой эрх баригчид яаж байна. Хууль хүчний байгууллагын удирдлагыг томилж байна, хяналт тавьж байна, бодлогыг нь гаргаж байна, Засгийн газраа байгуулж, Засгийн газар нь гэмт хэрэгтэй тэмцэж байна, тийм эрх баригч руу хандана.

Сөрөг хүчин болсон, өмнө нь гишүүн байсан энэ хүмүүсийг бол одоо нийгэм, хэвлэл мэдээлэл бол үндсэндээ тоохгүй шүү дээ. Тэгэхлээр эрх барьж байгаа хүмүүс одоо бид нар яах ёстой юм бэ гэхээр бид нар хариуцлагыг үнэнч шударгаар тооцох хэрэгтэй. Тэгээд өнөөдрийг хүртэл одоо энэ хууль хяналтын байгууллага дээр улс төрд нөлөө бүхий этгээд Улсын Их Хурлын гишүүдээс нэг ч мэдүүлэг аваагүй байна гэж байж боломгүй асуудал шүү дээ. Яг үнэндээ бол жижиг, дунд үйлдвэрийн асуудал гэх юм бол тухайн үеийн хариуцсан сайдтайгаа, тухайн үеийн гишүүдээс одоо тэр зүгээр нэр нь хэвлэл мэдээллээр дурдагдсан дурдагдаагүй хэчнээн ч хүн мэдүүлэг өгөх гэсэн юм мэдэхгүй, авч л байсан шүү дээ, тэр бүх хүмүүсийг тогтоож л байсан. Бүрэн эрхээ түдгэлзүүлэх асуудал оруулж л байсан. Ингэж байж энэ асуудал чинь бас одоо тийшээ хүн бас гар савраа дүрээд байх боломжгүй болсон гэж бодож байгаа шүү. Тэгэхээр хэрвээ энэ асуудлыг ингээд орхих юм болбол энэ улс орон чинь дампуураад л дуусна. Тэгээд ийм асуудлууд бас байна аа.

Тэгээд энэ асуудал дээр эрх баригч Монгол Ардын намаас мэдэгдэл гаргасан. Ерөнхий нарийн бичгийн дарга Амарбаясгалан байр сууриа илэрхийлсэн. За миний хувьд бол энэ мэдэгдэл болон энэ байр суурийг 100 хувь дэмжиж байгаа. Бид нар энэ дээр хариуцлага тооцож энэний цаана гарахгүй бол энэ зүгээр, энэ ганц банктэй холбоотой асуудал биш байхгүй юу. Энэ нийгэмд болж байгаа өнөөдрийг хүртэл энэ банк, санхүү, улс төр, бизнесийнхэн хэлхэлцсэн, бие биедээ захиалга өгдөг гүйцэтгүүлдэг, захиалгын хууль батлуулдаг, улс төрд улс төрчдийг санхүүжүүлдэг, сонгуульд нэр дэвших эрх авдаг, Улсын Их Хуралд суудал эзэлчхээд ард түмнийхээ төлөө биш тэр бизнесээ хамгаалахын тулд улам өргөжүүлж, улам том дүнгээр энэ улс орон, ард иргэдийнхээ татварын мөнгийг дээрэмдэх гэж л орж суудаг болсон ш дээ. Ийм л асуудал аа гэж хандах хэрэгтэй.

Тэгээд энэ би Ж.Эрхэмбаатар хуульчаас асуумаар байна. Хөгжлийн банкийг төлөөлөөд гүйцэтгэх захирлууд гээд байгаа юм, тийм үү? Тэгээд энэ гүйцэтгэх захирлуудаас дөрвөн гүйцэтгэх захирлын үед 1.8 их наядын чанаргүй зээл гарсан. Зарим гүйцэтгэх захирал одоо хэлээд байгаа юм, гүйцэтгэх захирал байсан би энэ асуудлыг хариуцдаггүй юм аа гээд байгаа байхгүй юу. Та сонссон байх? Тийм ээ. Гэтэл гүйцэтгэх захирал чинь өөрөө тэр эрсдлийн удирдлагыг хийдэг, зээлийн материалыг цуглуулдаг, бүрдүүлдэг, барьцаа хөрөнгийг үнэлдэг, Хөгжлийн бодлого, банкны бодлогод нийцэж үү үгүй юу, өөрөөр хэлбэл экспортыг дэмжиж, импортыг орлох бодлого нь байна уу, үгүй юу гэдгийг хянадаг мөн үү. Ингэж байж материалаа ТУЗ руу оруулдаг. Ийм одоо хариуцлага хүлээх этгээд мөн үү, биш үү? нэг.

Хоёрдугаарт, одоо жишээлбэл би Улсын Их Хурлын гишүүн Г.Амартүвшингийн хувьд хэлж байна л даа. Өөрөө ТУЗ-ийн гишүүн байсан уу, байгаагүй юу, байсан биз дээ. Тийм учраас энэ дөрвийн дөрвөн гүйцэтгэх захирал дээр одоо гурав нь хуулийн хариуцлага хүлээгээд асуугдаад яваад байхад

яхлаараа нэг нь одоо огт мэдүүлэг өгдөггүй, огт хариуцлага хүлээдэггүй ингээд яваад байдаг юм. 22 тэрбумын асуудал гэдэг чинь бас тийм хөнгөн асуудал бас биш шүү. Яахлаараа хамаарал бүхий этгээдүүд тэр “Вертекс майнинг”-ийн тэр хамаарлыг нь яахлаараа өнөөдрийг хүртэл тогтоочихож болдоггүй юм гэх мэтчилэнгийн асуудлын цаана бид нар одоо ний нуугүй гаргах хэрэг байна шүү дээ.

Энэ Хөгжлийн банкны зээл чинь зориулалтын бусаар зөндөө л байгаа шүү дээ. 20 хувь нь барилгын салбарт, 20 хувийг нь алтны компаниуд авчихсан ямар компаниуд байна, энийг нь яагаад одоо хүртэл ийм хурдан шуурхай шалгаж тогтоож олон нийтийн эргэлзээг тайлж болдоггүй юм. Тэгээд бүх л галыг нь Улсын Их Хурал л авч байна шүү дээ. Яг үнэн биз дээ. Энэ Улсын Их Хурал та нар одоо энэ 76 бараг л хулгайч нар суучихсан, ажлаа хийхгүй, ингээд идэж уугаад суугаад байна гээд, хэдэн хэсэг бүлэг ганц нэг хүмүүсээс болоод ингэж суумааргүй байна шүү дээ ний нуугүй хэлэхэд. Асуудал нь энд бол маш тодорхой байгаа шүү дээ. Шалгах тийм ч төвөгтэй тийм асуудал гэж ойлгохгүй байгаа. Тэгээд ийм асуудлууд дээр бас цэг тавих бол шулуухан хэрэгтэй. Тэгээд энэ иргэн, аж ахуйн нэгжид хуулийн хариуцлага хүлээлгэчихээд энэний цаана нь зээлийг олгосон, тэр эрсдлийн үнэлгээ хийлгэдэг эрсдлийн удирдлагын захирал нь, банкны гүйцэтгэх захирал нь хариуцлага хүлээхгүй байна гэж ерөөсөө байж болохгүй шүү. Одоо манай хууль хяналтын дарга нар маш анхааралтай сонсож байгаа байх. Нэг хэдэн иргэн, аж ахуйн нэгжийг цоллоод л ингээд явуулчихдаг, тийм ээ. Эрсдлийн үнэлгээ хийж байсан хүн чинь буруугүй юм уу? Яах гэж тэр зээлийг өгсөн юм. Эрсдлийн үнэлгээ хийж байгаа шүү дээ. Эрсдэлтэй зээл байсан учраас тэр зээл чинь төлөгдөхгүй улсыг хохироогоод байна шүү дээ. Эрсдэлтэй зээлийг яагаад гүйцэтгэх захирал, эрсдлийн үнэлгээний захирал олгочихов гэх юм бол, цаана нь авлигын асуудал байгаа шүү дээ. Энэ бол маш тодорхой асуудал шүү дээ. Тэгээд албан тушаалтан, ялангуяа дахин хэлэхэд энэ нийгэм албан тушаалтныг сонирхож байна аа. Албан тушаалтан, улс төрд нөлөө бүхий этгээд өмнө нь тэр дахин хэлэхэд зээл авчихсан байсан юм аа. Одоо гишүүн болохдоо одоо зээл нь үргэлжлээд явж байгаа. Гэхдээ би өмнө нь шийдүүлчихсэн байсан юм гэж байгаа юм бол байж болохгүй шүү дээ. Гишүүн байгаа бол бусдаасаа тийм давуу эрх эдлэх нь бас хуулиар хориотой асуудал ш дээ. Тэгээд ийм юм нь дээр чинь бас би нийгэм бухимдаад. Энэ хэвлэл мэдээллийн байгууллагуудаас асуулт асуучихъя хариултыг нь авчихъя гэж бодоод байгаа байх. Зарим гишүүд бас сая нэр усаар нь энэ нөлөө бүхий этгээдүүдийг нэрлээч гээд асуусан. Би бас энэ асуултыг дахиж асууя. Ерөнхий прокурор та хариулж өгөөч, энэ бол мөрдөн байцаалтын явцын энэ агуулга нууц байдаг болохоос биш хэнийг одоо сэжигтнээр, хэнийг гэрчээр, хэнийг яллагдагчаар татсан бэ гэдэг шалгаж байгаа гэдэг мэдээлэл бол нууц биш шүү дээ. За баярлалаа.

### **Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн Ж.Бат-Эрдэнэ:**

Т.Аюурсайхан гишүүний хариултад Хөгжлийн банк 22 номерын микрофон Эрхэмбаатар.

### **Хөгжийн банкны дэд захирал Ж.Эрхэмбаатар:**

За Т.Аюурсайхан гишүүний асуултад хариулъя жишээ татаад ярья. За жишээ нь түрүүн Н.Алтанхуяг гишүүний асуултад дурдагдсан 2015 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн Монгол Улсын Засгийн газрын тогтоол байна. Уг тогтоолоор “ТОСК” буюу одоо Төрийн орон сууцын корпорацад хөдөлгөөнт батлан хамгаалах, барилга үйлдвэрлэлийн цогцолборыг барих 9.6 тэрбум төгрөгийн зээлийг олго гэсэн тогтоолыг Ч.Сайханбилэг Ерөнхий сайдын үед гарсан. Хоёрдугаар тогтоолын

жишээ татахад 2015 оны 03 дугаар сарын 30-ны өдөр “Шинэ яармаг” төсөлд 50 сая ам.долларыг өг гэж үүрэг оногдуулаад.

**Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн Ж.Бат-Эрдэнэ:**

Энэ “ТОСК”-той холбоотой биш ээ. Энэ зээл олгосон гүйцэтгэх захирлын хариуцлага гээд байна шүү дээ.

**Хөгжийн банкны дэд захирал Ж.Эрхэмбаатар:**

Тийм. Би одоо хэлэх гэж байгаа юм. За ойлголоо, уучлаарай. Тэгээд энэ Засгийн газрын тогтоол нь Хөгжлийн банкны тухайн үед хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан хуулийн 16 дугаар зүйл 16.2-т зааснаар хувь нийлүүлэгчдийн шийдвэр болчихож байгаа юм. Өөрөөр хэлбэл, манайх компанийн зохион байгуулалттай байсан хувь нийлүүлэгчийн шийдвэрийг бол заавал хэрэгжүүлэх үүрэгтэй болчихдог. Ингээд гүйцэтгэх захирал өөрийн одоо удирдлагын баг болоод эрсдлийн хороо, зээлийн хороогоороо тухайн зээлийг судлаад хууль тогтоомжоор заасан шаардлага болон зээлийн бодлогын бичиг баримтад нийцэж байгаа эсэх талаар дүгнэлт гаргаад энэ дүгнэлтийн хамт Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулаад, тогтоол гарч байж энэ зээл нь шийдэгддэг. Өөрөөр хэлбэл гүйцэтгэх захирал энэ шийдвэр гаргахаас өмнөх бүх процессыг өөрөө удирдаж, зохион байгуулж, төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулдаг эрх бүхий албан тушаалтан мөн.

**Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн Ж.Бат-Эрдэнэ:**

Ерөнхий прокурор Б.Жаргалсайхан асуултад хариулъя. Гучин тавдугаар микрофон.

**Монгол Улсын Ерөнхий прокурор Б.Жаргалсайхан:**

Т.Аюурсайхан гишүүний асуултад хариулъя. Мөрдөн шалгах ажиллагааны явцад асуугдаж байгаа бүх хүмүүсийг дэлгэрэнгүй мэдээлэх ямар ч боломж байхгүй. Яагаад гэвэл тухайн хүний гэм буруугийн асуудал огт шийдэгдээгүй. Бидний үндсэн баримталдаг зүйл бол шүүхийн таслан шийдвэрлэх тогтоол гараагүй бол хэнийг ч гэм буруутай гэж үзэхгүй. Энэ бол нэг дэх хүний эрх талаасаа хамгийн том зарчим. Хоёр дахь асуудал бол тодорхой хэмжээний энэ хүмүүсийг асуудаг, нийтэд мэдээлдэг. Одоо энд тухайлбал хэн гэдэг хүн гэрчээр асуух, хэн гэдэг хүн яллагдагчаар татагдав гэдгийг ил илэрхийлэх нь эргээд мөрдөн байцаалтын ажиллагаанд саад учруулах ийм нөхцөл байдал бий болгодог. Тийм учраас бид хэлэхгүй байгаа.

Ер нь бол зүгээр хүмүүсийн, магадгүй одоо сая тэр нэр гараад энэ хүмүүс яагаад асуугдахгүй байгаа юм гээд сая Т.Доржханд гишүүн бас асууж байна. Яагаад энэ хүнийг одоо болтол асуухгүй байгаа юм бэ гэдэг тэр асуултыг би ч мөрдөгчөөс асууж чадахгүй, хяналт тавьж байгаа прокуророо ч асууж чадахгүй. Магадгүй нөхцөл байдал тодорхой мөрдөгч мөрдөн шалгах ажиллагаа явуулж байгаад зайлшгүй асуух шаардлага нь байвал энэ цаг хугацааны л асуудал. Тэрнээс зүгээр одоо өнөөдөр яагаад асуухгүй юм, маргааш асуугаад байгаа юм гэдгийг мөрдөх байгууллагын дарга ч мөрдөгчөөсөө асууж чадахгүй, би ч асууж чадахгүй. Энэ бол бие даасан мөрдөн шалгах ажиллагаа явагдаж байгаа, хяналт тавьж байгаа прокурорын хяналт.

**Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн Ж.Бат-Эрдэнэ:**

Т.Аюурсайхан гишүүний тодруулъя. Микрофоныг өгье.

**УИХ-ын гишүүн Т.Аюурсайхан:**

За ойлголоо тэгвэл мөрдөн байцаах байгууллагын удирдлага З.Дашдаваа даргаас асууя аа. Олон нийтэд мэдээлэл бол өгөгддөг л дөө. “Авлигатай тэмцэх газрын цаг” гээд долоо хоног болгон өгдөг л байсан. Одоо шүүхээр ороогүй хүмүүсийн мэдээллийг энэ хүний хэргийг одоо ийм байдалтай шалгаж байгаа, яллагдагчаар татчихсан явж байгаа гээд нэр устай нь зарладаг. Энэ чинь хуулиар хориотой байдаг биш л дээ. Тийм учраас энэ асуудал дээр одоо олон нийт хүлээгээд байна л даа, энийг сонсох гэж л. Өөрөөр хэлбэл энэ оролцогчдоос яг хууль хяналтын байгууллагын удирдлагуудыг нь дуудъя гэсэн байх л даа. Яах вэ, орлогчийг нь дуудчихаар нөгөө даргаасаа зөвшөөрөл аваагүй учраас хариулахгүй байдаг учраас манай энэ сонсголд оролцож байгаа Улсын Их Хурлын гишүүдээс удирдлагуудыг ер нь оролцъё гэсэн юм л даа. Тийм учраас та энэ одоо албан тушаал хашиж байгаа, сая Улсын Их Хурлын гишүүдээс нэр ус нь дурдагдсан, дээр нь Улсын Их Хурлын гишүүдээс, дээр нь сая одоо зарим нь Хөгжлийн банкны гүйцэтгэх захирлаар ажиллаж байсан хүртэл хүн байна шүү дээ. Энэ оны үед одоо 22 тэрбум төгрөг, одоо муу ангилалд орчихсон, найдваргүй болчихсон. Дээр нь одоо 6 томоохон зээл гарчихсан. Тэр нь одоо ямар ч ангилалд цаашаа шилжих юм. Ямар ч байдлаар одоо зээлийн агуулга нь байгаа юм билээ, тийм ээ. Тэгээд энэ талаар аа бас мэдээлэл өгөөч ээ. Энийг олон нийт нэг л сонсохыг хүсэж байгаа байх. Түүнээс биш улс төрчид бие, бие рүүгээ чи буруу, чи зөв гэж чихэхийг нэг их сонирхохгүй байгаа байх. Бодит үр дүн. Бид нар чинь өнгөрсөн хугацааны алдаа сургамж гээд л яриад байна шүү дээ. Бүхэл бүтэн хяналт шалгалтын Монголбанк дээр бүр нэг хэсэг гарлаа шүү дээ. Тэдэн хуудас алдаа сургамжлаад байх юу байдаг юм. Алдаа сургамж ганцхан шүү дээ. Хуулийн хариуцлага тооцож чадаагүй ийм л асуудал байгаа шүү дээ.

**Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн Ж.Бат-Эрдэнэ:**

Авлигатай тэмцэх газрын дарга З.Дашдаваа хариулъя, 25 дугаар микрофон.

**Авлигатай тэмцэх газрын дарга З.Дашдаваа:**

Аюурсайхан гишүүний асуултад хариулъя аа. Хөгжлийн банктай холбоотой асуудлыг манайх хүлээж аваад одоо сар орчим шалгаж байна. Урьд нь бол 2016 онд Хөгжлийн банктай холбоотой асуудлыг Улсын Их Хурлын ажлын хэсэг шалгаад нийтдээ хорин таван хэрэг бүртгэлийн хэрэг нээгдээд шалгагдаж байгаад 2018 онд 19 хэрэг нь хаагдсан байсан. Энэ 19 хэргийн хаагдсан хэргийг сая Хөгжлийн банкнаас гомдол гаргаж нийт прокурор дээр хаагдсан байсан хэргүүдээс 19 хэрэг сэргээгдэж. Ингээд манайд нийтдээ одоо 29 орчим хэрэг шалгагдаж байна аа. Нийтдээ энэ дээр бол 52 аж ахуйн нэгжийн зээлийг бол Хөгжлийн банкнаас шилжүүлэн ирүүлсэн. Энэ Хөгжлийн банкнаас шилжүүлэн ирүүлсэн 52 зээлээс 30 зээл дээр нь эрүүгийн хэрэг үүсгэж мөрдөн шалгах ажиллагаа явуулж байгаа. Харин мөрдөн шалгах ажиллагааны хүрээнд тодорхой одоо аж ахуйн нэгжүүдийн хөрөнгийг битүүмжлэх мөрдөн шалгах ажиллагааны хүрээнд цуглуулах баримт сэлтийг цуглуулах, түүнийгээ нотлох баримтаар үнэлэх энэ ажиллагаанууд бол



явагдаж байгаа. Энэ бол цаг хугацаа нэлээн ордог ажиллагаанууд аа. Энэ ажиллагааны үр дүнд ч гэсэн хохирол тодорхой хэмжээгээр нөхөн төлөгдөж байгаа. Зарим Хөгжлийн банканд одоо удирдах албан тушаал хашиж байсан албан тушаалтнуудыг бол хуульд заасан үндэслэл, журмын дагуу таслан сэргийлэх арга хэмжээнүүд аваад явж байгаа. Энэ дээр улс төрд нөлөө бүхий этгээдүүдийг одоо ингээд яагаад дуудаж байцаахгүй, шалгахгүй байна аа гэдэг асуудал та асууж байх шиг байна. Энэ дээр шалгалтын ажиллагаа явж байгаа. Өнөөдөр хэнийг, хэзээ, яаж, хэзээ дуудах вэ гэдэг асуудал бол өнөөдөр мөрдөгч, түүнд хяналт тавьж байгаа прокурорын тактикийн үйл ажил, тодорхой хэмжээгээр бид нар бол ажлаа хийгээд явж байгаа. Энэ дээр бол тэр энэ энийг үлдээчихнэ, энэ нь сугараад үлдчихнэ гэдэг асуудал байхгүй ээ. Ямар ч байсан өнөөдөр 30 аж ахуйн нэгжийн зээл бол одоо тодорхой хэмжээгээр энэ албан тушаалтнууд нөлөөлсөн байна. Энэ зээл бол одоо тодорхой хууль бусаар гарсан байна. Энэ дээр одоо тодорхой албан тушаалтнууд давуу байдал олгосон байна. Хариуцах албан тушаалтнууд нь албан тушаалын байдлаа урвуулсан байна гэдэг бол эрүүгийн гэмт хэргийн шинжүүд бол бүрдцэн хэрэг бүртгэл, мөрдөн байцаалтын ажиллагаа явж байгаа учраас энэ дээр бол одоо хэн нэгэн албан тушаалын байдлаа далимдуулаад энэ асуудлаас бол мултарч үлдэнэ гэсэн ойлголт бол байхгүй. Энийг бол одоо ямарваа нэгэн улс төрийн нөлөөгүйгээр манай байгууллага прокурорын хяналтад хийж гүйцэтгэж байгаа. Тийм учраас өнөөдөр бол Ерөнхий Прокурор хэлж байна, тодорхой одоо хэзээ, хэнийг дуудаж байцаах нь бол мөрдөн шалгах ажиллагааны энэ мөрдөгч болон хяналт тавьж байгаа прокурорын энэ үйл ажиллагаа, тэгээд энэ дээр бол тодорхой, одоо өнөөдөр тэрийг дуудаж байцаах, энийг дуудаж ингэ гэсэн ийм асуудал бол байж болохгүй ээ. Энэ бүх ажиллагаа бол хуулийн хүрээнд явагдаж байгаа.

#### **Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн Ж.Бат-Эрдэнэ:**

УИХ-ын гишүүн С.Чинзориг асуулт асууя.

#### **УИХ-ын гишүүн С.Чинзориг:**

Та бүгдийнхээ өдрийн амгалан айлтгая. Би энэ Улсын Их Хурлаас байгуулагдсан ажлын хэсэгт орж ажилласан учраас Хөгжлийн банкны үйл ажиллагаа, төсөл, хөтөлбөрүүдийн хэрэгжилттэй холбоотойгоор бас тодорхой мэдээлэлтэй байгаа. Тийм учраас олон юм асуухгүй. Цөөхөн хэдэн зүйл асууж тодруулмаар байгаа юм.

Нэг дэх асуудал нь энэ Хөгжлийн банк, за Монголбанк ч бас оролцох болов уу гэж би бодоод байгаа юм. Ер нь энэ эх үүсвэрүүдийг татах, гадаад эх үүсвэр татах, энэ татсан эх үүсвэрээрээ энэ төсөл, хөтөлбөрүүдээ хэрэгжүүлэхтэй холбоотойгоор, санхүүжилттэй холбоотойгоор менежментийг одоо маш муу хийсэн байна гэж ойлгож байгаа. Муу хийсэн байна гэж. Энэнээс чинь шалтгаалаад валютаар зээл авсан аж ахуйн нэгж, байгууллагууд дээр валютын өсөлттэй холбоотойгоор 467 тэрбум төгрөгийн эрсдэл оччихож байгаа юм. 2011 оноос өнөөдрийг хүртэл гадаад валютын ханш 125 хувиар өссөн байна. Тэгэхээр энэ валютаар зээл авсан аж ахуйн нэгж, байгууллагууд чинь нэг хэсэг нь өөрсдөө бас бүтээн байгуулалтын ажил хийх санаачилсан нэг хэсэг нь Улсын Их Хурал, Засгийн газрын тодорхой шийдвэрээр экспортыг дэмжих, импортыг орлох бүтээгдэхүүний үйлдвэрлэлтэй болгоё гээд төсөл хэрэгжүүлчихсэн нэг хэсэг нь бол бас бараг л Засгийн газрын захиалгатай гэж хэлж болохуйц Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт оролцсон томоохон зорилтууд хэрэгжүүлэх гээд. Тэгээд энэ Монголбанк, Хөгжлийн банкнаас энэ санхүүгийнхээ менежментийг бас муу хийснээс

шалтгаалаад энэ аж ахуйн нэгжүүд чинь, үндэсний компаниуд ч үндсэндээ тэгээд том ханшийн эрсдэлд орчих юм. Бид бол бас гадна талдаа зөв мэдээлэл өгөх ёстой. Урт хугацаатай, хүү багатай, бараг л хүүгүй шахам зээлийг л энэ улс төрчид оролцоод өөрсдийнхөө хамаарал бүхий компаниар хуваагаад авчихсан юм шиг л байх юм яваад байгаа шүү дээ. Газар дээрээ нөхцөл байдал бол арай өөр л юм байна лээ. Түрүүн манай ажлын хэсгийн ахлагч ч хэлсэн. Ер нь бол хөгжлийн зээл гэж хэлэхэд бол их хэцүү. Дунджаар ер нь зээлүүдтэй зээлийн чинь хугацаа тавхан жил байгаа шүү дээ. Таван жил за яах вэ, зарим зээлүүд дээр найман жил, арван жилийн хугацаатай, дийлэнх нь бол 5 жилийн хугацаатай валютаар авсан зээл бол жилийн 8-9.85 хувийн хүүтэй асар өндөр хүүтэй. Энэ бол нөгөө гаднаас татсан богино хугацаатай, өндөр хүүтэй арилжааны бондууд. Бас бондоор хөрөнгө босгосонтой холбоотой юм шиг байгаа юм. Тэгээд энэ санхүүгийнхээ эрсдэл, менежментийг муу хийсэн хариуцлагыг хэн хүлээх юм бэ. Тэгээд нөгөө шаварт унасан шарын эзэн гэдэг шиг тэр хэдэн валютаар зээл авсан компаниуд чинь өндөр хүүтэй зээл төлнө. Дээр нь валютын эрсдлийг ингээд үүрээд явах нь хэр зөв гэж та бүхэн үзэж байгаа юм. Яагаад энэ зээлийг авахдаа гадаадын эх үүсвэр босгочихоод, санхүүжилт зээл олгохдоо энэ санхүүгийнхээ менежментийг хийгээгүй юм. Би бол Монголбанктэй своп хэлэлцээ хийх ёстой байсан юм уу? Манайд байхгүй төрөл. Уг нь бол энэ даатгалд ч гэсэн энэ үүсвэрийг хамруулах ёстой, ийм менежмент хийх ёстой байсан байх. Манайх шиг ийм өндөр валютын ханш хэлбэлзэж байдаг газарт бол энэ бол маш эрсдэлтэй шүү дээ. Энэ эрсдлийг ерөөсөө тооцоогүй, нөгөө талаасаа зээл авсан аж ахуйн нэгж, байгууллагуудад бас ялгамжтай хандчих гээд байгаа асуудал байгаа юм. Валютаар зээл авсан компаниуд нь ингээд валютын ханшны эрсдэлд ороод байдаг. Төгрөгөөр зээл авчихсан байгууллага, компани, аж ахуйн нэгжүүд нь болохлоор арай бас давуу эрхтэй болж байгаа юм шиг. Төгрөгөөр зээл олгосноос үүсээд 214 тэрбум төгрөгийн ханшийн зөрүү үүсэж байгаа. Энийг нь Хөгжлийн банк үүрэхээр байгаа. Ингээд аж ахуйн нэгж байгууллагууд ялгамжтай хандаж байгаа. Санхүүгийн менежмент маш муу хийсэн байна аа гэж. Энэ дээр Хөгжлийн банк, Монголбанк ч гэсэн оролцох ёстой байх. Яагаад энэ санхүүгийнхээ менежментийг хийгээгүй юм бэ, энэ эрсдэл яагаад тооцоогүй юм бэ?

Хоёр дахь асуудал нь Хөгжлийн банкиг бас боловсронгуй болгох, үйл ажиллагааг нь бэхжүүлж төлөвшүүлэх гэж Засгийн газар, Улсын Их Хурлаас тодорхой арга хэмжээг авч байсан юм байна лээ. Үр дүн муутай. Түрүүн С.Одонтуяа гишүүн ч асууна билээ. Гүйцэтгэх захирлууд маш олон солигдсон. Удирдах зөвлөл маш олон солигдсон. Бид нар сая шалгалт хийж байх хугацаанд ТУЗ нь бол 8 удаа солигдсон юм байна лээ шүү дээ. 2011 оноос хойш 8 удаа солигдсон. Банкандаа, мэргэжлийн банкир, албан ажилтнуудыг мэргэжлийн хүмүүсийг тогтвор суурьшилтай ажиллуулж чадаагүй. Гурван жилийн хугацаанд гэхэд л ерөөсөө 2016-2019 онд байсан санагдаж байна, 111 хүнийг ажлаас нь чөлөөлөөд, халаад оронд нь 130 хүн ажилд авсан байдаг. Ингээд энэ компанийн гүйцэтгэх удирдлагууд бол энэ банкиг мэргэжлийн боловсон хүчнийг тогтвор суурьшилтай ажиллах талаар арга хэмжээ аваагүй. Энийг та бүхэн юу гэж үзэж байгаа юм. ТУЗ бол маш хайхрамжгүй ажилласан, маш хариуцлагагүй, төрийг төлөөлж байгаа энэ эрх хэмжээгээ муу хэрэгжүүлсэн, ажилдаа бол хайнга хандсан гэж үзэхээр юм байна лээ. Зөвхөн бидний үзсэн энэ зээлийн үлдэгдэлтэй байгаа 61 компани дээр чинь зээлийнх нь 72 хувийг, холбогдох зээлийнх нь 72 хувийг ТУЗ-ийн шийдвэрээр шийдвэрлэсэн байдаг. Гэтэл ТУЗ нь дандаа эчнээгээр голдуу. Дийлэнх нь 50 дээш хувь нь эчнээгээр голдуу хуралдаад шийдвэрээ гарчихсан. Ингээд төрийг төлөөлж байгаа энэ ТУЗ маш хариуцлагагүй ажилласан. Энэ дээр одоо бас манай Хөгжлийн банкныхан ямар дүгнэлт хийж байгаа юм бэ? Яагаад ийм байдал руу оруулсан юм бэ? Би хууль хүчний байгууллагынхан байгаа учраас яг тодорхой хэргийг

асуумааргүй байна. Тийм боломж байх ч үгүй. Хариулах боломж байх ч үгүй байх. Би шүүхэд бол итгэхгүй байгаа юм. Тийм учраас прокурорын газраас нэг зүйл асуумаар байна даа. Энэ “Монгол Драй Милк” ХХК гээд хуурай сүүний үйлдвэр байгаа юм. Тэгээд Хөгжлийн банк шүүхэд ханддаг. Сүхбаатар дүүргийн Уранчимэг гэдэг шүүгч тодорхой шалтгаангүйгээр шүүх хуралдааныг 12 удаа хойшлуулсан байгаа байхгүй юу. Арван хоёр удаа хойшлуулсан байх. Тэгээд энийг үзэх юм бол энэ хэрэг шүүхээр бол шийдэгдэхгүй байна аа. Прокуророор оо шүүхээр яваад шийдэгдэхгүй юм. Шүүхэд итгэх итгэл үнэмшил байхгүй байна шүү дээ. Ганцхан компанитай холбоотой асуудлыг л Хөгжлийн банк шүүхэд өгөхөөр ганцхан шүүгч 12 удаа шүүх хуралдааныг хойшлуулаад шүүх хуралдаан хийлгэдэггүй. Тэгэхээр би прокурорын тухай хуульд байдаг санаад байна. Төрийг төлөөлж төрийн өмнөөс нэхэмжлэл шүүхэд прокурор гаргаад, энэ ялангуяа чанаргүй, хугацаа хэтрэлтэй байгаа зээлүүдийг богино хугацаанд төлүүлэх тийм боломж бололцоо манай прокурорт байна уу, үгүй юу өрийн өмнөөс нэхэмжлэл гаргаж энэ өр, авлагыг барагдуулах тийм боломж байна уу, үгүй юу гэдгийг бас хэлж тодруулъя гэж. Манай Хөгжлийн банкныхан ерөнхийдөө Хөгжлийн банкны удирдлагуудад ч буруу байгаа байх, Засгийн газарт ч буруу байгаа. Ялангуяа Н.Алтанхуяг сайдын үед бол 2012 оны 12 дугаар сарын 03-ний өдөр Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, зөвлөмж гараад, бондын зөвлөл байгуулсан зөвлөмж гаргаад Н.Алтанхуяг сайд тэр үед 2012 оны 12 дугаар сарын 15-нд Засгийн газрын тогтоол гаргаад зөвлөл байгуулсан байдаг. Энэ зөвлөл байгуулснаас хойш л үндсэндээ энэ Хөгжлийн банкнаас дуртай юмандаа, шаардлага хангаагүй хөрөнгийн барьцаагүй ийм аж ахуйн нэгж, байгууллагууд зээл олгох үйл ажиллагаа бол эхэлсэн юм байна лээ. Би тэр Засгийн газрын тогтоолыг нь харсан. Хуулиараа бол Засгийн газар төсөл хэрэгжүүлэх төслүүдийн жагсаалтыг Засгийн газар батлах ёстой. Гэтэл тэр Н.Алтанхуяг сайдын гаргасан тогтоолыг харахлаар төслүүдийг сонгон шалгаруулах үзүүлэлтүүдийг тэр зөвлөл баталж мөрдүүлэхээр. Ингээд үндсэндээ Хөгжлийн банкны ТУЗ, гүйцэтгэх захирлынх нь эрх мэдлийг тэр Зөвлөлдөө шилжүүлчихсэн л юм байна лээ шүү дээ. Ингээд мордохын хазгай болсон юм шүү гэж би ойлгоод байгаа. Иймэрхүү юмнууд байгаа гэдгийг хэлье. Тэгээд би асуултдаа хариулт авъя аа.

### **Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн Ж.Бат-Эрдэнэ:**

С.Чинзориг гишүүний асуултад Хөгжлийн банк, дараа нь Монгол Улсын Ерөнхий прокурор хариулна. Хөгжлийн банк 21 дүгээр микрофон.

### **Хөгжлийн банкны гүйцэтгэх захирал Н.Мандуул:**

Гишүүний асуултад хариулъя аа. Энд санхүү, валютын ханшийн менежментийг хэр сайн, зөв хийсэн бэ гэж бодож байна аа гэсэн зүгээр санал асууж байх шиг байна. Тийм ээ, тийм, би зүгээр шинэ удирдлагын хувьд бол тантай санал нэг байна. Хөгжлийн банкны хувьд гаднаас эх үүсвэр босгодог, тэгээд түүнийгээ дандаа гадаад валютаар ам.доллар, юань, за тэгээд еврогийн, за тэгээд самурай бондын хувьд иений эх үүсвэр байгаа аа. Нөгөө талдаа Монголдоо аж ахуйн нэгжүүдэд, ялангуяа төгрөгөөр орлого олдог аж ахуйн нэгжүүдэд ханшийн эрсдлийг үүрүүлэх нь бол анхнаасаа буруу байсан юм байна аа. Энэ дээрээ бол ямар нэгэн тийм ханшийн менежмент хийх механизм тухайн үедээ Монголбанктайгаа ярьж байгаад бий болгоод, тэгээд цаашаа явах ёстой байсан гэж хувь хүний хувьд бол дүгнэж байгаа. Мөн ялгаа байхгүй нөгөө талдаа төгрөгөөр зээл олгосон дээрээ бас эргэн төлөлт дээрээ мэдээж ханшийн алдагдал банкны хувьд үүрнэ. Ирэх жил бид 800 орчим сая ам.долларын эргэн төлөлт хийх ёстой, 10, 12 дугаар сард. За тэгэхээр үүн дээр бас ханшийн асуудал гарч байгаа. Бид одооноос Монголбанканд бас санал

тавиад ярилцаж байна. Зарим боломжтой, ялангуяа стратегийн үндэсний үйлдвэрлэл, томоохон үйлдвэрлэлүүдээ бас энэ тал дээр хэрхэн дэмжих тийм механизм бий болгох тал дээр бас санал солилцоод явж байна аа.

Тэр боловсон хүчин зэрэг асуудал дээр бол үнэн. Та бас ажлын хэсэгт байж ажилласны үр дүнд бол бас сайн мэдээлэлтэй байх шиг байна. Ер нь бол банкны хувьд бас маш их боловсон хүчин орж гардаг, тэгээд бүтэц байнга солигддог. Арван жил ажиллах хугацаанд 9 удаа ТУЗ солигдсон, 9 удаа гүйцэтгэх удирдлага солигдсон юм байна аа. Тэгэхээр энэнд бол цаашдаа бас анхаарах ёстой юм аа. Гэхдээ нөгөө талдаа ТУЗ-ийн хувьд хууль дээр заасан заалтын дагуу ТУЗ өөрөө гүйцэтгэх удирдлагад хяналт тавина, бодлогыг нь батална. За мөн түүнчлэн зээл бүрийг батлах тийм үүрэгтэй болчхоод байгаа юм. Энэ нь өөрөө төрийн төлөөллүүд, одоо эчнээгээр ажилладаг ТУЗ-ийн гишүүдийн хувьд маш их хариуцлага, ачаалал үүрүүлэх тийм нөхцөл байдал бий болгоод байна гэсэн нь бас анзаарагдсан. Тэгэхээр цааш, цаашдаа хэрвээ хууль дээр ямарваа нэгэн өөрчлөлт хийх юм бол энэ тал дээр нь бас анхаарах нь зүйтэй болов уу.

Ер нь бол Хөгжлийн банкны хувьд бас энэ их асуудлууд юунаас болсон бэ гэж үзэж байна вэ гэвэл ил тод байдал дутуу байснаас болсон гэж үзэж байгаа. Энэ проблемууд бол аль 2015, 2016, 2017, 2019 оны шалгалтуудаар ерөнхийдөө тодорхойлчихсон байсан зүйлс байгаа юм. Тэгэхэд тэр мэдээлэл нь олон түмэнд ил тод байхгүй. Тэгээд төр засгийн хэмжээнд ингээд шийдвэр гаргах тийм нөхцөл бүрдээгүй, ингэж явсаар байгаад ийм байдалд хүрчихжээ гэж дүгнэж байна. Тэгэхээр ер нь бол Хөгжлийн банкны хувьд бол Төрийн өмчит банк байгаа. Бид ямарваа нэгэн ард түмнээс хадгаламж татдаггүй, төрийн нэрийн өмнөөс гаднаас зээл босгоод зээл олгож байгаа. Тэгэхээр энэ бол зүгээр нэг тийм арилжааны банкны операц биш юм аа. Тэгэхээр бид бол төрийн нэрийн өмнөөс хөрөнгө гаднаас босгоод хөгжлийн төслүүдийг санхүүжүүлж байгаагийнхаа хувьд энэ бүх процессыг ил тод байлгах ёстой. Тэгэхээр 01 дүгээр сарын 20-ний өдөр дотоод журмаа өөрчлөөд энэ процессыг бас эхлүүлсэн, цааш нь улам нээлттэй, ил тод ажиллана гэдгийг хэлмээр байна. За баярлалаа.

### **Монгол Улсын Ерөнхий прокурор Б.Жаргалсайхан:**

С.Чинзориг гишүүний асуултад хариулъя аа. Ер нь Хөгжлийн банктэй холбоотой хоёр чиглэлээр л явж байгаа юм. Нэгдэх нь иргэний журмаар прокурор төр, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах чиглэлээр. Нөгөөх нь энэ эрүүгийн журмаар явж байгаа. Тэр нь одоо тэр 42 хэрэг, хэрэг бүртгэх, мөрдөн байцаалтын ажиллагаа явагдаж байгаа. Хөгжлийн банкны удирдлагатай 2 удаа уулзалт хийсэн Прокурорын байгууллага. Хөгжлийн банкнаас 9 аж ахуйн нэгжид прокурор төр нийтийн ашиг сонирхлыг хамгаалах үүднээс нэхэмжлэл бичиж өгөөч ээ гэж хүсэлт ирсэн. Энэ хүсэлтээс 2 хүсэлтийг нь Хөгжлийн банканд нэмэлт материалаар шаардаж буцаасан. Тав нь шүүхэд иргэний журмаар нэхэмжлэл биччихсэн, Прокурор. Одоо хоёр нь эрүүгийн журмаар шалгах шаардлагатай байна гэж үзэж мөрдөх байгууллагад шилжүүлсэн. Энэ хоёр шилжүүлсний дотор таны сая ярьдаг “Монгол драй милк” ХХК гэдэг компанитай холбоотой асуудал эрүүгийн журмаар шалгуулахаар шилжүүлсэн. Тийм учраас нэгэнт эрүүгийн журмаар шалгагдаж байгаа учраас прокурор давхар төлөөлөн нэхэмжлэх боломж байдаггүй. Тийм учраас эрүүгийн журмаар ингээд шалгагдаад явж байгаа. Хариулт дууслаа.

**Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн Ж.Бат-Эрдэнэ:**

С.Чинзориг гишүүн тодруулах уу? За УИХ-ын гишүүн Ц.Мөнхцэцэг асуулт асууна.

**УИХ-ын гишүүн Ц.Мөнхцэцэг:**

Хөгжлийн банкны удирдлагаас асуух хоёр асуулт байна. Хөгжлийн банкны олгосон нийт зээлийн 69 орчим хувь нь барьцаа хөрөнгө нь хангалтгүй байгаа гэж банкны удирдлагуудын мэдээлэлд дурдагдаад байгаа. Тэгэхээр энэ хугацаа хэтэрсэн зээлдэгч нарын энэ хохирлыг ер нь бүрэн барагдуулж чадах уу? Улсад учруулсан хохирлыг хэзээ барагдуулах вэ? Өнөөдөр энэ ажлын хэсгийн мэдээллийг үзэхээр шүүхийн шийдвэр гарсан 3-хан зээлдэгч байгаа юм байна. “Төрийн орон сууцны корпораци”, тэгээд “Чингис хаан банк”, “Энсада инстern” ХХК гээд. Тэгээд яг гурван шатны шүүх дээр явж байгаа бараг 20 гаруй зээлдэгч байна аа. Тэгэхээр энэ тэртээ тэргүй барьцаа хөрөнгүүд нь хангалтгүй байгаа тохиолдолд тэр олон тэрбумын энэ өр, зээлийг ер нь банк одоо бүрэн төлж чадах уу, улсыг ер нь хохиролгүй болгож чадах юм уу, үгүй юу гэдэг дээр бол их эргэлзээтэй байна. Энийг бол тодруулж өгөөч.

Хоёрдугаарт нь ингээд Улсын Их Хурлын гишүүд бид нар тодорхой болсон мэдээллүүд ирж байна аа. Энэ зээлийн барьцаанд байгаа орон сууцууд ч одоо зарагдаад байна аа. Тухайлбал Сүхбаатар дүүрэг дээр “Хангай хотхон”-ы “Бэрэн групп” ХХК байгаа шүү дээ. “Бэрэн групп” ХХК бол энэ Хөгжлийн банкны их том хугацаа хэтэрсэн, барьцааны асуудалтай их том зээлдэгч байна аа. Гэтэл “Бэрэн групп” ХХК чинь Сүхбаатар дүүрэг дээр 100 гаруй айлуудад орон сууц зарчихсан байна шүү дээ. Энэ барьцаанд байгаа объектоос. Тэгэхээр энэ орон сууцыг авчихсан иргэд маань хохирч байгаа юм биш үү, иргэдийг одоо яаж хамгаалах вэ? Тэгээд энэ иргэдийг ер нь хохироохоос, цаашид энэ банкны барьцаатай шүүх рүү шилжчихсэн энэ объектуудыг худалдан авахаас яаж сэрэмжлэх вэ? Энэ тал дээр Хөгжлийн банк ер нь ямар ажил хийж байна? Энийг асууя. Дараа нь Авлигатай тэмцэх газраас асуулт байгаа.

**Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн Ж.Бат-Эрдэнэ:**

Хөгжлийн банк асуултанд хариулъя. 22 дугаар микрофон иргэдийн хохирлыг яаж барагдуулах юм бэ? Аж ахуйн нэгжүүдийн хохирлыг барагдуулах тал дээр яаж ажиллах юм бэ гэж.

**Хөгжлийн банкны дэд захирал Ж.Эрхэмбаатар:**

Ц.Мөнхцэцэг гишүүний асуултад хариулъя. Хөгжлийн банк одоогийн байдлаар хохирол төлбөр биш зээл төлөх, эргэн төлүүлэх ажиллагаа хийж байгаа юм. Өөрөөр хэлбэл зээлийн гэрээнээс үүдэлтэй шаардах эрхээ хэрэгжүүлээд ажиллаж байгаа. Барьцаа хөрөнгө хангалтгүй байгаатай 100 хувь санал нэг байгаа. Хангалтгүй байгаа хэд хэдэн шалтгаан байгаа. Тэр нь нэгдүгээрт, ирээдүйд бий болох хөрөнгө барьцаална, орлогоо барьцаална, дансны урсгал орлогоо барьцаална гэж гэрээ хийгээд, хэлбэр төдий хуулийн шаардлага, зээлийн журмын шаардлагыг хангуулаад зээл олгосон тохиолдол маш их байгаа. Энэ нь ирээдүйд нөгөө орлого нь бий болоогүй, бий болсон орлогыг хянаж чадаагүй, бий болсон үйлдвэр объектыг барьцаандаа буцааж аваагүй зарим нэг аж ахуйн нэгж жишээ нь

хэлэхэд “Хөтөл” ХХК. “Хөтөл” ХХК-ийн тухайд бий болсон хөрөнгө оруулалтаар хийсэн үйлдвэрээ улсын комисст одоо хүртэл өгөхгүй байж байгаад, Авлигатай тэмцэх газар Хөгжлийн банк гомдол гаргаж байгаад сая нэг улсын комисс авсан. Гэрчилгээ гаргуулж аваагүйгээс үүдэлтэй барьцааны эрхээ хэрэгжүүлэх чадваргүй болчихсон байгаа. Дараагийн нэг хүчин зүйл нь юу вэ гэхээр барьцаа хөрөнгө олон жилийн турш ялангуяа техник, тоног төхөөрөмжүүд бол элэгдээд, хорогдоод барьцааны үнэлгээндээ хүрэх бололцоогүй болчихсон байгаа юм. Сая ажлын хэсгийн дүгнэлтээр тэр магадлагаа хийгдсэн байгаа, энэ үнэлгээгээр, магадлагаагаар бол эрс буурчихсан байгааг та бүхэн анзаарсан байх. Энэ нь эргээд нөгөө түрүүн миний хэлсэн, ирээдүйд бий болно гэсэн буюу бий болгоно гэж ерөөсөө бололцоогүй, барьцааны шаардлага хангахгүй. Хэдийгээр иргэний хууль дээр барьцаалж болно гэсэн байгаа боловч эргээд барьцааны эрхээ хангах шаардлагатай, араас нь хянах, эрхээ боломжтой болгох энэ ажиллагаа хийгдээгүйгээс үүдэлтэй ийм эрсдэлд учирчихсан байгаа.

Хөгжлийн банкны зүгээс зээл төлүүлэх дээр хэд хэдэн зарчим барьж ажиллаж байгаа. Мэдээж зээлдэгч нартайгаа хамтарч ажиллах ёстой. За 8 орон сууцын зээл байгаа, үүнээс орон сууцаа зарчихсан. Зарим нэг тохиолдолд нөгөө барилгаа барихын тулд бартерт өгчихсөн тохиолдол бол байгаад байгаа, мөн газрын төлбөртөө өгчихсөн тохиолдлууд байгаад байгаа. Тэгээд иргэд хохирохгүй байх үүднээс эдгээр орон сууцны зээлүүдийг бид бол нээлттэй зарлаж байгаа. Мөн худалдан авагч иргэд маань банкны дансанд төлбөрөө хийсэн тохиолдолд байрыг нь чөлөөлөх байдлаар ингээд хамтарч ажиллаж байгаа. Зарим нэг барьцаа хөрөнгийг борлуулах ажлыг хийж байна, зохион байгуулж байна. Энэ тохиолдолд худалдан авагчидтай уулзаж байгаа. Шүүхийн шийдвэр биелүүлэх ажиллагаа хийгдэж байгаа 330 тэрбум төгрөгийн маргаан бүхий материал, 7 зээлдэгчтэй холбоотой материал явж байгаа. Үүний хамгийн том нь “Кью Эс Си” ХХК байгаа. За “Кью Эс Си” ХХК одоо Улсын Дээд шүүхийн тогтоол дөнгөж сая гараад, шийдвэр гүйцэтгэх ажиллагааг Ерөнхий прокурорын газартай хамтраад ингээд эхлүүлэхээр ажиллаж байгаа. Шийдвэр гүйцэтгэх ажиллагаа 300-800 хоног саатчихсан ч компани байна. Өөрөөр хэлбэл, уг нь шийдвэр нэгэнт гарчихсан бол хэрэгжих ёстой. Тэгээд Хууль зүйн сайдад бид хүсэлт гаргачихсан байгаа. Энэ нь юу вэ гэхээр ажлын хэсэг гаргаж өгөөч ээ. Энэ бол одоо Хууль зүйн сайдын шууд харьяаны агентлаг байгаа. Ажлын хэсэг гаргаж өг гэж ажиллахгүй бол шийдвэр гүйцэтгэгч нар маань нэлээн ачаалалтай байдаг. Процессын нэлээдгүй шаардлагууд байдаг. Энийг хэрэгжүүлэхийн тулд нэлээдгүй хүч хаяж, ажиллаж, хийж байж бодитой үр дүн гарна гэж тооцож байгаа. Зээлдэгч нар бол харьцангуй бас хамтарч ажиллаж байгаа. Өөрийн бизнесийн орлого болоод бусад төслөөсөө төлөлт бага багаар хийгдээд явж байгаа. Цаашид бас сайжруулах шаардлага байгаа.

#### **Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн Ж.Бат-Эрдэнэ:**

Ц.Мөнхцэцэг гишүүний микрофоныг.

#### **УИХ-ын гишүүн Ц.Мөнхцэцэг:**

Түрүүнд дурдсан Хангай хотхоны “Бэрэн групп” ХХК-ийн барьцаанд байгаа байшингаас 100 гаруй айл байр авчихсан. Эд нарын нарын ордер гарах юм уу, үгүй юу? Тэртэй тэргүй шүүхийн барьцаанд байгаа байрыг цаад “Бэрэн групп” ХХК мэдсээр байж, иргэдэд зарсан байна шүү дээ. Энэ тал дээр танайх ямар бодлого бариад байна.

## **Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн Ж.Бат-Эрдэнэ:**

Хөгжлийн банк, 22 дугаар микрофон.

### **Хөгжлийн банкны дэд захирал Ж.Эрхэмбаатар:**

“Бэрэн групп” ХХК-ийн тухайд 4 блок байшин байгаа. Нийтдээ 6 блок байшин байгаа. Үүнээс одоо хоёр блок нь бүтэн зарагдчихсан байгаа. Хөгжлийн банкны барьцаанд байгаа хэрнээ зарагдчихсан байгаа. За энэ нь эргээд нөгөө иргэд хохирох эрсдэл үүсчихсэн байгаа. Нэгэнт хэдийгээр иргэд зуун хувь төлбөрөө төлсөн ч гэрчилгээ гаргахгүй гэсэн үг. Энэ тохиолдолд энэ юунаас шалтгаалж байгаа вэ гэхээр зээлдэгч буюу “Бэрэн групп” ХХК-ийн үйл ажиллагаанаас шууд хамаарч байгаа юм. Үлдсэн блок борлуулалт нь эхлээгүй байгаа хоёр блок байгаа. Энэ хоёр блокийн борлуулалтыг бид харилцан хамтарч ажиллаад, иргэд худалдаж авсан тохиолдолд ялангуяа банкны зээлээр авсан тохиолдолд гэрчилгээг нь гаргаж өгөөд, цаад банканд нь барьцаалж, ингээд банкны орон сууцны зээлийг нь эргэн төлүүлэх байдлаар явна. Гэхдээ “Бэрэн групп” ХХК гэж компани маань өөрөө ахиад зээлтэй, арматурын зээлтэй. Энэ арматурын зээлийн эргэн төлөлт мөн хүндэрчихсэн байгаа. Тэгэхээр нэг хуулийн этгээд учраас тэр орон сууцын борлуулалт болоод цаашдаа барьцаа хөрөнгийг чөлөөлөх эсэх асуудал нь тухайн компанийн бусад зээлээс бас шууд хамаарч байгаа. Тийм учраас иргэдэд бид одоо урьдчилан сэргийлэх үүднээс хэлж байгаа зүйл юу вэ гэхээр барьцаанд байгаа шүү. Мөн барилгын компани буюу тэр тухайн зээлдэгчийг нэлээдгүй шахаж ажиллаж байгаа нь иргэдийг дахин хохироох эрсдлээс урьдчилан сэргийлэх үүднээс бусад эх үүсвэрээс шаардлагатай зээлүүдээ төлөх байдлаар, барьцаа, магадгүй барьцаа хөрөнгө нэмж өгөх байдлаар, барьцаа хөрөнгийн шаардлагаа хангуулж байж байр чөлөөлөх ажлыг зэрэгцээд борлуулалттайгаа уялдуулж хийгээрэй гэж хэлж, зөвлөж хамтарч ажиллаж байна.

## **Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн Ж.Бат-Эрдэнэ:**

Ц.Мөнхцэцэг гишүүн дахин асуулт асууя.

### **УИХ-ын гишүүн Ц.Мөнхцэцэг:**

Хөгжлийн банкны энэ олон чанаргүй зээл, за тэр зээлийн барьцаанд тавьчихсан үл хөдлөх хөрөнгийн объектууд байна. Тухайн компаниудын бизнесийн үйл ажиллагаа бүрэн зогсчихсон байгаа. Тэгэхээр энэ тохиолдолд нөгөө компани маань хохирлоо барагдуулах боломжгүй болчих гээд байна аа. Өөрөөр хэлбэл бид нар яг тухайн зээлдэгч компаниудын төлбөрийн чадваргүйдэлд орсон гэдэг статусыг нь хууль зүйн хувьд зохицуулмаар харагдаад байгаа юм. Өөрөөр хэлбэл Дампуурлын тухай хуульдаа бид нар бас шинэчлэл хиймээр байгаа юм. Энэ дээр одоо жишээлбэл, маш олон компаниудын үл хөдлөх хөрөнгүүд ингээд царцаад, барьцаанд ороод явчихсан байгаа. Хэрэв Дампуурлын хуулиа бид нар шинэчилсэн байвал, шинэчлэх юм болбол яг ийм тохиолдолд тухайн компаниудыг одоо шүүхийн журмаар удирдлага ч гэдэг юм уу, менежментийн багийг нь солиод хэвийн явуулна. Тэгэхдээ мэдээж улсыг хохиролгүй болгох үүднээс зээлийн эргэн төлөлтийг хиймээр санагдаж байна. Энэ тал дээр зүгээр Хөгжлийн банкны удирдлага ер нь юу гэж боддог юм бэ? Одоо ингээд л юу юугүй бүгдийг нь барьцаалаад л тэгээд зогсоочихоод байгаа шүү дээ.

**Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн Ж.Бат-Эрдэнэ:**

Хөгжлийн банк хариульъя 22 дугаар микрофон.

**Хөгжлийн банкны дэд захирал Ж.Эрхэмбаатар:**

Хөгжлийн банкны зүгээс байж болох бүх хувилбарыг судлах шаардлагатай хуулийн судалгаа болоод зээлдэгчтэй хамтарч ажиллаж байна. Дампуурлын буюу төлбөрийн чадваргүй болсон аж ахуйн нэгжүүд дээр хяналт тогтоох байдлаар, магадгүй зарим судалгааны үндсэн дээр тухайн бизнесийг дахин хөрөнгөжүүлэх байдлаар сэргээгээд ингээд борлуулалтын орлогоор нь төлөх бололцоотой байна уу, нэг бол бүр дампууруулаад байгаа эд хөрөнгийг нь худалдан борлуулах бололцоотой байна уу, ингээд явж байх явцад гуравдагч этгээдийн шаардах эрх байна уу гэдгийг бол онцгойлж харж байгаа. Өөрөөр хэлбэл бусад банкнуудад бас тодорхой үл хөдлөх эд хөрөнгүүдээ барьцаа барьцаалчихсан, ингээд 3, 4 төлбөр авагч тал гараад ирчихсэн байгаа. Дампуурлын процессыг цаашид үргэлжлүүлээд явахад хууль эрх зүйн орчин нь тодорхойгүй, шүүхийн практик дутмаг байгаа зүйл бас байгаа. Тийм учраас энийг бас сайхан зайлшгүй сайжруулах шаардлагатай гэж үзэж байгаа.

Хэдийгээр одоо Хөгжлийн банкны зүгээс тухайн зээлийг дахин санхүүжүүлээд явуулах бололцоотой мэт боловч зарим нэг компанийн тохиолдолд зээлийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулснаас болоод санхүүгийн сахилга бат муу, компанийн засаглал хяналтгүйгээс үүдээд бусад хамтарч ажиллах хувилбаруудаа хаачихаад байгаа юм. Өөрөөр хэлбэл ахиад хамтарч ажиллаад явснаар тэр ахиад орох хөрөнгө оруулалт маань эрсдэлд орох ийм эрсдэлтэй байгаа, бодитой. Энэ тохиолдолд бид яалт ч үгүй шүүхээр явах ёстой. Гэмт хэргийн замаар, гэмт хэрэг үйлдээд давуу байдал олоод тодорхой хуулийн болоод журмын заалтыг зөрчсөн байдлаар зээл олгосон тохиолдол бол маш их байна аа. Энэ тохиолдолд бид яалт ч үгүй Авлигатай тэмцэх газартаа өгөөд, хохирогчоор тогтоогдоод, хохирлоо тодорхойлоод явж байгаа. Хохирол дотор хохирол болоод хор уршгийн тооцоо гаргаж байгаа. Хохирол гэдэгт бол үндсэн зээлээ, хор уршиг гэдэгт хүүгийн зардлаа тооцоод, одоо та таны хэлж байгаа тэр хохирлыг тэдгээр хүний хамаарал бүхий, зарим нэг банкны тохиолдол зөвхөн зээлдэгчтэйгээ л маргаан үүсэх бололцоотой байгаад байгаа юм. Гэтэл тэр маань өөрөө цаашаа мөнгө нь охин компани руугаа, өөрийнхөө хувийн дансаар аваад ингээд цаашид дам дам захиран зарцуулчихсан. Хэлбэр төдий гэрээ хийгээд тоног төхөөрөмж худалдаж авах гэж байна гээд шилжүүлчихсэн ийм хуурамч бичиг баримт ашиглачихсан зүйлүүд ч байгаад байгаа юм. Тэгээд энэ тохиолдолд бол яалт ч үгүй гэмт хэргийн, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хүрээнд явна. Зарим зээлдэгч нартай бид бол хамтарч ажиллаад тодорхой хэмжээний зээлийн бүтцийн өөрчлөлт хийх замаар бизнесийг нь үнэхээр Ковидын нөлөөлөл болоод экспортын нөлөөллийг даван туулах бололцоог олгоод, цаашдаа ирээдүйтэй, боломжтой гээд тодорхой барьцаа хөрөнгийн шаардлага нэмэгдүүлээд хамтарч ажиллах хувилбарууд бол гараад судлагдаад явж байна.

**Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн Ж.Бат-Эрдэнэ:**

Ц.Мөнхцэцэг гишүүний микрофоныг залгая.



### **УИХ-ын гишүүн Ц.Мөнхцэцэг:**

Авлигатай тэмцэх газраас асуултууд байна аа. Энэ Хөгжлийн банкны зээл бол ерөөсөө авлигын гэмт хэрэг. Авлигын гэмт хэрэг гэдэг утгаараа бусад төрлийн гэмт хэргээс илүү нийгмийн хор хохиролтой, нийтийн эрх ашгийг хөндсөн ийм ноцтой гэмт хэрэг. Тэгээд гэмт хэрэг болбол одоо тохирсон шийтгэлүүд авах ёстой. Гэтэл энэ Хөгжлийн банк нь тодорхой нэр бүхий удирдлагууд, тодорхой албан тушаалтнууд гэмт хэрэг хөөн хэлэлцэх хугацаа дууссан гэдэг үндэслэлээр хэрэг нь хэрэгсэхгүй болсон тухай Авлигатай тэмцэх газрын хийсэн мэдээллүүд байна аа. Тухайлбал Хөгжлийн банкны захирлаар ажиллаж байсан Мөнхбатын хэрэг бол хэрэгсэхгүй болсон гэсэн байгаа. Тэгэхээр ер нь энэ Хөгжлийн банктай холбоотойгоор нийт хэдэн хэрэг дээр хөөн хэлэлцэх хугацаа дууссан үндэслэлээр хэрэгсэхгүй болчихов оо. Ер нь одоо гэмт хэрэг хөөн хэлэлцэх, хугацаа дуусах асуудлыг авлигын гэмт хэрэгт тооцох юм уу, үгүй юу. Олон улсын чиг хандлага бол аль болох хөөн хэлэлцэх хугацааг уртаар тавьдаг, ялангуяа авлига, албан тушаалын гэмт хэрэг дээр. Энэ дээр одоо энэ манай Монголын Авлигатай тэмцэх газар ямар байр суурьтай байдаг юм бэ? Ер нь ингээд өндөр түвшний, ялангуяа өндөр түвшний улс төрчид, эрх мэдэлтнүүд оролцсон олон гэмт хэрэг одоо хэрэгсэхгүй болгох тохиолдол гараад байгаа. Энэ дээр ер нь цаашдаа танай газар ямар санал, юуг одоо манай Улсын Их Хуралд оруулах гэж байна аа. Хоёрдугаарт нь, энэ авлигын гэмт хэргийг шалгах явцад, Хөгжлийн банкны энэ асуудлыг ингээд шалгах явцад нэлээд олон зээлдэгч нар зээлээ төлсөн, зээлийн эргэн төлөлт нэлээн сайжирч байна. Тэгэхдээ Авлигатай тэмцэх газар маань тухайн зээлийг анх авахдаа хэрвээ гэмт хэргийн эх үүсвэртэй байсан бол өөрөөр хэлбэл ямар нэг байдлаар албан тушаал, эрх мэдлийг ашиглаж давуу тал үүсгэж авсан эсэх дээр бас хяналт шалгалтаа хийж байгаа юу, эсвэл зээлээ төлчихсөн гэдэг үндэслэлээр тухайн хэргийг ингээд хаачихаж байгаа юм биш биз дээ. Энэ дээр бол манай иргэд, сонгогчид бас их асуулт асууж байгаа шүү. Давуу тал олгож, давуу тал үүсгэж зээл авсан байгаа тохиолдолд зээлийг төлсөн ч байсан гэсэн энэ дээр гэмт хэргийн, эрүүгийн хуулийн процесс үргэлжлэх ёстой. Энэ дээр одоо Авлигатай тэмцэх газрын байр суурь, ямар хэргүүд байна гэдгийг асуумаар байна.

### **Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн Ж.Бат-Эрдэнэ:**

Авлигатай тэмцэх газрын дарга З.Дашдаваагаас 2 асуулт асуулаа Ц.Мөнхцэцэг гишүүн.

### **Авлигатай тэмцэх газрын дарга З.Дашдаваа:**

Ц.Мөнхцэцэг гишүүний асуултад хариулъя аа. Өнөөдөр эрүүгийн хууль тогтоомжийн хүрээнд Монгол Улсын эрүүгийн хуулиар 22 дугаар бүлгийн гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа 5 жил байгаа. Тэгэхээр энэ 2017 оны өнөөдөр чинь одоо өнөөдөр 03 дугаар сарын 29-ний өдөр гэдэг чинь 2017 оны 03 дугаар сарын 29-нөөс одоо 2022 оны 03 дугаар сарын 29-нийг хүртэл 5 жил. 2017 оны 03 дугаар сарын 29-өөс өмнөх гэмт хэрэг болох хөөн хэлэлцэх хугацаа дууссан. Бид өнөөдөр зөвхөн хөөн хэлэлцэх хугацаа дууссанаасаа бас хязгаарласангүй. Хөгжлийн банкны асуудал дээр бид энэ дээр бас өөр төрлийн гэмт хэрэг байна аа. Энэ бас хавсарсан гэмт хэрэг байна, суурь гэмт хэрэг болбол албан тушаалын гэмт хэрэг байна. Түүний улмаас бол бас мөнгө угаах гэмт хэрэг бас энэ дээр давхар үйлдэгдсэн байна гэж үзэж хөөн хэлэлцэх хугацааг бол арай уртасгаж, бас энэ эрүүгийн хууль тогтоомжийн хүрээнд шалгаж байна зээлүүдийг. Тийм учраас өнөөдөр эрүүгийн

хууль тогтоомжоор өнөөдөр хуулийн хугацааг 5 жил тогтоосон. Энэ бол Улсын Их Хурлаас баталсан Монгол Улсын эрүүгийн хуулиар явж байгаа гэсэн үг. Бид өнөөдөр эрүүгийн, авлигын бүлгийн гэмт хэрэг дээр бол хууль хугацааны асуудлыг уртасгах, ялын бодлогыг чангаруулах. Энэ дээр бас мөн ял, ялын төрөл дээр бас тодорхой саналуудыг Хууль Зүй дотоод хэргийн яаманд хүргүүлж, хамтарч ажиллаж байгаа. Тийм учраас өнөөдөр шалгаж байгаа хэргүүд дээр бол тодорхой, бас зарим хэргүүдийн хөөн хэлэлцэх хугацаа дууссан хэргүүд бас байгаа. Энэ дээр бид нар давхар зүйлчлээд, бас мөнгө угаах гэмт хэрэгтэй зүйлчлээд, ингээд давхар шалгалтын ажиллагаа явж байна аа.

Энэ зээлээ төлсөн боловч бас энэ гэмт хэргийн шинжтэй тэр байдал нь үзэж байна уу гэсэн асуудал асуулт тавьж байна. Бид бол бүх зээлийг үзэж байгаа. Төлөгдсөн зээлийг ч гэсэн үзэж байгаа. Энэ зээл төлөх, төлөгдөх, төлөгдөнө гэдэг маань одоо энэ эрүүгийн гэмт хэргийн шинжтэй үйлдлээр энэ зээл авсан, зээлээ төлсөн гэдэг нөхцөл байдал бол тухайн зээл авагч буюу энэ албан тушаалын гэмт хэрэг үйлдсэн хүмүүсийг бол шүүх дээр хөнгөрүүлэх нөхцөл байдал болохоос, хэрэг хаагдах нөхцөл болохгүй ээ. Энийг бид нар давхар үзээд шалгаад явж байгаа. Хариулт дууслаа.

**Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн Ж.Бат-Эрдэнэ:**

Ц.Мөнхцэцэг гишүүн дахин асуулт.

**УИХ-ын гишүүн Ц.Мөнхцэцэг:**

Энэ Хөгжлийн банктай холбоотой нийт хэдэн хэрэг хөөн хэлэлцэх хугацаа дууссан гэдэг үндэслэлээр хэрэгсэхгүй болсон бэ гэдэг тоо асууж байна. Ер нь яг одоо хэдэн этгээдийн хэрэг хөөн хэлэлцэх хугацаа дууссан гэдэг үндсээр ял завших боломжтой болчихоод байгаа вэ? Энэ дээр тоо баримт байгаа юу?

**Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн Ж.Бат-Эрдэнэ:**

25 дугаар микрофон.

**Авлигатай тэмцэх газрын дарга З.Дашдаваа:**

Хөгжлийн банктай холбоотой хөөн хэлэлцэх хугацаагаар хэрэгсэхгүй болсон хэрэг бол одоогоор манай дээр байхгүй байна. Хөгжлийн банкны захирал асан Нанжидын Мөнхбаттай холбоотой хэрэг шүүх дээр нийтдээ 3 орчим жил болсон. Энэ асуудал сая өнгөрсөн намар Сүхбаатар дүүргийн анхан шатны шүүхээр байх аа шийдэгдээд, энэ бас зарим үйлдлүүд нь хөөн хэлэлцэх хугацаанд орсон байна аа гэдэг асуудал яригдаад шийдэгдсэн. Энэ асуудал дээр бол Прокурорын байгууллагаас эсэргүүцэл бичээд одоо Нийслэлийн давах шатны шүүхэд хандчихсан, энэ асуудал явагдаж байгаа. Тэрнээс бол яг одоо бидний хувьд бол ямар нэгэн байдлаар хөөн хэлэлцэх хугацаагаар Хөгжлийн банктай холбоотой асуудал бол хөөн хэлэлцэх хугацаанд хамруулж шийдсэн хэрэг одоогоор байхгүй байна.

**Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн Ж.Бат-Эрдэнэ:**

Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ гишүүн асуулт асууна.

### **УИХ-ын гишүүн Б.Бат-Эрдэнэ:**

Би товчхон асууяаа. Тэгэхээр энэ Хөгжлийн банктай холбоотой, ялангуяа энэ чанаргүй зээлийн ангилалд хамрагдчихаад байгаа 44 зээлдэгчийн 1.8 их наяд төгрөгтэй холбоотой ийм л асуудал байгаа юм л даа. Тэгээд ажлын хэсэгт ажиллаад, энэ материалуудтай, зээлдэгч тус бүрийнх нь газар дээр нь бодит байдалтай нь танилцаад эхлэхээр бол ерөөсөө анхнаасаа зориулалтын бус ашигласан, цаашид төсөл нь хэрэгжих боломжгүй, зээлээ бүрэн төлөхөөс зайлсхийсэн, барьцаа хөрөнгө хангалтгүй, барьцаагаа ирээдүйд олох орлого, ирээдүйд бий болох хөрөнгөөрөө барьцаалсан ийм асуудлууд их байгаа юм. Зөрчил ихтэй. Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хууль, Монголбанк болоод Хөгжлийн банкны дотоод журмыг зөрчиж зээл олгосон, зээлийг эхнээс нь зөрчилтэй, үндэслэлгүй, эдийн засгийн тооцоогүй болгосон, ямар нэгэн байдлаар улс төрийн нөлөө бүхий этгээд, төрийн албан тушаалтан оролцсон байж болох ийм нэг нөхцөлүүд л бий болоод байгаа учраас энэ чанаргүй зээлтэй холбоотой асуудал дээр яриад байгаа шүү. Тэрнээс хэвийн, төслүүд нь хэрэгжсэн, зээлээ төлөөд дууссан энэ бусад аж ахуйн нэгж, энэ зээлдэгч нартай холбоотой асуудлыг бол яриагүй. Энэ 1.8 их наяд төгрөгийг л одоо төр, ард түмнийг хохиролгүй болгох ийм том зорилго бид нарт байгаад байгаа юм шүү дээ. Тийм учраас түрүүн үдээс өмнө Засгийн газар 2019 оны шалгалтын дүнг танилцуулсан. Тэгээд энэ шалгалтын дүн дахиад нэг үдээс өмнө болбол цаг хугацаа их бага байсан учраас энэ дэлгэцээр гаргаж чадаагүй байх. Энэ зөрчилтэй аж ахуйн нэгжүүдийн жагсаалтыг нэг гаргаж өгөөч ээ гэж би энэ Сангийн сайдаас хүсэж байгаа юм. Боллоцоотой бол Монголбанк мөн энэ зөрчилтэй ийм аж ахуйн нэгжүүдийг хэлэх бололцоо байвал жагсаалтаар нь гаргаж өгөөч. Манай ажлын хэсгийн энэ шалгалтаар бол гаргачихсан шүү дээ. Энд компаниудын жагсаалтыг гаргачихсан юм. Тэгэхээр хамгийн гол нь танай Сангийн яамны хийсэн шалгалт, 2019 оны шалгалтаар энэ аж ахуйн нэгжүүдийн жагсаалтаараа гаргачих бололцоо байна уу, үгүй юу. Таныг би өглөө танилцуулж, би анхааралтай сонссон байхгүй юу. Тэгээд тэн дээр гараагүй юм. Тэгэхээр би бол цаг хугацаа шахаад байсан учраас та товч танилцуулга хийсэн байх аа гэж ойлгоод байхгүй юу.

### **Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн Ж.Бат-Эрдэнэ:**

Монгол Улсын Сангийн сайд Б.Жавхлан хариульъя.

**УИХ-ын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан:** 2019 оны шалгалтын материал бол ерөөсөө нууцын зэрэглэл дээр ороогүй, бүгд ил байгаа шүү дээ. Тэрүүгээр, одоо зөрчилтэй гэж дурдагдсан зээлдэгч нар, чанаргүй зээл, тэр хууль шүүхийн байгууллага руу шилжүүлэх жагсаалт бүгд ил байгаа юм. За ялангуяа одоо Улсын Их Хурлаар томилогдоод ажиллаж байгаа ажлын хэсгийнхэнд бол энэ асуудлууд бүгд нээлттэй байгаа шүү. Тэгэхээр танай ажлын хэсгийнхэн ажиллаж байх үедээ ажлынхаа шугамаар хэзээ ч авч болно. Тийм нээлттэй.

### **Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн Ж.Бат-Эрдэнэ:**

Хариулт болсон уу тодруулах уу?

### **Б.Бат-Эрдэнэ -УИХ-ын гишүүн:**

Байхгүй

**Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн Ж.Бат-Эрдэнэ:**

УИХ-ын гишүүн М.Оюунчимэг асуултаа асуух уу.

**УИХ-ын гишүүн М.Оюунчимэг:**

Дарга аа, Монголбанкны Ерөнхийлөгчийг бас дуудмаар байна. Энэ ийм чухал, хариуцлагатай байж байхад Ерөнхийлөгч нь бол байх ёстой гэж бодож байна аа. Тэгээд би Монголбанкны Ерөнхийлөгчөөс, Хөгжлийн банкны Мандуулаас, тэгээд Авлигатай тэмцэх газрын даргаас асуултууд асууя аа гэж бодож байна. Нэгдүгээрт нь юуны өмнө Төв банкны үндсэн зорилго ер нь юу вэ гэдэг асуултад нэг товч хариулт өгөөдхөөч. Тэгээд би дараа нь асуултаа тодруулж асууя гэж бодож байна. Төв банкны удирдлага нь байна уу, Төв банкнаас хэн байгаа юм, Монголбанкны дэд Ерөнхийлөгч Энхтайван байна. Монголбанкны Лхагвасүрэн Ерөнхийлөгч энэ чуулган дотор орчихсон сууж байна аа, сая орж ирчээд гараад явчихсан. Яг чуулганд сууж байна, над руу зургаа явууллаа, дуудуулсан.

**Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн Ж.Бат-Эрдэнэ:**

39 дүгээр микрофон.

**Монголбанкны дэд захирал Г.Энхтайван:**

М.Оюунчимэг гишүүний асуултад хариулъя. Монгол Улсын Төв банкны тухай хуулиар Монголбанк буюу төв банкны үндсэн зорилтыг бол тодорхойлж өгдөг байгаа. Энэхүү зорилтоор бол монгол төгрөгийн тогтвортой байдлыг хангах гэсэн үндсэн зорилтыг бол Монголбанк үйл ажиллагаандаа барьж ажилладаг аа.

**Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн Ж.Бат-Эрдэнэ:**

М.Оюунчимэг гишүүнд микрофон өгье.

**УИХ-ын гишүүн М.Оюунчимэг:**

Сая Энхтайван дэд Ерөнхийлөгч ярьж байна. Энэ төв банкны тухай хуулийн дөрөвдүгээр зүйлд үндэсний мөнгөн тэмдэгтийн тогтвортой байдлыг хангахад гол зорилго оршино оо гэсэн байгаа. Тэгэхээр энэ хугацаанд Хөгжлийн банкнаас энэ асар их мөнгүүд гарч байхад, за дээрээс нь ам.долларын ханшийн зөрүүний алдагдал бас томоохон Аж ахуйн нэгжүүдэд дарамт учирч байхад та нар энэ Төв банкны тухай хуулийн дөрөвдүгээр зүйлд заасан ханшийн тэр үнээс одоо урьдчилан сэргийлэх арга хэмжээ хэр хийж байсан бэ? Хийж чадсан уу, чадаагүй юу? Энэ үүргээ хэр биелүүлсэн гэж бодож байгаа вэ? Эсвэл тэр үеийн удирдлагууд энэ үүргээ биелүүлээгүй юу? Хөгжлийн банкнаас гарч байгаа энэ бүх мэдээлэл Төв банкны мэдээллийн санд байхгүй байсан, мэдээллийн санд тусгагддаггүй байсан нь бас хэнтэй холбоотой вэ? Энд бас эхлээд хариулт авчихъя.

**Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн Ж.Бат-Эрдэнэ:**

Монголбанк, 39 дүгээр микрофон.

## **Г.Энхтайван-Монгол банкны дэд захирал:**

Хөгжлийн банкны тухай хууль 2017 онд шинэчлэн батлагдсан. Түрүүн үдээс өмнөх хуралдаан дээр Монголбанкны Ерөнхийлөгч бас товч дурдсан. 2017 оны 11 дүгээр сарын 03-ны өдөр Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар Хөгжлийн банканд Төрийн өмчит төрөлжсөн банкны гэрчилгээ олгосон байгаад байгаа юм. Тэрнээс өмнө Хөгжлийн банк нь банк, Монголбанкнаас аливаа төрлийн лиценз, гэрчилгээ эзэмшиж байгаагүй. Тийм учраас Монголбанкны зүгээс 2017 оноос өмнө Хөгжлийн банкиг бол ямар нэгэн төрлийн банк гэж бол үзэхэд учир дутагдалтай байсан. Валютын ханштай холбоотой асуудал бол маш эмзэг сэдэв. Энэ бол дан ганц Төв банкны үйл ажиллагаанаас хамаарахаас гадна Монгол Улсын эдийн засгийн гадаад, дотоод нөхцөл байдал, гадаад сектороос бүрэн хамааралтай байгаад байгаа. Сүүлийн 20 гаруй жилийн турш Монгол Улсын төлбөрийн тэнцлийн урсгал дансны алдагдал дунджаар дотоодын нийт бүтээгдэхүүний 19.5 хувьтай тэнцэж явж байсан. Тэгэхээр энэ урсгал дансны алдагдлыг бол ихэнхдээ гадаад зээл тусламж, гадаад өрөөс хамааралтайгаар санхүүжүүлж явж байсан. Энэ нь бол ханшийн эрсдэл дээр бол маш томоохон сөрөг нөлөөг авчирч байсан. Хөгжлийн банкны хувьд бол гадаад сектороос их хэмжээний мөнгөн хөрөнгийг босгоод, дотооддоо бол арилжаалдаг. Энэ хүрээнд бол ханшийн эрсдлээ бол аж ахуйн нэгжийн хувьд тодорхой хэмжээнд өөрсдөө удирдах үүрэгтэй. Энэ хүрээнд 2017 онд Төв банк төрөлжсөн банкны гэрчилгээ олгосноос хойш бол Хөгжлийн банктай бодит бус своп хэлэлцээг 2018 оноос хойш хэрэгжүүлээд хийгээд явж байна. Одоогийн байдлаар 325 орчим сая ам.долларын бодит бус хэлцэл Хөгжлийн банктай хийгээд явж байна аа. Хөгжлийн банкны хувьд бол ам.доллараар буюу гадаад валютаар хөрөнгө татчихаад, тэрийгээ дотоодын мөнгөн тэмдэгт төгрөгөөр зээл олгоод явсан нь нэг талдаа ханшийн эрсдлийг Хөгжлийн банк үүрсэн. Хэрвээ ам.долларын эрсдэлд ам.доллараар буюу тухайн гадаад валютаар зээл олгоод явбал ханшийн эрсдлээ нөгөө талдаа аж ахуйн нэгждээ үүрүүлээд явах ийм л сонголттой байсан. Хөгжлийн банктай холбоотойгоор бол Төв банканд дээр төвлөрүүлсэн 325 орчим сая ам.долларын своп хэлэлцээ, своп гэрээ бол явж байгаа. Энэ гэрээ бол 2022 онд дуусгавар болно.

## **Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн Ж.Бат-Эрдэнэ:**

М.Оюунчимэг гишүүн асуухуу.

## **УИХ-ын гишүүн М.Оюунчимэг:**

Сая Энхтайван дэд Ерөнхийлөгч бол 2018 оноос хойших процессыг ярьж байна л даа. За 2018 оноос хойш бол ханшны эрсдлийг Хөгжлийн банк үүрэхээр болж байгаа гээд ярьж байна. Тэгвэл 2018 оноос өмнөх ялангуяа 1.8 их наяд төгрөгийн 1.4 их наяд төгрөг нь 2012-2016 онд гарсан байна л даа. Тэгэхээр энэ үеийн эрсдлийг аж ахуйн нэгжүүд үүрээд явсан байна л даа. Тэгэхээр би эндээс Хөгжлийн банкны Мандуул захирлаас асууя аа гэж байна. Банкны хүн нь илүү бас нэг хариулт өгчих байх аа. Асуудлаа мэдэж байгаагийн хувьд. Хөгжлийн банкны бас нэг үндсэн үүрэг бол 8.1.8 дээр нь заасан байдаг. Яг Хөгжлийн төсөл, хөтөлбөрүүдийг ханшны эрсдлээс сэргийлэх зорилгоор зөвлөгөө өгөх үүрэгтэй гэсэн байлаа. Тэгэхээр та бүхэн маань тэр 2012-2016 онд энэ их наядад нь мөнгө гарч байхад Хөгжлийн банк тухайн аж ахуйн нэгжүүдэд өндөр зээл авсан тэд нарт зөвлөгөө өгч байсан уу? Энэ эрсдлээс сэргийлэх талаар ямар нэгэн ажил хийж байсан болов уу, нэгдүгээрт энэ асуулт. Хоёрдугаар асуулт нь ингээд бүх

баримтуудыг би авч үзлээ л дээ. Зээл олгохдоо аж ахуйн нэгжүүдэд харилцан адилгүй хандсан байна л даа. Зарим аж ахуйн нэгжүүд маш өндөр хүүтэй, тэгээд тэр нь монгол төгрөгөөр, зарим аж ахуйн нэгжүүд ам.доллороор хэрнээ бага хүүтэй, бүр адилхан үйл ажиллагаа явуулдаг хоёр аж ахуйн нэгжийн авсан зээл, за тэр зарим нэг хөнгөлөлт, чөлөөлөлт энэ тэр нь хоёр тэс өөр, бүр үнэн ялгаатай хандсан байгаа юм л даа, жишээлбэл. Тэгэхээр та бүхэн маань надад өнөөдөр яг энд маш бага хүүтэй зээл авсан аж ахуйн нэгж, за түүнд нөлөөлсөн нөлөө бүхий хүмүүс одоо тэр албан тушаалтнуудыг нэрлэж өгөхгүй юу? Энэ гурав дахь асуулт нь. Хоёр дахь нь яагаад ийм зөрүүтэй олгосон юм бэ? Хэдэн аж ахуйн нэгжүүд ам.доллороор бага хүүтэй, хэдэн аж ахуйн нэгжүүд төгрөгөөр өндөр хүүтэй, за тэгээд одоо ам.доллар, төгрөгийн балансын зөрүү нь бол энэ аж ахуйн нэгжүүд тэс өөр байна л даа. Энэ бол миний хувьд бол улс төрийн юм уу, аль нэгэн эрх мэдэлтний нөлөөлөл оржээ гэж хардах хардлага төрөөд байгаа юм л даа. Тэгээд энэ хоёр дээр эхлээд тодорхой хариулт өгчихгүй юу?

### **Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн Ж.Бат-Эрдэнэ:**

Хөгжлийн банк Мандуул хариулъя. 21 дүгээр микрофон.

### **Хөгжлийн банкны гүйцэтгэх захирал Н.Мандуул:**

Гишүүний асуултад хариулъя аа. Тийм ээ, таны зөв өө. Ханшийн талаар зөвлөгөө өгч ажиллах ёстой байсан банкны өөрийн үүрэг байсан. Гэхдээ сая бас Энхтайван дэд Ерөнхийлөгч хэллээ. 2017 оноос өмнө бол Монголбанк Хөгжлийн банкиг яг банк гэж үздэггүй байсан юм байна лээ. Тэр утгаараа ямар нэгэн своп хэлцэл тийм зүйл байхгүй явж байсан юм байна лээ. Тэгэхээр нэг талдаа бол яах вэ, Хөгжлийн банканд тийм арга хэрэгсэл байгаагүй болж таарч байна. Гэхдээ нөгөө талдаа энэ талаараа бас сайн ажиллаад, ийм том хэмжээний ам.долларын зээлүүдийг аж ахуйн нэгжүүдэд бас үүрүүлэх нь шударга бус байсан гэж би зүгээр өөрийн хувьд үзэж байна. Тухайлбал одоо энэ хоёр цементийн үйлдвэр байна. “МАК цемент”, “Монполимет”. Засгийн газрын тогтоол нь ам.доллартой тэнцэх төгрөгөөр зээл олгоо гэсэн шийдвэр гарсан юм байна лээ. Тэгээд яг банканд дээр гаргахдаа ам.доллороор зээл гаргасан. Зээлийн гэрээ, ам.доллороор зурагдсан. Нэг талдаа бол мэдээж хүчээр зуруулаагүй. Аж ахуйн нэгж өөрөө хэлцэлд сайн дураараа орсон. Гэхдээ нөгөө талдаа бас энэ талаар бас Монголбанк болон Хөгжлийн банкны хувьд хангалттай сайн ажиллаж чадаагүй ээ гэж үзэж байна.

Хоёрдугаар асуултын хувьд аж ахуйн нэгжүүдэд харилцан адилгүй нөхцөл тавьж байна аа гэдэг. Энэ асуудлыг бол бид бас эргэж судалж байгаа. Банканд дээр бол хувийн хэргийн бүрдэл бас нэлээн хангалтгүй байна. Энэ хүмүүсийн их орж, гардагтай холбоотойгоор зарим материалууд бас дутсан зэрэг зүйлс байна. Бид бол Авлигатай тэмцэх газарт 52 зээлийн материалуудыг чадах чинээгээрээ оригинал хувиар нь хуулбарлаж өгсөн. Үүнээс бол таны тэр хүсээд байгаа асуултын хариулт бас гарах болов уу гэж найдаж байгаа. Бидний хувьд бол бүх мэдээлэл бол аж ахуйн нэгжээрээ байгаа. Ер нь бол цаашдаа бас улс төрд нөлөө бүхий этгээдийн харилцан хамаарал, зэргийг судалж байж бас цаашаа зээлийн шийдвэрүүд гаргаж явах ёстой юм байна лээ банкны хувьд. Өмнө нь бол тийм зүйл байгаагүй байх аа гэж.

Зээлийн хүүгийн тухайд бол эх үүсвэртэйгээ уялдуулаад явчихсан гэж тайлбарладаг юм байна лээ. Тэгээд тэр эх үүсвэр, өртөг маань ингээд Монгол Улсын эдийн засгийн нөхцөл байдлаас шалтгаалаад хөдлөөд байсан. Тэгэхээр сүүлийн үед бол ингээд өндөр болоод, за өмнө нь бол бага байсан ч гэдэг юм уу. Гэхдээ үүнийг бас

нягталж шалгаж, яг үнэн үү гэдгийг нотлох ёстой. Тэгэхээр бид бол үүн дээрээ судалгаа хууль хяналтын байгууллагуудтай хамтраад хийж байгаа.

**Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн Ж.Бат-Эрдэнэ:**

М.Оюунчимэг гишүүний микрофоныг нээнэ үү.

**УИХ-ын гишүүн М. Оюунчимэг:**

Н.Мандуул захирал бодит асуудал ярьж байх шиг байна. Энэхүү ярианд дурдагдсан шударга бус хандсан байдал, улс төрийн нөлөөлөл зэрэг нь хууль хүчний байгууллагын анхааралд орж байгаа байх бодож байна. Миний хувьд 2018, 2019 оноос хойш манай улсын хууль, хүчний байгууллага, хэвлэл мэдээллийн салбарынхан энэ тал дээр идэвхтэй оролцож байгааг сайшааж байна. Энэ дээр цаашдаа маш тууштай байх ёстой. Яагаад гэвэл 2013 онд анх энэ асуудлыг гаргаж тавиад бүлэглэлийн өмнө хүчин мөхөстөж байсан эдийн засгийн эрэн сурвалжлах чиглэлээр ажиллаж байсан хүний хувьд хэлэхэд. Энэ дээр “Кью Эс Си” ХХК нь хамгийн их зээлтэй, таг байдаг энэ тухай дурдагддаггүй. “Мон Лаа” ХХК, “Монгема” ХХК, “Төрийн орон сууц корпорац”, “Сэлэнгийн Герефорд”, Голомт банкны Баясгалантай холбоотой зээл байна. Энэ хуралд оролцож байгаа “Эрэл” ХХК-ийн захирал Д.Эрдэнэбаттай холбоотой зээл дээр би маш эргэлзээтэй хандаж байгаа. Энэ бүгдэд эрүүгийн шинж чанар байна уу, үгүй юу гэдгийг хууль хүчний байгууллагаас асуух гэсэн юм. Ялангуяа “Эрэл” ХХК манай Чингэлтэй дүүргийн МҮОНРТ-ийн эсрэг талын газрыг дахин төлөвлөлт хийх нэрээр аваад 7, 8 жил болж байна. Бид барилга болон үйлдвэр дээр очиж үзсэн. Ийм их зээл авчихаад тэр үйлдвэр өнөөдөр ажиллахгүй байгаа. Дахиад надад зээл өгвөл би энэ үйлдвэрийг ажиллуулна гээд явж байна. Яагаад тэр газар шүүх дээр дахин дахин сэргээгдээд байгаа юм. Тэгээд өнөөдөр энд орж ирээд баатар шиг юм яриад сууж байна гэдэг бол болохгүй, энд ичих нүүртэй олон хүн сууж байгаа байх. Энд үнэнийг ярих ёстой. 2012-2016 онд ажиллаж байсан Монголбанк, Хөгжлийн банкны удирдлагууд хууль бусаар зээл аваад түүнийгээ мөрийтэй тоглоомд алдчихсан хүмүүсийг хууль хүчний байгууллага шалгаж байгаа болов уу, шалгах уу? Эдгээр асуултад хариулт авъя.

**Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн Ж.Бат-Эрдэнэ:**

Монгол Улсын Ерөнхий прокурор болон АТГ-аас асууж байна. 35 дугаар микрофоныг нээнэ үү.

**Монгол Улсын Ерөнхий прокурор Б.Жаргалсайхан:**

Гишүүний асуултад хариулъя. Хөгжлийн банктэй холбоотой асуудал хууль хяналтын байгууллагын гадуур үлдээгүй. Энэ тал дээр бид, бид гэдэг нь Авлигатай тэмцэх газрын дарга, Ерөнхий прокурорын зүгээс удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах үүрэгтэй. Энэ үүргийнхээ дагуу ажлын хэсэг гаргаж ажиллаж байгаа. Тухайлбал: Авлигатай тэмцэх газраас 11 мөрдөгч, Нийслэлийн прокурорын газраас 5 прокурор яг энэ тухайлан ажлын хэсэгт орж ажиллаж байна. Өнөөдрийн нээлттэй сонсголтой холбоотой олон зүйл яригдаж байгаа учраас би мөрдөгч, хяналт тавьж байгаа прокурорууд шалгах ажиллагаанд анхаарах асуудлууд нэлээн гарч байгаа гэж ойлгож байна. Сая би хажууд сууж байгаа Нийслэлийн Ерөнхий прокуророос тодруулж асуулаа. Яг энэ сонсголтой холбоотой асуудлууд дээр ажиллаж байгаа мөрдөгч, хяналт тавьж байгаа прокурорууд сонсож байгаа юу гэсэн яг Нийслэлийн прокурорын газар дээр Сонсголтой холбоотой

асуудлуудыг хяналт тавьж байгаа прокурор, мөрдөгч сонсож байна. Энэ бас тодорхой хэмжээнд мөрдөх ажиллагаанд шаардлагатай зүйлүүдийг тодруулах ажилд тодорхой дөхөм өгч байгаа гэдгийг энд хэлэхийг хүсэж байна.

Хүмүүстэй холбоотой асуудлууд тодорхой хэмжээгээр орхигдохгүй шалгагдана, шалгах ч ёстой. Хөгжлийн банк гэдэг энэ шалгагдаж байгаа асуудал бол маш том асуудал учраас нэгдүгээрт, ажлын хэсэг гаргаж ажиллуулсан, хоёрдугаарт, нэлээн том цар хүрээтэй тодорхой шалгалтуудыг хийж байж хэн нь гэм буруутай, хэн буруугүй гэдгийг мөрдөх байгууллага, прокурорын байгууллага шийднэ. Энэ чиглэлээр дахин давтан хэлэхэд анхаарч ажиллаж байгаа гэдгийг хэлье. Энд давхар бас хэлэхэд нийтдээ 22 хүн, 74 аж ахуйн нэгжтэй холбоотой асуудлыг шалгаж байна. Үүнээс 14 нь Хөгжлийн банк дээр ажиллаж байсан албан тушаалтнууд, 8 нь аж ахуйн нэгжтэй холбоотой асуудлууд байна. Түрүүн хөрөнгө хязгаарлах асуудлууд ярьж байна. Ер нь хөрөнгө хязгаарлах асуудлууд нэлээн сайн хийгдсэн гэж үзэж байна, надад ирж байгаа мэдээллээр. Тухайлбал: 47 аж ахуйн нэгжийн хувьцааны асуудал, 61 иргэний 674 үл хөдлөх хөрөнгө, 763 тээврийн хэрэгсэл, 25 үл хөдлөхийн хувьцаа, шилжилт хөдөлгөөнийг хязгаарласан.

Түрүүн “Бэрэн” групптэй холбоотой асуудал яригдаж байсан. Би сая Нийслэлийн прокуророос тодорхой мэдээлэл байна уу гээд асуусан. 91 хөдлөх хөрөнгө, 20 тээврийн хэрэгсэл нь шилжилт хөдөлгөөнийг хязгаарласан байгаа гэсэн мэдээллийг өгч байна. Товчхондоо ийм мэдээллийг хариулт болгож хэлье. Хариулт дууслаа.

**Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн Ж.Бат-Эрдэнэ:**

Авлигатай тэмцэх газрын дарга З.Дашдаваа хариулна уу.

**Авлигатай тэмцэх газрын дарга З.Дашдаваа:**

М.Оюунчимэг гишүүний асуултад хариулъя. Хөгжлийн банкнаас ирүүлсэн 52 зээлийг шалгаж байгаа. Дээр нь тухайн өгсөн зээлээр хязгаарлагдахгүйгээр төлсөн болон тодорхой хэмжээгээр төлөгдсөн зээлүүд болон бүх гаргасан зээлүүдийг хөөж шалгаж байна. Гэхдээ Хөгжлийн банкны гаргасан зээл болгоныг гэмт хэрэг гэж тооцож болохгүй. Бид зээл болгоныг албан тушаалын гэмт хэрэг зээлийг дагаад байна уу, зээлийг зориулалтын бусаар ашиглагдсан байна уу гэдгийг шалгаж үзэж байгаа. Иймээс тодорхой хэмжээгээр буюу 30 орчим аж ахуйн нэгжийн зээлийг Хөгжлийн банкны тухай хууль, тогтоомжийг зөрчсөн байна, дээр нь Эрүүгийн хууль тогтоомжийг зөрчсөн байна гээд мөрдөн шалгах ажиллагаа явагдаж байгаа. Хариулт дууслаа.

**Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн Ж.Бат-Эрдэнэ:**

М.Оюунчимэг гишүүн дахиад асууя.

**УИХ-ын гишүүн М.Оюунчимэг:**

З.Дашдаваа даргын тэр Хөгжлийн банкнаас гаргасан зээл болгоныг гэмт хэрэг гэж үзэж болохгүй гэдэгтэй санал нэг байна. Энэ дээр бас хэлэхэд албан тушаалтан юм уу, нөлөө бүхий хүмүүс өөрсдөө аргалаад өнгөрдөг, нуруун дээрээ валютын болон эрсдэл үүрч байгаа аж ахуйн нэгжүүд, зарим нь тэгээд улс төрийн намын харьяалалтай бол хохироод дуусах юмнууд байж магадгүй учраас иймэрхүү



зүйл дээр анхаарч ажиллах байх, хуулийн хүрээнд. Үүнээс гадна гэмт хэргийн шинжтэй зүйлүүд байгаад байгаа шүү гэдгийг хэлэхийг хүсэж байна. Зарим нэг зүйл дээр хариулт өгсөнгүй. “Эрэл” компанитай холбоотой асуудал эрүүгийн шинжтэй юу, үгүй юу, эсвэл энэ компани цаашдаа дахин төлөвлөлт дээр ороод ажлаа хийгээд явах бололцоо байгаа юу, үгүй юу гэдэгт хариулт авч чадсангүй. Энд бол жич хариулт өгөх байх гэж найдаж байна. Тэгээд ер нь бол тухайн үед буюу 2012 оноос 2016 оны Төв банк, Хөгжлийн банкны удирдлагууд ямар ч хяналтгүй гаргасан зээлүүд, эргээд ямар ч төлөлтгүй муу зээл чанаргүй, эрсдэлтэй, зориулалтын бусаар ашигласан гэсэн энэ гаргасан зээлүүд дээр тодорхой хариултууд өгч, ард түмэнд зөв мэдээлэх ёстой. Тэгэхгүй бол өнөөдрийн үнэ, ханш өсөөд иргэдийн амьдрал ямар байгаа билээ. Түрүүн хэлж байна Монгол банк Хөгжлийн банкныг банк гэж үздэггүй байсан. Тийм учраас Монголбанк хяналт тавих бололцоогүй байсан. Хөгжлийн банк ч тэгж хэлж байна. Энэ чинь 2012 оноос хойш зохион байгуулалттай явсан гэдэг ойлголт, хардлагыг төрүүлж байна.

Бас нэг зүйл нь Аудитын дүгнэлт дээр 740 тэрбумаас 1.2 их наяд төгрөгийг зөвхөн сурталчилгаанд зориулсан гэж бичсэн байна. Яг үнэхээр сурталчилгаанд зарцуулсан уу, эсвэл өөр зүйлд зарцуулсан юм уу? Сурталчилгаанд зарцуулахдаа яг ямар байдлаар зарцуулсан гэх мэтээр аудитын дүгнэлт хийхдээ гүйцэтгэлийн аудит хийсэн үү эсвэл ерөнхий дүгнэлтээр ийм дүгнэлт гарч байгаа юм уу, ийм их мөнгийг сурталчилгаанд зарцуулах уу? Энэ хэдийн хугацааны зүйл вэ, та нарын шалгах хугацааных байсан уу? Аудитын газраас хариулт авъя.

#### **Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн Ж.Бат-Эрдэнэ:**

Үндэсний Аудитын газар 36 дугаар микрофоныг нээе.

**Үндэсний Аудитын газар:** Хөгжлийн банкны зар сурталчилгаатай холбоотой асуудлыг 2013-2017 оныг дуустал шалгасан. 2013 онд 720 сая төгрөг, дараагийн жил 1.2 тэрбум төгрөг, дараагийн жил нь 791 сая төгрөг, дараагийн жил нь 1.2 тэрбум төгрөг тус тус дөрвөн жилийн хугацаанд зарцуулсан байгаа.

#### **Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн Ж.Бат-Эрдэнэ:**

Оролцогч нарт 5 минут хэлэх үг байгаа. Хууль хяналтын байгууллагууд өөрсдийнхөө өнцгөөс хуулийн дагуу асуудлаа шийдэж байгаа байх гэж бодож байна. Мэдээж Хөгжлийн банк нь экспортыг дэмжих, импортыг нөхөж олгох стратегийн шинжтэй зээлүүдийг олгож байгаа шүү дээ. Үүнийг аль аль тал нь хууль хяналтын байгууллага, Улсын Их Хурлын гишүүд, ер нь сонсголын хүрээнд хийж байгаа эрх бүхий байгууллагуудын илтгэл дунд байгаа шүү. Үүнийг аль аль талаас нь харах хэрэгтэй байх. Дараагийн Улсын Их Хурлын гишүүн Ч.Хүрэлбаатарын микрофоныг нээнэ үү.

#### **УИХ-ын гишүүн Ч.Хүрэлбаатар:**

Би хэд хэдэн асуулт асууна, өмнө нь бас үг хэлнэ. Хөгжлийн банкны үйл ажиллагаа болохгүй байна гэж 2015 оноос Улсын Их Хуралд бид цөөнх байхдаа ярьж эхэлсэн. Тэгэхээр өнөөдөр хэд үү, 7 жилийн дараа Хөгжлийн банкны болохгүй, бүтэхгүй зүйлийг яриад сууж байна. Бүхэл бүтэн 7 жил өнгөрсөн. 2015 онд болохгүй байна гээд бид нарыг хэлж байхад гүтгэж байна гээд хар будаг цацаж, элдвээр гоочилж байсан юм. Энэ банкныхан бол нэлээд асуудалтай, зээл авсан хүмүүс цаанаа. Дахиад юм болохгүй байна гээд хэлэхээр дахиад л хөлснийх нь

хөлслөгдөөд үүнийгээ хэлээд явна. Дахиад 7 жилийн дараа бид нар ямар нэгэн асуудал болохгүй байна гэдэг юм яриад суух эрсдэлтэй шүү. Тийм учраас хэдийгээр 2015 оноос хойш 7 жилийн дараа энэ асуудал эргэж яригдаж байгаад би үнэхээр баяртай байгаа. Нэн ялангуяа хэвлэлийнхэнд баярлалаа гэдгээ бүр онцолж хэлмээр байгаа юм. Бид нарыг хэлэхээр мөнгө төлөөд барьчихдаг, хэвлэлийнхэн дуугараад эхлэхээр үр дүнд хүргэж болдог юм байна гэдгийг харууллаа гэж бодож байгаа.

За дараагийн асуудал бол Н.Алтанхуягын худлаа ярьж ярьж байгаад гарч байна. “Хөтөл” ХХК-д олгосон зээлийг 2012 онд өгсөн ба өмнөх Засгийн газар олгосон, надад хамаагүй гэж хэлж байна. Та бүгд тэр илтгэлүүдийг үзээрэй. “Хөтөл” ХХК-д олгосон зээл бол 2015 оны 10 дугаар сарын 05-нд олгосон. 2012 оны 6 сард Улсын Их Хурлын сонгууль болоод Ерөнхий сайдаар түрүүн худлаа яриад байсан Н.Алтанхуяг гэдэг хүн гарсан байсан, энэ хүнтэй холбоотой. Гадаадын удирдлагын багийг мэдэхгүй байхад нь гараад явчихсан юм шиг юм ярьж байна. Би тийм ой санамж муутай хүн биш. Улсын Их Хурал дээр орж ирээд энэ гаднынхан бүтэхгүй, Монголчууд яагаад өөрсдөө юм хийж болдоггүй юм гэж хэлж байгаад хөөж гаргасан. Тэгж хэлж байсан, архивд ч тэр байгаа байх, хайгаад олох л тухай асуудал болов уу гэж бодож байна. Ийм учраас үнэн юм үнэнээрээ явахгүй бол болохгүй.

Дараагийн нэг асуудал бүх буруу зүйлийг 2017 оны хууль руу чихэж байна. Энэ бол худлаа шүү. Яагаад вэ гээч, 2016 оны Улсын Их Хурлын сонгуулийн дараа Хөгжлийн банкны олгочихсон олон зээлүүдийг улсын төсөв рүү оруулсан. Одоо энэ Хөгжлийн банкны захирал гээд байгаа Н.Мандуул өөрөө чи Сангийн яаманд байхдаа тэр Хөгжлийн банкны хаа хамаагүй олгочихсон зээлүүдийг төсөв рүү шилжүүлэх, улс руу шилжүүлэх ажилд өөрөө гар бие оролцож байсан болов уу гэж би бодож байгаа юм, Сангийн яаманд байхдаа. 2016 онд та бүгдэд тоог нь хэлье би, 3 их наяд төгрөгийн Хөгжлийн банкны олгосон зээлийг улсын төсөв рүү татаж авчирсан, та нар бод доо 3 их наяд. Одоо олгочихсон байгаа нь хэд үү, 3.3 их наяд төгрөг. Ийм их хэмжээний олгочихсон зээлүүд, Хөгжлийн банкны зээл нь тухайн үедээ цэцэрлэг, зам гээд хорвоогийн байхгүй юм байгаагүй, бүгдэд олгож байсан. Яагаад гэхээр улсын төсөв шиг байсан юм. Ийм зүйл явагдаж байсан шүү, тэгээд цаг хугацаа өнгөрчихөөр үнэн, худал юм ярьж байгаад тэр нүглийг алга болгочихно гэж бодож байгаа бол тэрэн шиг том эндүүрэл байхгүй гэж хэлье.

Улсын Их Хурал дахь Монгол ардын нам цөөнх байхад шалгалтад нь орж үзэж байсан хүний хувьд үүнийг би та бүгдэд хэлж байна. 2017 оны хуульдаа биш ямар нэг ийм зүйл хуульдаа байдаггүй. Ямар ч хууль гарсан, тэрийг завхруулж байдаг хэдэн хүн олддог. Тэр хуулийг завхруулдаг хүмүүс нь дараа нь мөнгөөр хэвлэлийнхнийг, улс төрчдийг, төрийн бус байгууллагынхныг худалдаж авч нохой шиг хуцуулж дайруулдаг. Ийм зүйл явсаар эцэст нь даамжирсаар байгаад Хөгжлийн банкны асуудал өнөөгийнх шиг зүйл үүсэж байгаа юм. Улсын Их Хурал Б.Баттөмөр даргаар ахлуулсан ажлын хэсэг гаргаад байна. Ялангуяа зээлийн барьцаатай холбоотой зүйлүүдийг нэлээн ярьж байна. Энэ зээлийн барьцааг чөлөөлсөн шийдвэр нэг л байгаа. Нийтдээ төрийг 180-аад тэрбум төгрөгийн хохиролд учруулаад зээлийн барьцааг бүгдийг нь чөлөөлсөн. 2017 оны 12 дугаар сарын 25-нд анх шүүхэд хандсан. “Юнайтед прожектс” групп, “Шинэ яармаг төсөл”-д нийлээд 2017 оны 12 дугаар сарын 25. Дээд шүүхээс 2019 оны 06 дугаар сарын 25-нд 20 объект, 2 газрыг зээлийн барьцаанаас чөлөөлсөн. Барьцаагүй зээл гэж ер нь юу байдаг юм бэ? Барьцаагүй зээл болоод үлдсэн тэр 180-аад тэрбум төгрөгийн хэмжээгээр төр хохирч байгаа. Яагаад төр өөрөө улсыг ингэж хохироож байгаа юм. Яагаад шүүх анхан шатны шүүхээс эхлүүлээд дээд шүүх хүртэл явахдаа зээлийн

барьцааг чөлөөлдөг юм. Тэгээд барьцаагүй болчихсон зээл чинь чанаргүй зээл, муу зээл болчихсон өнөөдөржингөө л энд Монголбанк, Сангийн яам, Аудитынхны илтгэл дээр гарч байна. Тэгэхээр Б.Жаргалсайхан прокуророос асууя гэж бодож байна. Ингээд зээлийн барьцааг чөлөөлөөд төрийг хохиролд учруулчихсан энэ хүмүүсийг яах юм бэ, шүүгч нар. Энэ бүх хэрэг Х.Баттулгыг Монгол Улсын Ерөнхийлөгч байхад болсон зүйл. Би шүүхэд нөлөөлсөн байх гэж бодож байгаа. Би хардах эрхтэй. Тамгын дарга байсан хүн нь нөлөөлсөн үү, өөрөө нөлөөлсөн үү, мөнгө төгрөг өгөгдсөн үү мэдэхгүй. Тэгэхдээ зээлийн барьцааг чөлөөлж, улсын хохиролд учруулсан энэ хэргийг ямар нэгэн байдлаар одоо шалгагдаж байгаа юу гэдгийг би асуумаар байгаа юм.

Дараагийн нэг зүйл бол аудитын дүгнэлтэд гарлаа, Хөгжлийн банкны байрыг 20 орчим тэрбум төгрөгөөр, зах зээлийн үнээс өндөр худалдаж авсан гэдэг зүйл яригдаж байгаа. Үүнийг 2015 оноос л хойш ярьж байгаа, 7 жил яригдаж байна. Энэ дээр хэрэг үүсдэг юм уу, шалгадаг юм уу, шалгагдаж байгаа юм уу, тэгж болдог юм уу. Энэ талаар Ерөнхий прокуророос мэдээлэл авъя.

3 дахь зүйлийг Монголбанкнаас асууя. 2018 оны 07 дугаар сарын 20-нд Хөгжлийн банкиг шалгасан юм байна. Монголбанкны дүгнэлтүүд зүгээр л гэж байсан байна. 3 жилийн дараа 2021 онд хийсэн шалгалтаар 755.7 тэрбум төгрөгөөр эрсдлийн сан байгуул гэдэг зөвшөөрөл олгосон байна. Гэтэл энэ Хөгжлийн банкны чинь чанаргүй зээл, муу зээл нь 1.4 их наяд ч юм уу, 1.7 их наядар байгуулагдчихсан энэ дээр явж байна шүү дээ. Тэгвэл яагаад 1.4-өөр нь эрсдлийн санг байгуулахгүй түүний талаар байгуулж байгаа юм. Бид нар 2015 онд шалгаж байхад бид нар болохгүй байна, буруу байна гэдэг зүйл хэлээд байхад 2018 онд шалгачхаад зүгээр байна гэж яагаад хэлж чадаж байна аа Монголбанк аа. Тэгчихээд буруутанг бусдад наадаг, нөгөө зээл авсан хэдэн хүнийг улалзуулаад явж байх шиг байна. Болохгүй бүтэхгүй байгаа юм бол яагаад тэр үед нь хэлж байгаагүй юм. Яагаад болохгүй, буруу зүйлийг буруу, болохгүй байна гэж яагаад хэлж болдоггүй юм, яахав муулуулна л биз нэг хэсэг. Гэхдээ та бүгд өөрсдөө хэлж байх ёстой шүү дээ. Тэгэхээр би та бүгдийг Монголбанкийг энэ хулгайтай, энэ луйвартай гар бие оролцож, хамтарч явж байсан байх гэж бодож байгаа юм. Яах вэ хэдэн мөнгөн дуртай хүнд мөнгө төлөөд муулуулах л биз. Тэглээ гээд та бүгд үүнийг дагаад байх шаардлага байхгүй шүү дээ. Яагаад та бүгдийн дүгнэлт энэ дээр өөр байгаад байгаа юм?

Дөрөв дэх асуулт. Сая тэр Хөгжлийн банкны захирал Н.Мандуул 750-аад тэрбум төгрөгийн зээлийг улсын төсөв рүү шилжүүлнэ гэж байна. Тийм юм байхгүй. “Шинэ яармаг” гээд тэр Женко Х.Баттулгатай холбоотой зүйлүүдийг улсын төсөв рүү шилжүүлнэ гэж байхгүй. 2016 онд 3 их наядыг шилжүүлсэн та нар. Одоо дахиад 750 тэрбум төгрөг хийж, урд өмнө нь хийж байсан тэр луйврыг дахиад давтах гэж байна уу? Тэр шилжүүлсэн үеийн бүх үйл явдлыг уг нь шалгах ёстой юм. Тэр дотроос их юм гарна. Тэгэхээр Н.Мандуул аа, чи тэр чанаргүй зээлүүдийг улсын төсөв рүү өгнө гэдэг энэ зүйлээ зүгээр татаж аваарай эртхэн шиг. Яагаад гэхээр улсын төсөв энд тэндхийн хогуудыг авч санхүүжүүлж байдаг, дарж байдаг зүйл биш. Улсын төсөв татвар төлөгчдийн мөнгөөр орж ирдэг мөнгө. Хаа хамаагүй чанартай, чанаргүй зээл олгоод зээлийн барьцаануудыг нь суллуулчихаад одоо үлдсэн зээлийг нь улсын төсөв дээр авчирна гэж юу яриад байгаа юм. Тийм зүйл байхгүй шүү. Тэгээд ер нь энэ тал дээр зээл авсан хүмүүст янз бүрийн юм нь бас хэлэмгүй байна. Хамгийн гол нь Төрийн байгууллагууд, улс төрчид өөрсдөө хэлэх ёстой үгээ цагт нь хэлж бай, 7 жилийн дараа ухаантай юм яриад хэнд ч хэрэггүй, бүх юм хохирол өнгөрчихсөн. Өмнө нь урьдчилж хэлж, адлагдаж бай, хамаагүй. Харин төрийн байгууллагууд энэ

бүх хүмүүсүүдтэй гар хөлөө нийлүүлж явж болохгүй шүү. Би үүнийг хэлье. Тэгээд асуултдаа хариултыг би ганцхан Б.Жаргалсайхан прокуророос авъя.

**Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн Ж.Бат-Эрдэнэ:**

Монгол Улсын Ерөнхий прокурор Б.Жаргалсайхан хариулъя.

**Монгол Улсын Ерөнхий прокурор Б.Жаргалсайхан:**

Ч.Хүрэлбаатар гишүүний асуултад хариулъя. Хөгжлийн банктэй холбоотой хэрэгт холбоотой ажлын хэсэг өмнө нь шийдэгдсэн 50 гаруй хэргийг хянасан. Энэ хэргүүдээс 19 хэргийг сэргээсэн. Тухайн үед яагаад энэ хэргүүд, жишээлбэл: хэрэг бүртгэлтийн хэрэг хаагдсан, эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзаж хаасан байсан юм гэхээр зориулалт нь яг зориулалтынхаа дагуу зарцуулж байсан, дээр нь хүү төлөлт нь хугацаандаа байсан гэдэг үндэслэлээр хааж хэрэгсэхгүй болгож байсан юм байна лээ. Одоо тэр үеэс хойших хугацаанд хэргүүдийг зайлшгүй хянаж, тухайн тэр нөхцөл байдлаасаа хойш ямар нөхцөл байдал болсон юм бэ гэдгийг зайлшгүй хянаж үзэхээс өөр аргагүй ийм нөхцөл байдал үүссэн учраас хянасан юм. Одоогийн байдлаар 19 хэрэг хянагдаж байна. Би тодорхой хэргийн нарийн мэдээллийг одоо яг хэрэг бүртгэх, мөрдөн байцаалтын ажиллагаан дотор явж байна уу, үгүй юу гэдэг мэдээллийг бол аваагүй байна. Тийм учраас эргэж танд мэдээлэх шаардлага гарч байна гэж үзэж байна. Түрүүн Мөнхцэцэг гишүүн ч гэсэн бас ярьж байна, “Бэрэн” групптэй холбоотой үл хөдлөх хөрөнгүүд зарж борлуулагдаж байна гээд. Тийм учраас би дахин давтан хэлэхэд ажлын хэсэг энэ яригдаж байгаа энэ зүйл дээр анхаарал хандуулах болно оо гэдгийг хэлье. Хариулт дууслаа.

**Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн Ж.Бат-Эрдэнэ:**

Ч.Хүрэлбаатар гишүүн тодруулах уу?

**УИХ-ын гишүүн Ч.Хүрэлбаатар:**

Би ерөөсөө бусдыг нь асуугаагүй, ганцхан тэр зээлийн барьцааг чөлөөлсөн тухай асуудлыг ярьж байгаа юм. 2017 оны 12 дугаар сарын 25-нд анхан шатны шүүх дээр тэр “Юнайтед Прожектс” дээр “Шинэ яармаг төсөл”-тэй холбоотойгоор зээлийн барьцааг чөлөөлөх үйл ажиллагаа эхэлсэн юм байна лээ, шүүх дээр. 2019 оны 06 дугаар сарын 25-нд Дээд шүүхийн шийдвэр гараад 20 объект, нэг билүү хоёр газрыг зээлийн барьцаанаас чөлөөлсөн. Тэгэхээр барьцааг нь чөлөөлчихлөөр үлдсэн зээл нь муу зээл болоод хувирчихсан байгаа юм. Тэр хэмжээгээр төр хохирч байгаа. Үүнтэй холбоотой хэрэг үүсэж тэр шүүгч нар дээр, тэр шүүгч нарт нь нөлөөлсөн хүмүүс дээр нь хэрэг үүсгэж шалгаж байгаа юу л гэж асуусан ганцхан асуулт, өөр юм асуугаагүй.

**Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн Ж.Бат-Эрдэнэ:**

Б.Жаргалсайхан Ерөнхий прокурорын 35 дугаар микрофоныг нээе.

**Монгол Улсын Ерөнхий прокурор Б.Жаргалсайхан:**

Би бас хариултадаа хэлсэн. Хоёр асуудал яригдаж байна. Нэг нь Мөнхцэцэг гишүүний тэр “Бэрэн” групптэй холбоотой асуудал, сая таны ярьсан энэ

асуудлуудыг би өдөр бүр хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд бас оролцдоггүй учраас тодруулж эргэж танд тухайлан танилцуулъя гэж хариулт хэлсэн.

**Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн Ж.Бат-Эрдэнэ:**

Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн гишүүн асуулт асууя.

**Ажлын хэсгийн гишүүн, УИХ-ын гишүүн Ц.Даваасүрэн:**

Би ажлын хэсэгт ажилласан учраас нэг их олон зүйл асуухгүй. Хөгжлийн банктэй холбогдолтой асуудлаар шалгалт хийж байгаа, хамаарал бүхий зээлдэгч байгууллагууд байгаа учраас би зарим нэг зүйлийг хэлье гэж бодоод байгаа юм. Ингээд шалгаад үзэхэд дэндүү гоомой хандсан гэх юм уу, ийм зүйлүүд Хөгжлийн банканд дээр гарсан байгаа юм. Төлөөлөн удирдах зөвлөлүүдийн гаргасан шийдвэрүүд, сүүлдээ захирал нь 6 тэрбумаас доош олгодог болчихсон. Тэгэхээр энд хоёр хугацаа байгаа юм. Манай хүчний байгууллагынхан энэ тал дээр анхаарахад гэмгүй. Ямар зээлүүд хүнд байдалд ороод, эзэнгүй холбогдоггүй болчихсон зээлүүд ч байгаа. Эзэнгүй холбогдохгүй болчихсон малууд ч байгаа гэж ярьсан шүү дээ, тэрэн шиг. Тэгэхээр 2017 оны 07 дугаар сараас 09 дүгээр сарын хооронд бөөнөөр нэг хэсэг олгосон байгаа. 2017 оны 12 дугаар сард /оны төгсгөлд/ бөөнөөр олгосон байгаа юм. Энэ олгосон зээлүүд нь зээлд тавигдах шаардлага, Хөгжлийн банкны хуулийн шалгууруудыг хангаагүй байсан, одоо хамгийн асуудалтай байгаа зээлүүд бол энэ зээлүүд. Тэгэхээр үүнийг шалгаж, тодруулж байх явцад бас ажлын дэд хэсгээс зарим улсууд эргэж буцсан юмнууд гарсан. Тэгэхээр энэ бидний гарсан тайлан, дүгнэлтэд орсон юм. Дараа нь шалгагдаад гарсны дараа зөрөх юм болбол энэ нөлөөлөлд орсон, энэ ажлын дэд хэсэгт ажилласан улсуудыг хариуцлага хүлээнэ шүү гэж хэлж байгаа. Тийм учраас энэ холбогдох хуулийн байгууллагууд ч гэсэн анхаарах хэрэгтэй. Ямар нэг байдлаар үүнийг цайруулах үйл ажиллагаа явуулж болохгүй. Зөндөө сануулсан би ажлын дэд хэсгийнхэнд. Тийм хандлагууд бас гарч байна, гарсан. Тийм учраас тэр улсууд бол одоо холбогдох газруудад өөрсдийнхөө тайлбарыг өгөх хэрэгтэй. Яагаад өмнөх шалгалтын материалууд дээр буруу байсан юмыг зөв болгож оруулаад ирээд байгааг хууль хяналтын байгууллагуудад очиж тайлбар өгөх хэрэгтэй. Энэ дээр аль аль талдаа хариуцлагатай хандахгүй бол болохгүй. Ингээд өнгөрөөх юм бол дахиад л энэ луйвар гарна. Сая би тойрогтоо ажиллахад ерөөсөө тэгж байна шүү дээ, та нарыг сонгоод өгдөг, та нар ингээд банк дээрэмдэж байна гэж. Тийм учраас энэ одоо асуудалд цэг тавихын тулд маш нарийн, ялангуяа миний тэр хэлсэн шалгуур хангаагүй байхад олгосон зээлүүдийн энэ асуудлыг сайн үзэх хэрэгтэй. Энэ бол цэвэр улс төрийн нөлөөлөлтэй гэж ажиглагдаж байгаа, энэ зээлүүд дээр бол. Шалгуур огт хангаагүй байхад олгочихсон зээлүүд байгаа. Энийг анхаараач гэж би холбогдох байгууллагууд бас хэлнэ.

Энэ дампуурах гэж байгаа явцгүй болчихсон банкнууд руу ямар шийдвэрээр шилжүүлсэн юм бэ гэдгийг чинь ер нь нягталж үзэх хэрэгтэй юм байна лээ. Хөгжлийн банк, Капитал банк, Чингис банк мөн DBM leasing-ээр дамжуулж олгосон зээлүүд их асуудалтай зээлүүд байгаа юм. Хоёр зээлээс бусад нь төлөгдсөн. Тэгээд бид нар үүний цаана юу байсан юм гэдгийг шалгаж нэгтгэж хүчний байгууллага ч чадахгүй шүү дээ. Ер нь ямар учир шалтгаан байв, ямар дүрэм журам зөрчив гэдэг хүрээнд л шалгалт явагдана. Тийм учраас энэ шалгуур хангаагүй олгогдсон зээлүүдийн хувьд анхаарал татаж байгаа юм гэдгийг хэлье гэж бодож байна. Энэ зээлүүд дотор бас сайн зээлүүд байгаа. Төлөлт нь хүндэрчихсэн болохоос биш тэр “МАК цемент” ХХК-

ийн зээл байна, “Монполимет” ХХК-ийн зээл байна, “МИАТ” ТӨХК-ийн онгоцны зээл, ТЭЦ-4-ийн эрчим хүчний эрэлт хэрэгцээг хангаад явж байгаа зээл байна. Мөн тэр муугаар дуудагдаад байгаа боловч “Бэрэн” ХХК-ийн зээл чинь Монголчууд бидний хийж чадаагүй төмөрлөгийн үйлдвэрийг л хийсэн юм байгаа юм лээ шүү дээ, бид нар Сайдынх нь яг энэ зээл дээр хийсэн шинжээчийн дүгнэлтийг авч үзсэн байгаа, ширэм гаргадаг юм байна лээ. Улсынхаа хийж чадаагүйг л хийх гэж оролдсон байна лээ. “Эрэл” ХХК байна, тэгэхдээ би “Эрэл” ХХК-ийн нэг зүйл дээр эргэлзээ төрлөө. Би бол үнэтэй юм байна гэж бодсон байхгүй юу, тийм учраас одоо энэ цутгамал байшин хямд учраас энэ байшингийн үйлдвэрлэл явагдахгүй байгаа юм гэж ойлгосон. Өнөөдөр өөрөө хэлэхдээ хямд гэж байна. Хямд юм бол заавал улсыг харж суух хэрэг юу байна. Захиалгаа аваад хувийн хэвшлийнхэн байшин барилга барьдаг шиг, зээлээ төлөх санаачилга гаргах хэрэгтэй байсан юм биш үү. Хэрвээ тийм сайхан төсөл юм бол улс руу та нар ингэсэн гээд байх биш, өөрөө зээл авсан учраас. Бид нарт тайлбарлахдаа энэ бол үнэтэй гэж тайлбарласан. Одоо байшин босоод ирэхээр үнэтэй болчихоод байгаа юм (энэ цутган байшингуудаас) тийм учраас энийг одоо зээлээ төлөхөд хүндрэл учирдаг юм байна, захиалга ирдэггүй юм байна гэж ингэж ойлгуулсан. Тэгээд энэ дээр арай л өөр юм явагдаж байна.

Огт эзэн холбогдогчгүй болчихсон зээлийг хэн төлөх юм бэ гэдэг зээлүүд ч байх юм. Энийг одоо анхаарах хэрэгтэй. Одоо хэн төлөх вэ? Зээл авчихаад өөр хүний компани руу шилжүүлээд хаячихсан байна. Үүнийг та нар тодруулж болох байх. Тэр компани чинь нэг газар байрлаж байгаа шүү дээ. Тэрүүгээр нь хөөж бариад тэгээд эзэн холбогдогчийг нь олоод, тогтоох ажлыг бид нар хууль хүчний байгууллага биш учраас хийж чадаагүй. Бидний нэг гол хийсэн юм бол яг юу хийж вэ, яг юм байгаа юм уу, үгүй юм уу гэдгийг өмнөх шалгалтуудаас ялгарсан гэж үзэж байна. Хэдэн хувьтай байгаа юм. Нөгөө нэг юм бол баталгаа. Баталгаагүй олгогдсон 11 зээл байгаа шүү дээ. Ирээдүйд олох орлогоор, ирээдүйд худалдаж авах тоног төхөөрөмжөөр барьцаалсан зээлүүд байж байгаа. Энэ зээлүүдийн баталгааг хангах асуудал дээр бас анхаарсан байгаа. Түрүүн энд яригдаад байгаа, гишүүдийн хэлээд байгаа орон сууц барьцаалсан зээлүүд дээр Хөгжлийн банкныхан анхаарахгүй бол болохгүй, нэг орон сууц байгаа гээд ингээд байж болохгүй, тэр Шинэ яармаг хороолол дээр ч тэр. Зарчихдаг дараа нь иргэн, банк хоорондын маргаан болоод явчих ийм зүйлүүд байгаа учраас хэдийгээр шалгалт явж байгаа гээд тайвшрахгүйгээр хөрөнгийн баталгаа гаргах асуудал дээр анхаарах ёстой. Үндсэн хөрөнгийн баталгаагүй олгосон зээлүүд байгаа, эдгээрийг баталгаатай болгох хөрөнгөжүүлэх энэ чиглэл дээр. Цаашдаа ингээд Түр хороо байгуулаад явах юм бол нэг анхаарах ёстой юм бол бас холбогдож шалгаж байгаа байгууллагууд хамтарч ажиллахгүй бол болохгүй байгаа юм. Жишээлбэл: бид сая шалгалтын материал гэхээр АТГ аваад явчихсан гэх юм, үнэн юм уу, худлаа юм уу мэдэхгүй. Тэгээд бид нарыг аргалчих юм байна ш дээ. Аваад явчихсан материалыг бид үзэж чадахгүй, худлаа хэлээд байгаа юм уу. Тэгээд яахав байгаа хуулбарласан материалууд дээр л ажиллана шүү дээ. Тийм учраас цаашдаа хэрвээ Түр хороо байгуулагдаад ч юм уу, энийг нягтлах шаардлагууд гарах байх. Тэгэх юм бол хоорондоо нэлээн уялдаатай ажиллахгүй бол буруу зөрүүтэй ойлголт хүрэх юмнууд гарч магадгүй юм байна лээ гэдгийг хэлье.

Эцэст нь өмнө нь хийгдсэн зөндөө олон шалгалтууд, зөвлөмж дүгнэлтүүд гарсан. Тэгэхдээ тэр хэрэгжээгүй. Тэгэхээр одоо хэрэгжих үү гэдэг асуудлыг л бид нар хариулт өгөх хэрэгтэй, яаж хэрэгжих юм. Шинэ удирдлага тавилаа, зүгээр яах вэ хуучин удирдлагуудыг нь шалгах шаардлагатай болоод шинэ удирдлага тавьчихсан уу яасан. Эд нар чинь түүхээ мэдэхгүй байгаа байхгүй юу. Яг юу болсныг нь сайн мэдэхгүй байгаа юм. Бид нар дуудаад яг юу болсныг тодруулах гэхээр яг

нарийн сайн мэдэхгүй болчихоод байгаа юм. Энэ нь баллуурдсан юм болчих вий. Нөгөө улсууд нь ингээд одоо үүрэх юм уу үүрээд, тэгээд чив чив үгүй алга болоод сүүлдээ ингээд одоо тайлбаргүй холбогдох эзэнгүй нэг ийм юм болох гэж юм байна. Тийм учраас өнөөдрийн энэ сонсгол ч тэр аль нь ч тэр цаашдаа дүгнэлт гараад явлаа ч гэсэн ер нь өмнө нь зөвлөмж, дүгнэлт хэрэгжээгүйг одоо хэрэгждэг болох чиглэлд бид юу хийх ёстой юм бэ гэдэг дээр анхаарах ёстой юм шиг байна лээ. Тэрнээс биш сенсац болгоод яриад ингэхдээ биш. Үүнийг эцсийн цэг тавихгүй бол ЖДҮ, Хөгжлийн банкны асуудал. Энд бол нийгэм үнэхээр дургүйцэж байгаа шүү дээ, үнэхээр дургүйцэж байгаа. Хувьдаа зээл авчихсан, ялангуяа улс төрчид гээд, тэгээд нөлөө орчихсон. Ялангуяа Хөгжлийн банкн дээр шалгуур хангаагүй олгосон зээлүүдийг нэг бүрчлэн үзэх хэрэгтэй. Яагаад шалгуураа хангаагүй байхад нь олгочихов. Бусад нь гүйгээд гүйгээд авч чадахгүй байгаа шүү дээ. Хэчнээн хүсэлт тавиад монголд хэрэгтэй юм хийе гэсэн хүн зээлээ авч чадахгүй байгаа шүү дээ. Тийм улсууд бас бид нар руу ярьж байна лээ. Бид нар ингээд авч чаддаггүй байсан шүү дээ. Би одоо ингээд ноосоор хийх гэсэн, ерөөсөө авч чаддаггүй байсан юм, ингээд та нар чинь хэдэн тэрбумаар нь авчихдаг юм байна шүү дээ гээд. Энд бол цэг тавих ёстой. Тэгж л одоо бид нар энэ шалгалтыг, сонсголыг хийж байгаа гэж би ингэж ойлгож байгаа юм. Баярлалаа.

### **Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн Ж.Бат-Эрдэнэ:**

Ц.Даваасүрэн гишүүн санал хэллээ. Ажлын хэсэг дотор ажиллаж байгаа Б.Бат-Эрдэнэ гишүүн, С.Чинзориг гишүүн, Ц.Даваасүрэн гишүүн, Б.Баттөмөр гишүүд ерөнхийдөө саналуудаа хэллээ, танилцуулгаа ч хийлээ. Дараагийн гишүүн Ц.Цэрэнпунцаг гишүүны микрофоныг нээе.

### **УИХ-ын гишүүн Ц.Цэрэнпунцаг:**

Надад гурван асуулт байна. Нэгд, Хөгжлийн банкныхнаас асууя. Шинэ удирдлага нь байгаа юм шиг байна, үүх түүхийг нь мэдэж байгаа байлгүй дээ. Хөгжлийн банк өөрөө хуультай. Тэгээд энэ хуулиа яагаад ер нь хэрэгжүүлдэггүй юм бэ? Хөгжлийн банк менежмент нь бол уул нь Олон улсын нээлттэй сонгон шалгаруулалт явуулаад менежментээ сонгох ёстой гээд, энэ яагаад өдий болтол хэрэгждэггүй юм бэ, энийг тодорхой хариулна шүү. Хоёрдугаарт, 2012 онд гадаадын менежментийн баг ажиллаж эхэлсэн юм байна. Тэгээд энийг солиод хаячихсан байна. Тэгээд улс төрчид өөрсдийнхөө хамааны хүмүүсийг тавьсан юм байна. Үүнийг яг ямар улс төрчийн зааварчилгаагаар, ямар улс төрч гол шийдвэр гаргаад, ер нь хэн Ерөнхий сайд байсан юм бэ, үүнийг хэн хийсэн юм. Энэ хоёр асуултыг Хөгжлийн банкнаас асууя.

Хоёрдугаар асуулт, Ерөнхий прокурор байгаа учраас нэг асуулт асуучихъя. Энэ одоо хохирогч, гомдол гаргагч нь мэдээж Хөгжлийн банк л байгаа байх, зээлээ олж авах гэж байгаа. Тэгэхдээ Монгол Улсын нийт татвар төлөгчид Монголын ард түмэн хохирогч болчихоод байна шүү дээ. Тэгэхлээр энэ нийтийн эрх ашиг зөрчигдөж, хохирогч болчихоод байгаа учраас Ерөнхий прокурор энэ дээр ажиллаж хохирогчдыг нэг бүрчлэн тодорхойлох хэрэгтэй байх гэж бодож байна. Татвар төлөгчид хохирогч болсныг хэн ч зөвшөөрнө, маргахгүй. Харин энэ шударгаар бизнесээ хийгээд, ажлын байрыг бий болгосон, найдвартай, буцаад авсан зээлээ төлчихөөр сайхан төсөл, хөтөлбөрүүд хийгээд энэ банкн дээр гүйж очоод цаас бичиг цаасыг нь өгөөд хад мөргөсөн хэчнээн бизнесүүд байгаа юм, энэ бүгдийг хохирогчид үзэх үү? Үзсэн бол энэ бүх зээлүүдийн явсан түүх, архив нь гаргаж ирээд энэ олгосон зээлүүдтэй цуг тэр зээлүүдтэй өрсөлдөж, энэ бүх аж ахуйн нэгжүүдийг

бүгдийг нь одоо жагсаалт болгож энэ хохирогчдод оруулах ёстой. Энэ боломжтой юу, хуулийн процессыг хийх ажил нь ийм хүндрэлтэй юм байдаг юм уу, одоо ингээд бичиг баримтыг нь устгаад хаячихсан юм байдаг юм уу? Би энэ бүгдийг бас тодорхой хариулт авмаар байна, Прокуророос.

Гуравдугаарт, Зээлдэгч талаас бизнесийнхээ талд ярина. Эд нар чинь очоод та нарт буу тулгаж байгаад энэ мөнгийг аваагүй байх. Тэгээд өгсөн тал нь ерөнхийдөө хариуцлага хүлээх ёстой. Ер нь Хөгжлийн банкны тухай хуулинд байгаа харилцагчдаа энэ банк нь уул нь хамгаалах ёстой, зөвлөгөө үйлчилгээ үзүүлнэ гээд байж байна. Хөгжлийн банкны хуулийн 8.1.8-д байна шүү дээ. Зарим бизнесүүд нь улс орны хөгжилд хэрэгтэй том төсөл, хөтөлбөр хэрэгжүүлээд, зээл аваад эрсдэлээ үүрээд, өөрсдийн хөрөнгөөрөө эрсдэл гаргаж хөрөнгө оруулалт хийгээд зөвхөн Хөгжлийн банкнаас ч биш одоо бусад гадаадын банкнаас аваад өр, зээлээ төлөөд, ажлын байр хэдэн мянгаар нь бий болгоод, хэдэн арван зуу, тэрбумаар нь татвар төлөөд явж байгаа тэр зээлдэгчдээ яагаад та нар ингээд энэ автобусны доогуур шиднэ гэдэг шиг ийм юм хийгээд байгаа юм бэ. Яллагч болгоод дуудуулаад, олон нийтийн өмнө цоллуулаад. Жишээлбэл: “Монполимет” ХХК үлгэр жишээ, сайн зээлдэгч байна шүү дээ. Энэ ямар эрсдэлд орсон юм. Зээлийн эрсдэл биш шүү дээ. Энэ чинь бизнесийн эрсдэл биш. Ханшийн эрсдэлд орчихсон. Энэ ханшийн эрсдэл үүрч байгаа нь хэний буруу юм. Зээлдэж авсан зээлдэгчдийн буруу юм уу? Монголбанкны ганц ажил нь тийм үү, хууль байгаа биздээ, уншиж болно шүү дээ. Монголбанкны үндсэн зорилт нь үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгийн тогтвортой байдлыг хангахад оршино гэж. Монголбанк өөрөө ажлаа хийгээгүй, энэ ханшийг нь савуулж хаячихаад, тэгээд ханшны эрсдэлд орчихсон бизнесээс Хөгжлийн банк олон тэрбумын алдагдлыг нэхэж байгаа юм байна гэж би ойлгосон. Тэр компаниас хүн байвал нэг тайлбар өгөөрэй. Нөхцөл байдал нь ямар байгаа юм. Яг одоо хэдэн төгрөгийн зээл эрсдэлд орсон, юунаас болж үүссэн юм. Ийм юмнуудыг ялгаж салгах хэрэгтэй. Бизнесүүдрүүгээ мууг нь чихдэг. Увайгүй улс төрчидтэй нийлсэн хэдэн хүмүүсийн ажил болоод л хохирогч нь хамгийн муу нэрийг зүүдэг нь бизнесийнхэн болоод байна. Тэгэхээр үүнийгээ нэг ялгаж салгаж бас ойлгомоор байгаа юм. Энэ гурван асуултад хариулт авъя.

#### **Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн Ж.Бат-Эрдэнэ:**

Хөгжлийн банкны 21 дүгээр микрофоныг нээе.

#### **Хөгжлийн банкны гүйцэтгэх захирал Н.Мандуул:**

Гишүүний асуултад чадахаараа хариулъя. Хөгжлийн банкны хувьцаа эзэмшигчийн эрх, үүргийг Сангийн яам хэрэгжүүлж байгаа. Тэгэхээр миний хариулж чадахгүй байгаа асуултад Сангийн яамнаас хариулж болох байх. Солонгос захирлын хувьд бидэнд байгаа мэдээллээр 2011 оны 09 дүгээр сараас 2012 оны 07 дугаар сар хүртэл ажилласан юм байна. Тухайн үед ТУЗ-ийн дарга нь Шинэбаатар гэж хүн байсан. Тэр үеийн хуулийн зохицуулалтаар бол ТУЗ-аа Засгийн газар шууд томилдог, ТУЗ нь гүйцэтгэх захирлаа томилдог байсан. Түүнээс хойш сайн мэдэхгүй байна. Манай одоогийн шинэ удирдлагын хувьд бол бүгд үүрэг гүйцэтгэгчээр ажиллаж байгаа. Шууд хэлэхэд ний нуугүй хэлэхэд яг ийм хүндэрсэн банкн дээр одоо шууд гадны мундаг менежмент хүрээд ирэх нь юу бол, гэхдээ тэрийг хувьцаа эзэмшигч шийдэх асуудал байх.



**Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн Ж.Бат-Эрдэнэ:**

Ц.Цэрэнпунцаг гишүүн тодруулъя.

**УИХ-ын гишүүн Ц.Цэрэнпунцаг:**

Энэ шийдвэрийг ямар улс төрч гаргасан юм бэ гэж асуусан шүү дээ. Тэр цаг хугацааг нь мэдэж байгаа юм бол хэн нь ямар Засаг байсан юм, ямар Ерөнхий сайд байсан юм. Энэ мэдээж дээрээс л явсан байгаа шүү дээ.

**Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн Ж.Бат-Эрдэнэ:**

Д.Жавхлан гишүүн нэмж хариулт өгье.

**УИХ-ын гишүүн, Сангийн сайд Д.Жавхлан:**

Ц.Цэрэнпунцаг гишүүний асуултад нэмж хариулт өгье. Солонгосын хөгжлийн банк С.Батболд Ерөнхий сайдын Засгийн газрын үетэй гэрээ хийгээд 2011 оны 09 дүгээр сарын 16-нд Ким Жан Жин гэж ахлагчтай баг ирж ажилласан, Хөгжлийн банкн дээр. Энэ гэрээ үргэлжилж яваад 2013 оны 07 дугаар сарын 16-нд дуусгавар болоод буцжээ. 2012 онд дараагийн Засгийн газар гарч ирж ажилласан, тэр үед Н.Алтанхуяг Ерөнхий сайд, Засгийн газрын хувьцаа эзэмшигчийг тухайн үеийн Эдийн засаг хөгжлийн яам буюу Б.Батбаяр сайд эрхэлж байжээ. Ийм хоёр Засгийн газар, хоёр Сангийн сайдыг дамжсан байна. Хуулиараа Олон улсад нээлттэй зарлах заалт байдаг. Харамсалтай нь энэ солонгосын багийг буцааснаас хойш манай Хөгжлийн банкныг Олон улсын байгууллагууд ер нь огт сонирхохоо больсон. Үндсэндээ хашраасан гэсэн үг. Энэ болж байгаа процессуудыг дэлхий нийтээрээ бид цацаж байгаа шүү дээ, ганцхан энэ өрөөнд бид нар байгаад мэдээд байгаа зүйл биш. Ингэж зарлаад одоогийн удирдлагууд нь ч тэр, өмнөх удирдлагуудыг ч гэсэн дээ, би санаж байна өмнөх Б.Батбаяр захирлыг томилж байхад олон улсад бас нээлттэй зарлаж байсан. Сая ч бас зарлаж байсан. Ийм баланстай ийм байхад гаднын ялангуяа нэр хүндтэй хөгжлийн банкнууд наашаа орж ирэх нь юу л бол. Ер нь албан ёсоор хүсэлтээ тавьсан, сонирхож байгаагаа илэрхийлсэн тохиолдол ерөөсөө байхгүй сүүлийн үед. Тийм учраас дотоодын багууд ажиллаад явж байгаа. Сонгон шалгаруулалт зарласан, хууль нь тийм. Хүсэлт ирж байгаа багууд дотроо явж байгаа. Хүсэлт ирэхгүй бол хувьцаа эзэмшигчийг Засгийн газар төлөөлж шууд ТУЗ-аа санал болгоод томилогддог.

**Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн Ж.Бат-Эрдэнэ:**

Хоёр дахь асуултад Монгол Улсын Ерөнхий прокурор хариулна.

**Монгол Улсын Ерөнхий прокурор Б.Жаргалсайхан:**

Ц.Цэрэнпунцаг гишүүний асуултад хариулъя. Хохирогчийг тогтоох эсэх, асуудал нь хянаж байгаа прокурор, мөрдөгчийн гаргах шийдвэр. Тийм учраас одоо яг ямар хүмүүсийг ямар байдлаар тогтоосон юм бэ, яг таны хэлдэг шиг тэр хүмүүсийг хохирогч гэж үзэх юм уу гэдэг асуудлыг мөрдөгч, хянаж байгаа прокурор хоёр шийднэ. Хөгжлийн банк хохирогчоор тогтоогдоод явж байгаа, хохирогч гэдэг хүн ямар хүн байдаг юм бэ гэдгийг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуулийн 8.1 дээр хүний бие, амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бусаар

хохирсон хүнийг хохирогч гэдэг. Тийм учраас энэ хохирогч тогтоох эсэх асуудал нь мөрдөгч, хянаж байгаа прокурорын асуудал юм. Хариулт дууслаа.

### **Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн Ж.Бат-Эрдэнэ:**

“Монцемент” ХХК-ийнхан байна уу? За наад микронфон нээе. Индэр В.

### **“Монполимет” группийн “Монцемент Билдинг Материалс” ХХК-ийн захирал Ц.Халиун:**

Ц.Цэрэнпунцаг гишүүнд баярлалаа. Үнэхээр “Монцемент” төслийг нийгэмд онцлоод Хөгжлийн банкны зээлээ төлөхгүй байгаа юм шиг маш буруу ташаа мэдээллүүд энэ олон сарын хугацаанд явсан. Нэгдүгээрт, би нэг зүйлийг маш хариуцлагатайгаар хэлмээр байна. Энэ зээлийг авахад зээлийг 18 сар судалсан байдаг, зээлийг авахад ямар нэгэн улс төрийн нөлөө байхгүй. Манай үүсгэн байгуулагч, ер нь манай компаниас 2014, 2015 оны үед төрийн өндөр албан тушаал хашиж байсан хүн бол байхгүй гэдгийг би бас хариуцлагатайгаар мэдэгдье гэж бодож байна. Хоёрдугаарт, энэ төслийн бүтээн байгуулалтын төлөө амьдралаа зориулсан энэ ахмад үе маань байгаа. Тэнд ажиллаж байгаа мянгаад ажилчид, залуус маань байна. Эдгээрийг төлөөлөөд хариуцлагатайгаар нэг юм хэлье. Энэ зээл гэдэг бол угаасаа эргэн төлөгдөх ёстой. Энэ бол зарчим, хамгийн гол нь бид нар дээр үүсэж байгаа хүндрэл бол ханшийн хохирол байгаад байгаа юм. Үйлдвэрлэгчээс шалтгаалаагүй энэ ханшийн хохирлыг дангаараа ингээд үйлдвэрлэгч үүрээд байгаа нь шударга бус юм. Сүүлийн хоёр жил үүнийг дэвшүүлсээр ирсэн. Хоёрдугаарт, Иргэний хуулийн 222.2 гээд заалт байна. Хугацаа хэтрэхэд хүргэсэн нөхцөл байдал нь үүрэг гүйцэтгэгчийн гэм буруугаас болоогүй бол үүрэг гүйцэтгэгчийг хугацаа хэтрүүлсэн гэж үзэхгүй гээд. Ерөнхий сайд бас хэлсэн, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр цар тахлаас болоод үнэхээр хүндрэлтэй байсан, үйл ажиллагаа нь тасалдсан, тогтвортой байх боломж байгаагүй, төсөл нь тэгэхдээ амжилттай хэрэгжсэн төслийг бол чанаргүй зээл гэж үзэхгүй. Мөн баялаг бүтээгчээ дэмжиж энэ үйлдвэрлэгчдээ дэмжих бодлогыг барина гээд бас хэлсэн байгаа. Энэ дээр ингээд чанаргүй зээл гээд байгаа дээр манай хамт олны зүгээс бол санал нийлэхгүй байна. Ер нь сүүлийн 4, 5 жил засаг захиргааны бүх байгууллагууд Хөрөнгө оруулалтын тухай хуулийн асуудлыг дэвшүүлсээр ирсэн. Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 11.2.1 барилгын материал, газрын тос, хөдөө аж ахуйн зориулалтаар үйлдвэр барих гэж байгаа аж ахуйн нэгжийн импортын тоног төхөөрөмжийг бол гаалийн болон НӨАТ-аас чөлөөлнө гээд энэ заалт байгаа. Өнөөдөр энэ заалт хэрэгждэггүй эсвэл ялгавартай хэрэгждэг. Газрын тос дээр жишээ нь технологийн бус тоног төхөөрөмж нь хүртэл ингээд чөлөөлөгдөөд хөдөө аж ахуйн салбар ч гэсэн чөлөөлөгдөөд явдаг. Нэг удаагийн хууль гаргах замаар барилгын материал, үйлдвэрлэл дээр энэ хууль өнөөдрийг хүртэл хэрэгжилтгүй байгаа. Үүнийг бид нар шат шатны байгууллагад хандсаар ирсэн. Сүүлд Захиргааны хэргийн шүүх ч гэсэн энэ “Монцемент” бол ингээд хөрөнгө оруулалтын тухай хуульд заасан дэмжлэгийг авах эрх бүхий хуулийн этгээд мөн байна гэдгийг бас тогтоосон байсан. Тэгээд ер нь аливаа Төр засгаас өгч байгаа, гаргаж байгаа дэмжлэгүүд нь манай барилгын материал үйлдвэрлэл дотроо цементийн үйлдвэрүүд маань дандаа гадуур ингээд орхигдоод байдаг. Сая цар тахлын хуулиар ч гэсэн эрчим хүчний хөнгөлөлтийг бүх салбарын аж ахуйн нэгжүүдэд олгосон. Гэвч цементийн үйлдвэрийг бас орхисон байсан. Хоёрдугаарт, Хөгжлийн банкны төлөөлөл, удирдлагууд хэлсэн, төгрөгөөр борлуулалттай байдаг энэ аж ахуйн нэгжүүд бол үнэхээр ингээд ханшийн хохиролд бол өртчихөөд байгаа, үүнийг хоёр талаасаа ч байдаг юм уу, Төв банкны угаасаа үүрэг нь төгрөгийн

ханшийг тогтвортой барих гээд ингээд заачихсан байгаа, тэгэхээр үүнийг хэрхэн ямар байдлаар шийдэх вэ гэдэг асуудлыг бид нар энэ олон жил бол тавьсаар ирсэн, ийм л асуудалтай байгаад байгаа юм.

### **Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн Ж.Бат-Эрдэнэ:**

Аж ахуйн нэгжүүдээс бид нар санал авах, өөрөөр хэлбэл сонсгол явуулахаас 2 хоногийн өмнө бүх аж ахуйн нэгжүүдээс санал аваад хаах ёстой. Тэгээд энэ хүрээнд 4 аж ахуйн нэгж орж ирсэн. Өнгөцхөн харахад тэнцвэртэй байдлыг хадгалаагүй юм шиг харагдаад байгаа болохоор би таны яриаг хязгаарлачихлаа шүү, түрүүн та танилцуулгаа хийчихсэн. Хөгжлийн банканд дээр шинэ удирдлага гарч ирсэн цаашдаа яаж ажиллах юм, урьд өмнөх алдаа дутагдлыг бас сайн, олигтойхон шиг ярь аа. Сая Сангийн сайд хэллээ шүү дээ, 2011-2013 онд хүртэл Ким Жан Жин гэсэн үү, энэ хүн ажиллаж байсан. За энэ хүний удирдлага бол, жишээ нь би тухайн үед Зам тээвэр, барилга хот байгуулалтын Төрийн нарийн бичгийн даргаар ажиллаж байсан. Зам барилгын чиглэлийн эргэн төлөгдөхгүй зүйл дээр хөрөнгө оруулалт оруулах гэсэн зүйл дээр, манай яамны чиглэлээр гарч байгаа зээл, төслүүд дээр зээл өгдөггүй байсан шүү дээ, наад баг чинь. Өөрөөр хэлбэл менежмент нь зөв явж байсан гэсэн үг. Тэрнээс хойш болохоо байсан. Үүнийг сайн тодорхой хэлж яриарай бас. Ц.Цэрэнпунцаг гишүүн минут үлдсэн байна дахиад тодруулъя.

### **УИХ-ын гишүүн Ц.Цэрэнпунцаг:**

Хариулт авлаа. За тэгээд цаашдаа энэ Түр хороо байгуулагдаад бид нар энэ дээр удаан ажиллах байх, ер нь уганд нь тултал ажиллах ёстой гэж бодож байна. Тэгээд Түр хороо байгуулагдахаар хохирогч дээр анхаарах хэрэгтэй, эрүүгийн хуульд хохирогч гэдгийг нь сая бас прокурор бас тодорхойлж хэллээ. Тэгэхээр өөрийнхөө боломжийг хулгайд алдчихсан улсууд ер нь хуулиараа болохгүй юм шиг байна. Гэхдээ бид энэ бизнесүүдийг нар авчирч тэр үедээ Хөгжлийн банканд хандаад бусдад шударга бус, улс төрчидтэй хуйвалдаж энэ алтан боломжоо хулгайлуулчихсан, алдчихсан бизнесүүдийг авчирч нэг бүрчлэн ярина, тэндээс тодорхой болно шүү дээ. Яагаад зэрэгцээд 10, 20 сайхан төсөл хажууд сонгогчиоор байж байхад энийг сонгов. Тэгээд энэ хууль хяналтын байгууллагынхан үйл ажиллагаагаа явуулах, хянан шалгах, тогтоох үйл ажиллагаанд бас нэмэр болох байх. Цаашид бид нар хүний эрх, эрх чөлөөнд халдах, ялангуяа бизнес эрхлэх, ашиг орлоготой байх, чадвар чадамжаа бүрэн дүүрэн ашиглах бололцоог нь хаан, боож боломжийг нь хулгайлж байгаа энэ явдал бол том гэмт хэрэг шүү. Үүнтэй бид нар хатуу тэмцэх ёстой. Өнөөдөр өчнөөн олон боломжоо алдчихсан өчнөөн жишээ байна. Захын жишээ гэхэд төрийн мөнгөөр гадаадад сурсан залуучууд байдаг. Тэгтэл хөдөө орон нутаг хэчнээн сайхан алт шиг сэжиглэсэн хүүхдүүдэд байна, боломж байхгүй. Хэдэн хэдэн даргын хүүхдэд хуваагаад тэр боломжийг нь хулгайлдаг. Энэ гэмт хэрэг биш юм уу, Прокуророо. Боломжоо алдаад арван хэдхэн насандаа ид цэцэглээд, дэлбээлээд эх орон, улс орондоо асар их бүтээх чадвартай сайхан залуучуудын боломжийг хэдэн дарга цэрэг нарын хүүхдүүд хуваагаад идчихсэн. Өөрсдөө юу ч биш хагас хугас гадаад хэлээр ярьчихна, өөр юм байхгүй. Ингээд хохироочихож байгаа нь улс орон цаад утгаараа том утгаараа хохирч байгаа юм шүү. Тэгэхээр энэ дээр бас анхаарч үзээрэй, энэ дээр бид цаашдаа бас ярина. Мөн хувийн бизнесүүд түрүүн ярьсан, ханшны эрсдэлийг хамгаалах ёстой байгууллага нь үүргээ гүйцэтгээгүй байж бизнесүүд дээр эрсдэл нь ирээд байна. Бизнесүүд зөвхөн бодит төлбөр, алдагдлыг төлөхөөс гадна олон нийтийн өмнө олон жил хуримтлуулсан бизнесийн нэр хүнд бүх юмаа алдан алдагдал хүлээгээд явж

байна. Энэ шударга бус юмыг одоо бид нар цаашдаа зогсоох ёстой. Ер нь Хөгжлийн банк нь хэрэглэгчидтэйгээ цуг байж, тэднийг эрсдэлээс хамгаалахад хамтдаа ажиллаж зөвлөгөө өгөх ёстой. Хөгжлийн банкныхан санаатай нийлж хулгай хийдэг нэг хэсэг, дээрээс нь мэргэжлийн ур чадвар байхгүй нөхдүүдээс бүрдсэн менежмент байгаа байхгүй юу.

Энэ чинь валют олж ирдэг, экспортын чиглэлтэй үйл ажиллагаа явуулдагт нь валютаар нь тийм үү, ам.доллар бол ам.доллараар, иен бол иенээр зээл олгох ёстой. Тэр дотооддоо энэ цемент зарах гэж байгаа бол тэр чинь төгрөгөөр олгох ёстой шүү дээ. Энэ чинь зүгээр л зарчим шүү дээ. Тэгээд ийм юмаа хийж чадахгүй...

### **Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн Ж.Бат-Эрдэнэ:**

Улсын Их Хурлын гишүүн Д.Батлут асуулт асууя.

### **УИХ-ын гишүүн Д.Батлут:**

Та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе. Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 179 дүгээр тогтоолоор Бондын бодлогын зөвлөгчийг байгуулсан байна. Тэгээд тус зөвлөлийн даргаар Ерөнхий сайдаар ажиллаж байсан Н.Алтанхуяг, Дэд даргаар Эдийн засгийн хөгжлийн сайд Н.Батбаяр, Нарийн бичгийн даргаар Эдийн засгийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн Б.Шинэбаатар нар томилогдож ажилласан байгаа юм аа. Энэ тогтоолын 2.2-т “үүсэж болох эрсдлийг урьдчилан тооцож, үнэлгээ гаргах үүрэг бүхий ажлын дэд хэсэг байгуулж ажиллана” гэсэн байгаа. Яг үнэндээ энэ ажлын дэд хэсэг нь ямархуу байдлаар байгуулагдсан юм бол доо. Ямар хүмүүс томилогдсон юм бол, энэний цаана нь ямар хүмүүс санал болгож энэ дэд ажлын хэсгийг бүрдүүлэв ээ, улс төрөөс ямар хамааралтай байв гэдгийг судлах хэрэгтэй гэж харж байгаа юм. Энэ тал дээр би нэг хариулт авмаар байна.

Энэ дэд ажлын хэсэг маань ямар журмаар ажилласан юм. Энэ хүмүүс ажлаа хийгээгүйгээс болоод барьцаа хөрөнгөгүй зээл, зээлийн шаардлага хангаагүй зээлүүд гарсан байна. Мөн дээрээс нь валютын ханшийн зөрүүгээс бөөн хохирол алдагдлууд үүссэн байна. Ингэснээрээ улс болоод аж ахуйн нэгжүүд хохирч байна гэж харж байгаа юм. Тэгэхээр энэ бодлогын зөвлөлийн тэр дэд ажлын хэсэгт ямар хүмүүс орсон, ямар журмаар ажилласан, журмыг нь бас Засгийн газар батлах ёстой байх л даа. Дээрээс нь ямар одоо улс төрийн хамаарал бүхий этгээдүүд вэ гэдгийг тодорхой болгох хэрэгтэй. Энэ тал дээр холбогдох байгууллагууд надад хариулт өгөөч ээ.

Чанаргүй зээл, анхаарах ёстой зүйлүүд гэж нэлээн олон зээлүүд гарчихсан байгаа. Тэр дотор манай монголын толгой баячууд гэж нэрлэгддэг хүмүүс, аж ахуйн нэгжүүд байх юм. Үгүй одоо тэгээд тэр хүмүүс чинь чанаргүй зээл авч ч байдаг, тэрийг нь олгочихож ч байдаг гэж бодохлоор энэ банк чинь өөрөө улс төрөөс шууд хамааралтай байгаа юм биш үү? Хэн үүрэг өгөөд энэ зээлүүдийг олгуулчихсан юм. Одоо зөндөө л хүмүүс ярилаа шүү дээ. Тэр “ТОСК”-той холбоотой асуудал, мөн дээрээс нь энэ “Худалдаа хөгжлийн банк”-тай холбоотой асуудлууд. Тэгэхээр энэ хүмүүс чинь, одоо яг гардан гүйцэтгэж байгаа хүмүүс чинь энэ Хөгжлийн банкн дотор байгаа юм байна шүү дээ. Одоо тэд нар ямар ажил хийж байгаа юм. Ямар албан дээр байдаг юм. Эд нарт тодорхой арга хэмжээ авсан зүйл байгаа юу. Хууль хяналтын байгууллагууд яг энэ чиглэлээр ажилласан уу? Цагдаагийн байгууллага, Авлигатай тэмцэх газрынхан гээд. Одоо мөрдөн байцаах ажлыг мань мэт нь заалтай

биш дээ. Ер нь бол зүгээр нэг зах сэжүүр байхад тэгээд явах ёстой л болов уу гэж бодож байгаа шүү дээ.

Одоо “Хөтөл” ХХК-ийн асуудал яригдаж байна. Бас “Хөтөл” ХХК, “Кью Си Эс” компани 500 гаруй тэрбум төгрөгийн зээл авчихсан гээд. Хөтөл компани нь авсан юм болов уу, Хөтлийн Цемент шохой нь авсан юм болов уу. Бас маргаантай. Явж явж байж одоо төрд авлаа гээд тэгсэн энэ Хөтлийн Цемент шохойн үйлдвэрийг, эргэж явж байгаад нөгөө 500 гаран тэрбум төгрөгийн өр төр төлөх болчих юм биш биз дээ, нөхдөө. Тэр Хөтлийн Цемент шохойн компанийн чинь эзэн нь нас барчихсан, эзэнгүйдчихсэн байгаа. Тэгээд төр авчихсан. Одоо тэгээд төр төлөх үү. Энд нэг хариулт өгөөч ээ.

За үнэхээр маш хүнд байдалд байгаа банкууд олон байна. Тухайлах юм бол “Чингис хаан” банк гээд, төлбөрийн чадваргүй болчихсон. Гэтэл яагаад энэ банкууд дээр одоо мөнгө байршуулаад байгаа юм бэ. 25 тэрбум төгрөг. Энэ мөнгөө буцааж авч чадахаа байчих юм биш биз дээ, нөхөд өө. Энд ер нь тэгээд сэтгэл гаргаж ажиллаж байгаа хүн байна уу, нөхөд өө. Хөгжлийн банкныхаан, монголын төлөө ажиллах гээд байгаа юм уу, хэн нэгэн хүмүүс рүү чиглэж ажиллах гээд байгаа юм уу. Хэн нэгэн хүмүүс, бизнесмен, улс төрчдийг дэмжиж ажиллах гээд байгаа юм уу, ойлгохоо байлаа.

Түрүүн ярьсан 700 гаруй тэрбум төгрөгийг улсад улс төлүүлэхээр болох гээд байгаа ч юм шиг. Хэний захиалгаар энэ үйлдлийг хийх гээд байгаа юм бэ, Хөгжлийн банкныхаан. Тэгээд бодохлоор захирлыг нь одоо хэн нэгний улс төрчийн хүн байна гэж шууд тодорхойлоход буруудахгүй болчих гээд байна шүү дээ. Энэ хугацаанд бас 2 хэрэг хөөн хэлэлцэх хугацаа нь дууссан учраас хэрэг үүсгэхгүй гэсэн байна. Ямар хэргүүд юм, ямар хэмжээний хохирол үүсгэсэн юм бэ? Тэр хохирлыг хэн хариуцах вэ? Цаашлаад энэ олон зээлдэгч нар яг ингэж явсаар байгаад хөөн хэлэлцэх хугацаа нь дуусаад хэрэгсэхгүй болгоод улс хохироод үлдэх вий дээ, нөхөд өө. Энийг яг хэн, яаж хариуцах вэ? Маш ойлгомжгүй нөхцөл байдлууд байна. Тэгэхээр энэ засаг төрөөс анхаарч, тал талаасаа анхаарч, хууль хяналтын байгууллагатайгаа хамтарч энэхүү ажлуудыг маш сайн цэгцэлж өгөхгүй бол болохгүй байна аа гэж одоо харагдаж байна аа.

Хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөлүүд бас онцгой эрхтэй байсан. Тэд бол зээлийг авч хэлэлцдэг, зээл олгох үгүй дээр шийдэл гаргадаг.

Би одоо ХҮН-аас сонгогдсон Улсын Их Хурлын гишүүн Т.Доржхандын санаачилгыг дэмжиж байна л даа. Хариуцлага байх ёстой. Тэгээд судлаад харангуут 2012-2014 онд ХҮН-ын одоо даргаар ажиллаж байгаа хүн маань энэ ТУЗ-ийн хараат бус гишүүн байна, байсан байна. Тэгэхээр би таныг энэ хариуцлагын асуудлыг үлгэр дуурайлал болгож эхлээч гэж хүсэж байгаа юм. Ингэж байж цаашдаа улс төрд шинэ соёл бий болох болов уу гэж харж байна. Мэдээж энэ ТУЗ-ийн гишүүн гэдэг бол үүрэг рольтой оролцож байгаа. Хариуцлага байх ёстой. Та энэ хүндээ бас хариуцлага тооцож, намын одоо дарга хүн шүү дээ, наадах чинь танай намын дарга хүн. Шийдэл бол гаргах ёстой байх аа гэж харж байгаа юм аа. Тухайлах юм бол ТУЗ-ийн шийдвэрээр маш олон асуудлууд гарсан байгаа. Ганцхан жишээ хэлье. Худалдаа хөгжлийн банкны 13 давхар байшингийн 11, 12 дугаар давхар 3394 м.кв газрыг 28.5 тэрбум төгрөгөөр худалдан авах шийдвэрийг ТУЗ нь гаргачихсан байна шүү дээ. 1 м.кв нь наян хэдэн сая төгрөг гээд бод доо. Үгүй нээрээ ийм шийдвэр гаргаж байдаг ТУЗ байх ч гэж, ийм шийдвэрийг гүйцэтгэж байдаг захирлууд нь байх гэж. Тэгэхээр энэ мэтчилэнгийн Хөгжлийн банктэй холбоотой асуудлыг

шалгах ажлын хэсгийг яаралтай байгуулж, дээрээс нь энэ хууль хяналтын байгууллагуудтай хамтарч маш хурдтай ажиллах хэрэгтэй байгаа шүү. Нэлээн олон жилийн өмнөх асуудал яригдаж байгаа. Яван явсаар яг түрүүний миний хэлдэгчлэн нөгөө хөөн хэлэлцэх хугацаа дууссан хэлбэр лүүгээ ороод алга болох вий дээ гэж болгоомжилж байна шүү нөхөд өө. За баярлалаа. Асуултад хариулж өгнө үү.

**Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн Ж.Бат-Эрдэнэ:**

Хөгжлийн банк хариулъя, дараа нь Авлигатай тэмцэх газар, Монгол Улсын Ерөнхий прокурор хариулъя.

**Хөгжлийн банкны гүйцэтгэх захирал Н.Мандуул:**

За гишүүний асуултад хариулъя. Ашиг сонирхолтой этгээдүүд манай банканд дээр байна уу гэж. За ямар ч байсан удирдлагын түвшинд бол байхгүй ээ. Манай удирдлага томилогдоод хэдхэн сар болж байна. Өмнөх энэ болсон үйл явцыг судалгаа хийгээд Монголбанкны шалгалт ороод олон төрлийн процессын үйл ажиллагаа хийсний эцэст дотоод үйл ажиллагааны журмаа өөрчлөөд ил тод ажиллах ёстой гэсний үндсэн дээр энэ бүх зүйл гарч ирж байгаа юм аа. Тэгэхээр бид бас үүнийг засаж залруулахын төлөө ажиллаж байгаа гэдгийг ойлгоорой.

За хоёрдугаарт, тэр өмнө нь нэг нээлттэй хэлэлцүүлэг явсан, түүн дээр маш олон саналууд гарсан. Би өөрөө байсан. Талууд бол байр сууриа илэрхийлээд ер нь бол ингээд шийдэл ярьцгаая аа, зүгээр ингээд шоу попрех ийм зүйл болгохоо больё оо гэсэн тийм саналууд гарч байсан. Тэгэхээр Хөгжлийн банк менежментийн хувьд ийм шийдэл байж болох юм гэсэн саналаа танилцуулсан юм. Мэдээж шийдэх эрх нь Засгийн газар, Улсын Их Хуралд байгаа. Шийдэл олоод ир гээд бид толгойгоо ажиллуулаад нэг ийм шийдэл байж болох юм гэсний төлөө ингээд хардаад байж болохгүй болов уу. Тэгвэл цаашдаа ажил хийх хүн олдох уу, үгүй юу. Чингис хааны барьцааны асуудал, биш ээ депо юм байна, 2018 оны 12 дугаар сард нэг жилийн хугацаатайгаар 25 тэрбум төгрөг Хөгжлийн банкнаас “Чингис хаан банк”-д байршуулсан юм байна. 2019 оны 12 дугаар сард гэрээ дуусаад 3 сараар сунгасан юм байна. Тэгээд 2020 оны 02 дугаар сараас хойш манай банк мөнгөө авч чадахгүй явж байгаа юм. Ингээд хүүтэйгээ нийлээд 37.5 тэрбум төгрөгийн өр нэхэгдчээд, бид бас шүүхдээд явж байгаа. Тэгэхээр энэ бол өмнө нь болсон процесс. Бид өмнө болсон алдаануудыг засаж залруулах гээд ингээд ажиллаад явж байна. За манай дэд захирал “Хөтөл” ХХК-ийн талаар мэдээлэл хийнэ.

**Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн Ж.Бат-Эрдэнэ:**

22 дугаар микрофон.

**Хөгжлийн банкны Үйл ажиллагаа хариуцсан дэд захирал Ж.Эрхэмбаатар:**

“Бэйзмент” гэж компанид Хөгжлийн банк 2012 онд 61 сая ам.долларын зээл олгосон. Энэ компани нэрээ солиод “Хөтөл” хязгаарлагдмал хариуцлагатай компани болчихсон байгаа. Энэ компанийн 100 хувь хувьцаа эзэмшигч иргэн 2018 онд нас барснаар эзэнгүй өмч болчихсон байгаа. Гэхдээ энэ эзэнгүй өмчийг төр иргэний хуульд заасан эзэнгүй өмчийн хуулийн зохицуулалтаар аваагүй шүү. Төрийн өмчийн хорооноос тогтоол гараад, Засгийн газраас тогтоол гараад ямар асуудал шийдэгдсэн бэ гэхлээр “Цемент шохой” буюу энэ компанийн охин компанийг

хувьчилсан асуудал нь хууль бус болохыг тогтоогоод үүнийг засаж янзлах шийдвэр гарсан. Өөрөөр хэлбэл энэ “Бэйзмент” гэдэг компанийн охин компанийг авсан байгаа. Төрөөр энэ зээлийн өр төлбөрийг төлүүлэх ямар ч алхам хийгээгүй ээ. Хийхээр Хөгжлийн банк огт шаардаагүй байгаа. Төр одоо охин компани буюу нэгэнт зээл олгох явцдаа бодлогын том алдаа гаргасан нь “Хөтөл цемент шохой” үйлдвэрийг өргөтгөөд хуурай аргаар баяжуулах үйлдвэртэй болгоно гэсэн зээлийг өгөхдөө “Хөтөл”-д нь биш огт үйл ажиллагаа явуулдаггүй, туршлагагүй, алдагдалтай, гуравдагч этгээдэд зээлтэй компанид нь өгчихсөн байгаа юм. Эндээс алдаа гарч байгаа юм. Энэ компани нь цаашдаа тэр зээл шилжүүлэхдээ “Худалдаа хөгжлийн банк”-д 34 сая ам.долларыг шилжүүлчихсэн, 5.5 сая ам.долларыг нь “Улаанбаатар хотын банк”-д шилжүүлчихсэн. Ингээд 21 сая ам.доллар цаашаа төсөл рүү орсон уу үгүй юу гэдэг асуудлыг шалгах ажил явагдаж байгаа гэж ойлгож байгаа. Нэр зааж хэлээд байгаа энэ хувийн өмч гээд заагаад байгаа “Цемент шохой” дээр баригдчихсан байгаа тэр үйлдвэр чинь Хөгжлийн банкны хөрөнгөөр боссон үйлдвэр. Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 3-т шударгаар өмч олж авах эрхтэй, үүнийг нь төр хамгаалах үүрэгтэй. Тэр бол зээлийн хөрөнгөөр үүсчихсэн хөрөнгө учраас одоогоор тухайн иргэний хувийн өмч шууд утгаараа болохгүй. Дээр нь нэмэх нь гэрчилгээ байхгүй байгаа юм тэр байшинд өөрөөр хэлбэл хэн нэгний өмчийг нотлох эрх бүхий байгууллагын бүртгэлийн бичиг баримт тэр байшин дээр байхгүй. Ингээд хэн нэгэн эзэн гарч ирээд энэ миний, энэ чинийх гэсэн маргаан үргэлжлэхээр байгаа. Гэхдээ энд маргашгүй нэг зүйл байгаа нь юу вэ гэхээр тэр “Хөтөл” гэдэг компанийн ч өмч биш, тийм гэрчилгээ байхгүй, “Цемент шохой”-гийн өмч биш, тийм гэрчилгээ байхгүй. “Цемент шохой” гэдэг компани шийдвэр гаргах боломжтой болчихсон буюу хувьцаа эзэмшигчтэй болчихсон. Энэ хувьцаа эзэмшигчтэй болчихсон боломжоо ашиглаад хяналт шалгалт тогтоогоод зээлийн мөнгө одоо хаашаа явсан, хэн зарцуулсан, юунд зарцуулсан гэдгээ олж тогтоогоод хууль бусаар зарцуулсан энэ зүйлийг эргэн төлүүлэх байдлаар зээл төлөх бололцоог нээж олж ажиллана гэж найдаж Хөгжлийн банк энэ асуудал дээр хамтарч ажиллаж байгаа. Тэгэхээр энэ бол төр төлж байгаа зүйл бол огт байхгүй байгаа.

**Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн Ж.Бат-Эрдэнэ:**

За Монгол Улсын Ерөнхий прокурор.

**Монгол Улсын Ерөнхий прокурор Б.Жаргалсайхан:**

Гишүүний асуултад хариулъя аа. Хөөн хэлэлцэх хугацаагаар дууссан нэг л хэрэг бий. Тухайлбал Хөгжлийн банкны захирал асан Мөнхбаттай холбоотой хэрэг, тэгэхдээ анхан шатны шүүхээр хөөн хэлэлцэх хугацаагаар хэрэгсэхгүй болсон. Давж заалдах шатны шүүхэд одоо хянагдаж байна. Энэ хэрэг хэрэгсэхгүй болгосонтой холбогдуулж хөөн хэлэлцэх хугацааг дууссантай холбогдуулж хохирлоос чөлөөлөгддөг хууль зүйн зохицуулалт байхгүй ээ, чөлөөлөгдөхгүй ээ. Тийм учраас шүүхээр шийдмэгц шүүхийн журмаар, гүйцэтгэх ажиллагааны журмаар хохирол нөхөн төлөгдөх ёстой. Нөгөө талд хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагааны явцад буюу давхар прокурорын шатанд хэрэг хөөн хэлэлцэх хугацаагаар хэрвээ дуусвал мөн адил хохирлын асуудлаас чөлөөлөгдөхгүй ээ хохирол төлөгдөнө өө. Тухайлбал прокурорын байгууллага өөрийн санаачилгаар хохирлыг төрийг төлөөлөх ажлынхаа хүрээнд шийдвэрлэх ийм хууль эрх зүйн зохицуулалттай. Хариулт дууслаа.

**Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн Ж.Бат-Эрдэнэ:**

Авлигатай тэмцэх газраас бас асуусан байх аа үгүй юу? За Б.Жавхлан сайд.

**Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан:**

Яах вэ, би зүгээр Д.Батлут гишүүний ярьсан дээр нэмж үг хэлэх гэсэн юм. Д.Батлут гишүүнээ одоо ажиллаж байгаа энэ удирдлагад нь ажиллаж байгаа багийн залуучуудыг зөв ойлгоорой. Бид одоо яг дэмжих ёстой цаг үед нь байгаа юм шүү. Хамгийн хүнд үед нь ажиллаж байгаа, үндсэндээ үлдсэн шааран дээр нь ажиллаж байгаа байхгүй юу. Хамгийн хүнд үед нь ажиллаж байгаа энэ банк биш өр барагдуулах албанд ажиллаж байгаа залуучууд, хэрвээ эд нарыгаа шантраагаад загнаад мохоогоод явуулчих юм бол дараа нь бид нар Олон улсад битгий хэл дотооддоо зарлаад ч энд хүн ажиллахгүй шүү, нэг ч хүн ажиллахгүй, төрийнхөн нь улс төрийнхөн нь өөрсдөө зээл авдаг тэгээд өөрсдөө хөөгөөд явуулчих юм бол дараа нь энд хэн ч ажиллахгүй, хэн ч ажиллахгүй. Энэ Мандуул гэж залуу Сангийн яаманд газрын даргаар ажиллаж байсан, санал тавиад ийшээ очоод ийм хүнд үед нь багаа бүрдүүлээд ажиллаж байгаа. Энэ хүнд зээлүүдийн чинь ард дандаа л одоо хүнд гарууд байгаа. Хамгийн хэцүү үед нь ажиллаж байгаа шүү. 2020 оны 04 дүгээр сард Засгийн газрын хувьцаа эзэмшигчийг Сангийн яам төлөөлдөг болоод ингээд ажиллаж байгаа юм. Одоо шүүхэд оччихсон байгаа, хуулийн байгууллагад оччихсон байгаа нийтдээ 46 зээл байгаа, үүнээс яг шүүхэд очсон нь 29. Үүний 28 зээлийг нь Сангийн яаманд ирснээс хойш шилжүүлж өгсөн. Би 3 захирлаар нь хэлье, Амартүвшин захирлын үед 9, Мөнхсүх захирлын үед 7, тэгээд Мандуул захирлын үед 12, нийтдээ Сангийн яаманд ирснээс хойш 28 зээлдэгч, энэ муу зээлдэгч нартай ийм байдалтай ажиллаж байгаа юм. Өнөөдөр ийм бүрэлдэхүүнтэйгээр олон нийтэд нээлттэй сонсгол хийх ийм боломж бүрдсэн. Энэ бүх санаачилгыг энэ залуучууд анх гаргаж тавиад за ерөөсөө ингэж ажиллахгүй бол болохгүй юм байна аа гээд ингээд явж байгаа юм аа. Хөгжлийн банкныг цааш нь үнэхээр яг хөгжлийг санхүүжүүлдэг ийм институц болгож ажиллуулахын тулд яг энэ цаг үед ийм арга хэмжээ авч, томоохон өөрчлөлт хийж, ингэж явахгүй бол цаашаа энэ банк хөгжлийн битгий хэл хөгжлийг хойш нь татдаг ийм болж, ийм институц болж, одоо институц гэх нь хаашаа юм нэр ч өгөх боломжгүй, ийм болж үлдэнэ. Тийм учраас одоо бид энэ ажиллаж байгаа баг бүрэлдэхүүн, тусалж хамтарч ажиллаж байгаа энэ хуулийн байгууллагууд, дээрээс нь энэ хэвлэлийнхэнд бид нар талархах ёстой гэж ингэж бодож байна. Энэ олон муу зээлдэгч нарыг шүүхэд өгөөд хуулийн байгууллагад өгөөд төлөгдсөн нь бараг байхгүй дээ. Харин энэ олон нийтийн анхааралд тавиад олон нийтийн хариуцлага гэдэг тавцан дээр гаргаж тавьснаас хойш 136 тэрбум төгрөг төлөгдсөн байна. Яг үүнээс 88.5 тэрбум төгрөг нь сүүлийн үед төлөгдсөн байгаа. Одоо энэ зарлагдаад байгаа муу зээлүүдээс, цаашдаа ч ойрын хугацаанд эргэж төлье яаж төлөх вэ, ийм боломжууд байна, ийм боломжгүй байна, ийм цаг хугацаа хэрэгтэй байна гээд эргээд төлөх хандлага нь сэргэж ирж байгаа, хандлага нь зөв болж ирж байгаа бас ийм үр дүн байгаа юм. Тэгэхээр энэ тал дээр бас тодорхой хэмжээнд бид одоо хэвлэлийнхэн ингэж олон нийтийн анхаарлын төвд оруулж улам хариуцлагажуулж ингэж хамтарч ажилласанд талархах ёстой гэж үг хэлэх боломж олдсоных хэлье гэж бодлоо. Тийм тэгэхээр энэ залуучуудыг бүгдээрээ дэмжиж бас хамгаалж ажиллах ёстой шүү. Баярлалаа.

**Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн Ж.Бат-Эрдэнэ:**

Д.Батлут гишүүн. Д.Батлут гишүүний микрофон.



### **Улсын Их Хурлын гишүүн Д.Батлут:**

Би Хөгжлийн банкны энэ залуучуудыг дэмжихгүй дээ үг хэлээгүй юм. Маш сайн дэмжинэ, хамгийн гол нь шударга ажиллах хэрэгтэй. Хамгийн боломжит хувилбаруудыг гаргаж ирж ажиллах ёстой гэж харж байгаа юм. Хууль хяналтын байгууллагуудтай хамтраад, хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтраад өнөөдөр яг үнэн шүү дээ. Манай хэвлэл мэдээллийн байгууллагууд сайн ажилласан Заригийнхан, Улаанбалынхан үнэхээр олон нийтийн түвшинд анхаарлыг татуулж чадсан. Тэгж байж энэ асуудал дээр нэлээн томоохон ахиц, үр дүнгүүд гарсан гэж харж байгаа юм. Харин тэр бодлогын зөвлөл байгуулаад түүний дараа дэд ажлын хэсэгт орж ажилласан хүмүүс гээд тэр ажилладаг журам.

### **Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн Ж.Бат-Эрдэнэ:**

Б.Жавхлан гишүүн маань Хөгжлийн банкныхан нэлээн санаачилгатай ажиллаж байгаа энэнтэй санал нэг байгаа юм. Гэхдээ өнөөдрийн сонсголыг Б.Баттөмөр гишүүн, Ш.Адъяаа гишүүн, Ж.Бат-Эрдэнэ миний бие Ц.Даваасүрэн, Ц.Сэргэлэн, Г.Тэмүүлэн, Н.Учрал, Д.Цогтбаатар гэсэн гишүүд маань санал гаргаж өнөөдрийн энэ нээлттэй сонсголыг хяналтын сонсголыг хийж байгаа шүү гэдгийг бас дахиад нэг тодруулчихъя аа гэж. За дараагийн үг хэлэх гишүүн Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж.

### **Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж:**

Нэг асуулт байна. Хөгжлийн банкны тухай хуулийн 21.3 дээр байдаг юм. Гүйцэтгэх захирал, тэргүүн дэд захирал, газрын захирлуудыг энэ хуулийн 21.4-т заасан журмын дагуу Олон улсын нээлттэй сонгон шалгаруулалтаар сонгож төлөөлөн удирдах зөвлөлөөс томилж чөлөөлнө өө гэж Н.Мандуул захирал та Олон улсын нээлттэй сонгон шалгаруулалтад орсон уу? Хариулна аа.

### **Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн Ж.Бат-Эрдэнэ:**

Н.Мандуул захирал, 21 дүгээр микрофон.

### **Хөгжлийн банкны гүйцэтгэх захирал Н.Мандуул:**

Түүрүүн адилхан ийм асуулт асуугаад би бас хариулсан байгаа. Б.Жавхлан сайд бас нэмж хариулсан байгаа. Би яг одоогийн байдлаар бол түр орлон гүйцэтгэгчээр ажиллаж байна.

### **Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн Ж.Бат-Эрдэнэ:**

Б.Пүрэвдорж гишүүн.

### **Б.Пүрэвдорж-Улсын Их Хурлын гишүүн:**

Тэгэхээр зөвхөн Мөнхбатыг яриад байх шиг байгаа юм. Батбаяр, Амартүвшин энэ Мандуул энэ тэр бүгдээрээ хууль зөрчиж томилогдсон улсууд л даа. Тэгээд ганцхан хүн дээр юм ярьдаг тэгээд хүний олон бүгдээрээ нийлж байгаад л дайраад байх юм шиг байна л даа. Бүх юмыг зөвхөн ардчилсан нам руу хандуулаад. Тэгэхээр ийм юм байхгүй ээ гэдгийг хэлье. Ажлын хэсэг бол Улсын Их Хурлын даргын захирамжаар байгуулагдсан, тэр одоо захирамжийн хүрээнд хийсэн ажлаа бол

хангалттай хийж байгаа, хийсэн. Тийм ч учраас өнөөдөр энд хариулаад сууж байгаа. Харин иргэдийн хүсэн хүлээгээд байгаа, хэвлэлийнхний хүсэн хүлээгээд байгаа тэр хүлээлтэд бол очиж чадахгүй. Яагаад очиж чадахгүй вэ гэх дээр энэ ажлын хэсэг Хөгжлийн банкн дээр очоод бичиг баримттай нь үзэж танилцъя гэхээр бүгдийг нь хууль хяналтын байгууллага аваад явчихсан байгаа. Дээрээс нь мөрдөн байцаагч шиг одоо тэр аж ахуйн нэгжийн захирлыг нууж авчраад танайд ямар одоо улс төрч эрх мэдэлтэн нөлөөлсөн бэ гэдгийг бол асуух боломжгүй. Гуравдугаарт нь тэр компанийн нууцад халдаад данс тооцоог нь одоо яасан ийсэн гэж шалгах боломжгүй. Дөрөвдүгээрт нь хууль хяналтын байгууллагууд бас энэ барьцааг нь сулласан янз янзын хөөн хэлэлцэх хугацаагаар хэрэгсэхгүй болгосон. Ийм олон асуудлууд байгаа. Энийг асуух, одоо хуулийн байгууллагынхныг дуудаж асуух ийм боломжгүй байсан учраас энэ ажлын хэсэг бол тодорхой баримт дээр суурилоод ажил хийсэн, тэгээд энийгээ одоо ингээд танилцуулж байна. Мэдээж одоо эндээс сонсголын явцад тодорхой тоон мэдээллүүдийг нэмж авч байгаа байх гэж харж байна. Тэгэхээр зээлийг бол 2 ангилна. 2016 оноос өмнөх, 2016 оноос хойших гэж ангилна. 2012 оноос 2016 онд нийтдээ 1.7 их наяд төгрөгийг 2 мянга гаруй аж ахуйн нэгжид өгдөг байсан. Энэ үед энэ банк бол ард түмний банк байсан юм. Ашигтай ажилладаг банк байсан юм, тэгээд 2016 оны 12 дугаар сард энэ Хөгжлийн банкны тухай хуульд өөрчлөлт оруулаад хаврын чуулганаар Хөгжлийн банканд олгох зээлийн асуудлыг баталдаг байсныг нь болиулаад төлөөлөн удирдах зөвлөлд нь эрхийг нь өгсөн энэ эрх өгснөөс энэ хуулийг би батлуулахгүй гэж бүр завсарлага аваад эсэргүүцээд бараагүй л дээ. Тэгээд энийг баталснаас хойш энэ Хөгжлийн банк 40 зээлдэгчид л зээл олгосон, энэ банк ард түмний банк байж байгаад дарга нарын банк болсон юм аа. Дарга нарын банк болсон учраас энэ банк яасан байх вэ, алдагдалтай ажиллаад эхэлсэн байгаа юм. Тэгэхлээр өнөөдөр энэ банкны асуудлыг ярьж байгаа нь маш чухал. Ер нь бол энэ банкны бондыг Олон улсын санхүүгийн байгууллагууд авсан энэ Олон улсын санхүүгийн байгууллагууд маш анхааралтай ажиглаж байгаа. Улс төрчид нь ингээд нөлөөлөөд энэ зээлийг нь аваад идээд уучихдаг юм байна гэдгийг харж, маш анхааралтай харж байгаа, дээрээс нь өнөөдөр хэвлэлийнхэн, ард түмэн, бас дээрээс нь хууль хяналтын байгууллагууд нь бүгдээрээ нийлж байгаад энэ зээлээ буцаан төлүүлэх ажлыг хийж чаддаг юм байна гэдгийг бас харж байгаа. Тийм учраас бид бүхэн энэ ажлын хэсэг, дээрээс нь энэ сонсголын хүрээнд бас тодорхой ахиц гараад ажлаа сайн хийх юм бол яах вэ? Бид нар олон улсын Мүүдис, Фитчис байдаг юм уу, энэ одоо байгууллагууд бид нарт бас энэ санхүүгийн эрсдэлд оруулах зэрэглэлийг бууруулах ийм асуудлаас гарч чадна аа л гэж би харж байгаа. За тэгэхлээр, энэ банкн дээр бас тодорхой ажлуудыг хийх ёстой гэж би цаашдаа ямар арга хэмжээ авах юм бэ гэдэг бас нэг дүгнэлт хэлье гэж бодож байна. Зарим аж ахуйн нэгжүүдийг нэмж санхүүжүүлэх хэрэгтэй байна. Жишээ нь “Бэрэн групп” гэж компани байна, үеийн үед одоо ингээд л нөгөө сүүлийн 30 жилийн туршид л манай төмрийн хүдэртэй компаниуд бүгдээрээ Хятад нэг эзэнд хүнд хувьцаагаа өгч байгаад л урагшаа зөөгөөд тэгээд л төмөрлөгийн үйлдвэрлэл ерөөсөө явдаггүй ийм л байгаа. Гэтэл энэ “Бэрэн групп” компани чинь урагшаа нэг ширхэг ч хүдэр гаргаагүй, хэрвээ гаргадаг байсан бол энэ Хөгжлийн банкнаас зээл авах ямар ч шаардлага байхгүй шүү дээ. Хэдэн төгрөг олж байгаа түүнээрээ хөрөнгө оруулалт хийгээд энэ үйлдвэрлэлээ байгуулчих боломжтой. Энэ улс нь хийж чадахгүй, төмөрлөгийн үйлдвэр гэдэг чинь бүх үйлдвэрлэлийн, хүнд үйлдвэрлэлийн гол суурь ажил шүү дээ. Энэ барилгын материал одоо маш их өндөр үнэтэй болчихсон байна. Хайлш гаргадаг болчихсон. Тэгээд хайлшнаасаа цаашаа цуваад л цувимал хийгээд тэгээд тэрүүгээрээ арматур хийх боломжтой ийм хэмжээнд оччихсон үйлдвэр байгаа юм. Тэр захирлынх нь толгойд бүх ноу-хау нь байж байгаа шүү дээ. Тэгээд тэр хүн нь байхгүй бол үйлдвэр явахгүй. Тэгээд бүр их эрсдэлд оруулах ийм нөхцөл байдал руу оруулж байгаа юм. Тийм учраас энэ Хөгжлийн банк

дахиж нэмж, Засгийн газар ч гэсэн энэ улс нь хийж чадахгүй байгаа ажлыг иргэн нь зориг гаргаад хийж байгаа ажлыг нэмж санхүүжүүлэх хэрэгтэй гэж би үзэж байна.

Хоёрдугаарт ханшийн эрсдлийн асуудал дээр Монголбанк, Хөгжлийн банк хамтарч ажиллах хэрэгтэй. Монгол төгрөгийн тогтвортой байх асуудлыг тодорхой хэмжээгээр шийдэх ийм үүрэг нь Монголбанканд байж байгаа, Сангийн яам энд тодорхой хэмжээгээр оролцох ёстой. Тийм учраас энэ ханшийн эрсдэлд орж байгаа компаниудыг тодорхой хэмжээгээр асуудлыг нь авч шийдвэрлэх тэр ажлыг Монголбанк хийх ёстой. Ажлын хэсэг ихэнх нь хэвлэлд гарчихсан тэр мэдээлэлтэй ижил хэмжээний л мэдээллийг өгч байгаа. Тэгэхээр энийг цаашдаа улам эрчимжүүлэхийн тулд бид бүхэн Түр хороо байгуулах ёстой гэж би үзэж байгаа юм. Улсын Их Хурлын хянан шалгалтын тухай хуулийн дагуу Түр хороо байгуулах юм бол мөрдөн шалгах, гэрчээр дуудах, нотлох баримт цуглуулах, шинжээч томилох энэ тэр гээд нэлээн олон олон эрхүүдтэй байдаг. Тэр эрхүүдээ хэрэгжүүлээд явах юм бол яах вэ. Тэр зарим аж ахуйн нэгжийн барьцаа хөрөнгийг чөлөөлсөн байж байна шүү дээ. Тэр хүмүүсийг дуудаад асуух, яагаад ийм шийдвэр гаргасан юм, хэн нөлөөлсөн юм гэдгийг асуух ийм боломж нь бүрдэнэ ээ л гэж харж байгаа юм. Дөрөв дэх цаашдаа авах арга хэмжээ бол энэ Хөгжлийн банкиг татан буулгах хэрэгтэй. Нэг талдаа тэр активын удирдлагын компани байгуулаад тэр муу зээлийг нь тэндээ үүрүүлээд, тэндээ төлүүлэх тэр арга хэмжээг нь хэрэгжүүлэх ёстой. Сайн зээлүүдийг нь одоо Хөрөнгө оруулалтын банк болгож, өөрөөр хэлбэл Хөрөнгө оруулалтын банкиг өнөөдөр батлах цаг болсон. Энэ хэдэн банкнууд гадаадын банкиг оруулж ирэхгүй. Ингэж гацаасаар байгаад өнөөдөр Монгол Улс ганцаараа шахуу гадаадын банк, хөрөнгө оруулалтаар орж ирээгүй ийм улс орон болж хувирч байгаа. Зээлийн өндөр хүүтэй учраас Төрийн банк ч юм уу, аль эсвэл одоо Хөгжлийн банк нэрээр банк байгуулаад, тэндээсээ улсын төсвөөс 1 их наядаар нь төгрөг оруулж байгаад бондоос мөнгө авч байгаад, тэрийгээ одоо төрд үүрүүлж байгаад тэгээд эндээсээ ингээд улс төрчид нь нөлөөлж зээл авдаг ийм тогтолцоог бол болих хэрэгтэй. Хөрөнгө оруулалтын банк орж ирэх юм болбол яах вэ? Гадаадаас маш бага эх үүсвэртэй, хүүтэй эх үүсвэр оруулж ирээд энийгээ зээл болгоод өгөх юм болбол хэн нэгэн албан тушаалтанд хандахгүйгээр, тэр банкнаас очоод зээл авах боломж нь иргэдэд компаниудад очих юм аа, ийм одоо эрх зүйн өөрчлөлтийг хийхгүй бол цаашдаа явахгүй юм байна аа гэдгээ хэлье. Тэгээд Түр хороо байгуулах энэ санаачилгыг манай бүлгийн дарга Ганбат гишүүн гаргаад тэрний дагуу 17 гишүүн гарын үсэг зурчихсан байгаа. Тун ойрын үед 2 гишүүн гарын үсэг зураад Түр хороо байгуулах санаачилга цаашаа явна аа гэж би харж байгаа. Тэрхүү Түр хороон дээр энэ парламентын засаглалтай Монгол оронд парламентын энэ эрх үүрэг ямар хүчтэй байдгийг бас харуулах ийм цаг болсон гэдгийг хэлэх байна. Баярлалаа.

**Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн Ж.Бат-Эрдэнэ:**

Б.Жавхлан сайд.

**Б.Жавхлан-Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд:**

Ганц нэг тоон дээр нь тодруулж хэлье ээ. Б.Пүрэвдорж гишүүн ээ, хэрвээ 2016 оноос өмнө, хойно гэж статистикаа харах юм бол ийм байгаа юм. Одоо чанаргүй зээл гээд ангилагдчихаж байгаа 1.8 их наядын 1.2 их наяд буюу 66 хувь нь гуравны хоёр хувь нь 2016 оноос өмнө, 2016 он хүртэл гэсэн үг. Бусад үлдсэн 600 тэрбум нь 2016 оноос хойш гэж ингэж ангилагдаж байгаа юм. Тэгэхээр Хөгжлийн банк өөрөө бие даасан хуультай, ийм институц, арилжааны банк биш арилжааны банктай өрсөлдөх учиргүй өөрөөр хэлбэл арилжааны банкны ажилладаг тэр олон нийтийн

ритейл зах зээл дээр өрсөлддөг банк байж болохгүй. Хөгжлийн санхүүжилт хийдэг томоохон төслүүдийг санхүүжүүлдэг ийм л институц байх ёстой. Өөрөөр хэлбэл тоондоо биш чанартаа чухал байх ёстой. Ийм олон зээлдэгчтэй чухал биш, цөөхөн сайн хөгжлийн хөрөнгө оруулалтууд дээр бүтээн байгуулалтуудыг хийгдэх ёстой ийм институц, ийм байгаа юм. За тэр татан буулгая гэж байна. Хөгжлийн банкийг хэрхэвч татан буулгаж болохгүй хэрхэвч болохгүй. Хөгжлийн банк нь зээлжих зэрэглэл өндөртэй, сайн ажиллаж байвал энэ тухайн улс орныхоо, ялангуяа Засгийн газрынхаа маш том нүүр царай нь болж байдаг. Тийм учраас бид одоо үүсчихээд байгаа чанаргүй зээлтэйгээ л сайн ажиллах ёстой. Энийгээ одоо богино хугацаанд учрыг нь олж төлж барагдуулж, ингээд хуулийг нь маш сайн боловсронгуй болгож, улс төр болон төрөөс оролцдог энэ буруу тогтолцоогоо халж аваад цааш нь Хөгжлийн банкийг жинхэнэ утгаар нь хуулийнхаа дагуу ажиллуулах нь өөрөө чухал юм байгаа юм шүү. Харин хөрөнгө оруулалтын банкнууд, гаднын банкнуудыг оруулж ирэх ёстой гэдэг дээр 100 хувь санал нийлж байна. Өнгөрсөн 4 жил өргөн баригдсан хууль одоо хүртэл явж өгөхгүй байгаа юм. Ж.Бат-Эрдэнэ дарга Эдийн засгийн байнгын хорооны гол гишүүдийн нэг, энэ хуулийг бас нэг эргэж хараарай. Ойрын хугацаанд уг нь энэ банкны системд хийгдэж байгаа хуулийн өөрчлөлтүүдийн хүрээнд энийг заавал авч үзэх ёстой байгаа юм шүү.

### **Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн Ж.Бат-Эрдэнэ:**

Гаднын банк ер нь оруулж ирэх хэрэгтэй байгаа байх шүү ер нь энэ дээр анхаарал хандуулахгүй бол болохгүй байгаа юм. Б.Пүрэвдорж гишүүн. Хэдэн минут үлдчихэв?

### **Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж:**

Хөгжлийн банк амжилттай явсан дөрөвхөн улс байдаг юм л даа. Япон, Солонгос, Сингапур гээд нэг хэдхэн улс байдаг юм. Бусад нь бол ерөнхийдөө ингээд амжилтгүй болоод дууссан ийм л зүйл байдаг юм. Тэгэхээр энд эрх зүйн орчныг нь сайн бүрдүүлж чадсан учраас энэ улсуудад бол нэлээн сайн явсан, тэгээд дээрээс нь хариуцлагаа сайн тооцож чаддаг улсууд байхгүй юу. Тийм учраас сайн явсан юм. Тийм учраас манайхан шиг ийм бүх юманд улс төрчид нь дайраад орчихдог ийм улсад бол амжилттай явж чадахгүй ээ гэдгээ хэлье. Тэгээд би тийм учраас энэ Хөгжлийн банкийг Хөрөнгө оруулалтын банкаар солих хэрэгтэй. Хөрөнгө оруулалтын банк нь ихэнхдээ гадаадын бага эх үүсвэртэй зээлийг оруулж ирэх чадвартай тийм банкнууд байх ёстой гэж үзэж байгаа юм. Таны хэлдэг үнэн. 1.2 их наяд нь бол 2012-2016 онд тавьсан зээлүүд гэгдэж байгаа юм. Хөгжлийн банкны 2016 онд хийсэн Б.Энхбаяр гишүүний ахалж хийсэн тэр шалгалтыг яагаад нууцалсан юм, яагаад нууцалсан юм бэ гэхлээр тэр тухайн үед 16 компани эрсдэлд орсон байсан. Тэрний 6 нь төрийн өмчийн компани, 7 нь ч байна уу, Монгол ардын намын гишүүдийн компани тэгээд тэр үлдсэн нь Худалдаа хөгжлийн банк гэж явдаг. Тийм учраас нууцалсан. Тэгээд “Худалдаа хөгжлийн банк”-ны муу нэр нь манай нам дээр гардаг. Үнэн. Яагаад гэвэл энэ мөнгө энэ бүх мөнгүүдийг бүгдийг нь тэр нөгөө “Эрдэнэт”-ийг худалдаж авахад зарцуулсан гэж тооцдог. Тэгээд энэ зээлийг олгосон гэдэг муу нэр нь гардаг. Сайныг нь Монгол ардын нам хүртсэн. 2020 оны сонгууль, 2021 оны сонгуулиар энэ “Эрдэнэт” үйлдвэрийн мөнгөөр сонгуулиа хийцгээсэн. Нийт иргэдийн, нийт аж ахуйн нэгжүүдийн цахилгааны мөнгийг Эрдэнэтийн 2 их наяд төгрөгөөр тэглэж, энэ хугацаандаа сонгогчдод нөлөөлөх замаар та нар олонхын суудал авсан. Хэрвээ энэ 49 хувь Оросод байсан бол тэр 2 их наядыг та нар зарцуулж чадна аа, Оросуудын өмнө гөлөг болчихсон байж байгаа байх. Ийм л юм. Тэгээд ер нь бол энэ Хөгжлийн банкны 2 мянган аж ахуй нэгжид зээл олгосон.

Тэрнээс 17 нь асуудалтай болж хойшоо орж ирсэн шүү. Үлдсэн нь одоо маш их олон үйлдвэрүүд импортыг орлосон, экспортыг дэмжсэн маш их олон үйлдвэрүүд бий болсон тэрний буянаар өнөөдөр улсын төсвийн татварын орлого, НӨАТ-ын орлого энэ бүх орлогууд чинь хангалттай өндөр хэмжээнд байгаа шүү. Та бүхний хийсэн ажил ч гэж мэдэхгүй юм байна. Дарханы 200 километр замаа ч тавьж чадахгүй.

### **Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн Ж.Бат-Эрдэнэ:**

Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа үгээ хэлье.

### **Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа:**

Хөгжлийн банкнаас олгосон зээлийн талаар сая мэдээлэл зөндөө л сонслоо. Одоо чи би гэж яриад нэмэргүй байх аа. Тэгээд л Монгол Улсын нэр хүнд Олон улсад тавигдаж байна. Үнэнээ хэлэхэд Б.Жавхлан сайдын хэлж байгаа үнэн. Өнөөдөр тэр гадаадын компаниар удирдлагыг нь хийлгэж байгаад л тэгснээ хамгийн сүүлд гэрээг нь яг нүүрэн дээр нь ураад л май чи энэ гэрээгээ аваад зайл, чамаар бид нар менежментээ хийлгэхгүй гээд хөөгөөд явуулсан л гэж ярьдаг шүү дээ угаасаа одоо тэгэхээр ийм болчихсон байгаа банкныг хэнийг ирж удирд гээд хэн удирдах юм. Гадаадад ажилгүй явж байгаа хүн л ирдэггүй л юм бол одоо өөр хүн бол ирнэ гэж байхгүй шүү дээ, ойлгомжтой. Тэгээд 1.8 их наядын чанаргүй зээл, 1.2 их наядыг 2012-2016 онд олгосон нь үнэн. Энүүнээс Худалдаа хөгжлийн банкны хуульч байсан Батсуурийг Захиргааны хэргийн танхимын хэргийн шүүгчээр томилсон, Батсуурийн аав Д.Мишиг гэдэг хүн “Хөтөлийн цемент шохойн” үйлдвэрийг үнэгүйдүүлэн авсан. “Бэйзмент” компанийн 20 хувийг одоо хувь эзэмшигч нь байсан гээд үүн дээр манай энэ та бүхэн Хөгжлийн банкныхан та бүхэн өөрсдөө энүүн дээр нэмж надад үүнийг тодруулж тайлбарлаж өгөөрэй.

Хоёрдугаарт энэ Хөгжлийн банкны бас нэг Эрсдлийн удирдлагын газрын захирал Бат-Оргил гэдэг хүн Хөгжлийн банканд 213 тэрбумын өртэй “Кью Эс Си” ХХК-ийн хувьцаа эзэмшигч энэ компанийн бас эзэн гэсэн ийм мэдээлэл байна. Энэ үнэн үү? Тэгээд өөрөө өөртөө зээл олгоод өөрийнхөө өрийг одоо өөрөө хариуцдаг, ийм байж болох юм уу? Тэгээд одоо энэ Хөгжлийн банкныг далдаас удирдаад байна гээд байгаа. Энэ бүх зээлийг чинь аваад өнөөдөр Монгол Улсыг өрөнд оруулаад байгаа энэ бүх юмны чинь ард ийм том сүлжээ яваад байхад энэ хууль хяналтын байгууллагууд өнөөдөр энүүн дээр ямар яг ажлууд хийгээд ямар эргэн төлөлт хийгдсэн юм бэ? За одоо энэ нэг цементийн үйлдвэр энэ тэр гээд л нэг хэдэн хүмүүсийг бүр улс эх орноороо барьж идэхээ шахаж байх шиг байна. Гэхдээ хэрвээ хэдэн зуун тэрбумаар, таван зуун тэрбумаар нь ингэж авчхаад, тэгээд өөрийнхөө хүмүүсийг аваачаад томилчхоод ингэдэг юм бол монголын төртэй ер нь хэн харьцах юм, цаашдаа. Бид нар 2016 онд энэ ажлын хэсэг гаргаад дүгнэлтүүдийг өгөөд хууль хяналтын байгууллага ч гэсэндээ заримыг нь шилжүүлсэн л дээ. Үүн дээр бол уг нь бол маш тодорхой бичсэн байсан. Аягүй өндөр дүнтэй телевизийн сурталчилгааны гэрээнүүд байгуулчихсан би одоо ойлгохгүй байгаа юм. Хөгжлийн банк хэрвээ зар сурталчилгаа хийхгүй бол хүмүүс ирж зээл авахгүй байсан юм уу хаашаа юм. Зөвхөн Блүүмберг телевизтэй гэхэд 2013 оны 10 дугаар сард 1.8 сая ам.долларын гэрээ байгуулаад, 2013 онд 652 мянган ам.доллар шилжүүлсэн байгаа юм. Тэгээд энэ ямар одоо нэг жижигхэн банк байгаа биш, банк бус санхүүгийн байгууллага байгаа биш ломбард байгаа биш. Ингэж их зээллэг явуулахын төлөө ингэж их зар сурталчилгаа гаргана гэдгийг бол би жишээлбэл ойлгохгүй байгаа юм. 2016 онд худалдан авсан нийт гэрээний үнийн дүн бол 1.2 их наяд энүүний ихэнхийг нь олон нийтийн мэдээллийн хэрэгслээр сурталчилгаа явуулахад зориулаад Улсын Их

Хурлын 2016 оны сонгуулийн өмнө буюу 06 дугаар сард энэ гэрээнүүдийг байгуулсан байсан. Өөрөөр хэлбэл Хөгжлийн банк бол 2016 оны сонгуулийн, тухайн үед эрх барьж байсан хүмүүс энэ одоо захирал нь сонгуульд зориулж энэ бүгдийг гаргасан юм шиг байгаа юм. Тэгээд сонгуулийн өмнө маш их зээллэг хийх гээд байсан юм уу, одоо хаашаа юм. Тэгээд энэ төрийн өмч компаниудын урсгал зардлуудад баахан мөнгө гаргачихсан. Энэ одоо ямар хууль эрх зүйн орчноор яаж гаргасан юм бүү мэд. 1.4 их наяд төгрөгийг жишээлбэл “Эгийн голын усан цахилгаан станц”-д энэ нь тэгээд баригдаагүй, “Таван толгойн цахилгаан станц”-д зориулаад 3 сая ам.доллар энэ нь бас байхгүй. “Шинэ төмөр зам”-д зориулаад хуулийн зөвлөх үйлчилгээ нь 3.2 сая ам.доллар, энэ би бүр 2016, 2017 оны тоо баримтуудыг дурдаж байна шүү. Техникийн зөвлөх үйлчилгээнд 3 сая ам.доллар, санхүүгийн зөвлөх үйлчилгээ 1.6 сая ам.доллар, “Хаан банк”-ны зээл, хүүгийн төлбөр 6.5 сая ам.доллар. Тэгээд одоо яг үнэнийг хэлэхэд энэ төслүүдээс хэд нь явсан билээ. Та бүхэн өөрсдөө бүгдээрээ сайн мэдэж байгаа. Тэгээд цаашид яах юм бэ дарга нараа. Одоо зөндөө том ажлын хэсэг ажиллаад нийгэм тэр аяараа баахан бухимдаад. Хүмүүс ипотекийн зээлээ ч төлж чадахгүй, банк бус санхүүгийн байгууллага, ломбард дээр ч мөнгөө төлж чадахгүй, өмч хөрөнгөө хураалгаж байхад нэг хэсэг хүмүүс нь бол бараг барьцаа мөнгө ч үгүйгээр ирээдүйн орлого гэдэг юмаар барьцаалаад тэгээд ийм их мөнгийг авчихдаг юм байна аа. Тэгэхээр иргэд бид нар яах юм бэ гээд бухимдаад байна аа. Энүүн дээр одоо тэгээд яах юм бэ? Манай хууль хяналтын байгууллага өнөөдрийг болтол одоо тэгээд шалгаж байгаа гэж байгаа юм. Тэгээд одоо миний бодлоор бол ингэнэ, одоо адгийн зарга арав хоног энэ ахиад аягүй бол 10 жилийн хэрүүл болно. За нэг хэдэн хүмүүсийг аваачаад хийнэ, аягүй бол максимум нь 2 жил суугаад гарна. Тэгэхдээ энэ Хөгжлийн банкны зээлийг чинь одоо бид нар төлдгөөрөө төлөх ёстой шүү дээ гадаадад. Түрүүн Н.Алтанхуяг гишүүн бараг л надад мөнгөтэй засаг Хөгжлийн банк өгчихсөн Сү.Батболд гээд ингээд бараг уурлаад байх шиг байна лээ. Нөгөө өөх өгсөн хүнтэй өдөр шөнөжин хэрэлдэнэ гэгчээр. Нээрээ л нэлээн их мөнгө босгоод энүүнийг Монгол Улсын хөгжлийн томоохон төслүүдийг санхүүжүүлээрэй гээд өгсөн, 2012 оны 10 дугаар сараас авахуулаад том зээлүүдийг нь гаргасан юм байна лээ. Тэрнээс өмнө гарсан зээл ч бараг байхгүй юм байна лээ. Тэгэхээр одоо тэгээд яах юм энүүний чинь эргэн төлөлтийг хэрвээ Хөгжлийн банк өөрөө хийж чадахгүй гэх юм бол улсын төсвөөс төлөх юм уу. Мандуул захирал аа. Энэ одоо ямар зарчимтай, яаж энэ зээллэгүүд нь, бондууд нь, эргэн төлөлтүүд нь яаж хийгдэхээр танайтай гэрээ байгаа юм бэ, нэгдүгээрт.

Хоёрдугаарт цаашид ер нь яая гэж бодож байгаа юм бэ. Энэ олон компаниудыг ингээд бүгдийг нь чанаргүй, чанаргүй гээд оруулчихжээ. Та бүхэн одоо Ковид хүртэл ядаж зээллэгээ төлөөд явж байсан компаниудтай нь дахиж одоо зээлийг нь төлөх хуваарийг баталж болохгүй юм уу. Ковид болсонд энэ хүмүүсийн буруу байхгүй шүү дээ, урд хил хаагдсанд энэ хүмүүсийн буруу байхгүй шүү дээ. Украин, Оросод дайн болсонд энэ хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийн буруу байхгүй шүү дээ. Тэгээд ингээд ханш нь өнөөдөр өсөөд явчихсанд манай энэ хувийн хэвшлийнхний, иргэдийн байдаг юм уу буруу байхгүй шүү дээ. Тэгээд эд нарыг ингээд царцаалаа, дансыг нь хаачихаж байгаа юм. Бизнесийг нь зогсоочхож байгаа юм. Тэгэхээр танайд эргэн төлөлт хийгдэх юм уу? Эргэн төлөлт хийгдэхгүй бол танайх энэ бүх мөнгийг яаж төлөх юм. За эд нарын барьцаалсан хөрөнгийг эсхүл энэ цементийнх нь үйлдвэрийг авлаа. Та нар цементийн үйлдвэр ажиллуулах юм уу? “ТОСК”-тай өчнөөн жил миний мэдэхээр сүүлийн тав зургаан жил ноцолдоод “ТОСК”-ийн менежментийг сайжруулаад энэ эргэн төлөлтийг нь хийж чадахгүй байгаа шүү дээ. Тэгээд одоо тэгвэл эд нарын бүгдийнх нь бизнесийг нь хураагаад ав л даа, тэгээд яах юм. Активын удирдлагын тухай хууль гэж бид нарт

батлагдаагүй. Тэгэхээр энэ бүх чанаргүй зээлүүдийг барьцаа хөрөнгүүдийг энэ бизнесүүдийг яах хууль эрх зүйн орчин нь одоо хүртэл тодорхойгүй. Тэгэхээр одоо Төрийн өмчийн удирдлага зохицуулалтын газраас би одоо бас өнөөдөр энэ дээр яагаад хүн байхгүй байгааг ойлгохгүй байна. Яагаад гэвэл гуравны нэг зээлүүдийг нь төрийн өмчит компаниуд авчхаад, одоо ингээд энийг улсын төсөвт шилжүүлэх нь зүйтэй гээд түрүүний Мандуул захирлын ярьж байгаа бол төрийн өмчит компаниудын зээлийн асуудлуудыг яриад байсан. Үгүй ээ юу гэж бид нар улсын төсвөөс, одоо энэ төрийн өмчит компаниуд, захирлууд нь бид нараас өчнөөн өндөр цалинтай, өчнөөн олон дэд захиралтай, бүгдээрээ том том машин унасан хүмүүсийн зээлийг бид нар яахаараа төлдөг юм, улсын төсвөөс, татвар төлөгчдийн мөнгөөр, Ковидын үед цэцэрлэг сургуулиа барьж чадахгүй эмнэлгээ барьж чадахгүй байхад. Тэгэхээр одоо цаашаа явъя гэж байгаа арга зам нь яг юу юм бэ. Чанаргүй зээл гээд баахан зарлачихлаа. Одоо энэ компаниудыг чинь бараа бүтээгдэхүүнийг хүмүүс авахгүй шүү дээ. Гэрээ хийхгүй шүү дээ. Танайх угаасаа битүүмжлэгдэх гэж байгаа юм биш үү, бизнес чинь зогсох гэж байгаа юм биш үү гээд дансыг нь бараг царцаачихсан юм биш үү? Хаачихсан юм биш үү? Тэгээд одоо цаашаагаа явах гэж байгаа арга замыг би ерөөсөө ойлгохгүй байна аа, нэгдүгээрт.

Хоёрдугаарт та нар ер нь ямар зарчмаар энэ ийм ялгаатай, хүүтэй зээлүүдийг өгсөн юм. Заримд нь 3 хувьтай, заримд нь 10 хэдэн хувьтай, бүр ам.долларын. Мэдэхгүй би одоо ойлгохгүй байна, уг нь бол энэ Хөгжлийн банкныг чинь Монгол Улсын хөгжилд хөтлөх том том төслүүдийг арилжааны банкнууд санхүүжүүлэхгүй учраас энүүнийг Хөгжлийн банкаар бид нар санхүүжүүлэе гэж анх энэ Хөгжлийн банкныг байгуулаад улсын төсвөөс анхны эх үүсвэрийг нь, за тэгээд бондуудыг босгосон. Тэгсэн чинь одоо маруужингийн үйлдвэр хүртэл санхүүжүүлээд явчихсан, тухайн үед энэ бол стратегийн хөрөнгө оруулалт байсан юм шиг байгаа юм. Би бол одоо тэгж л ойлгосон сүүлдээ. Тэгэхээр төмөр замаа тавьж чадахгүй байж байж, боомтуудынхаа шинэчлэлийг хийж чадахгүй байж байж, маруужингийн үйлдвэр барих нь одоо нэн чухал байсан юм болов уу тухайн үедээ гэж би ойлгоод байгаа юм. Тэгээд энэ гүйцэтгэх удирдлагуудыг томилсныг нь харахаар одоо ийм миний хяналт шалгалт хийж байх үеийнх Мөнхбат захирал шаардлага хангасан эсэх, хангаагүй ээ. Хөрөнгө оруулалтын газрын захирал Буянмөнх шаардлага хангасан эсэх, хангаагүй ээ. Одонтуул Зээлийн газрын захирал, бүр мэдээлэл байхгүй ээ. Батбилэг Хяналт, захиргааны газрын захирал, хангаагүй ээ. Бат-Өлзий Актив пассивын удирдлагын газрын захирал, хангаагүй ээ. Тэгээд ингэж, одоо би л хувийн хэвшил бол ийм байдлаар хүмүүс өөрийнхөө бизнесийг удирдуулах уу? Хэзээ ч үгүй шүү дээ. Ард түмний мөнгийг болохоороо тэгээд эргэн төлөлт нь хэн нэгнээс хийгдчих юм чинь гээд ингээд хаячихдаг юм шиг байна. Тэгээд одоо цаашаагаа яая гэж бодож байгаа юм бэ, энэ ажлын хэсэг дээрээс нь нэмээд Сангийн яам байх уу? Сангийн яам дээр энэ 2020 оны 04 дүгээр сард ирсэн. Түрүүн Ч.Хүрэлбаатар гишүүн бас хэлж байна лээ. Сангийн яам энүүн дээр ямар оролцоотой байсан юм бэ гээд, өмчийн удирдлага бол тухайн үед Засгийн газрын Хэрэг эрхлэхэд байсан. Тэгээд зарим нэг хийж байгаа тайлан мэдээллүүд бол үнэнхүү мөлгөр байна, энэ Үндэсний аудитын газраас хийж байгаа тайлан, мэдээллүүд бол авч ч болохгүй, хаяж ч болохгүй баахан тоо уншаад л байх юм уншаад л байх юм. Эсрэгээрээ бид нар акт тавьсан, энэ дээр ийм арга хэмжээ авсан. Бид нар тэдэн онд ингэж анх тавьсан, ингэж эргэн төлөлт хийгдсэн гэдэг ийм л юм хүмүүс хүсээд байгаа шүү дээ. Тэрнээс биш одоо наад тоог чинь сонсоод, санаа сэтгэлээр унахаас илүү цаашаа юм бол алга л даа. Тэгээд ийм хэдэн асуултуудыг асуух гэсэн юм. Мандуул захирлаас, Жавхлан сайд бас заримыг нь хариулах байх гэж бодож байна.

## **Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн Ж.Бат-Эрдэнэ:**

Хөгжлийн банк 21 дүгээр микрофон.

### **Хөгжлийн банкны гүйцэтгэх захирал Н.Мандуул:**

Гишүүний асуултад хариулъя аа. Булгантуяа гишүүн цаашид яах вэ гэж байна. Бид бол одоо байгаа, чанаргүй болсон 1.8 их наядын зээлийн багцаа шинж чанараар нь ангилсан юм. Шийдвэр гаргагч нарт шийдвэр гаргахад бас дөхөм болох болов уу гэсэн үүднээсээ ингээд ангилаад үзэхээр нэг хэсэг нь ойролцоогоор гуравны нэг нь төрийн өмчит компаниудын зарцуулсан төсвийн шинж чанартай зардал байна. Тэрийг нь гаргаж ирж тавьж байгаа юм. Сая бас намайг засаг руу өгөх гээд байна энэ тэр гээд засаг руу өгөх энэ тэр асуудал чинь Улсын Их Хурал болон Засгийн шийдэх асуудлаа, бид зүгээр шийдлийн хувилбар гаргаж тавьж байгаа юм. Нөгөөдөх нь 500 орчим тэрбум төгрөг нь “Хөтөл” болон “Кью Эс Си”. Манай Ж.Эрхэмбаатар дэд захирал миний дараа бас таны тэр тодруулна гэсэн асуултуудад нэмээд хариулчихна. Ингээд үзэхээр цаана нь 980 ойролцоогоор 1 их наяд төгрөгийн хувийн хэвшлийн чанаргүй зээлийн багц үлдээд байгаа юм. Энэ дээр бид сая бас нэлээн олон яригдлаа шүүхэд нэхэмжлэл гаргасан шүүхэд өгчихсөн одоогоор ингээд шүүхээр явж байгаа 30 гаруй зээлдэгчийн асуудал байна. Заримтай нь янз янзын бас хэлэлцээр хийж байна, төлье гээд эхнээсээ төлж байна. Өнөөдрийн байдлаар 136 тэрбум төгрөг төлөгдөөд явж байна. За энэ бол бас нэг талаараа амжилт. Бид хэрвээ энэ үйл ажиллагаагаа цааш нь эрчимжүүлээд хууль хяналтын байгууллагуудтай хамтарч ажиллаад явах юм бол ямар ч байсан энэ 1 их наяд төгрөгөө оны эцэс гэхэд барагдуулчихна гэж харж байгаа юм. Эдгээр бүгдийнх нь бизнесийг нь булааж авна гээд байгаа юм байхгүй, хэлэлцээрт орж байна. Зээлээ барагдуулах тал дээр хуваарь тохиролцъё гэсэн саналууд ирж байна. Тэгэхээр бид нөхцөлөө муутгахгүйгээр яаж энэ зээлээ хурдан төлүүлэх вэ гээд янз янзын аргууд яриад явж байна л даа. Зарим нь бүр байхгүй нөхдүүд ч бас байна, барьцаа хөрөнгө ч байхгүй, эсвэл өөрсдөө олдохгүй байгаа нөхдүүд байна. Тэд нар яалт ч байхгүй тэр хууль хяналтын байгууллагаар явахаас өөр арга байхгүй. Нэг ийм арга, хувилбар санал болгосон шүү. Нөгөө талдаа актив удирдлагын компани байгуулах асуудлыг боловсруулаад оны өмнө бид Сангийн яаманд хувилбараа санал болгосон. Ер нь бол шийдвэр гаргагчдын зүгээс шийдлийн хувилбар санал болгооч ээ гэдгийг хүсээд байгаа гэж ойлгоод байгаа юм. Тэгээд бид бол чадах ядахаараа хувилбарууд санал болгоод байна. Тэгээд мэдээж буруу зөв, давуу сул талууд хувилбар болгон дээр байгаа. Түүнийг үнэлж дүгнээд Улсын Их Хурал, Засгийн газар дээр шийдэх болов уу гэж бодож байна.

Зээлүүдийн хувьд 2016 оноос өмнө 3 төрлийн зээл гарсан байгаад байдаг юм Хөгжлийн банкнаас. Нэг нь бол шууд Хөгжлийн банк өөрөө зээл гаргасан байгаад байгаа юм. Нөгөөдөх нь бол дамжуулангын зээл гээд одоо гишүүний яриад байгаа тэр жижиглэнгийн зээлүүд бол арилжааны банкуудаар дамжуулсан тэр зээлүүд болов уу. Нийтдээ 2016 он хүртэл 1.2 их наяд төгрөгийн 13 хөтөлбөр арилжааны банкнуудаар дамжиж гарсан байдаг юм байна лээ. Гурав дахь бүлэг нь улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй гээд төсөв батлахад Улсын Их Хурлаас жагсаалт болгож баталсан тэр зээлүүд. Түүнийг шууд төсвийн тухай хуулиараа жилийн төсвийн хуулиар Хөгжлийн банк энийг санхүүжилтийг нь олго, эргүүлээд ирэх жилийн төсвөөс улсаас төлнө өө гэсэн тийм нөхцөлтэйгөөр хууль болгоод баталчихсан, тэр санхүүжилтүүд гэсэн нэг тийм бүлэг байгаад байна. Тэдгээр нь 2017 онд, 2016 оны жилийн эцсээр гэхэд нөгөө талдаа Чингис бондын хөрөнгөтэй офсет болоод суутган тооцож, тэгж цэвэрлэгдсэн тийм асуудал байгаад байгаа.



Миний танилцуулга дээр зээлийн багц болон өр төлбөр, пассив талынх нь тоонууд дээр тэдгээр нь бүгд харагдаж байгаа юм. Тэгэхээр нэг иймэрхүү зүйлүүд байгаа юм. Ер нь одоогийн байдлаар банкны хувьд зээл гаргахгүй байгаа. Шинэ удирдлагын хувьд нэг ч шинэ зээл гаргаагүй. Өмнө нь 2017 оноос хэсэгхэн хугацаанд гүйцэтгэх удирдлага өөрөө шийдээд бага дүнтэй зээл бас олгож байсан юм байна лээ. Тэдгээрээс энэ чанаргүй актив дээр явж байгаа. Дараа нь дүрмийн өөрчлөлт оруулаад 20 тэрбумаас доош зээл олгохгүй ээ гэдэг дүрмийн заалттай болоод гаргах зээлийн дүнгүүд нь томорсон тийм зүйл байгаа. Одоо Ж.Эрхэмбаатар захирал “Хөтөл” ХХК, “Кью Эс Си” ХХК-ийн талаар мэдээлэл өгнө өө.

### **Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн Ж.Бат-Эрдэнэ:**

22 дугаар микрофон.

### **Хөгжлийн банкны үйл ажиллагаа хариуцсан дэд захирал Ж.Эрхэмбаатар:**

Х.Булгантуяа гишүүний асуултад хариулъя манай банкны нэлээн хүндэрчихсэн 2 зээлийн хариуцагчийн хамаарлын талаарх мэдээллийг хөндлөө. Энэ дээр бүрэн мэдээлэл өгөх үүднээс дараах тайлбарыг өгье. “Кью Эс Си” ХХК бол 2008 онд үүсгэн байгуулагдсан байгаа. “Бэйзмент” гэдэг компани мөн яг нэг өдөр үүсгэн байгуулагдсан байгаа. Ингээд “Улаанбаатар капитал” гэдэг компани 10 хувь, “Юнайтед секьюритс” гэдэг компани 30 хувь, “Ти Ди Би секьюритс” гэдэг компани 30 хувь, “Оргил смарт солюшн” гэдэг компани 30 хувийг эзэмшдэг. Энэ “Оргил смарт солюшн” гэдэг компанийн эзэн болох Бат-Оргил нь 2016 оны 03 дугаар сард Хөгжлийн банканд ажилд ороод нэг шийдвэр гаргалтад оролцчихоод 08 дугаар сард нь оролцчихоод 09 дүгээр сард нь ажлаа өгчихсөн байгаа юм. Энэ ямар учиртай шийдвэр гаргалт байсан бэ гэхээр “Кью Эс Си” гэдэг компанид 33 километр гэж ярьдаг, 36 гэж ярьдаг, 20.4 гэж ярьдаг ингээд ийм уртын хувьд тодорхойгүй маргаан бүхий километр төмөр замын барилгын ажлыг санхүүжүүлэх зорилготой 71 сая ам.долларын зээл олгосон. Үүнийг Засгийн газар бол худалдаж авах буюу вексель, өрийн бичиг бичээд авчихсан өөрийн өмчлөлдөө. Энэ векселийг “Улаанбаатар хотын банк”, “Худалдаа хөгжлийн банк” аль аль нь аваад 2016 оны 08 дугаар сарын 09-ний өдөр Хөгжлийн банканд дээр ирж ирээд мөнгөжүүлчихсэн. Энэ мөнгөжүүлэх хэлэлцээрт энэ хүн өөрөө биечилж оролцоод дүгнэлт гаргаад оролцоод явчихсан байгаа. Өөрөөр хэлбэл өөрийнхөө эзэмшлийн компанийн векселийг мөнгөжүүлэх ажиллагаанд өөрөө оролцсон гэсэн үг. “Улаанбаатар капитал” гэж компанийг төлөөлөн удирдах зөвлөлийн дарга нь Мөнхбаатар гэж этгээд байдаг. Энэ бол “Монгол зэс корпораци”-ийн Мөнхбаатар, төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Мөнхбаатар, үүний гэр бүлийн хүн нь өнөөдөр Хөгжлийн банканд ажилладаг ажлаас гарах тухай мэдэгдлийг өгчихсөн байгаа.

Хоёр дахь компанийн тухайд 2008 оны мөн 10 дугаар сарын 31-ний өдөр, ингээд нэг өдөр үүсгэн байгуулж байгаа юм. “Бэйзмент” гэдэг компани Равсалын Мөнхтуул гэж хүн үүсгэн байгуулсан. За улмаар 2010 оны 11 дүгээр сарын 02-ны өдөр Чулуунбаатар овогтой Энхболд 50 хувь, Мөнхтуул нь 30 хувь, Дэлгэр овогтой Мишиг 20 хувь эзэмшиж байгаа юм. Энэ Мишиг гэдэг хүн бол 1948 онд төрсөн хүн байгаа. 2011 оны 01 дүгээр сарын 04-ний өдөр Мөнхтуул, Мишиг нар нь хувьцаа нь өөрчлөгдөнө бага зэрэг. За ингээд 2015 оны 10 дугаар сарын 27-ны өдөр тэдгээр 3 хувьцаа эзэмшигч гурвуулаа Мэжиг овогтой Бөх-Очир гэж иргэнд хувьцаагаа бэлэглэчихэж байгаа юм, үнэ төлбөргүйгээр. Энэ 2015 он гэхэд “Хөтөл” гэдэг компани бол 2012 онд 2010 оны хөрөнгө оруулалтын гэрээгээр болоод манайхаас

авсан “Бэйзмент” гэдэг компани маань манайхаас авсан зээл гээд ингээд нэлээд хөрөнгөтэй. “Хөтөл цемент шохой” үйлдвэр дээр хяналтаа бүрэн тогтоочихсон хувьчлаад авчихсан ийм л үнэ өртөгтэй компанийг бэлэглэчихэж байгаа юм. Энэ хэлцэл бол 2015 оны 10 дугаар сарын 27-ны өдөр болсон. За ингээд энэ 11 дүгээр сарынхаа 09-ний өдрөө “Бэйзмент” гэдэг компани “Хөтөл” болж өөрчлөгдөөд өнөөдрийг хүртэл ингээд Цемент шохойтой холилдоод ингээд ойлгомжгүй байдал үүсгэчихээд яваад байгаа. 2018 оны 11 дүгээр сард хувьцаа эзэмшигч нас барсан. Үүнээс хойш дэд захирал Ганзориг гэдэг этгээд буюу “Бэйзмент” гэдэг компанийн удирдах зөвлөлийн дарга, одоо “Цемент шохой”-д санхүү эрхэлсэн захирал эрхэлж байгаа Оюунчимэг гэж хүний хүүхэд нь талийгаач Бөх-Очироос итгэмжлэл аваад 3 жил үйл ажиллагаа явуулсан. Хувьцаа эзэмшигч эрхээ хэрэгжүүлсэн. Уг нь иргэний хуулиар итгэмжлүүлсэн төлөөлөгч нь нас барвал тэр итгэмжлэл хүчингүй болдог хуультай. Тэгээд ингээд хүчин төгөлдөр бус хэлцлээс үүдэлтэйгээр харилцаа үүсгээд явчихсан. Яг Хөгжлийн банк өрөө төлүүлье гээд шүүхэд өгөхөөр ирдэггүй. Энэ үйл ажиллагааг бол Авлигатай тэмцэх газар шалгаж тогтоогоод яллагдагчаар татаад ажиллаж байгаа гэж ойлгож байгаа.

### **Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн Ж.Бат-Эрдэнэ:**

Тодруулах цаггүй болчихлоо. Улсын Их Хурлын гишүүн Л.Энх-Амгалан асуулт асууя аа.

### **УИХ-ын гишүүн Л.Энх-Амгалан:**

За энэ их сайн зүйл ээ. Тэгээд нийгмээрээ ингээд шүгэл хүлээж байгаа анхны бараг тохиолдол болж байх шиг байна. Өнөрөөгийн үлээсэн шүгэл, Лодойгийн үлээсэн шүгэл ингээд нийгмийн шүгэл болж байгаа нь их сайн зүйл, улс төрийн намууд нь бүгдээрээ оролцож ингэж ярилцаж байна. Энэ бас цоо шинэ ч сэдэв биш ээ. 2015 оноос эхэлсэн энэ сэдэв, 2015 онд би Улсын Их Хурлын гишүүн, цөөнхийн гишүүн байхдаа энэ ажлын хэсгийг ахалж шалгаж байсан. Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо, Төсвийн байнгын хорооны 2015 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн тогтоолоор байгуулагдаж байсан ийм ажлын хэсэг. Би ахлаад Г.Батхүү гишүүн, Ц.Баярсайхан, Х.Болорчулуун, Я.Санжмятав, Г.Уянга, Б.Чойжилсүрэн, Ч.Хүрэлбаатар, Л.Эрдэнэчимэг, Д.Гарамгайбаатар гишүүд гээд ажлын хэсэг ажилласан юм. Ардчилсан намаас ч орсон, Ардын намаас орсон. Тэгээд энэ ажлын хэсэг их сайн ажилласан юм уг нь, маш сайн ажилласан юм хоёр Байнгын хороо. Тэгээд 2 удаа аудитын дүгнэлт гараад, тэгээд энэ аудитын дүгнэлт гаргасан 10 хүн ажлаасаа халагдчихсан юм. 10 хүн ажлаас халагдчихсан. Тэгээд өнөөдөр ингээд энэ 2015 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр гаргасан Олон улсын зах зээлд гаргасан Засгийн газрын үнэт цаасны арилжаагаар төвлөрсөн хөрөнгийн зарцуулалт, эргэн төлөлт болон санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрийн сонголт, Хөгжлийн банкны үйл ажиллагаатай танилцсан ажлын хэсгийн санал, дүгнэлтийг энэ бол маш сайн дүгнэлт гаргаад, маш сайн зөвлөмж гаргаад, тэгээд холбогдох бүх байгууллагад нь өгөөд тэгээд л ингээд л орхичихсон байхгүй юу. Энэ дээр яг энэ дүгнэлтийг үзэхэд одоо би Баттөмөр гишүүнд ч гэсэн хүргүүлсэн тийм үү? Энэ дүгнэлтийг уншихад өнөөдрийн бид нарын байж байгаа үүссэн нөхцөл байдлыг тэр үед яг ийм нөхцөл байдал үүсэх нь шүү гэж анхааруулж байсан. Маш их чанаргүй зээлүүд гарч байна шүү. Улсын Их Хурал, Засгийн газрын тогтоолгүй зээлүүд гарч байна шүү. Барьцаагүй зээлүүд гарсан байна шүү, энэ зээлүүдээ та нар Монголбанк зээлийнхээ санд бүртгэж аваарай, чанаргүй зээлийнхээ санд бүртгэж аваарай. Энэ Чингис бонд, Самурай бондын мөнгөөр зарим арилжааны эрсдэлтэй банкнууд дээр байршиж байсан байна шүү гээд. Энийг Лодой, Өнөрөө хоёр уншсан байх энэ бүх

дүгнэлтүүдийг. Тэгээд энэний мөрөөр арга хэмжээ авчихсан байсан бол өнөөдөр одоо ингээд нэг ийм ниргэсэн хойно нь хашгирав гэдэг шиг ийм зүйл болохгүй л дээ. Тэгээд би яагаад ингээд өнөөдөр энд ирж байр сууриа илэрхийлж байгаа юм гэхээр энэ Хөгжлийн банк шалгаснаас хойш намайг ингээд Хөгжлийн банк энэ 2015 оноос хойш, ер нь Хөгжлийн банкны хамгийн том зээлдэгч гээд нэг ийм золбин үг тараасан л даа. Тэгээд хэд хэдэн удаа би өөрөө энийгээ шалгуулсан юм. Тэгэхдээ энэ Улсын Их Хурлын түүхэнд анхны тохиолдол байх аа, 2016 онд би дахиж Улсын Их Хурлын гишүүн болоод 11 дүгээр сард Улсын Их Хурлынхаа бүрэн эрхээс татгалзаж шалгуулах анхны хүсэлтийг би Улсын Их Хурлын гишүүний түүхэнд гаргаж байсан гишүүн. Улсын Их Хурлын дарга, Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хороо, Ёс зүйн дэд хороонд ингэж гаргаж байсан. Улсын Их Хурлын бүрэн эрхээсээ татгалзсан анхны тохиолдол шүү Улсын Их Хуралд. Ингээд энэний дагуу Авлигатай тэмцэх газраас энэ холбогдох нэр бүхий компаниудыг ингэж шалгаад тантай ямар ч хамааралгүй юм байна аа гээд энэ гарсан дүгнэлтүүд байна. За ингээд хамгийн сүүлд 2019 онд энэ Хөгжлийн банкнаас авсан зээл байхгүй, аливаа өр, өрийн үлдэгдэлгүй ээ гээд ингээд гаргаж өгсөн тодорхойлолт, эсвэл ийм худлаа тодорхойлолт гаргаж өгч байсан юм уу. Тэгээд нэг ийм маягаар одоо ингээд өнөөдөр гүтгүүлж явж байгаа юм аа. Тэгээд энэ нь дандаа гүтгэлэг байсан л даа харамсалтай нь. Тэгээд өнөөдрийн бас энэ Улсын Их Хурлын нэр бүхий ажлын хэсгийн одоо гаргаж ирж байгаа энэ мэдээлэл дээр гээд би дахиад нэг юм ээлжит гүтгэлэг болоод, тэгээд улс төрийн өрсөлдөгчдөө намнадаг нэг ийм хэрэгсэл болчих вий дээ гэж би санаа зовж байгаа юм. Би олон үр дүн гарч байгааг үгүйсгэхгүй байна. Өнөөдөр ингээд энэ зарлаж байгаа хэвлэл мэдээллийн хэрэгслээр зээлдэгчдийн улс төрийн нөлөө хамаарлын тухайд гээд ингээд нэг ийм 20 улс төрчийг зарлаж байгаа. Тэгээд энэ чинь одоо яг үнэхээр тогтоогдсон юм уу гээд асуухаар хэвлэл мэдээл дээр л гарсан нэрүүд гэж байгаа. Тэгээд Улсын Их Хурлын гишүүд ингэж хэвлэл мэдээллээр гарсан, одоо санаатай санаагүй, гүтгэж байсан, доромжилж байсан энэ зүйлүүдийг ингэж гаргаж ирж тавьдгийг би өнөөдөр гайхаад байгаа юм. Гайхаад байгаа юм. Би өөрөө нэг их тийм тендерт дуртай хүн биш л дээ. Бас нэг авлигал албан тушаалтай бас нэр холбогдоод байдаггүй. Ер нь бол улс төрчийн хамгийн үнэтэй капитал чинь нэр төр шүү дээ. Нэр төр. Улс төрчийн капиталыг өөрийнх нь хадгаламжийн хэмжээ, өөрийнх нь эзэмшиж байгаа хөрөнгөөр хэн ч хэмждэггүй ард түмний итгэл үнэмшлээр л хэмждэг. Цэвэр улс төрчийн улс төрчид өөрөө өөрсдийнхөө ингэж золиосолдог, намнадаг ийм арга хэлбэр лүү л одоо орох гэж байгаа ийм л хэлбэр байна шүү дээ. Би үнэхээр тендерт дуртай байсан хүн бол би Боловсролын сайд болоод монголын хамгийн их тендертэй 500 тендерийг шилжүүлэхгүй байсан байх аа. Шилжүүлэхгүй байсан байх. Ингэж эрх мэдлээ шилжүүлэхгүй байсан байх. Би Төрийн банкиг шалгаж явсан болохоос биш Төрийн банкиг ерөөсөө тонож явна гэж ерөөсөө зүүдлээгүй, тонуулчин гэж хэлүүлнэ гэж зүүдлээгүй байх. Энэ яг юу болоод байгаа юм. Ийм байж болохгүй шүү дээ. Би тэгж тэр тендерээр тэрбумтан болоогүй, өнөөдөр өөрийнхөө амьдарч байгаа байшинг, өөрийнхөө унаж явж байгаа машиныг ямар орлогоор авснаа тайлагнаж чадахгүй бэмбэгнэж байж ийм шударга царайлсан ийм нөхдүүд байж болохгүй шүү дээ. Энэ юу болоод байгаа юм. Өнөөдөр ингээд ийм нотолгоогүй, баталгаагүй ингээд тийм шүүх хурал болоод байгаа юм уу, яагаад байгаа юм. Ийм байдлаар одоо ингээд бид нар бие биедээ ингэж хандаж болох юм уу? Тэгээд хэлж байгаа тайлбарууд нь тийм их ядмаг тайлбар.

Хууль хяналтын байгууллагууд чинь хэлээд байна шүү дээ, заримыг нь шалгаад байна, нэр холбогдож байгаа улсуудыг нь графикайн дагуу шалгаад явж байна гээд хэлээд тайлбарлаад байж байна шүү дээ. Тэгэхээр яг ийм байдлаар улс

төрийн жижиг тооцоо, өшөө хонзон маягаар ийм нөхцөл байдлыг төрүүлмээргүй байна гэж би харж байгаа. Тэгээд бизнесийнхний бас нэр хүнд байх шиг байна.

Энэ ажлын хэсгийн гол зорилго бол хэн нь өнөөдөр улс төрийн зээл авчихсан юм бэ, хэн нь өнөөдөр улс төрийн нөлөөгөөр зээл авчихсан юм. Аль зээл нь өнөөдөр яг жинхэнэ утгаараа бизнесийн зээл юм, аль нь өнөөдөр барьцаатай зээл юм, барьцаа нь хангагдаж байгаа юм, аль нь барьцаатай зээл авч байгаад дараа нь барьцаагаа, цуцалчихсан юм гэсэн ийм зүйлүүдийг л бид нар нэг нэгээр нь гаргаж ирж тавих ёстой л гэж би ойлгоод байгаа шүү дээ. Тэгээд одоо хаа хамаагүй байсан “Монгема” гэж компанитай би яахаараа хамааралтай болчихов. Өнөөдөр улс төрчдийн чинь ганц юмаа үнэлдэг юм чинь хөрөнгө орлогын мэдүүлэг л байгаа. Хөрөнгө орлогын мэдүүлэг дээрээ бид нар эзэмшдэг хувьцаагаа, эзэмшдэг хөрөнгөө, унадаг машинаа хүртэл тайлагнадаг шүү дээ. Улс төрчийн хөрөнгө орлогын мэдүүлэг дээр байхгүй зүйлүүдээр, бүүр 2011 онд юм шиг байгаа юм, 2011 онд би Улсын Их Хурлын гишүүн байгаагүй. Тэгэхэд тэр “Монгема” гэж компанийн 50 орчим хувийг нь барьцаалж, хувьцааны барьцаа өгч, жижиг зээл өгч байсан юм билээ. Тэгээд тэр зээл нь эргээд буцаад төлөгдсөн. Ийм байдлаар 2011 оны юмнуудыг тухайн компанийн бизнесүүдийн харьцааны юмнуудыг өнөөдөр гаргаж ирж ингэж шийдэх юм уу, ингэж бусдынхаа нэр төрд увайгүйгээр хандах юм. Ийм байж болохгүй шүү дээ. Харин ч энэ Хөгжлийн банкиг чинь шалгаж 7 жил нэр төрөө гутаалгаж явлаа шүү дээ. Тийм учраас би ганцхан өөрийнхөө нүүрийг хамгаалж байгаа юм ерөөсөө асуудал байхгүй. Өнөөдөр улс төрчдийн болоод энэ баялаг бүтээгчдийнхээ юмнуудыг жинхэнэ утгаар нь ялгаасай, салгаасай л гэж харж байгаа юм, Б.Баттөмөр гишүүнээ. Ийм үндэслэлгүйгээр ингээд мэдээллүүд хийгээд, энэ мэдээллүүдээ тойроод хэвлэл мэдээллийнхэн нь бужигнаад байж байх үнэхээр надад бол их л харамсалтай л санагдаж байна. Тэгээд их сайн жишгүүд байна сая Сангийн сайд хэлж байх шиг байна. Ер нь бол нийгмээрээ ингэж шүгэл үлээх нь магадгүй банк дампууруулснаас илүү их үр дүнд хүрдэг юм байна. Өнөөдрийн зээлийн эргэн төлөхөд 130-140 тэрбум төгрөг, дахиад компаниуд нь зээлээ эргэн төлье гээд ингээд явъя гэдэг байдлаар хандаж байна гэж байна шүү дээ. Тэгэхээр энэ хэлбэрлүүгээ цөмөөрөө эндээс эрүүл саруул шийдлүүд гаргаад явах нь хэн хэндээ, монголын ард түмэнд ашигтай болов уу л гэж бодож байгаа. Монголын ард түмэнд. Эргээд энэ чинь Хөгжлийн банкны мөнгө бол Монголын ард түмний татвар төлөгчдийн мөнгөөр барьцаалагдаж ирсэн зээлийн мөнгө. Тэгэхээр энэ дээр ийм эрүүл саруул байдлаар шийдлүүдээ гаргаж ирж ингэж ярихгүй бол хаа хамаагүй 2011, 2012, 2013 оны бизнесүүдийн хоорондын өгч авч байсан өгөө аваануудыг дэлгээд гаргаад, ингээд өнөөдөр тэр нь 2021, 2022 онд хамааралтай юм байна гэсэн ийм байдлаар үндэслэлгүй дүгнэлтүүд хийгээд, гүтгээд доромжлоод сууж болохгүй. Би хариуцлагатай няцаалт өгч байна, Б.Баттөмөр гишүүн ээ. Бас би Улсын Их Хурлын түүхэнд анх удаа өөрийнхөө бүрэн эрхийг татгалзуулж шалгуулья гэж улс төрийн эр зориг гаргаж байсан гишүүний хувьд ингэж бодож байгаа юм. Ингэж би үнэхээр энэ няцаалтуудыг өгье гэж бодож өнөөдөр хуралд оролцъё гэж бодсон юм.

Хоёрдугаарт 2015 оноос хойш хийсэн энэ шалгалтын материалууд, энэ бүх зүйлүүдийг өнөөдөр хууль хяналтын байгууллагуудад ч гэсэн олон удаа өгч байсан. Дахиад бас өгч байгаа. Сая шүгэл үлээсэн сэтгүүлч нар ч хүртэл энийгээ аваад өнөөдрийн гаргаж байгаа энэ юмнууд бүгдээрээ л бүх нийтэд үнэн, зөв мэдээллүүд хүрч байх шиг байна. Бүгдийг үгүйсгээгүй, бүгдийг үгүйсгэхгүй. Тийм учраас асуудалд эрүүл, саруулаар хандах хэрэгцээ шаардлага бас үүсэж байгааг би хариуцлагатайгаар мэдэгдье л гэж бодож байна.

**Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн Ж.Бат-Эрдэнэ:**

Сангийн сайд Б.Жавхлан хариульъя.

**УИХ-ын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан:**

За баярлалаа. Х.Булгантуяа гишүүний асуулт дээр нэмж хариульъя. Одоо бид яах вэ гэж байгаа, одоо бидэнд өрөө барагдуулахаас өөр зам байхгүй. Ойрын хугацаанд тийм гэгээлэг өөр аятайхан зүйл ярих юм байхгүй. Өнөөдөр энд дурдагдахгүй байгаа нэг зүйл байгаад байна. 2023 оны 12 дугаар сард Самурай бонд төлөгдөнө. 30 тэрбум иен, одоогийнхоор бол 270 сая ам.доллар, төгрөгөөр бол 780-аад тэрбум төгрөг байгаа юм. Хэрвээ энэ төлөгдөхгүй бол Засгийн газрын давхар баталгаатай, төлөгдөхгүй бол Хөгжлийн банк дефолт үүснэ, Засгийн газар энийг төлөх болно. Татвар төлөгчдийн мөнгөөр төлөх ийм эрсдэл байгаа. бидэнд 1 жил 8 сарын хугацаа байна. За ийм эрсдэлтэй зүйл рүү яваад орчихмооргүй байна. Одоо байгаа энэ 1.8 их наяд чанаргүй зээлийн талыг нь, тал арай ч хүрэхгүй юм уу даа. Энийг нь төлүүлчих юм бол Хөгжлийн банк өөрөө энийгээ асуудалгүй төлөөд явчих юм байна. Чанаргүй зээлтэй ажиллаж байгаа энэ богино хугацаанд 136 тэрбум орчим төгрөгийн зээл төлөгдсөн байна. За нэлээдгүй хүнд зээлүүдээс 88.5 тэрбум төгрөг төлөгдсөн байна. Энэ хурдаараа тал, талаасаа хамтраад ажиллах юм бол бас боломж байна гэж харагдаж байгаа. Харин сая бодогдож суусан зүйл гэвэл Активын удирдлагын тухай хууль энэ тэр гэхээр их олон янзын хар дагуулаад, өмнөх 4 жилийн хугацаанд ч бас сайн хууль гарч өгөөгүй. Харин зүгээр Хөгжлийн банканд дээр зориулаад Хөгжлийн банкны чанаргүй зээлийг албадан төлүүлэх тухай ч гэдэг юм уу, өөрөөр хэлбэл шүүхийн бусад замаар Хөгжлийн банкны нөхөд өөрсдөө албадлагын арга хэмжээ аваад, хүчний байгууллагуудтай нийлээд шүү, шүүх дээр очихоос өмнө хүчний байгууллагуудтай нийлээд төлүүлчих, энэ чанаргүй зээлтэй ажиллачих боломжууд, хуулийн гарцууд байгаа болов уу гэж харж байгаа. Түрүүн би нэг зүйл дутуу хэлсэн байна лээ, шүүх дээр очоод ингээд явчихаар манай шүүхийн нас маань 3-4 жил, бараг зарим тохиолдолд шүүхийн шийдвэр гүйцэтгэлтэйгээ нийлээд бараг 5 жил болдог. Хуулинд тогтолцоо нь өөрөө ийм байгаад байгаа юм. Харин тэрнээс наана Авлигатай тэмцэх газар, Эрүүгийн цагдаагийн газар, дүүргийн цагдаагийн газрууд харин ч илүү, шүүхээс наана төлүүлэх, албадлагын арга хэмжээ авах, шахалт үзүүлэх энэ зүйлүүд дээр хамтарч сайн ажиллаж багагүй үр дүн гараад явж байгаа. Тэгээд ойрын хугацаанд ерөөсөө ийм л ажил хийгдэнэ. Ийм юм байгаа, за тэр татан буулгах асуудал хэрхэвч байж болохгүй.

**Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн Ж.Бат-Эрдэнэ:**

Б.Баттөмөр ажлын хэсгийн ахлагч асуултад хариульъя.

**УИХ-ын гишүүн, ажлын хэсгийн ахлагч Б.Баттөмөр:** Л.Энх-Амгалан гишүүний асуултад хариульъя. Энэ “Монгема” гээд компани байгаа юм. Муур, нохойны хоол тэжээл боловсруулна, үйлдвэр байгуулна гэсэн ийм зээл байгаа юм, 12.8 тэрбум төгрөгийн чанаргүй зээлтэй. Тэгээд компанийн түүхийг судлаад үзэхээр “Интер групп интернэшл” гээд компани 55 хувийг нь эзэмшиж байсан юм байна. Сая Л.Энх-Амгалан гишүүн хэлж байна, мөнгө зээлдээд хувьцааг нь барьцаалсан юм байна. Энэ компани нь 2017 оны 07 дугаар сарын 05-ны өдөр энэ компаниас нь гараад явчихсан юм байна. Энэ утгаараа Л.Энх-Амгалан гишүүнд ямар нэгэн улс төрийн хамаарал байхгүй. Бид нар энэ хяналт шалгалтын ажлыг хийж байх явцад хэвлэл, мэдээллээр гарч байгаа энэ асуултуудыг анхааран судалж үзсэн юм. Одоо

сүүлийн үед хэвлэл, мэдээллийн хэрэгслээр бидний мэдэхгүй, мэдээгүй асар их олон зүйлийг гаргаж ирж тавьж байна. Энд үзэхээр Л.Энх-Амгалан гишүүнийг нөлөөлсөн гэдэг хардлага сэрдлэг хэд хэдэн хэвлэл дээр гарсан юм. Тэгээд нөлөөлсөн байж болзошгүй гэдэг утгаар нь энэ сая 20 нэрд оруулсан юм. Энэ бол ямар нэгэн байдлаар тогтоочихсон юм биш. Ер нь бол энд орсон улсуудыг хууль хяналтын байгууллагад хандаад нэр төрөө цэвэрлэж авдаг юм уу, үнэхээр үнэн юм уу, худлаа юм уу энийгээ тодруулаач гэсэн утгаар ингэсэн юм. Л.Энх-Амгалан гишүүний хувьд эрчтэй, хүчтэй, мэдлэг боловсролтой маш сайн боловсон хүчин, өнөөдөр сайд хийж байгаа, цаашдын улс төрийн карьер нь асар өндөр. Би бас Л.Энх-Амгалан гишүүнийг хүндэтгэж явдаг. Ийм учраас хардлагад ингэж өртөж сайн, муу хэлүүлж байснаас тэр хуучин туршлага байгаа юм байна, гишүүнээсээ татгалзаж байгаад ч гэсэн шалгуулъя гээд, энд бол татгалзаад байх юм байхгүй. Хууль хяналтын байгууллагад өгөөд нэрээ цэвэрлээд авчихаач ээ. Энд битгий эмзэглээрэй. Улсын Их Хурлын гишүүдээс бүрдсэн ажлын хэсэг 5 гишүүнтэй ярилцаад л энийг ингэж оруулж ирсэн юм. Ийм учраас энд эмзэглэх хэрэггүй. Ингээд шийдээд шалгуулаад нэрээ цэвэрлээд авчих нь зүйтэй гэдэг утгаар ингэж оруулсан шүү, Л.Энх-Амгалан гишүүн ойлгоорой.

Ажлын хэсгийн ахлагчийн хувьд хэдэн зүйл хэлье. Х.Булгантуяа гишүүний асуултад, ер нь бол аливаа зүйлийг эхлүүлэхдээ төгсгөлийг нь харж чаддаг удирдагч бол хамгийн сайн удирдагч гэдэг. Тийм учраас Хөгжлийн банкныг давшгүй юм бол энд байхгүй шүү. Бүх эрх зүйн орчин байна уу, байна. Бүх материаллаг бааз байна уу, боловсон хүчин байна уу. Одоо энийг цаашаа авч явах л асуудал. Улсын Их Хурлаас эрх зүйн орчныг нь бүрдүүлж өгье. Хөгжлийн банк өөрөө Монгол Улсын хөгжлийн асуудлыг бодоод төлөвлөөд их зээл өгөөд явчихна гэж бодохгүй байна. Ийм учраас Засгийн газар санхүүжүүлэх төсөл, хөтөлбөрийг нь гаргаж өгч байх ёстой. Би ингэж бодож байна. Энэ утгаараа 2017 онд гаргасан тэр Засгийн газар хөгжлийн хөтөлбөрийг баталж өгөхгүй гэсэн буруу заалт гэж би бодож байгаа юм. Энийг бол хийж өгөх хэрэгтэй. Тэгээд Хөгжлийн банктайгаа Засгийн газар хамтраад энийг хийгээд явах боломжтой. За маш сайн удирдлагын багийг бүрдүүлж ажиллах шаардлагатай. Би томилогдож байгаа залуучуудыг сайн залуучууд томилогдсон байх гэж бодож байгаа. Маш сайн ажиллах шаардлагатай, мэдлэгтэй байх хэрэгтэй. Мэдлэг гэдэг хэл мэдсэнээр бол мэдлэгтэй гэдэг биш шүү дээ. Англи, Монголоор хольж ярьснаар мэдлэг гэдэггүй. Тийм учраас мэдлэг гэдэг бол сонголт хийх чадвар, мэдлэг гэдэг бол туршлага гэж байгаа юм. Ийм учраас туршлагатай хүмүүс, банкирууд, сайн эдийн засагч нар, инновацын сайн мэргэжилтнүүд энэ банканд ажиллах шаардлагатай. Ийм ийм зүйлүүдийг хийхэд энэ банк цаашаа ажиллаад явах боломжтой гэж ингэж үзэж байгаа юм. За баярлалаа.

#### **Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн Ж.Бат-Эрдэнэ:**

Түрүүн Х.Булгантуяа гишүүний цаашид яах вэ дарга нараа гэсэн асуулыг би бас тодруулах гээд энэ хүмүүст цаг өглөө. Сангийн сайд Б.Жавхлан, ажлын хэсгийн дарга Б.Баттөмөр, тэндээс бас Хөгжлийн банкныхан тайлбар хэллээ. Цаашид ямар арга хэмжээ авах юм бэ гээд. Л.Энх-Амгалан гишүүний хувьд бол нэр андуурсан байна тэ. Нэр андуурагдаад явсан юм байна, тэрийг тодруулъя. Ш.Адъяа Улсын Их Хурлын гишүүн үгээ хэлье.

**УИХ-ын гишүүн, ажлын хэсгийн гишүүн Ш.Адъяа:** Бид Хөгжлийн банкны асуудлыг олон сар ярьж байна. Өнөөдөр Монгол Улсын Их Хурлын нээлттэй сонсгол хийх хуулийн дагуу өргөн оролцоотой хэлэлцүүлэг хийж байна. Эндээс тодорхой шийдэл гарч, Монгол Улсыг барьцаалж авсан их хэмжээний өр ширний асуудал нэг

тийшээ болох байх гэж бодож, өнөөдөр хэлэлцүүлэгт оролцож, зарим зүйлийг бас тодруулъя гэж бодсон юм. Өнөөдөр энд ярьж байгаа Улсын Их Хурлын гишүүд олон янз бүрийн байр сууриас хандаад байна. Ардчилсан намын үед ч энэ зээл олгогдсон, Ардын намын үед ч энэ зээл олгогдсон. Хэн хэнийгээ буруутгах ийм өнгө аяс цухалзаж байгаа нь энэ хэлэлцүүлэг Хөгжлийн банкны асар их луйврын үр дагаврыг саармагжуулж болзошгүй гэдгийг нь цаашдаа анхаарах шаардлагатай байна.

Хөгжлийн банкнаас 2-3 зүйлийг тодруулъя. Хэвлэл, мэдээллээс авсан бидний мэдээллээс Хөгжлийн банканд авсан зээлийн 30 хувь буюу 1.8 их наяд төгрөгийн зээлийг Төрийн өмчит компаниудын авсан зээл байгаа гэсэн мэдээлэл байна. Ямар ямар Төрийн өмчит компаниуд энэ зээлийг авсан юм, ямар зорилгоор авсан юм, хөгжлийн ямар хөтөлбөрийг санхүүжүүлэхээр авсан бэ гэдгийг тодруулмаар байна. Тодорхой хариулт авъя. Өнөөдөр бид нар Төрийн өмчит компаниуд гээд ялсан намын улс төрчдийн тэтгэвэрт гарсан хүмүүсийг тэжээдэг, цүнх барьсан залуучуудын хоргодох байр болсон энэ Төрийн өмчит компаниудыг бид цэгцлэхгүй байсаар ямар нэгэн шийдвэр гаргахгүй, энийг хаацайлж улам өргөжүүлэх ийм асуудал газар авсан. Энэ талаар мэдээлэл авъя.

Дээр нь энд нэг сонин юм би гайхаад байгаа юм. 2016 онд Монгол Ардын Нам засгийн эрх авсан, 2020 онд засгийн эрхийг авсан, 2 сонгууль дараалан төрийн эрхийг барьж байна. Гэтэл өнөөдөр 2012-2016 онд асар их том луйвар илэрсэн. Тэрийг бид засах гэж улсын нууцад оруулчихсан гээд юм яриад байна. Улсын нууцад оруулсан шалтгаанаа тайлбарлахдаа Азийн хөгжлийн банкнаас бид нар зээл авах гэсэн юм, саарал жагсаалтад орох гээд энийгээ нуугаад гэж ийм онигооны юм яриад байна. Энд би итгэхгүй байна. Яагаад гэвэл тэр Азийн хөгжлийн банкнаас 2017, 2018 онд зээлээ аваад эдийн засаг сайжирсан гэсэн мэдээллийг эрх баригч, түүний Сангийн яам өгөөд байгаа шүү дээ. Тэгээд энийгээ яагаад өнөөдөр 2022 он, хоёр Улсын Их Хурлын бүрэн эрхийн хугацаа байхад яагаад энийг шийдэхгүй байсан юм? Би энийг бол нуун дарагдуулж байгаад дараагийн Хөгжлийн банкны зээлийг улс төрчид аваад одоо гаргаж ирж байгаа гэж ойлгож байгаа. Ийм хардах үндэслэл байна. 6 жил энийг дарна гэж байдаг юм уу? Энд чинь хэн итгэх юм. Дээр нь нууцад орсон материалаас нэг юман дээр гайхаад байгаа юм. Энэ нууцад байж байгаад ил болгосон гээд АСЕМ-ийн Ази, Европын орнуудын өндөр хэмжээний уулзалт зохион байгуулсан энэ асуудал дээр Засгийн газраас тогтоол гаргаад өндөр хэмжээний зочид буудлуудад зээл өгөх зорилгоор 275 тэрбум төгрөг өгсөн баримт байна. Ямар зочид буудалд энэ зээлийг өгсөн юм бэ? Энэ зээлээ төлсөн юм уу? Ямар их мөнгө вэ? 150 сая орчим ам.доллар байна тухайн үеийн ханшаар. Энэ зээлээ одоо хаана төлсөн юм, ямар зочид буудлууд авсан юм, тэр хүлээн авалтад ямар хүнд хэчнээн төгрөгийн бэлэг сэлт өгсөн юм. Энэ бас их сонирхолтой юм байна. Энийг авъя. Дээр нь Прокурор, Авлигатай тэмцэх газрын удирдлагуудаас нэг зүйлийг тодруулъя. Өнөөдөр энэ Хөгжлийн банкны хэрэг, зөрчлийг илрүүлж, гэм бурууг тогтоох талаар хууль хүчний байгууллагуудаас тодорхой арга хэмжээнүүдийг авч байгаа, хуулийн хүрээнд. Хөрөнгө битүүмжлэх, хөрөнгөө нуун дарагдуулах, хууль бусаар олсон орлогоо нуухаас сэргийлж Эрүүгийн байцаан шийтгэх хууль бусад хуульд заасан шаардлагатай арга хэмжээнүүдийг авч байгаа, авах нь зөв. Ингэж авч байж бид энэ хохирлыг барагдуулна. Гэтэл энэний хажуугаар асуудлууд үүссэн тухай иргэдээс бас мэдээлэл ирээд байна. Тухайлбал “Ган-хүдэр” ХХК дээр эрүү үүссэн, Дарханы төмөрлөгийн үйлдвэр дээр эрүү үүссэн. Дарханы төмөрлөгийн үйлдвэрийн Хятад улс руу гаргаж байгаа төмрийн хүдрийг хэд хэдэн вагоны цувааг замд нь өртөөн дээр битүүмжилсэн асуудал байгаа юм байна. Гэхдээ энэ төмрийн хүдрийг битүүмжлэх нь зөв, хөрөнгө хохирлыг. Гэтэл тэрнийг зөөж явж байсан

хувийн хэвшлийн вагон, тээврийн хэрэгслүүдийг хамт битүүмжилсэн асуудал байгаа юм байна. Улс орны экспортыг дэмжих вагоны хомсдолд орсон энэ нөхцөлд асуудлаа бас анхаарч үзэж асуудлыг шийдэх талаар анхааруул яасан юм бэ гэдэг асуултад тодруулга авъя.

**Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн Ж.Бат-Эрдэнэ:**

Хөгжлийн банк, 20 дугаар микрофон.

**Хөгжлийн банкны дэд захирал З.Батырбек:**

Сайн байцгаана уу, би бизнес хөгжил хариуцсан дэд захирлаар ажиллаж байгаа З.Батырбек байна. Гишүүний асуултад хариулъя. “Эрдэнэс монгол”-той холбоотой одоогийн байдлаар 150 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна. Энэ бол засмал замтай холбоотой авсан зээл байгаа, Төр шилжүүлж авсан, тухайн үедээ хийгдсэн. Эрчим хүчний яамны 45 тэрбум төгрөгийн үлдэгдэл байгаа. Энэ бол “Таван толгой”-той холбоотой станцын төслийг санхүүжүүлэх зорилгоор авагдсан. “Төрийн орон сууцны корпорац”-тай холбоотой 4 төрлийн зээл байгаа. Түрүүн ярьдаг “Шинэ яармаг”-аас бусад нь болохоор “Буянт-Ухаа-1”, “Буянт-Ухаа-2”, хөдөлгөөнт тоног төхөөрөмжийн зээлүүд байгаа. “Буянт-Ухаа-1” дээр болохоор 74.4 тэрбум төгрөг, “Буянт-Ухаа-2” болохоор 95 тэрбум төгрөг, Хөдөлгөөнт дээр болохоороо 25.6 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байгаа. “Шинэ яармаг”-тай холбоотой 117 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байгаа.

“Эгийн голын усан цахилгаан станц”-тай холбоотой 43.3 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байгаа. Энэ мөн төслийг санхүүжүүлэх зорилгоор авсан. Зорчигч тээврийн автобус шинэчлэхтэй холбоотой 17.3 тэрбум төгрөгийн зээлийн үлдэгдэл байгаа. “Дорнод бүсийн эрчим хүчний систем” буюу Чойбалсанд дулааны цахилгаан станцын өргөтгөл хийж байгаа 50 МВт-ын, энд зориулж бас зээл авсан байгаа. 4-р цахилгаан станцын өргөтгөлийн ажилд зориулж одоо 247 тэрбум төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байгаа. “МИАТ”-тай холбоотой, “МИАТ”-ын онгоцтой холбоотой 16 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй. “Монголын газрын тос боловсруулах үйлдвэр”-тэй холбоотой зээлийн нийт үлдэгдэл 242 тэрбум төгрөгөөр батлагдсан, одоогийн байдлаар авчихсан байгаа нь хүүтэйгээ болон бүх зээлийн үлдэгдэл нь 202 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байгаа. “АСЕМ Вилла”-тай холбоотой нийт 132 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байгаа. Тухайн үед Ази, номхон далайн улс орнуудын удирдагч нарын уулзалт Монгол Улсад зохион байгуулахтай холбоотой тухайн үед зочид буудлын асуудлыг санхүүжилт зорилгоор авсан зээл. За баярлалаа.

**Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн Ж.Бат-Эрдэнэ:**

Монгол Улсын Ерөнхий прокурор.

**Монгол Улсын Ерөнхий прокурор Б.Жаргалсайхан:**

Ш.Адьяаа гишүүний асуултад хариулъя. Би түрүүн мэдээлэл өгч байх үед олон хязгаарласан, битүүмжилсэн тоо баримтыг хэлсэн. Магадгүй энэ дотор яг таны хэлж байгаа асуудал битүүмжлэгдсэн байхыг үгүйсгэхгүй. Хэрвээ үндэслэлгүйгээр битүүмжлэгдсэн байна. Эсвэл хэрэгт шалгагдах холбогдолгүйгээр яг таны хэлж байгаа шиг өөр хүний асуудал ингээд битүүмжлэгдсэн байна гэвэл холбогдох мөрдөх байгууллага болон прокурорт гомдол гаргадаг. Өнөөдрийн байдлаар гомдол гаргасан асуудал байхгүй байна. Тийм учраас гишүүн та тийм гомдол таньд ирсэн



бол мөрдөх байгууллага болон прокурорын байгууллагад шилжүүлж бид нар хууль зүйн үндэслэлийг нь үзэх боломжтой. Хариулт дууслаа.

**Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн Ж.Бат-Эрдэнэ:**

Ш.Адъяа Улсын Их Хурлын гишүүн.

**УИХ-ын гишүүн, ажлын хэсгийн гишүүн Ш.Адъяа:** Хөгжлийн банкнаас тодруулъя аа. Зочид буудлын 152 тэрбум төгрөг гэдэг чинь яагаад төлөгддөггүй юм, ямар зочид буудалд байгаа юм. Өнөөдөр зочид хүлээж авна гээд зээл авч байгаа нь Хөгжлийн банкны чинь концепцитай яаж байна. Энэ дээр ямар дүгнэлттэй байна. Тэгээд зочид буудлууд нь ямар зочид буудлууд нь мөнгөө төлдөггүй юм. Энэ талаар хариулт авъя.

Б.Жаргалсайхан прокурор бас та зөв ойлгоорой. Өнөөдөр би тэр Дарханы төмөрлөгийн үйлдвэрийн ачиж яваа төмрийг битүүмжилсэнг яриагүй, төмрийг нь ачаад явж байсан хувийн компанийн вагонууд нь хамт зогсоод байгаа асуудлыг ярьсан. Тэрнээс биш тэр Дарханы төмөрлөгийн үйлдвэрийн хууль бусаар гаргаж байгаа хохирол барагдуулахын төлөө битүүмжилсэн хөрөнгийн тухай яриагүй, тэрнийг ачаад явж байсан тэр хувийн компанийн вагонуудыг хамт зогсоогоод байгаа тухай асуудлыг л хөндөж ярьсан шүү. Тэрнээс биш тэр Дарханы төмөрлөгийн үйлдвэрийн гаргасан төмрийг эрүүгийн хуулийн хүрээнд хөрөнгө битүүмжлэх асуудлыг хөндөж яриагүй шүү. Та зөв ойлгоорой.

**Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн Ж.Бат-Эрдэнэ:**

20 дугаар микрофон.

**Хөгжлийн банкны дэд захирал З.Батырбек:**

Гишүүний асуултад хариулъя. 2015 оны 331 дүгээр Засгийн газрын тогтоолоор уг зээл гарсан. Арилжааны банкнуудаар дамжиж гарсан, 2020 онд бүрэн төлөгдөж дууссан. Одоо ямар нэгэн зээлийн үлдэгдэл байхгүй.

**Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн Ж.Бат-Эрдэнэ:**

Б.Энхбаяр гишүүн.

**УИХ-ын гишүүн Б.Энхбаяр:**

Би асуулт асуухгүй үг хэлнэ. Хэнээс ч асуух вэ. Ард иргэд энэ удаагийн сонсголыг цөхрөлийн нүдээр харж байгаа гэдэгт эргэлзэхгүй байна. Итгэлийн нүдээр харж байгаа нь юу л бол. 2020 оны Улсын Их Хурлын сонгуульд нэр дэвшээд сонгогчидтойгоо уулзаад явж байхад иргэдийн нэг нүдийг мартдаггүй. Тэр нь бол итгэлийн нүд. Маш их итгэсэн, ийм найдсан харцаар уулзаж байсан. Энэ их итгэл гэдэг бол ачаа. Бидний хамгийн дээд эзэн бол энэ итгэлийг тээж байгаа ард түмэн байгаа. Энэ итгэлийг үнэхээр их алдсан гэдгийг энэ удаагийн сонсголд харуулж байгаа байх. Яагаад гэхээр бид боломж хулгайлагчдын тухай ярьж байгаа. Найдваргүй болсон, хулгайлсан мөнгөн дүнг нь авч үзэх юм бол Монгол Улсын дөнгөж төрж байгаа нярай хүүхдээсээ эхлээд өвгөд хөгшдөө хүртэл хүн тус бүрд 2 сая төгрөг өгөхүйц ийм их хэмжээний мөнгийг, ийм их хэмжээний боломжийг хулгайлсан хулгайн тухай ярьж байгаа. Энэ хулгайнаас хоцорсон гэр бүл гэж нөгөө

топ-10 биш зуун гэр бүл бараг бүгд оролцсон. Төрийн тэргүүнээсээ эхлээд хууль тогтоогч сайд, бидний хамгийн их итгэж найддаг шүүх, мөрдөх байгууллага, прокурорын нөхдүүд энэ хулгайд оролцсон. Яагаад тэд итгэл дүүрэн өнөөдрийг хүртэл энэ хулгайг үргэлжлүүлсэн бэ? Энд Ерөнхийлөгчид оролцсон. Тэд хуулийн байгууллагынхны хамгийн дээд ноён оргилуудыг томилж байгаа. Тэднээрээ дамжуулж хаацайлсан. Мөн ар нь түүз байгаа учраас өөрсдөө хулгайд гардан оролцсон. Гол нь бүгдийг нь ярих гэхээр багтахгүй, бид хамгийн томыг нь л ярих ёстой, томтой нь толгойтой нь. Сая Ш.Адьшаа гишүүн асууж байна, АСЕМ дээр 200 хэдэн тэрбум төгрөг идчихсэн байна. Энэ Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржтой холбоотой. Одоо өөрөө “Асем вилла”-д амьдарч байгаа. “Асем вилла”-гийн нэг байшин 4 тэрбум төгрөгийн үнэтэй. Энийг холоос хайгаад байх хэрэг байхгүй. АСЕМ-ийн асуудлыг 2016 оны Хөгжлийн банкны шалгалтын дүнд байгаа, шалгаагүй. Яагаад тэр үед Ерөнхийлөгч нь Ц.Элбэгдорж байсан. Дараа нь Ерөнхийлөгч нь Х.Баттулга болсон, Төмөр замын хулгай, “Хөтөл”-ийн асуудал, “Шинэ яармаг”, “Богд уул” энэ хулгайг гардаж хийсэн этгээд. Эх орноо жинхэнээсээ хөгжүүлнэ гээд улс орон тойроод явж байгаа. Ард иргэд маань хэрсүү бай. Эх оронч хулгайч гэж байхгүй. Ардчилсан хулгайч гэж байхгүй. Хулгайч бол хулгайч. Энэ боломжийг хулгайлсан өртгийг цаашдаа яах вэ гэж. Хулгайчид нэг зүйл дээр нэгддэг юм шүү. Зовлон дээрээ нэгддэг юм. Адил зовлонтой болохоороо нэгдчихдэг юм. Ц.Элбэгдорж, Х.Баттулга хоёр одоо үзэлцэж байгаа ч гэсэн нэгдэнэ. Юун дээр? Шоронд орохгүйн тулд нэгдэнэ. Бүх хулгайч нар нам үл харгалзан нэгддэг юм. Энэний золиос нь ч гэсэн би өөрөө болж явсан. Тэгэхдээ 2016 оныхноос нэг ялгаа байна. Х.Баттулга яваад одоо бид яриад сууж байгаа юм. Х.Баттулга байсан бол ярихгүй. Яриад сууж байна одоо энэ асуудал яагаад бөмбөг тэсрээд ил болоод, нээлттэй болж байна гэвэл ард түмэн тэр хулгай, хулгайчийг үргэлжлүүлсэн бол энэ бол улам үргэлжлэх байсан юм. Одоо улс төрийн манлайлал байна. Нам үл харгалзан хулгайчдаас салъя гэдэг улс төрийн манлайлал байна. Тийм учраас одоо ярьж байгаа нь сайн. Энийг үргэлжлүүлэх ёстой. Эцсийн хариуцлагыг хэнд тооцох вэ гэхээр хууль, шүүхийн байгууллагууд тооцно. Тийм учраас шүүхийн шинэчлэл явж байгаа юм. Энэ үр шимээ өгөх ёстой. Одоо нэг гарц байна Улсын Их Хурлын зүгээс юу хийж болох вэ гэж. Би бодож байна хууль, шүүхийн байгууллагууд одоо ажиллаад, 2016 оны тэр шалгалтыг дарсан шиг биш, жинхэнэ эзэн холбогдогч нарыг илчлүүл ээ. Хэн авлига авч байгаад зээл өгсөн, хэн бизнесийг нь дээрэмдэж байгаад зээл өгснийг одоо бизнес эрхлэгчид, эндээс зээл авсан хүмүүсээ хэл. Хэлвэл Улсын Их Хурал тэр эзнийг хэлсэн, авлигачийг, хамгийн дээд талын хүнийг хэлсэн хүнийг нэг удаагийн хууль гаргаад өршөөе. Жишээлбэл “Эрэл групп”-ийн Б.Эрдэнэбат та хэл одоо, таны бизнесийг хэн дээрэмдсэн билээ? Та хэнд авлига өгсөн, зээл авсан билээ хэлчих. Таныг өршөөе хууль гаргаж байгаад та эзнээ хэлчих. Тэр хамгийн том хүнийг нь хэлчих. Улсын Их Хуралд өршөөж дэмжье. Тантай асуудал ярихаа больё. Ийм байдлаар гол эздийг хариуцлага тооцох дээр Улсын Их Хурал санаачилга гаргая. Бидний хийж чадах зүйл энэ байна. Улсын Их Хурлын манлайлж чадах зүйл бол энэ л байна.

Эцэст нь бол би энэ зохион байгуулалттай холбоотой бас санал байна. Би хамгийн эхэнд хэлсэн энэ бол Улсын Их Хурлын хяналт шалгалтын хамгийн анхны сонсгол болж байгаа. Тийм учраас зохион байгуулалт өндөртэй байх ёстой. Улсын Их Хурлын гишүүд дээр тарааж байгаа материал алга. За яах вэ манай тоонд сайн гишүүд бол түрүүн дэлгэцэнд харуулсан тэр олон оронтой тоог цээжилсэн байж магадгүй. Би бол цээжлээгүй, цээжилж барах ч үгүй юм байна. Тийм учраас асуухад их төвөгтэй байна. Ийм байдлаар бол цааш цаашдаа сонсголыг бол хийж болохгүй гэж хэлмээр байна. Баярлалаа.

## **Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн Ж.Бат-Эрдэнэ:**

Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, хариулт авлаа. За ингээд Б.Энхбаяр гишүүн бас нээлт дээр хэлж байсан. Нэг сонсголыг хууль дүрмийнхээ дагуу явуулах ёстой. Тэгээд хуульд яг оролцогчдоос асуух асуулт гэсэн зүйл бол бас тодорхойгүй. За тэр утгаараа өөрийнхөө нэг багахан эрх мэдлийг гэх юм уу даа, хөтлөгч хийж байгаагийн хувьд сэтгүүлчдээс энэ хууль дотор сэтгүүлчид гэсэн юм байхгүй, оролцогч гэж байгаа, тэгэхээр хэвлэл, мэдээллийнхнийг би нэг жоохон оролцуулаад үг өгчихдөг юм уу гэсэн бодолтой байгаа юм. Өнөөдрийн сонсголын гол зорилго бол ард иргэддээ мэдээлэл өгөх шүү дээ. Төрийн удирдах үйл ажиллагаанд оролцох эрхийг хангах, мэдэх бололцоог олгох ийм сонсгол. Ер нь бол анхны сонсгол. Анхны сонсгол энэ анх хууль батлагдсанаас хойш явж байгаа анхны сонсгол. Алдаа мадаг байна. Надад туслалцаа үзүүлж байгаа Улсын Их Хурлын Тамгын газрынхан маань бас зарим зүйл дээр дутуу хийсэн зүйлүүд байна. Гэхдээ анхны удаа хийж байгаа ард иргэддээ мэдээлэл өгч байгаа, Улсын Их Хурлаас явуулж байгаа, Улсын Их Хурлын бүтцийн хүрээнд хийгдэж байгаа анхны сонсгол, мэдээлэл. Үүний цаана бид нар Байнгын хороондоо бүх тайлангаа өгнө. Байнгын хорооноос тодорхой асуудлууд дэвшүүлэгдэх байх. Тэгээд Улсын Их Хурал дээр дахиад асуудал дэвшүүлэгдээд сая жишээ нь Б.Энхбаяр гишүүний хэлсэнчлэн тодорхой асуудлууд гараад явах байх. Энэ бол Улсын Их Хурлын хүрээнд хийгдэж байгаа анхны ажил юм. Эхлэл гэж тооцож болох юм. Ингээд 4 хэвлэл, мэдээллийнхэн бас санал хэлье гэсэн зүйл байна, энэ хүрээнд асуудал нь явах болов уу гэж бодож байна. Зариг.мн Н.Өнөрцэцэг. “А” индэр дээрээс 5 минутад асууж, 5 минутад хариулт авна шүү үүнийгээ анхаараарай.

## **“Зариг.мн” Ерөнхий эрхлэгч, сэтгүүлч Н.Өнөрцэцэг:**

Хөгжлийн банкны асуудлаар нээлттэй сонсголд тал, талын байр суурийг илэрхийлж, мэдээлэл өгч байгаа эрхэм Улсын Их Хурлын гишүүд, албаны хүмүүс, мөн улс төрийн намын төлөөллүүд, хэвлэл мэдээллийн ажилтнууддаа баярлалаа. Энэ өдрийн мэндийг хүргэе ээ. За өглөө 09.00 цагаас хойш тасралтгүй сууж мэдээллийг сонслоо. Ерөнхийдөө нэг их айхтар шинэ зүйл алга. Уучлаарай. Нохойд барьдаг мод гэгчээр 20 хүнийг зарлалаа л даа, ажлын хэсгийнхэн. Тэгээд тэр 20 хүнийг нь хэн зарлачихсан юм гэхээр хэвлэлд гарсан мэдээллээс гэж байгаа байхгүй юу. Тэгээд би хамаагүй шүү дээ, энд чинь гэхээр. Уучлаарай гээд энэ дотор бие биеийгээ хараад бөөрөнхийлөөд. Яагаад Улсын Их Хурлаас ажлын хэсэг байгуулагдаж хоёр сар болчихоод Засгийн газар ажилчихаад, хууль хяналтын байгууллагууд ажилчихаад, яагаад холбоо хамаарлыг нь яг тодорхой хэлээд өгч болохгүй байгаа юм бэ. Сэтгүүлчид бид зүгээр л нээлттэй мэдээлэл дээр тулгуурлаж л мэдээлэл олж авдаг. Хууль хяналтынхан, байгууллагынхан та нар шиг, Улсын Их Хурлын гишүүд та нар шиг бүх мэдээлэлд нэвтэрдэг тийм эрх байхгүй. Яг холбоо хамаарлыг нь тогтоогоод хэлээд өгөөч. 20 хүнийг хэвлэлийнхэнд зарласан. Би хамаагүй шүү гээд. Яагаад биднийг ингээд нохойд барьдаг мод шиг хандаад байгаа юм. Энэ дээр би бол үнэхээр гайхаж байна. Тодорхой хариулт өгөөч. Хуулийн байгууллагаас нь яг асуучихмаар байна. Яг хэн хэн гэдэг гишүүн оролцчихсон юм, хэн хэн гэдэг гишүүн нөлөөлчихсөн юм бэ гэдгийг нь тодорхой хэлээд өгөөч гэж хэлмээр байна.

Хөгжлийн банкны асуудлыг гаргаж тавьснаас хойш бидний амь насанд заналхийлсэн. Дээр нь өнөөдөр энэ сонсголын танхимаас муусайн гудамжны сэтгүүлчид гар гэж нүд үзүүрлэж байх шиг байна. Хэвлэл, мэдээллийнхэн бидэнд ажиллах орчин бүрхэг ээ, би сэтгүүлчийнхээ үүднээс яримаар байна. Бид

чадлынхаа хэрээр мэдээлэл гаргаад тавьдаг. Энэ дагуу нь маш сайн үр дүнтэй яагаад ажиллаж болохгүй байгаа юм бэ гээд хууль хяналтын байгууллагаас дахиад л асуумаар байна. Нэг ч Улсын Их Хурлын гишүүнийг дуудаж асуугаагүй гэж байна шүү дээ. Ерөнхий прокуророос цаашаагаа 4 хүний зайнд Х.Ганхуяг гишүүн сууж байгаа юм. Бүгдээрээ ингээд сууж байна. Яагаад дуудаад асууж болохгүй байгаа юм. Яагаад энгийн аж ахуйн нэгжүүдийн хэдхэн хүмүүсийг дуудаад дансыг нь битүүмжлээд, хөрөнгийг нь битүүмжлээд байгаа юм. Яагаад Төрийн ордонд, саарал ордонд байгаа хүмүүсээ ялгаж харьцаад байгаа юм бэ. Энэ Хөгжлийн банкны луйвар булхайг хуулийн байгууллага л хамгийн сүүлд нь цэг хатгана шүү дээ.

Гурав дахь асуулт чоно үүрэндээ өлзийтэй гэдэг. Энд ингээд хараад байхаар Монгол Ардын намынхан нь бол намынхныгаа хамгаалаад байх шиг байна. Эдгээр хүмүүс “Кью Эс Си” гэдэг компани руу дайраад байх шиг байна, би тэгж харлаа. Ардчилсан намынхан нь болохоор Хөгжлийн банкныг татан буулгая гээд Хөгжлийн банк гэдэг галыг л нэг нэгэн рүүгээ шидэж байгаа харагдаж байна. Ингэж харагдаж байна. Ж.Мөнхбат гэдэг гишүүн байхгүй байна, “Чандмань майнинг” гэдэг компанитай холбоотой. Тэр хүн Хөгжлийн банканд дээр уурхайн лицензээ тавьсан гэдэг, уурхайн лиценз нь алга болсон гээд хууль хяналтын байгууллагууд дээр явж байдаг. Энэ хүмүүсийн чинь нэр дутуу байна. С.Бямбацогт гишүүн Хөгжлийн банкнаас зээл авах материал нь бүрдэж дуусаагүй байхад зээлийн шийдвэр нь гарчихдаг. Яагаад энэ дээр хуулийн байгууллага нь бас ажиллахгүй байгаа юм бэ? Яагаад нэг муу сэтгүүлчээс долоон дор мэдээлэлтэй байгаа юм. Дээр нь тэр “Сэлэнгийн репорт” гэдэг компани 5 тэрбум төгрөгийн зээл аваад үхэр л үлдсэн гэж байна. Тэгвэл тэр үхрийн эзнийг чинь хэлээд өгье. Гэндэнпилийн Батдорж гэж хүн байгаа. Бүр сайн ярих юм бол Ерөнхийлөгчийн ойр тойрны хүмүүс байгаа шүү. Х.Ганхуяг гишүүн ээ, та зээлээ төлөөч ээ гэж хэлмээр байгаа юм.

Би энэ заалан дээрээс 1 их наяд төгрөг босчих юм байна гэж харсан шүү. Х.Ганхуяг гишүүн 33 тэрбум төгрөг, цаашлаад “Монгэма” гэдэг компани 15 тэрбум төгрөг, за “Бэрэн групп” 120 тэрбум төгрөг, за ингээд наашлахаар “Эрэл групп” 190 тэрбум төгрөг. Хорвоогийн хамгийн сайн төсөл юм бол яагаад зээлээ төлөхгүй байгаа юм бэ “Эрэл групп”-ийн Б.Эрдэнэбат аа. Дээр нь “Монполимент”-ын тэр Ц.Гарамжав гэдэг хүнд нүдийг нь боож байгаад буу тулгаж байгаад зээл өгчихсөн юм уу? Тэр мөнгө чинь гаднаас ам.доллороор авсан мөнгө биз дээ. Тэгвэл манай Улсын Их Хурлын гишүүн байсан хүн, мундаг том дэд сайд байсан хүн энэ зээлийг аваад ам.доллороор төлөхгүй, төгрөгөөр төлнө гээд байна.

### **Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн Ж.Бат-Эрдэнэ:**

За хууль хяналтын байгууллага гэж байгаад асуулт асуулаа. За уучлаарай. Таван минут ч өнгөрчихлөө, би бас сануулсан. Авлигатай тэмцэх газар, Ерөнхий прокурор 2 асуултад хариулъя. 35 дугаар микрофон.

### **Монгол Улсын Ерөнхий прокурор Б.Жаргалсайхан:**

Мөрдөн шалгах ажиллагаа гэдэг бол сонсгол хэлэлцэж эхлэлээс өмнө л хэлсэн, мөрдөгч, прокурор хоёрын шийддэг асуудал. Тэрнээс хэн нэгэн хүний дур зоргоор чи тэрийг асуугаагүй юм уу, чи энийг яагаад асуудаггүй юм гэдэг ийм байдлаар явагддаг ажил биш. Тийм ч учраас би дахин, дахин тодотгож хэлэхэд магадгүй энэ нэр дурдагдсан хүмүүс асуугдах шаардлагатай бол цаг хугацааны асуудал байх аа гэдгийг би хэлсэн. Сая энэ дүгнэлттэй холбоотой хорин хэдэн хүн гээд ингээд ярьж байна. Ер нь мөрдөн байцаалтын ажиллагаа хоёр асуудлаар л

яригддаг. Ажлын хэсэг ажиллаад дүгнэлтээ гаргасан гэж байна. Мэдээж энэ дүгнэлт мөрдөн шалгах байгууллагад ирнэ. Энэний дагуу тодорхой ажиллагаа хийгдэх байх. Нөгөө нэг ажил нь энэ хийгдсэн ажлуудтай холбогдуулаад зайлшгүй шинжээчийн дүгнэлт гаргах шаардлагатай бол шинжээчийн дүгнэлт гаргадаг. Ийм л зарчмаар хэрэг бүртгэх мөрдөн байцаалтын ажиллагаа явагддаг. Тийм учраас хэн нэгэн хүний дур зоргоор мөрдөн шалгах ажиллагаа явдаггүй. Тэрийг Авлигатай тэмцэх газрын дарга ч удирдахгүй, Ерөнхий прокурор ч удирдахгүй. Ямар тохиолдолд энэ асуудал яригддаг юм гэвэл анхан шатны мөрдөгчийн шийдвэр, прокурорын шийдвэрийг эс зөвшөөрөх юм бол шат шатандаа энэ асуудал хянагдаж явдаг болохоос биш тэрийг энийг асуулаа, яагаад гэдэг асуултад би ч хариулж чадахгүй, Авлигатай тэмцэх газрын дарга ч хариулж чадахгүй. Хариулт дууслаа.

### **Авлигатай тэмцэх газрын дарга З.Дашдаваа:**

Ерөнхийд нь Ерөнхий прокурор саяын асуултад хариулчих шиг боллоо. Мөрдөн шалгах ажиллагаа, процесс явагдаж байгаа, процессыг бид нар нэлээн шуурхай хүн хүч гаргаад нэлээн ажиллаж байгаа. Өнөөдөр Монгол Улсад мөрдөгдөж байгаа эрүүгийн хууль тогтоомжийн хүрээнд бүх ажил явж байгаа. Монгол Улсад мөрдөгдөж байгаа эрүүгийн хууль тогтоомжоор бүх нотлох баримт, баримт сэлтийг бол олж аваад түүнийг нотлох баримт болгох, нотолгоожуулахын тулд тодорхой цаг хугацаа ордог. Хоёрдугаарт бүх нотлох баримтыг цаасан суурьтай байхыг шаарддаг. Цахимаар асуудлууд шийдэх боломжтой боловч хуулиараа бүх зүйлийг цаасан сууриар ингээд нотолгоожуулна явдаг. Тийм учраас цаг хугацаа орж байгаа.

Нэр дурдагдсан, ажлын хэсгээс гарсан нэрсээр шалгасангүй, асуусангүй гэж байна. Бид тодорхой хэмжээгээр юмаа нотолгоожуулаад тодорхой цаг хугацаанд хүрсэн, хангалттай боллоо гэсэн үедээ бол асууж тодруулах юмаа асууна. Ийм л байр суурьтай байна.

### **Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн Ж.Бат-Эрдэнэ:**

За дараагийн хүнийг урьж байна. Улаанбал нэвтрүүлгийн хөтлөгч Ч.Лодойсамбуу. А индэр дээрээс. Нэг зүйлийг бас сануулъя, сонсголын эхэнд хэлж байсан. Энэ заал бол өнөөдөр ямар нэгэн шүүхийн танхим биш ээ. Энэ бол мэдээллийг бид олон нийтэд нээлттэй өгөх гэсэн танхим шүү, ийм сонсголын танхим шүү. Хэлэлцүүлэг ч биш энэ бол.

### **Улаанбал нэвтрүүлгийн хөтлөгч Ч.Лодойсамбуу:**

Хэдийгээр хууль бус ч гэсэн олон нийтийн мэдээлэл өгөх сэтгүүлчдэд бас оролцоогоор хангаж байгаа хурал даргалагчдад баярлалаа. Тодорхой 2, 3 асуулт байгаа юм.

Энэ бол Монгол Улсын Их Хурлын үйл ажиллагаа хууль тогтоох байгууллага, Төрийн өмчөө хамаардаг, Төрийн өмчөө хамгаалдаг, эзэмшдэг төрийн үйл хэрэг явж байгаа юм. Хяналт байхгүй бол бүх гэмт үйлдэл нээлттэй. Тэгээд өнөөдөр ажлын хэсгийн дүгнэлтийг сонслоо. Бид нар холбогдох байгууллагуудын дүгнэлтийг ч гэсэн сонслоо. Энэ дунд ерөөсөө үүссэн шалтгаан нь юунаас болоод байгаа юм бэ гэдэг мэдээлэл хомс байв уу даа гэж. Тэгээд би тодорхой асуулт асуух гэсэн юм. Ч.Хүрэлбаатар гишүүнээс асуух гэсэн байхгүй байна. Одоо сонсож байвал дараа нь та хариулаад өгөөрэй гэж. 2015 оноос хойш ийм асуудал байгаа гэдгийг мэдэж

байсан гэж өөрөө хэлж байгаа. 2017 оны хуулийн өөрчлөлтөөр Сангийн яам, Сангийн сайд энэ асуудалд тодорхой хянах, шалгах үүрэгтэй, эрхтэй өөрчлөлт орсон. Түүнээс хойш ямар шалгалтыг Сангийн яам яг хийсэн бэ, бие дааж. Түрүүн гарч байна лээ 2016, 2019 онд хамтарсан шалгалт хийсэн гэж. Хууль дээр 2 жилд 1 удаа, шаардлагатай бол хугацаа хамаарахгүйгээр шалгах хуулийн зохицуулалттай. 2016 онд нэг хийсэн 2019 онд хийсэн. Өөрөөр хэлэх юм бол энэ хугацаанд шаардлагатай гэж үзээгүй юу? Нэгдүгээр ийм асуулт. Хөгжлийн банкны санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой асуудлыг санхүү төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнээр дамжуулан Засгийн газарт хүргэнэ гэсэн. Энэ хооронд үүссэн асуудлууд, аудитын дүгнэлтүүд дээр ч байна. Маш олон шалгалтуудаар ил болсон байна. Хэдэн удаа Засгийн газарт яг ямар мэдээлэл хүргэж, одоо өнөөдөр яригдаад байгаа энэ асуудлуудыг шийдэхийн төлөө ямар алхам Ч.Хүрэлбаатар гэдэг хүн 4 жил сайд байхдаа алхам хийсэн бэ?

Хөгжлийн банкны захирал Н.Мандуул захирал түрүүн хэлж байна лээ. Энэ бол ерөөсөө ил тод байдал байхгүйгээс үүдэлтэйгээр одоо ингээд бөөндөө асуудал ил болж байгаа юм гэж. Хөгжлийн банкны сайт дээр ганцхан тайлан байгаа. “Делойт” гээд Олон улсын байгууллага, Монгол компанийн хамтарсан ийм Олон улсын байгууллага 270 сая төгрөгөөр 2 жил дараалаад шалгалт хийсэн. Ер нь бол 2012 оноос хойш хийсэн шалгалтууд, аудитын дүгнэлтүүд дандаа ямар ч зөрчилгүй гэж гарч байсан. Энэ шалгалт дээр бас нэг зүйл байгаа. Ийм асуудлууд үүсээд байна аа гэдгийг хэлэхийн дээр нэг ийм дүгнэлтийн хэсэг байгаа юм Хөгжлийн банк нь банкны тухай хуульд заасан арилжааны банкны үйл ажиллагааг эрхлэнэ гэсэн дүгнэлт байгаа ... 15 хувьтай холбоотой. За уучлаарай. Монгол Улсын хөгжлийн томоохон төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэх зорилго бүхий ашгийн төлөө Төрийн өмчит хуулийн этгээд болохыг тодорхойлох хэдий ... энэ биш байна. За уучлаарай. Шалгалтад хамарсан хугацаанд ханш нь дунджаар 15 хувиар унасан төгрөгийн тогтворгүй байдлаас шалтгаалан америк доллароор зээл авсан ихэнх зээлдэгчдэд хүндрэл учирч байна. Тиймээс банк нь харилцагчдаасаа гадаад валютаарх зээлээ төгрөгт шилжүүлэх хүсэлтэй эсэхийг нь асууж лавлах шаардлагатай юм гэдгийг 2017 онд хэлж байсан. Үүнтэй холбоотой би Сангийн сайдаас асуулт асуух гэсэн юм. Бодлоготой холбоотой, ер нь томоохон төслүүдийн төрийн бодлогын залгамжгүй байдал, хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудлууд үүсч үү гэж. Монгол Улсад зах зээлдээ 3 цементийн үйлдвэрт бид нар зээл олгосон байдаг. Эхлээд “Хөтөл”, дараа нь “МАК цемент”, одоо “Монцемент” гээд. Одоо “Хөтөл”-ийг нь хурааж аваад, жишээлбэл төрийн санаачилгаар хэрэгжүүлэх орон сууцын төслүүдийг цементээр хангана гэж байгаа юм. Нэг талдаа нэг гараараа та бүхэн ийм үйлдвэр байгуулаад хөгж өө гэдэг, нөгөө гараараа төр нь ингээд нөгөө компаниудынхаа зах зээлийг булааж байгаа хэрэг болохгүй юу Сангийн сайд аа. Энэ дээр тодорхой хариулт авах гэсэн юм. За тэгээд цаг нь ч дуусчихлаа. Одоо уг нь олон асуулт байгаа. Баярлалаа.

**Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн Ж.Бат-Эрдэнэ:**

Сангийн сайд хариулах уу, Б.Жавхлан сайдын микрофон өгье.

**Сангийн сайдаар, УИХ-ын гишүүн Б.Жавхлан:**

За баярлалаа. За сэтгүүлч Улаанбал нэвтрүүлгийн хөтлөгч Ч.Лодойсамбуугийн асуултад хариулъя. Ер нь бас яг тиймэрхүү байдал үүснэ. Гэхдээ зах зээлийн зарчмаараа л явах ёстой. Хөгжлийн банкнаас олгогдсон энэ 3 цементийн үйлдвэрийн төслийн сүүлийн 2 төслийн талаар бол бас нэлээн

мэдээлэлтэй ингэж ажиллаж байгаа. Төсөл амжилттай хэрэгжсэн. Зээл эргэн төлөлт дээр асуудал үүсэж байгаа. Анх ам.долларын зээл яагаад өөрсдөө төгрөгийн орлоготой байж ам.долларын зээл авсан юм. За Хөгжлийн банкны хувьд бол ам.долларын эх үүсвэртэй байсан. Энийгээ төгрөгөөр өгөх юм бол банк мэдээж өөрөө алдагдалд орно. Тэгээд ам.долларын зээл тулгасан юм шиг байгаа юм. Энэ дээр ямар нэг валютын зохицуулалт хийлгүйгээр ингээд аваад явчихсан юм, гэрээгээ хийгээд. Гэрээг бол ямар нэгэн хүчээр хийгээгүй, энэ бол иргэний хуулиар зохицуулагдах ийм л харилцаа үүсээд явсан байгаа юм. Ийм байдлуудаас болоод ингээд хүндрэлүүд үүссэн байна. Зах зээлийн зарчмаар одоо зээлдэгч одоо эрсдлээ хүлээгээд явахаас өөр арга байхгүй. Ямар Хөгжлийн банк эргээд одоо энэ дээр эрсдэл хуваалцана гээд ханшийн эрсдлийг хуваалцалтай нь биш. За төслийн хувьд бол яалт ч үгүй гарцаагүй л хөгжлийн төслүүдийн нэг мөн. Төсөлдөө эх үүсвэрээ зуун хувь зориулж ашигласан, үйлдвэр технологийн хувьд маш сайн явж байгаа гээд сайн зүйлүүд бол байгаа. “Хөтөл”-ийн хувьд хувьчлалтай холбоотой асуудал шүү. Энэ бол Хөгжлийн банкны бодлого биш, Хөгжлийн банкны бодлого биш. Хувьчлалтай холбоотой асуудал дээр Засгийн газар өөрийнхөө шийдвэрийг гаргасан. Би Засгийн газрын хурал дээр ч тэр, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын дарга, удирдлагуудаас бас бас тодруулсан. “Хөтөл”-тэй холбоотой Хөгжлийн банкн дээр маш том зээлийн үлдэгдэл байгаа шүү, энийгээ яах юм бэ, энийг улс үүрч чадахгүй шүү гэж. Зах зээлийнх нь зарчмаар ажиллуулаад төлнө гэсэн хариу өгч байна лээ. Ер нь л бас эрсдэлтэй. Ийм зүйл байна. Түрүүн Н.Мандуул захирал хэлэхдээ жоохон санаагаа л буруу ойлгуулчих шиг боллоо. Одоо жишээ нь энэ төслүүдийг төлүүлэх маш олон арга замууд байна. Нилээн дөнгүүр ойрхон харагдаж байгаа нь жишээ нь энэ жил төсвийн хөрөнгө оруулалтаар нэлээдгүй ажил хийгдэхээр төсөв дээр төлөвлөгдсөн байдаг юм. За тэгээд эндээс бүхий л бүтээн байгуулалт барилгын ажлуудын 20-30 хувьд нь энэ цементийн худалдан авалт хийгдэж таараа. Тэгвэл төсвөөс гарах тэр зардлуудыг компани руу нь шилжүүлэлгүй Хөгжлийн банкных нь зээлэнд нь төлүүлээд авчих ч гэдэг юм уу, иймэрхүү хувилбарууд санал болгоод ингээд судалгаа хийгээд явж байгаагаа ярьснаа жоохон буруу илэрхийлчих шиг боллоо, төрд хариуцуулна, төсөвт хариуцуулна энэ тэр гээд. Иймэрхүү байдлаар чанаргүй зээлүүдтэйгээ ажиллаад явах боломжууд байгаа. Тийм учраас саяын сэтгүүлчийн асуултад хариулахад бол зах зээлийнхээ зарчмаар явна. Бид үнэд шууд нөлөөлөх боломж бас 100 хувь байхгүй, тэгэхдээ бас эцсийн зээлдэгчийн хувьд саналаа хэлэлгүй яахав. Сүүлд 2 компани үнээ нэмэхдээ Барилга, хот байгуулалтын яаман дээр очиж санал солилцсон юм байна лээ. Гэхдээ харамсалтай нь үнээ нэмснийхээ дараа уулзацгаасан байна лээ. Уг нь ярилцаад үзсэн бол энэ жил жишээ нь төсөв Сангийн яамтай нийлж сууж байгаад жилийн бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтууд дээрээс өмнөх үнэ дээрээ барьж байгаад төлүүлчих бас боломжууд байсан л байгаа. Гэх мэт бас 2 талаасаа, хэд хэдэн талаасаа ийм бүтээлч байдлаар зээлээ төлүүлээд явчих юм бол хойтон тэр Самурай бондыг төлөх ёстой тэр эрсдлээсээ наана нь гараад явцгаачихъя гээд бүгдээрээ хамтарч ажиллах шаардлагатай байгаа. За баярлалаа.

### **Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн Ж.Бат-Эрдэнэ:**

Дараагийн сэтгүүлч маань Б.Өнөртогтох, “Дардас.мн”. А индэр.

### **“Дардас.мн” сэтгүүлч Б.Өнөртогтох:**

За сайн байцгаана уу. Би бас өглөөнөөс хойш энд суулаа. 2017 оноос хойш энэ асуудлыг бичиж байсан сэтгүүлчдийн нэг. Энд бас нэг тийм шинэ юм

яригдсангүй. Тэгээд ер нь сэтгүүлч хүнд баримт бас дахин баримтлал чухал байдаг. Тэгэхээр би эндээс ядаж нэртэй гармаар байх юм. 20 хүнийг нэрлэлээ, нөгөөдүүл нь ингээд захаасаа эхлээд би биш гээд үгүйсгээд эхэллээ. Одоо ингээд бичсэн сэтгүүлчид, тэрийг зурагтай нь тавьсан сэтгүүлчид эхнээсээ хүн гүтгэсэн хэрэгт орох нь тодорхой юм байна. Тэгэхээр энэ 1.8 их наяд төгрөгийг авсан энэ 79 дотор чинь нэг ч тийм хөгжлийн төсөл байхгүй юм уу? Сайн түүхтэй тийм нэг ч аж ахуйн нэгж байхгүй юм уу? Тэрийг бас нэрлэж өгөөч байдаг бол. С.Чинзориг гишүүн бас халт дурдаад хаячих нь билээ. Тэр зээлийн муу түүхтэй буюу шаардлага хангаагүй аж ахуйн нэгжүүдэд зээл өгсөн байна гэж, эд нарыгаа нэрлэж өгөөч ээ. Сая Хөгжлийн банкны материалд дурдагдах болов уу гэсэн чинь “Хөтөл”, “Кью Эс Си” хоёрыг нэрлэхээд л энэ талд нь шүүхэд шилжинэ гэж бичээд есөнзуун хэд гээд багцлаад хаячихсан байна лээ. Энийгээ нэрлэж өгөөч гэдгийг хэлмээр байна.

Хоёрдугаарт Улс төрчид болоод Хөгжлийн банкныхны ганц санал нэгдэж байгаа зүйл нь валютын ханшийн зөрүүнээс алдагдал хүлээсэн аж ахуйн нэгжүүдээ яах вэ гэдгийг бас хөндөж байгаа нь их чухал санагдлаа. Энэ ханшийн зөрүүнээс эрсдэл хүлээсэн аж ахуйн нэгжүүдтэйгээ гурван талд ч юм уу хэлэлцүүлэгт орно гэж ч ойлгож болох уу, тийм үр дүн гарах уу? Тэгэхгүй бол аягүй инээдтэй байгаа байхгүй юу энэ жагсаалт байгаа юм. Тэгсэн чинь энэ жагсаалтын хамгийн нэгдүгээрт байгаа зээлийн сайн түүхтэй гэнгүүтээ “Ди Би Эм лизинг” Хөгжлийн банкны охин компанийг биччихсэн, тэгснээ энэндээ 3 хувийн хүүтэй, төгрөгийн зээл рүү шилжүүлэхэд 6-хан хувийн хүүтэй зээл өгсөн сайн түүхтэй гээд бичсэн. Доор нь “Ачлал трейд”, “Дархан минж”, “Вестерн холд” гээд экспортыг дэмжих, импортыг орлох ийм төслүүддээ болохоор 10 хэдэн хувийн хүүтэй зээл өгөөд тэгээд нөгөөдүүл нь ханшийн зөрүүнээсээ болж эрсдэл хүлээчихсэн энд сайн, муугаараа дуудуулаад сууж байдаг ийм асуудал байна. Тэгэхээр энэ дээр Хөгжлийн банк, Сангийн яам, Монголбанк аж ахуйн нэгжүүдтэйгээ хэлэлцүүлгийн ширээний ард суугаад энэ асуудлаа ярина гэж, ийм үр дүн гарна гэж ойлгож болох уу.

Гуравдугаарт нэг асуудал байна. Өчигдөрхөн “Хөтөлийн цемент шохойн үйлдвэр”-ийн газрын дарга байсан М.Бөх-очир гэж хүний хүүхэд нь гараад ирлээ. Тулга гээд залуу гараад ирчихсэн. 2019 оноос хойш зээл хөөцөлдсөн чинь ингээд өгөөгүй. Тэгээд нотариатын танхим руу ингээд намайг битгий аваарай гэж ингээд өгчихсөн байна. Гэтэл Засгийн газраас энийг юу гэж хэлсэн бэ гэхээр эзэн холбогдогч байхгүй, өвлөж авах хүн байхгүй учраас төр авч байна гэсэн. Энэ дээр Сангийн сайд юм уу, хэн нь юм вэ хариулт өгөөч. Тэгээд сая Н.Өнөрцэцэг асуусан чинь хариулахгүй өнгөрчих шиг боллоо, тэр С.Бямбацогт гишүүн үнэхээр зээл нь шалгагдаж байхад өөрөө хөөцөлдөж гүйж яваад авчихсан юм уу? Ийм увайгүй зүйл байж болдог юм уу, энэ дээр бас холбогдох байгууллагынх нь хүмүүс ч юм уу, эсвэл тэр компанийнх нь төлөөлөл байгаа бол хариулт өгөөч гэж хэлэх гэсэн юм. За баярлалаа.

### **Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн Ж.Бат-Эрдэнэ:**

Улсын Их Хурлын гишүүн, Б.Баттөмөр ажлын хэсгийн ахлагч нэг дүгнэлт хэлэх үү. Нэртэй гарах л гээд манай хэд нэр л нэхээд байх юм. Энэ чинь зүгээр мэдээлэл өгөх асуудал шүү дээ. Хууль хяналтын байгууллагууд, Авлигатай тэмцэх газрын даргыг нь урьж авчирлаа. Монгол Улсын Ерөнхий прокурорыг урьж авчирлаа. Хуулийн хүрээнд хэлж болох бүх л зүйлүүд хэллээ. Цагдаагийн газрын даргыг ч бас авчирлаа.



### **УИХ-ын гишүүн, ажлын хэсгийн ахлагч Б.Баттөмөр:**

Бидний хувьд бол 20 нэр гаргасан байгаа. Энэ бол юу вэ гэхээр хэвлэл, мэдээллийн байгууллага дээр олон удаа нэр нь давтагдсан. Тэгээд үзээд шалгаад хамаарлын судалгааг, эцсийн өмчлөгчийг тодорхойлох гэж бид оролдсон. Их төвөгтэй юм байна. Өнөөдөр яг тэгж гаргахад их төвөгтэй. Тэгээд энэ 20 нэрийг бол яахав дээ ер нь бол зөвлөж байгаа юм бид нар, энийгээ хууль хяналтын байгууллагаар шалгуулаад нэг талд нь гарчихаач ээ гэсэн ийм л зүйлийг одоо хэлэх гээд байгаа юм.

Амжилттай хэрэгжсэн төсөл байна уу гэсэн, түрүүн миний илтгэлд гарсан байгаа. 8 төсөл байгаа. “Дулааны цахилгаан станц-4” гээд энийг амжилттай хэрэгжсэн гэж үзэж байгаа, 76 сая евро буюу 244.4 тэрбум төгрөг байгаа. “Дорнод бүсийн одоо эрчим хүчний систем” Төрийн өмчит компани, энэ бол 19 тэрбум төгрөг. “Газрын тос боловсруулах үйлдвэр” дээр 203 тэрбум төгрөг байна. “Говь” компани 76.5 тэрбум төгрөг байна. “МИАТ” компани дээр 19.8 тэрбум төгрөг байна. Зургаад нь “Зорчигч тээвэр 4” гэсэн Орон нутгийн өмчит газар, энд бол парк шинэчил, цахилгаан автобусаар хангах ажил, 21.2 тэрбум төгрөг аваад энийгээ төлсөн. “МАК цемент” төсөл, 70.9 сая ам.доллар, 164 тэрбум төгрөг болж байгаа, үйлдвэр ажилд орсон байгаа. Тодорхой хуваарийнхаа дагуу энийг хийнэ, Корона вирустэй холбогдоод хүндрэлтэй байна, хугацаандаа төлнө гэсэн ийм тайлбарыг хэлж байгаа. “Монполимет” гэж компани байгаа 65 сая ам.доллар, 113.5 тэрбум төгрөг байгаа. Ингээд нийт дүнгээрээ 862.3 тэрбум төгрөгийн 8 компанийн амжилттай хэрэгжсэн төслүүд гэж ингэж үзэж байгаа.

Валютын ханшийн тухайд бол одоо нэгэнт гаднаас авчраад валютаар олгосон. Төр аваад ингээд хийх юм бол тэр ханшийн алдагдлыг төр үүрнэ гэсэн үг. Өнөөдөр бидэнд байж байгаа тооцоогоор бол 460 орчим тэрбум төгрөг аж ахуйн нэгжүүд дээр ханшийн зөрүүнээс гарч ирж нуруун дээр нь ачаа болж ирж байгаа. Хөгжлийн банкн дээр 214 тэрбум төгрөг. Ингээд нийлээд 680 орчим тэрбум төгрөг зөвхөн ханшийн зөрүүнээс алдаж байгаа. Тэгэхээр одоо түрүүний би хэлсэн энэ хөгжлийн зээл бол биш юм хугацаа нь бага байна, хүү өндөр байна. Ийм учраас цаашдаа энэ Хөгжлийн банкныг Хөгжлийн банк шиг ажиллуулах юм бол бага хүүтэй, урт хугацаатай зээлийг аж ахуйн нэгжүүддээ олгох ийм л ажлыг хийх шаардлагатай юм гэж үзэж байгаа. Төр, хувийн хэвшлийн байгууллагууд ханш дээр зөвлөлдөхийг үгүйсгэхгүй байна. Тэгэхдээ яах вэ гэдгийг урьдчилж тааж хэлэхэд төвөгтэй байна.

### **Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн Ж.Бат-Эрдэнэ:**

Ерөнхийдөө хариулчихлаа даа. Тэр “Вестрн холд” гээд “Ховдын цементийн үйлдвэр”-тэй холбоотой хүн нь байна уу? Аль тэр сая дахиад асуулт асуулаа шүү дээ. Тэр С.Бямбацогттой ер нь ямар холбоотой юм бэ? Тэрийг нэг хэлээдэхээч. 15 дугаар микрофон.

### **“Вестрн холд” ХХК-ийн төслийн удирдагч С.Жавхланбаатар:**

Сэтгүүлчийн асуултад хариулъя. Хөгжлийн банкны анх зээл авах шийдвэр нь гарахдаа шаардлага хангаагүй байна гэсэн асуулт асууж байх шиг байна. Нэгдүгээрт тэрэнд бол бид нар бүрэн шаардлагаа хангасан, зээлийн шийдвэр 2018 онд гарсан, зээлээ 2019 оны 09 дүгээр сарын 24-ний өдөр зээлээ авсан байгаа.

Хөгжлийн банкны тухай хуульд заасан 10.1-ийн шалгуурыг бүрэн хангасан гэдгийг болбол Хөгжлийн банкны вэб хуудсаар ороод цахим датад нь байж байгаа. Хөгжлийн банкны удирдлага бас нэмж хэлэх байх гэж бодож байна. Тэгэхээр зээл авсан, зээлийн шийдвэр гарсан хоёрыг хооронд нь холиод байна уу гэсэн ийм бодол байна.

Хоёрдугаарт нь манай төсөл яг ид хэрэгжээд явж байгаа, маш хүнд цаг үед бүтээн байгуулалт явж байгаа. Өнөөдөр бүтэн өдөржингөө яригдсан энэ ханшийн эрсдэл, цаашид энэ Хөгжлийн банктайгаа хэрхэн хамтран ажиллах вэ гээд бүх асуудал бидэнд бас тулгарч болзошгүй, тулгараад эхэлчихсэн байна. Ханш өнөөдөр 200 төгрөг даваад хэлбэлзчихлээ бидний авч байсан үеэс. Тэгэхээр энэ хэмжээгээр бид нар эрсдэлд орчихсон байна гэсэн үг, нэмэгдээд л байна, өдөр болгон нэмэгдэж байна. Дээр нь Хөгжлийн банк одоо бүх зээлдэгч нарт хамаатай, манай компанийн хувьд, манай төслийн хувьд бид нар нэг завин дээр суусан.

### **Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн Ж.Бат-Эрдэнэ:**

Б.Отгон сэтгүүлч. А индэр дээр.

### **Сэтгүүлч Б.Отгон:**

Та бүхэндээ энэ өдрийн мэнд хүргэе. Би сэтгүүлчээс гадна Авлигатай тэмцэх газрын олон нийтийн зөвлөлийг төлөөлж байгаа. Тэгэхээр Авлигатай тэмцэх газрын олон нийтийн зөвлөлөөс анх энэ Хөгжлийн банкны асуудал дэгдэнгүүт ер нь энийг нээлттэйгээр хэлэлцье ээ, нээлттэй сонсгол хийе гэсэн шаардлагыг бас Улсын Их Хуралд хүргүүлж байсан. Тэр дагуу бас энэ сонсгол болж байгаа байх гэж бодож байна. Яах вэ, өдөржин ингээд сонслоо үнэхээр харамсалтай байна. Бид нар өнөөдөр үнэхээр энэ нэг чөтгөрийн тойргоосоо гарч чадахаа байчихжээ. Бүгдээрээ бие биедээ барьцаалагдчихаж, бүгдээрээ бие биеийнхээ нүүрийг хараад юу ч хэлж чадахаа байчихаж.

Би ингээд хамаагүй ээ, наад компаниас чинь гараад явчихсан гэхээр за уучлаарай тийм, нэрээ цэвэрлэхгүй юу. Ийм байдлаараа бид нар үнэхээр ийм том хулгай луйврыг дарж чадахгүй ээ. Ямар хоёр нүүртэй байдаг юм бэ та нар. Дээрээс нь энэ сэтгүүлчид тэгээд худлаа бичсэн болж таарч байна уу? Тэр одоо холбоо хамаарлыг нь хайгаад үз л дээ. Хөрөнгө орлогын мэдүүлэг дээрээ байгаа компаниар ямар тэнэг улс төрч зээл авдаг юм бэ? Тэд нар чинь дандаа яаж гаргаж ирж байна гэхээр тэр тухайн улс төрчийн хөрөнгө орлогын мэдүүлэг дээр байхгүй шүү дээ. Эхнэрийнх нь юм уу, ах дүүсийнх нь, тэгээд хамтарсан компани нь, ахиад өөр компани дээр хувьцаа эзэмшиж байгааг нь гаргаж ирж байж энэ нэгдмэл ашиг сонирхолтой этгээд байна гэдгийг бид нар илчилж байгаа шүү дээ.

Түүнээс биш би хөрөнгө орлогын мэдүүлэг дээрээ бичээгүй гэхээр нээрээ тийм байна гэвэл энэ хулгай чинь илрэхгүй ээ. Бид нар энэ гэмт хэрэг гараад 7 жил болж байна. Уучлаарай 7 жил бүгдээрээ нууж ирлээ. Улс төрчид нь өөрсдөө хулгайч болохоороо нэгнийгээ илчилж чаддаггүй. Дээрээс нь Ерөнхийлөгч нь, Ерөнхий аудитор нь, Сангийн сайд нь, Ерөнхий сайд нь бүгдээрээ хулгай хийсэн байна шүү дээ. Энийг илчлэх ёстой, мэдээлэх ёстой. Нөгөө мэдэх эрхийг хангах ёстой хэвлэл, мэдээллийн байгууллагууд нь яасан, Хөгжлийн банкнаас өөрсдөө мөнгөө авчихсан, өөрсдөө жилд 720 саяас 1.2 тэрбум төгрөгийн мөнгө аваад тэгээд Хөгжлийн банкийг сурталчилсан гээд байгаа юм. Ийм дампуурсан банкийг сурталчилж болдог юм уу. Ингэж болохгүй ээ. Дээрээс нь тэр өнөөдөр энэ чанаргүй зээлийг өгчихсөн тэр

Хөгжлийн банкны удирдлагууд яагаад хариуцлага хүлээхгүй байгаа юм. Монголбанкныхан яагаад хариуцлага хүлээхгүй байгаа юм. Тэр ханшийн алдагдал үнэхээр Монголбанкны нэн тэргүүний үүрэг зорилт мөн биз дээ. Тэгээд өнөөдөр тухайлбал Хөгжлийн банкны зээлийн эрсдлийн газрын захирлаар ажиллаж байсан Ганбямбын Дөлгөөн гэж одоо Улсын Их Хурлын гишүүний хүүхэд байгаа. Тэр одоо Монголбанкны хяналт, шалгалт хариуцсан дэд Ерөнхийлөгчөөр оччихсон, би ингээд Хөгжлийн банкиг шалгасан юм гээд өмнө нь болсон хэлэлцүүлэг дээр өөрөө өөрийнхөө ажлыг шалгаж байна шүү дээ. Тэгээд энийг нь ийм юм байж болох уу гээд бичихээр өнөөдөр ингээд хэлэлцүүлэгт ирж чадахгүй зугтаачихаж байгаа юм. Маш олон хүн эндээс зугтааж байна. Дээрээс нь энэ хууль хяналтын байгууллагууд өнөөдөр ямар үүрэгтэй юм бэ та бүхэн. Татвар төлөгчдийн мөнгийг тэр тангараг өргөсөн гол үүрэг, зорилго чинь юу юм бэ? Энэ гэмт хэрэг гарсан байхад үүнийг таслан зогсоох, шалгах ёстой биз дээ. Тэгээд өнөөдөр ганц хүний нэр хэлж чадахгүй, бүгдээрээ ингээд хараат бус байдал нь алдагдчихсан. 20 компанийг мэдэхгүй, бид нар мэдэхгүй, тэр хэвлэлээр явсан юм гээд ингээд сууж байж болохгүй.

Ер нь энэ хуулиараа өнөөдөр гэмт хэрэг гарчихсан байхад прокурорын байгууллага төрийн нийтийн эрх ашгийн өмнөөс нэхэмжлэл гаргах эрхтэй ганц байгууллага чинь прокурор шүү дээ. Уг нь энийг сэтгүүлчид шалгаа гээд явж байхаас илүү прокурор өнөөдөр нийтийн эрх ашгийн өмнөөс нэхэмжлэл гаргаж байх ёстой. Энэ ажлаа хийхгүй юм уу гэдгийг Б.Жаргалсайхан даргаас асууя. Дээрээс нь Сангийн сайд Б.Жавхлангаас та Чингис хаан банкны хамаарал бүхий этгээд мөн үү, учир нь таны эхнэр Чингис хаан банкны хувьцаа эзэмшигчдэдээ нэгдмэл ашиг сонирхолтой буюу хамтарсан компанийг эзэмшдэг. Хөгжлийн банк өнөөдөр Чингис хаан банк руу асар их хэмжээний мөнгийг зээл болгоод гаргачихсан. Та өнөөдөр Хөгжлийн банкиг хариуцаж байна Сангийн сайдын хувиар. Тэгээд ийм байж болох уу? Дээрээс нь та арилжааны банкнаас авсан зээлээ Төрийн банк руу шилжүүлсэн. Энэ асуудал дээрээ тайлбар өгөхгүй юу? Дээрээс нь ер нь бид нар энэ Хасуурын Ганхуяг гээд гишүүн одоо яриад л байна зээл авчихсан, тэгээд ингээд суугаад байх юм. Одоо энэ хүн үгээ хэлэх болоогүй юу, тэр гурван гишүүн зээл авсан. Одоо нүүр нүүрээ харж ярилцъя. Бид нар энэ байдлаар бол 7 жилийн дараа ахиад л ийм юм яриад, ахиад л та бүхэн маань хулгайгаа хийгээд л сууж байх юм байна. Тийм учраас одоо энийг таслан зогсоохгүй бол энэ улс орон чинь сүйрлээ, энэ тусгаар тогтнол гэж байхгүй боллоо. Өнөөдөр 30 тэрбум ам.долларын гадаад өртэй, тэгээд дээрээс нь ингээд хулгай хийгээд ингэж сууцгаагаад байж болдог юм уу? Энд цугласан хүмүүс бид нар бүгдээрээ энэ татвар төлөгчдийн мөнгөөр амьдарч байгаа. Гэтэл өнөөдөр тэр ард түмэн чинь яаж амьдарч байна. Тэр комиссын бараанд оочерлоод л өмсөх хувцасгүй, ингээд зогсож байгаа биз дээ. Тэгэхэд бид нар энд ингээд хурал хуй хийгээд өдөржингөө яасан их завтай, одоо хийх ажилгүй хүмүүс үү? Үр дүн гаргахгүй бол ингэж өдөржингөө хуралдахын ч хэрэг байхгүй шүү дээ.

**Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн Ж.Бат-Эрдэнэ:**

Сангийн сайд хариулт өгье.

**УИХ-ын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан:**

Сэтгүүлчийн асуултад хариулъя аа. Асуух ч болов уу гэж бодож байлаа. Нэлээдгүй бас бичээд байгаа юм. Таны саяын хэлсэн зүйл, би болон өөрийн хамааралтай этгээд, хуулийн этгээдүүдээр дамжуулж хэрвээ Хөгжлийн банканд нэг төгрөгийн эрсдэл учруулсан бол би ямар ч хариуцлага хүлээхэд бэлэн байна. Хөгжлийн банктэй холбоотой эрсдэлтэй, энэ одоо муу чанаргүй зээлүүдтэй ажиллах

энэ давлагаа үүссэнээс хойш нэлээдгүй юм болдог юм байна. Нэлээдгүй юм болдог юм байна. Би дахиад хэлье, хэрвээ ямар нэг эрсдэл би учруулсан, би өөрөө оролцох нөлөө үзүүлсэн зүйл байдаг юм бол би ямар ч хариуцлага хүлээхэд бэлэн байна. Та өөрөө тэр одоо Авлигатай тэмцэх газрын олон нийтийн зөвлөлд байдаг бол тэр байгууллага энийг шалгахад бүрэн нээлттэй байгаа, дуудаж ч шалгаж байгаа байх, дуудахгүй ч шалгадаг байгууллага.

Сэтгүүлчдийн хувьд эрэн сурвалжлах сэтгүүл зүй гээд мэдээж юм хардах эрх байлгүй яах вэ. Тэгэхдээ хамаагүй ингэж хэлмэгдүүлж болохгүй. Би ч өөрөө бас хардах эрхтэй. Энэ чанаргүй зээлийн асуудлууд эхэлснээс хойш энэ давлагааг мохоох гэсэн, зогсоох гэсэн, сарниулах гэсэн аягүй их оролдлогууд гарч ирж байгаа. Би ч гэсэн таныг хардаж байгаа юм. Тантай нийлээд яваад байгаа, танд одоо янз бүрийн дутуу ийм мэдээлэл аваачиж өгөөд зориуд ингээд бичүүлээд байгаа нөхдүүд чинь ч гэсэн асуудалтай байгаа шүү. Таныг би арай ч бас нэг тийм юманд ороод явчихгүй болов уу гэж бас найдаж байгаа юм. Ямар ч хамаарал байхгүй, ямар ч хамааралгүй байх шүү.

Тэгээд би эцэст нь хэлье. Л.Оюун-Эрдэнийн Засгийн газраас Хөгжлийн банктаа авч хэрэгжүүлж байгаа энэ муу зээл, чанаргүй зээлийг төлүүлэх энэ том давлагаанд хэн ч, юу ч саад болж чадахгүй. Бид цаашдаа илүү их, хүчтэй ажиллах бол энэ Хөгжлийн банкнаас үүдэж гарах эрсдлүүдийг татвар төлөгчдийн нуруун дээр аваачиж буулгахгүй, нэмж эрсдэл гаргахгүй байх тал дээр бүх боломжит арга хэмжээгээ авч ажиллана. Та тэр зээлийг ярьж байна. Би бас тэрийг чинь уншсан. Өнөөдөр монгол иргэн хүн бүр, аж ахуйн нэгж бүр аль ч банкнаас зээл авах эрхтэй. Гэхдээ би өөрөө зээл аваад миний шууд хамааралтай этгээдүүд аваад одоо банканд дээр чанаргүй зээл үүсгэчихсэн нэг төгрөгийн ч асуудал байхгүй шүү. Тэнд би өөрөө нөлөөлөөд тэгсэн зүйл огт байхгүй. Миний хэлэх зүйл боллоо.

**Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн Ж.Бат-Эрдэнэ:**

Монгол Улсын Ерөнхий прокурор Б.Жаргалсайхан.

**Улсын ерөнхий прокурор Б.Жаргалсайхан:**

Б.Отгон сэтгүүлч миний асуулт, хариултад хэлж байсан зүйл дээр бас хоцорчихсон юм уу гэж л би ойлголоо. Би асуулт хариулт хэлж байх үед Хөгжлийн банктэй холбоотой, тухайлбал удирдлагуудтай нь прокурорын байгууллага 01 дүгээр сар, 03 дугаар сард уулзсан. Энэ ажлын хүрээнд 9 нэхэмжлэл бичих санал, хүсэлт Хөгжлийн банкнаас ирсэн. 2 хүсэлтийг нь нэмэлт материал хийлгэхээр буцаасан. 5-ыг нь нэхэмжлэл биччихсэн байна. 2 хүсэлтийг нь энэ бол нэхэмжлэл хэлчих боломжгүй эрүүгийн гэмт хэргийн шинжтэй байна гэж мөрдөх байгууллагад шилжүүлсэн. Бид нар энэ хүрээнд л ажиллаж байна. Тийм учраас төр нийтийг ашиглах сонирхлыг хамгаалах чиглэлээр өөрийн боломжтой нэг талаас нь иргэний чиглэлээр, нөгөө талаас нь эрүүгийн чиглэлээр прокурорын байгууллага ажиллаж байна. Хариулт дууслаа.

**Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн Ж.Бат-Эрдэнэ:**

Сэтгүүлчдээс саналаа хэлж асуулт асууж, хариулт авлаа. Ингээд оролцогчдоосоо бид нар санал авсан. 17-18 оролцогч санал хэлж, тайлбар өгнө гэсэн байгаа. Ингээд Н.Ариунболд хуульч. Таван минутад багтааж саналаа хэлнэ. Б индэр дээр.

## **Хөгжлийн банкны захирал асан Н.Мөнхбатын өмгөөлөгч, хуульч Н.Ариунболд:**

Баярлалаа. Та бүхэнд энэ оройн мэнд хүргэе. Өнөөдрийн хэлэлцүүлэгт орж байгаа, оруулсан, үг хэлэх боломж олгосон ажлын хэсгийн дарга, ажлын хэсэг, ер нь хэлэлцүүлэг зохион байгуулж байгаа нийт хүмүүстээ бас талархаж байгаа илэрхийлье. Би Н.Мөнхбат гэж хүний өмгөөлөгчөөр ажиллаж байгаа хуульч хүн байгаа юм. Тийм учраас энэ хэлэлцүүлэгт бүр зорьж ирж, одоо Н.Мөнхбатын асуудлаар тодорхой мэдээлэл, нэг талын мэдээллийг бас өгөхгүй бол болохгүй юм байна гэсэн ийм дүгнэлтийн үндсэн дээр энд ирж бас тодорхой мэдээллийг өгөхөөр зорьж ирсэн шүү.

Өнгөрсөн, ер нь бол бидний түүхэнд бол үе, үеийн том хэргүүд бол манддаг. 80-аад жилийн өмнө Лхүмбийн хэрэг гээд хэрэг гарсан, тодорхой хугацааны дараа бол одоо цагаадсан. Өнөөдөр Хөгжлийн банкны гэх ийм хэрэг мандаад олон нийтээр үзэн ядуулаад, тэгээд яллаад, шүүгээд бараг цаазлах нь холгүй ийм нөхцөл байдалтай байгаад байгаа шүү. Тэгээд Н.Мөнхбаттай холбогдуулаад нэг товчхон хэлэе. Өнөөдрийн хэлэлцүүлгийн үед бол нэг 5-6 удаа нэр нь дурдагдлаа, хийсэн үйлдлийнх нь талаар, бас хэд хэд дурдагдлаа Ерөнхий прокурорын орлогчоос бас тухайн үед бол хэлэлцүүлэг хийхдээ бас нэг хэд, хэдэн асуудалд дурдсан. Энэ тал дээр нь товчхон тайлбар, одоо мэдээлэл өгчихье гэж бодож байна. Тайлбар юу байх вэ. Маргааш өглөө давж заалдах нь шатны шүүх хуралдаан зарлагдсан, болно.

Нэгдүгээрт прокуророос Н.Мөнхбатыг 3 хэрэгт ялласан байгаа, бараг 5-6 жилийн өмнө. Энэний 2 нь цагаадсан, 1 нь хөөн хэлэлцэх хугацаа гэдэг зүйлээр хугацаа одоо ингээд дууссан гэдэг ийм зүйлийг тайлбарлаад байгаа. Тэр нь тэгэхдээ “Мон лаа” ХХК-д зээл хууль бусаар олгосон гэж байдаг, ТЭЗҮ байхгүй гэж үндэслээд л буруутгасан. Тэрнээс одоо мөнгө авсан, идсэн уусан ийм зүйл бол байгаагүй, тогтоогдоогүй байж байгаа. Тэгэхлээр тэр “Мон лаа” гэж компани нь бол ТЭЗҮ-гээсээ батлаад өгчихсэн юм байна лээ. Энэ бол болохгүй ТЭЗҮ байна аа, өөртөө ТЭЗҮ нь авъя аа гэдэг, өөр ТЭЗҮ байх ёстой гэдэг үндэслэлээр ялласан. Энийг нь шүүх одоо гэмт хэрэг мөн гэж үзээд ингээд л шийдээд явчихсан ийм нөхцөл байдал байгаа.

Н.Мөнхбат дээр одоо бас эрүүгийн хэрэг үүсгэчихсэн явж байгаа. 2017 онд хэрэг бүртгэлийн хэрэг үүсгээд хаачихсан байснаа түрүүн энэ сошиал, олон нийтийн сүлжээнд хэвлэл, мэдээллийн хэрэгслээр маргаан, ийм дуулиан дэгдсэн учраас бол хэргээ нээсэн юм шиг байгаа юм. Ийм одоо олон нийтийн санаа бодолд автаж, одоо хэрэг бүртгэл, мөрдөн байцаах ажлыг бас явуулж болохгүй гэдгийг бол энэ хуульчийн зүгээс хэлэх нь зүйтэй байх гэж бодож байна. Тэр нь бол нөгөө товчхон дурдахад яллагдагчаар татсан тогтоол дээр нь гарчихсан байна л даа. Тэр нь юу юм гэхээр “Эм си эс” компаний барьсан “Говийн зам” гэдэг замынх нь төлбөрийг “Эрдэнэс монгол” гэдэг компанид зээл олгох асуудлыг шийдвэрлэсэн, тэр зээлээ “Эрдэнэс монгол” нь өнөөдрийг хүртэл төлөөгүй байгаа. Энэ дээр нь буруутгаж одоо Хөгжлийн банкны захирал асан Н.Мөнхбатыг буруутгаж, яллагдагчаар татаад, ингээд шалгаад явж байгаа. Өнөөдөр бол одоо цагдан хорьчихсон байж байгаа. Уг нь бол тэр шалгагдаж байгаа тэр захирал байсан хүмүүсийг бүгдийг нь уг нь энд дуудаж ирээд тодорхой нэг талынх нь тайлбарыг өгүүлэх нь их зүйтэй байх байсан гэж бодсон. Гэхдээ нэгэнт цагдан хорьчихсон байгаа учраас тэнд тэр хүний Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажсан нотлох баримтыг шалгуулах, өөрийгөө өмгөөлөх ийм эрхүүдийг бол олгохгүй байгаа шүү. Тэгэхдээ энэ асуудлаар ярьж гонгиноод яах вэ?

Хөгжлийн банкны тухай хуулийн 8.2-т заасан байдаг. Нийт зээлийнхээ 60-аас доошгүй хувийг зөвхөн экспортын зорилгоор зээл олгоно гэдэг. Тэгэхдээ өнөөдрийн байдлаар бол одоо энэ хуулийн заалт зөрчигдсөн асуудал байгаа юм байна. Энд үүнийг манай Хөгжлийн банкны удирдлагууд хэлэх ёстой байх. Дараачийн нэг асуудал, Н.Мөнхбат гэж хүн нэг үнэтэй байр авсан гэдэг, 80 саяар авсан гэнэ үү? Нэг гишүүн тэглээ. Энэ одоо 3 дугаар ангийн хүүхэд үржүүлчих хэмжээний тоо байгааг ингэж алдаж болохгүй л дээ. Ингээд тухайн үед бол Хөгжлийн банк байр авахдаа хэд хэдэн газруудаас ингэж үнийн санал авсан юм байна лээ. “Макс таур” гэхэд л 8.8 сая төгрөгийн санал өгсөн, “Блюскай” гээд одоо бид нарын мэддэгээр Сэлмэн барилга бол одоо 13 сая төгрөгийн өртөгтэй байсан юм байна лээ зах зээлийн ханш нь. “Ай Си Си таур” гээд 8 сая 140 мянга гээд нэлээдгүй олон байгууллагуудаас үнийн санал аваад, ингээд одоо банкны шаардлага хангасан ийм барилгыг барилга гээд 8 сая 400 мянгаар худалдаж авсан юм байна лээ шүү. Тэрнээс биш энэ тал дээр бол одоо ямар нэгэн байдлаар хууль зөрчөөд давуу байдал олгоод хулгай хийгээд ингээд авчихсан, эндээс нь идсэн уусан юм бол байхгүй гэж зарласан. Түрүүн бас хэн гишүүн хэлчихэв, нэг эмэгтэй гишүүн хэлчих шиг боллоо, 1.2 сая ам.доллар хэдэн сая ам.доллароор сурталчилгаа хийсэн гээд, Н.Мөнхбатын зүгээр эдийн засагч гэдэг түүхийг нь харахлаар бол нийт дүнгээрээ бол нэг 2.5 тэрбум ам.долларын одоо санхүүжилтийг гадаадын зах зээлээс босгосон ийм банкир л юм байна лээ. Мэдээж хэрэг энэ зээл олгохдоо сурталчлах биш, энэ Монгол Улсыг гадаадын зах зээл дээр энэ том хөрөнгө оруулагчдын өмнө сурталчлахад гадаадын том том хэвлэл, мэдээллийн байгууллагуудаа сурталчлахад тодорхой хэмжээний мөнгө шаардлагатай байдаг. Энэ хүрээнд энэ том бондуудыг мөнгө босгохын тулд тодорхой хэмжээний зардал гаргаж Монгол Улсыг сурталчилсан ийм л юм байлаа шүү гэдэг. Энийг бас ойлгоорой баярлалаа.

### **Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн Ж.Бат-Эрдэнэ:**

Дараагийн оролцогч “Монцемент Билдинг Материалс” ХХК-ийн Технологи хариуцсан захирал Jungsoo Lee.

### **Jungsoo Lee:**

Би “Монцемент Билдинг Материалс” ХХК-ийн Технологи хариуцсан захирлаар ажилладаг. Олон улсын цементийн салбарт бол 45 жилийн ажилласан туршлагатай. Солонгос, Япон, Филиппин, Хятадын тухайд бол ингээд 13 жил ажилласан ийм туршлагатай хүн байна. Солонгос улсын хувьд бол 1957 оноос эхлээд энэ цементийн үйлдвэрийг бол барьж эхэлж байсан. Цементийн үйлдвэр гэдэг бол аливаа улс орны бол хамгийн чухал салбар, барилгын талх. Сүүлийн энэ жилүүдэд болохоор би нийт одоо 20 төслүүдэд энэ олон жилийн хугацаанд ажилласан.

Солонгосын сайн туршлагыг ярих юм бол цементийн үйлдвэрүүдээ яаж дэмждэг вэ гэхлээр одоо бусад улс орнуудаас оруулж ирж байгаа энэ тоног төхөөрөмжийг бол ямар нэгэн байдлаар татвараас хөнгөлөх, чөлөөлөх бодлогыг барьж явдаг. Ийм дэмжлэгийн бодлогууд байдаг учраас Солонгос улсын хувьд бол дэд бүтцийн хөгжил бол маш хурдтай хөгжиж ирсэн. Одоо адилхан туршлага бол Хятадад бас байдаг. Хятад бол цемент, үйлдвэрлэлээрээ дэлхийд тэргүүлдэг. Сүүлийн жилүүдэд бол цар тахлын хүндрэл бол бүх улс оронд байсан, Солонгост ч бас тохиолдсон. Сүүлд гарсан энэ Украин, Оросын дайн, тээвэр ложистикийн гацаа гээд бүх зүйлийн үнэ өсөх ингээд маш олон хүндрэлүүд тулгарч байна. Цар тахлын үед бол энэ Засгийн газрууд нь бол энэ цементийн үйлдвэрүүдийг маш эрчимтэй

дэмжиж байсан. Жишээлбэл тухайн ажилтан ажиллаж чадахгүй нөхцөлд 1-2 сая төгрөгийн цалинг нь төрөөс олгох, энэ дэмжлэг 1 жилийн хугацаанд хэрэгжих ийм арга хэмжээнүүдийг авч байсан.

Солонгосын Хөгжлийн банк гэж бас байдаг, Хөгжлийн банкнаас нь бас маш хөнгөлөлттэй зээлүүдийг гаргах, 2.5 их наяд төгрөгийн энэ зээлүүдийг гаргахаар шийдвэрлэсэн байгаа. Энэ бол яг дэлхий даяар одоо яригдаж байгаа тогтвортой хөгжил буюу байгаль орчин нүүрс хүчлийн хийг буулгах, тоосжилтыг багасгах гэх зэрэг энэ үйл ажиллагаанд одоо идэвхтэй дэмжиж ажиллаж байгаа эдгээр цементийн үйлдвэрүүдэд ингэж дэмжлэг үзүүлсээр ирсэн.

### **Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн Ж.Бат-Эрдэнэ:**

Дараагийн оролцогч Х.Владимир Сүхбаатар дүүргийн иргэн. Х.Владимир байна уу? Алга байна. Д.Энхсайхан Сүхбаатар дүүргийн иргэн. В индэр.

### **Сүхбаатар дүүргийн иргэн Д.Энхсайхан:**

Б.Энхбаяр гишүүнээр ахлуулсан 2016 оны ажлын хэсгийн дүгнэлт гарсан байгаа. Тэгэхээр энийг одоо өнөөдөр хүртэл улсын нууцад аваад одоо саяхан ил болголоо. Тэгэхээр энэ бол одоо зохион байгуулалттай тийм бүлэг дээрэм байсан шүү гэдгийг одоо бүгдээрээ хүлээн зөвшөөрчихсэн нь зөв өө. Ер нь өглөөнөөс хойш суулаа Улсын Их Хурлын гишүүд маань шийдэл, гарц ерөөсөө ярихгүй юм. Өөрсдийгөө өмөөрсөн, үгэн дотроо улс төр хавчуулсан тийм асуудлаар хандаж байна. Тэгээд яг одоо шийдэл, гарц ярьсан гишүүн бол одоо Б.Пүрэвдорж гишүүн, Б.Энхбаяр гишүүн хоёр тодорхой бас шийдлийг ярилаа.

Ер нь энэ Хөгжлийн банкны хулгай, дээрмийн асуудлыг яаж энэ мөнгийг хохиролгүй болгох вэ, 1.8 их наяд төгрөгийг. Цаашид энэ хулгай, дээрмийг бид нар гаргахгүй тал дээр ямар арга хэмжээ авах ёстой юм гэдэг асуудлыг л бид ярих ёстой энд. Х.Булгантуяа гишүүн маань бүр шийдэл ч байхгүй, яах вэ, яах вэ гэж байгаад ингээд шийдэлгүй сууж байх жишээний. Үнэхээр харамсалтай байна. Тэгэхээр би хэд хэдэн саналыг хэлье ээ гэж бодож байна. Нэгд бол эрүүгийн хуулийг бид өөрчлөх шаардлагатай. Одоо Ерөнхий прокурор асан М.Энх-Амгалан 2018 онд Улсын Их Хурлын чуулган дээр хэлж байсан та бүхний баталж өгсөн хууль, эрх зүйн орчин чинь энэ ээ гээд. За одоо энэ Жастын Батхүүгийн хэрэг 10 жил болж байна. Нэр бүхий шүүгч “Монгол драй милк” компанийн хэргийг 10 удаа хойшлуулсан гэж байгаа юм.

Манай нөгөө Х.Хаянхярваа хялбаршуулсан журмаар 40 сая төгрөгөөр торгуулаад ингээд гарч байдаг. Тэгэхээр энэ эрүүгийн хуулинд цаашдаа авлига, албан тушаалтай холбогдсон энэ албан тушаалтныг бол нийтийн албанд насаар нь сонгохгүй байх нэг, хоёрт гэвэл хөрөнгийг нь хураадаг, заавал хорих ялаар ялладаг байх ийм зарчмуудыг одоо тусгаж өгмөөр байна гэдэг саналыг би хэлж байна. Хоёрт гэвэл энэ 1.8 их наяд төгрөгийн энэ хулгай, дээрмийн асуудлыг хэрвээ Улсын Их Хурлын гишүүд хүсээд шийдвэл гарц байгаа. Тэр өр барагдуулах хуулиа яагаад та нар ярихгүй байгаа юм бэ? Гарц байж л байгаа шүү дээ. Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар нэг дурдсан. Сая одоо Сангийн сайд нэг дурдаж байна. Үүнийгээ ашиглалдаа. Улсын Их Хурлын гишүүд хууль санаачлах энэ Монгол Улсын Үндсэн хууль дээр заасан төрийн эрх барих дээд байгууллага шүү дээ. Хүсвэл та нар шийдэх бүх боломж гарц, гаргалгаа нь байж байгаа. Энэ асуудлыг та нар одоо тэр Түр хороо байгуулаад яаралтай хэлэлцэх байх гэж бодож байна.

Дараа нь Улсын Их Хурлын гишүүний одоо хамаарал бүхий этгээдүүд энэ төртэй холбоотой сан, энэ төрийн банкнаас ерөөсөө зээл авч болохгүй гэдгийг нь хуульчлаад өгөөч ээ. 30 жил ярилаа шүү дээ энэ авлигалыг байхгүй болгоё, үгүй болгоё гээд 30 жил шоудлаа шүү дээ. Энэ ард түмэн чинь бүр залхаж байна шүү дээ. Тийм учраас энэ 3 саналыг Улсын Их Хурлын гишүүд бас хүлээж аваад одоо ажил болгооч ээ гэдгийг би хичээнгүйлэн хүсэж байна. Тэгээд би эрүүгийн хуулийн нэг хэсэг энэ 22 дугаар бүлэг авлигын гэмт хэрэг гээд яг энэ эрүүгийн хуулийн тусгай ангийн 22 дугаар бүлгийг ингээд хэвлээд аваад ирсэн юм. Энэ эрүүгийн хуулийн энэ заалт бол энэ Монгол Улсад шударга ёсыг тогтоох, бэхжүүлэх боломжгүй авлига, албан тушаалтныг одоо өмөөрсөн хамгаалсан ийм хууль юм. Тийм учраас би Монголын ард түмний өмнөөс энэ хуулийг би одоо ингэж, хуулийн зөвхөн энэ 22 дугаар заалтыг шүү, би урж хаяж байгаа юм. Ингээд урж хаялаа. Одоо Улсын Их Хурлын гишүүд энэ хуулиа та нар санаачлаарай хийгээрэй. Нэг ийм л юм байна, зүгээр нэг асуулт байна. Зүгээр хариулчихаарай, цаг бол байна. Хөгжлийн банкны захирал Мандуул та өөрөө хэдэн төгрөгийн цалинтай вэ, танай газрын дарга нар чинь хэдэн төгрөгийн цалин авч байна. 3000 метр квадрат талбайд суудаг гэж байна. Тэнд одоо хэчнээн хүн ажиллаж байна? Танай цалингийн зардал, тэр урсгал зардал чинь одоо ямархуу байна? Тэр арилжааны банкуудтай харьцуулахад одоо.

#### **Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн Ж.Бат-Эрдэнэ:**

Д.Энхсайхан Сонгинохайрхан дүүргийн иргэн гурван санал гэж байна. Манай ажлын хэсгийнхэн бас өгчихнө биз наадах аа. За урсан хуулиа бас өгчихөөрэй. Дараагийнх Г.Янсанжав гавьяат эдийн засагч, доктор профессор.

#### **Г.Янсанжав-Гавьяат эдийн засагч, доктор профессор:**

Улсын Их Хурлын ажлын хэсэг сайн ажиллажээ, сайхан дүгнэлт гаргажээ. Тэгээд энэ дээр бол мэргэжлийн хүний хувьд би мэргэжил нэгтэй учраас ингэж ярьж байна. Би бол яг банкны урт хугацаатай зээлээр Европод арван хэдэн сар сурсан. Энэ Хөгжлийн банкны яг мэргэжлийн хүн, энийг хэдүүн ч бас хэлж байсан. Тийм учраас цаашдаа Сангийн сайд Б.Жавхлан сайд энэ тэр шаардлагатай бол намайг дуудаад асууж байгаарай. Аж үйлдвэрийн комбинатын энэ арван хэдэн үйлдвэр, гутлын үйлдвэр энэ тэр бүгд банкны урт хугацаатай зээлээр бид нар бариулсан. Бид нар ерөөсөө орон тоо цөөхөн. Тэгээд яг ажлын гүйцэтгэлээр нь. Одоо энэ чинь ерөөсөө Төслийн хэмжээгээр нь одоо хичнээн л гардаг юм тэрүүгээр нь мөнгийг нь өгчихдөг бололтой юм. Тийм юм байж болохгүй. Яг гарсан ажлын гүйцэтгэл, хийгээд гараад ирсэн ажлын гүйцэтгэл дээр нь уялдуулж зээлийг өгч явдаг. Түүнээс одоо 100 тэрбумын төсөл байж байлаа, 100-г бөөнөөр нь өгчих юм. 40 сая ам.доллар гээд л одоо энэ асуудал бас яригдаад ингээд яваад байна.

Тийм учраас энэ дээр цаашид одоо миний хэрэг бол дуудаад ер нь Хөгжлийн банкны тэргүүн дэд захирлаар Энхбат болоод намайг нэг дуудаж бас ярьж байсан юм. Тийм учраас цаашдаа энэ дампууруулах энэ тэр гэдэг бол буруу, тэгэх юм бол одоо зээл төлөгдөхгүй болоод явчихна. Тэгээд өрөө ч барагдуулах хэрэгтэй, цааш нь ажил авч явах хэрэгтэй. Ажлыг нь боловсронгуй болж Улсын Их Хурал, Засгийн газар чиглэлийг нь зөв гаргаж өгөх хэрэгтэй юм. Хэрвээ шаардлага бол намайг дуудаарай, би тэгээд одоо цаашид санаа оноогоо хэлэхэд бэлэн байна. Баярлалаа. Өөр олон юу байх вэ, амжилт хүсье.



## **Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн Ж.Бат-Эрдэнэ:**

Баярлалаа. Баянгол дүүргийн иргэн О.Отгонбаатар. В индэр дээр.

### **О.Отгонбаатар:**

Та бүхэнд оройн мэнд хүргэе. Хэдүүлээ шударга л байя, шударга ярьцгаая. Би 2016 оны Б.Энхбаяр гишүүний хийсэн ажлын тайлантай танилцсан. Тэр бол маш сайн шалгалт болсон байна лээ. Маш сайн дүгнэлт гарсан байна лээ. Танд бас баярлалаа. Би өнөөдрийн ажлын хэсгийнхэн ийм дүгнэлт гаргах болов уу гэсэн миний арай санаанд хүрсэнгүй. Уучлаарай таны нэрийг оруулчихсан байна гээд буцаагаад нэг хүн гомдол гаргахаар нэрийг нь татчихаж байх шиг.

Б.Энхбаяр гишүүний ажлын дүгнэлтийг гарсан шиг ийм дүгнэлт гарах болов уу гэж хүлээж байсан талаар боллоо. Дээрээс нь би энэ сонсгол дээр Ц.Цэрэнпунцаг гишүүн аж ахуйн нэгжүүдээ өмөөрнө гэж 20 минут яриад гарлаа. Б.Пүрэвдорж гишүүн болохоор тийм ч бяргүй байлаа. Ийм чадалгүй бол ийм шалгах боломжгүй байлаа гэж 20 минут ирээд сүүлд нь баахан улс төржиж сонгууль ярьсаар байгаад гараад явлаа. Н.Алтанхуяг гэдэг хүн нь бол ерөөсөө өөрийгөө 20 минут өмөөрчихөөд тавьсан юмаа ч авч чадахгүй, Ш.Адъяаа гишүүн тэрийг нь араас нь аваад явж байна. Н.Алтанхуяг өөрийгөө өмөөрөх шаардлагагүй шүү дээ. 2015 оны 12 дугаар сарын 15-ны өдөр бондын зөвлөл байгуулагдсанаас хойш энэ бүх бузар булай тонуулын чинь эхлэл эхэлсэн шүү дээ. Та тэр үнэт цаас гаргана, 2013 оны 12 дугаар сарын 03-ны өдөр Засгийн газрын үнэт цаасны талаар авах зарим арга хэмжээний тухай гээд баталсан байдаг. Ингээд та үнэт цаас гаргадаг, худалдаж авдаг Хөгжлийн банк. Улаанбаатар хотын банк Хөгжлийн банкнаас худалдаж авдаг. Хадгаламж, харилцах байршуулна Улаанбаатар хотын банк, Худалдаа хөгжлийн банкнаас байршуулдаг, бүр 200, 300 тэрбум төгрөгөөр илүүдэлтэй байршуулдаг. Ийм байсан энэ Засгийн газрын үед та энэ Монгол Улсыг толгойлж, Н.Алтанхуяг сайдаа та капитан байсан шүү дээ Монгол Улсын. Тэгээд би танд хандаж хэлэх гэж байна. Дээрээс нь энэ “Хөтөл”, “Кью Эс Си”-ийг яриад яриад байна гээд байх юм, Н.Алтанхуяг сайдын үед олгогдсон шүү дээ. Намайг бууснаас хойш 10 хоногийн дараа Ч.Сайханбилэг олгосон билээ гэнэ, уучлаарай таны үед судлагдаад, таны үед зөвшөөрөгдөөд, таны үед олгогдсон зээл. Н.Алтанхуяг сайд аа та одоо энэ нэг хошин шогоо боль. Тогдгор Галсантогтох гээд Монгол Улсад нэг хошин шогч агуу хүн байсан. Та төрийн ордонд харин тэрийг дуурайгаад байгаа юм уу? Эгдүүцэл, зэвүүцэл хүрч байна энд. Н.Алтанхуяг сайдыг би бол одоо энэ Хөгжлийн банкийг тонох ажлыг эхлүүлсэн хүн бол мөнөөсөө мөн. Б.Мөнхбатыгаа танихгүй гэлээ. Уучлаарай, Фортуна та хоёр таны удирдаж байсан яамны чинь Төрийн нарийн бичгийн дарга, таны удирдаж байсан яамны чинь туслах нь очоод гүйцэтгэх захирал хийчихсэн. Дээр нь өнөөдөр бид нар аягүй олон тэрбум төгрөг, аягүй гоё 213 тэрбум төгрөг энэ тэр гээд яриад ард талынх нь ярихаа больчихлоо, 600 сая тэр чинь мөнгө. Одоо би та нарт өшөө зүйл хэлье энэ бид нар олон тэрбумыг яриад байна, “Хөтөл”-ийг яриад байна, “Кью Эс Си” ХХК-ийг яриад байна, үгүй байхгүй юу. Одоо жишээлбэл Гарамгайбаатарын “Монроуд” гэдэг компанид 300 саяын ямар ч магадлангүй, ямар ч зураг төсөлгүй ажлыг өгөөд, ажил дууссаных нь дараа зураг төсөл нь магадланг нь хийлгүүлээд, хүссэн мөнгийг нь хэлэхээр нь өгөөд ийм л байсан шүү дээ, энэ чинь. 1 тэрбум 2 тэрбумын асуудлууд яригдахгүй юу өнөөдөр Н.Алтанхуяг гишүүн ээ. Одоо дээрээс нь би бас нэг санал хэлэх гэж байна. Би Н.Алтанхуяг гишүүнийг Авлигатай тэмцэх газар өгье. Авлигатай тэмцэх газар шалгах уу? Шалгах үндэслэлтэй гэж байвал Улсын прокурор нэрийг нь татах уу Улсын Их Хурлаас. Би энийг бүр асуумаар байна. Та нар жоохон шударга түс тас

хийгээд хариулчихаач дээ. Дээрээс нь би энэ Б.Энхбаяр гишүүнд бүр цөхөрсөн иргэний л үг л дээ. Улсын Их Хурал дээр одоо бид нар эндээс ингээд тараад юм болохгүй. Дээр нэг, хоёр сэтгүүлчийн хэлэлцүүлэгт бид нар орсон үр дүнтэй болсон. Сүүлд нь хүмүүс иргэд одоо тэгээд яах вэ гэдэг юмаа яриад тарсан байхгүй юу. Одоо энд бол ямар ч шийдэл гарахгүй. 20 минут өөрөө өөрсдийгөө өмөөрөөд.

Н.Алтанхуяг нь өөрийгөө өмөөрөөд авчирсан материалаа авч чадахгүй бол салгалаад гараад явлаа. Эндээс шийдэл гарахгүй Б.Энхбаяр гишүүн ээ. Улсын Их Хурал дээр нэг удаагийн хууль батлаад энэ асуудлыг шийдэж болдоггүй юм уу? Одоо жишээ нь тэр хууль хяналтын байгууллага нь 3 сарын дотор асуудлыг шийддэг, 12 буцаадаггүй, 8 жил болдоггүй, 7 жил болдоггүйгээр 1 удаагийн ийм хууль гаргаад энэ асуудлаа цэгцэлж аваад цуцалчих ийм хууль зүйн үндэслэл нь юу байдаг юм бэ? Би одоо бол Н.Алтанхуяг сайдыг Авлигатай тэмцэх газар өгнө. Дээрээс нь шалгаад энэ хүнийг эргүүлэн татах хүртэл би. Эд нар чинь нөгөө нэг Ерөнхийлөгчийг нь бүртгэсэнгүй, нэр дэвшүүлсэн хүнийг нь бүртгэсэнгүй гээд Улсын Их Хурлын бүлгийнхэн нь гадаа гараад хэвтчихдэг юм байна лээ шүү дээ. Эрх ашиг нь зөрчигдөхөөр. Одоо би Н.Алтанхуягийг шалгахгүй болбол ард иргэдтэйгээ яриад энэ гадаа хэвтчихье. Энэ Монголыг тонон дээрэмдэх үйлс, энэ монголын том дээрэмдэх бүх зүйлийн цучил буюу галыг Н.Алтанхуяг асаасан шүү. За баярлалаа.

#### **Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн Ж.Бат-Эрдэнэ:**

С.Батзориг “Бэрэн групп”-ийн Хөрөнгө оруулалт, хөгжлийн газрын захирал. В индэр.

#### **“Бэрэн групп”-ийн Хөрөнгө оруулалт, хөгжлийн газрын захирал С.Батзориг:**

Та бүхэнд энэ оройн мэндийг хүргэе ээ. Үг хэлэх боломж олгосонд баярлалаа. Би “Бэрэн групп”-ийн Хөрөнгө оруулалт хариуцсан захирал байна. “Бэрэн групп”-ийн нэр өнөөдөр нэлээн олон дурдагдлаа. Манай компанийн хувьд Хөгжлийн банкнаас хоёр төсөл зориулж зээл авсан байдаг. Барилгын арматурын үйлдвэрт 27.2 сая ам.доллар, Хангай хотхоны 5 дугаар блокийн төсөлд 11.7 сая ам.долларын зээл авсан байдаг. Цаг бага учраас төслүүдийнхээ талаар товчхон дурдаад өнгөрье.

Хангай хотхон төсөл маань болохоор гэр хорооллын дахин төлөвлөлтийн төслийн хүрээнд хэрэгжиж байгаа төсөл. Гэр хорооллын дахин төлөвлөлтийн төсөл маань ерөнхийдөө бусад арилжааны шинж чанартай барилгын төслүүдээс бол ялгаатай. Иргэдээс 500 метр квадрат талбайг 2 ширхэг 2 өрөө байраар сольж, өндөр өртөгтэй газар дээр бага, дунд орлоготой иргэдэд зориулсан орон сууц барьдаг. Ц.Мөнхцэцэг гишүүн ярьж байна лээ барьцаалсан байраа зарчихсан байна гээд. Энэ бүгдийг Хөгжлийн банктайгаа анхнаасаа зөвшилцөж байгаад хийсэн. Хөгжлийн банкандаа танилцуулаад ийм зүйл хийх гэж байна гэдгээ танилцуулж байгаад хийсэн байгаа. Яагаад гэвэл бидэнд өнөөдрийн байдлаар Хангай хотхоны 5 дугаар блокийн 3 барилга, 5 орц, 360 айлын орон сууц ашиглалтад ороход бэлэн болчихсон байж байна. Борлуулалтын орлого, бусад үл хөдлөх хөрөнгөтэй нийлээд 33 тэрбум төгрөг зээлээ төлөхөд хангалттай.

Энэ 3 барилгын Хөгжлийн банканд барьцаалсан дүн нь өөрөө 7.8 тэрбум төгрөг зээлийн эргэн төлөлттэйгөө уялдуулаад Хөгжлийн банкны барьцааны шаардлагатай уялдуулаад барьцаа хөрөнгөөс чөлөөлөөд зээлээ эргэн төлөхөд одоо бид нар бэлэн байна.

Дараагийн төсөл барилгын арматурын, үйлдвэрийн төсөл маань өөрөө “Эрдэнэтийн төмөрлөгийн үйлдвэр” төслийн дэд төсөл юм байгаа юм. Анх 2014 онд зээл авахаас өмнө юу юу хийсэн байсан бэ гэвэл 2003 оноос эхэлсэн төсөл 2003 онд төслийн бэлтгэл ажлууд хийгдээд 2007 онд монголын анхны нойтон баяжуулах үйлдвэр баригдаад ажилласан. Монголын анхных. Дараа нь 2009 онд “Хөх ган” шууд ангижруулсан төмрийн үйлдвэр, энэ үйлдвэр одоо ажиллаж байгаа. Бид нар гангийн үйлдвэрлэлд шаардлагатай коксоо үйлдвэрлээд хагас кокс буюу полкосон туршилт амжилттай гээд явж байна. Үйлдвэрлэл явж байна.

Дараагийн үйлдвэр “Агаан” 2011 онд шууд ангижруулсан төмрийн үйлдвэр. Архангай аймагт байрлалтай. Тэгээд үүний дараа 2014 онд бид нар Хөгжлийн банкнаас зээл аваад барилгын арматурын үйлдвэрийн төслийг хэрэгжүүлсэн. Үүнтэй зэрэгцээ гээд 2014 оны 11 дүгээр сард Монгол Улсад анх удаа ширэм үйлдвэрлэсэн. Энийг одоо болтол экспортод гаргаж байна. Бүгд найрамдах Хятад ард улс, Бүгд найрамдах Солонгос ард улсад одоог хүртэл экспортолсоор л байна бага хэмжээгээр. Монголдоо Улаанбаатар төмөр замд нийлүүлж байгаа. Машинаар бол наклад гэж нэрлэдэг төмөр замын вагоны наколоткийг нийлүүлж үйлдвэрлэдэг. Сая Ковидоос өмнө Казахстан руу нийлүүлэхээр байсан боловч Ковидын шалтгаанаас болоод хойшилсон. Бид нарт бол экспорт хийх боломжууд бол бүрэн байгаа.

Хоёр төслийн хувьд юу тохиолдоод байгаа вэ гэвэл томоохон төслүүдэд тохиолддог төслийн эрсдэл яг бодитоор учирсаар л байна. Улс төрийн, нийгмийн, эдийн засгийн, технологийн бүгдээрээ бодитоор учирсан. Тэгэхдээ бид нар энд цөхрөөгүй давахыг нь даваад бүдрэх дээр нь бүдрээд өдий хүрсэн. Бид нар 2 зүйл дээр алдсан гэж боддог.

Нэгдүгээрт, төр засагтаа хэтэрхий их найдчиж. Энэ төслийг үргэлжлүүлээд санхүүжүүлээд явах болов уу гэсэн санхүүжүүлээгүй. Холбогдох мэргэжилтнээс нь Ерөнхийлөгч хүртэл бүх түвшний төрийн албан хаагч нар манай үйлдвэр дээр очиж үзсэн бахархалтайгаар энийг дэмжих ёстой төсөл байна гээд л явдаг. Ард нь дэмжлэг байдаггүй.

Хоёрдугаарт энэ үйлдвэр үндэсний компани, үндэсний үйлдвэр. Энэ үйлдвэр дээр бид нар гаднын хөрөнгө оруулалт татахыг үнэхээр хүсээгүй юм. Стратегийн ач холбогдолтой бүтээгдэхүүн учраас гаднын хөрөнгө оруулалт, гаднын компани орж ирээсэй гэж үнэхээр хүсээгүй. Ийм хоёр алдаа гаргасан байна. Сая өнгөрсөн 7 хоногт болсон эдийн засгийн чуулган дээр зарим нэр бүхий албан тушаалтнууд дурдаж байна лээ. Тэнд нэг юм бүтээе гэхээр нэг далд гар байгаад байдаг юм байна лээ. Хийлгэхгүй бүтээхгүй гэсэн.

Сүүлийн жилүүдэд тэрийг маш ихээр мэдэрч байгаа. Яг энэ төсөл дээр гардаж ажиллаж байгаа миний хувьд яг хувь хүнийхээ хувьд энэ үйлдлийг, энэ байдлыг маш ихээр мэдэрч байна. Тийм зүйл байдаг юм байна. Өшөө нэг алдаа бид нар үйлдлээрээ хийгээд харуулчихвал болно доо гэж бодоод олон нийтэд үйл ажиллагаагаа сурталчилдаггүй байж байгаа. Өнөөдрөөс эхлээд бид нар олон нийтэд нээлттэй үйл ажиллагаагаа танилцуулаад ярья. Маргаашнаас эхлээд сэтгүүлчдээс ч юм уу олон нийтийн байгууллагуудаас манай компани дээр ирээд манай үйл ажиллагаатай танилцах, Хөгжлийн банкны зээлтэй холбоотой асуудлаар уулзалт, ярилцлага авъя гэвэл бүгдэд нь нээлттэй гэж хэлмээр байна.

## **Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн Ж.Бат-Эрдэнэ:**

Баярлалаа. Дараагийн оролцогч Б.Эрдэнэбат “Эрэл групп”-ийг үүсгэн байгуулагч. Б индэр дээрээс.

## **“Эрэл групп”-ийг үүсгэн байгуулагч Б.Эрдэнэбат:**

Ц.Даваасүрэн гишүүн, М.Оюунчимэг гишүүн хоёрт товчхон нэг хариулчихъя, уул нь сая дэлгэцэн дээр харуулах байсан юм. Тэгээд энэ дэлгэц нь орой одоо ингээд бас ажиллахгүй шалтгаантай гэсэн ийм үндэслэлээр одоо би цаасаар л товчхон харуулахаас гэж бодож байна. Тэгээд миний ярьж байгаа бүх юм бол одоо, сүүлийн би чинь, сүүлийн 4 жил ингээд цахимаар янз бүрээр өнөөдөр Эрэл компани, түүний хамт олон гээд бүгд л ингээд гүтгүүлээд дайруулаад байдаг, тэгээд Улсын Их Хурал, Засгийн газар дээр ч гэсэн, саяын тэр Туушин зочид буудалд болсон ч гэсэн ерөөсөө тэр чигээрээ гүтгэлэг, тэгээд тэр гүтгэлгийг нь засах гээд одоо ингээд энэ хэвлэлийн бага хурал хийгээд бүх нотлох баримтуудаа харуулсан. Сая өнөөдөр ч гэсэн би одоо бүгдийг нь нотлох баримтад тулгуурлаж ярьж байгаа. Миний үг өгүүлбэр болгон дандаа ардаа хамгийн доод тал нь Засгийн газрын тогтоол, Улсын Их Хурлын тогтоолтой гэж би одоо ингэж хэлээд яриад байгаа шүү дээ. Тэгэхээр энийг их зөв талаас нь ойлгомоор байгаа юм. Энэ үйлдвэр өөрөө яах вэ Ц.Даваасүрэн гишүүд хэлээд байна л даа, хувь хүн захиалаад өөрсдөө одоо энийг хийчхэж болдоггүй юм уу гэж. Энэ хот тосгон барьдаг үйлдвэр байхгүй юу даа. Манай өнгөрсөн зууны Улаанбаатарыг, Дархан, Эрдэнэтийг барьсан үйлдвэрийг, одоо ийм юм бид барих гээд байна шүү дээ. Тэгээд энийг тийм учраас бид хамгийн анханд нь түрүүн үзүүлсэн.

Ингээд Засгийн газраасаа жил болгон 150 мянган метр квадрат соёл, олон нийтийн барилга, 5000 айлын орон сууцыг захиалж тухайн үеийн зах зээлийн ханшаар авна гэсэн болохоор би зээл авч энийг одоо хийсэн шүү дээ. Түүнээс юу гэж өнөөдөр, энэ чинь нэг бол яагаад гэхлээр том захиалга хэрэгтэй байгаа юм. Одоо 220 мянган өрхийн гэр хорооллыг агаар хөрсний бохирдлоос нь яг салгах ийм төсөл энэ мөн өөрөө. Тийм учраас л одоо өнөөдөр болбол бид тодорхой хэмжээнд, одоо тэр Улсын Их Хурал, Засгийн газрын тогтоолоо одоо хэрэгжүүлээч ээ гээд. Энэ тогтоол нь бол байгаа 2016 оны одоо 121 дүгээр тогтоол байна, 2019 оны 202 дугаар тогтоол байна. Тэгээд энэ дээр би одоо энийг бас дахиад одоо ингээд уншаад өгчихье. Одоо энэ яг бүх юм нь Хөгжлийн банканд гаргасан, энэ чинь баталгаа гэж үзнэ шүү дээ. Улсын Их Хурлын одоо 2 тогтоол, 36 дугаар тогтоол, 23 дугаар тогтоолыг үндэслээд Засгийн газрын 171,180 дугаар тогтоолыг үндэслээд, тэгээд гэр хорооллын дахин төлөвлөлт, агаар, хөрс, усны бохирдлыг бууруулах ийм зорилгоор стратегийн ач холбогдолтой ийм төсөл өө.

Энийг өнөөдөр жил болгон 184 мянган өрх тухайн үед байсан байна. Жил болгон одоо 150 мянган метр квадрат ийм талбай, 5 мянган айлын орон сууцыг тус үйлдвэрт захиалж, зах зээлийн ханшаар худалдаж авна гэсэн юу сая миний үзүүлдэг. Дараад нь би бас сая хэлсэн 2016 оны Засгийн газрын тогтоол нь энэ 2016-2020 он хүртэл Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр жил болгон өнөөдөр энэ дээр ингээд бүр баталчихсан хийх ажлыг нь 2017, 2018, 2019, 2020 онд энэ дээр угсармал барилга хийцийн үйлдвэр гээд хамгийн дэлхийн орчин үеийн техник технологийг ажиллуулна. 2019 онд үйл ажиллагааг нь жигдэлнэ, 2020 онд өвөл, зунгүй тасралтгүй үйл ажиллагаа явуулж барилгажуулна гээд. Дараагийнх нь тогтоол болбол 2019 оны 202 дугаар тогтоол байгаа юм, энэ тогтоолоор бол жил болгон 2019 оноос эхлээд 2500 айл, нийтдээ 2019, 2020, 2021, 2022 онд 10 мянган

айлыг барилгажуулж, хэрэгжүүлж гэр хорооллыг дахин төлөвлөнө гэсэн. Тэгэхээр энэ тогтоолууд маань одоо ингээд хэрэгжээгүй байхгүй юу даа. Тэгээд хэрэгжээгүй хүндэтгэх шалтгааныг нь би ойлгож байна л даа. Одоо 2019 оноос Ковид гээд одоо ингээд ийм юм гарсан, Олон улсын давагдашгүй хүчин зүйл болсон ийм үүдлээс гэж байгаа юм. Тэгэхээр өнөөдөр энэ М.Оюунчимэг гишүүн өөрөө болбол эрэн сурвалжлах дээр хуучин ажиллаж байсан гэж ярьж байна. Тэгээд Улсын Их Хурлын гишүүн хүн Засгийн газар, Улсын Их Хурлынхаа тогтоолыг үзээд судлаад, үндэслэлтэй, тэгээд хэн хэний буруу юм тэгвэл. Засгийн газрын тогтоолыг хэрэгжүүлээгүй нь хэний буруу юм? Засгийн газрын тогтоолыг бүх яам агентлагууд Хөгжлийн банк хэрэгжүүлэх ёстой, би ингэж үзэж байгаа.

Өнөөдөр би өөрт чинь юу гэж хэлэх вэ гэхээр “Эрэл групп” компани 2017 онд үйлдвэр ашиглалтад оруулснаас хойш бүтэн 4 жил ажилгүй зогсож байна шүү дээ. Ийм хариуцлагыг бид нийгмийн өмнө хүлээгээд тэвчээртэй янз бүрийн юм яриад, Засгийн газрыг шүүхэд өгөлгүй байж байгаа. Хамгийн гол нь энэнээс гарах гарц бий юу гэвэл гарц байгаа. Түрүүн Сангийн сайд Б.Жавхлан хэлсэн, ажлын хэсгийн дарга одоо бас Б.Баттөмөр гишүүн хэлсэн. Үнэндээ бидэнд бол маш олон янзын вариант байна. Олон улсаас стратегийн хөрөнгө оруулагч олъё, тодорхой хэмжээгээр үндсэн зээлийн төлөлтөө явуулах.

#### **Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн Ж.Бат-Эрдэнэ:**

Баярлалаа дараагийн оролцогч Б.Жагар “Ард түмний штаб”-ын тэргүүн. А индэр.

#### **“Ард түмний штаб”-ын тэргүүн Д.Жагар:**

Юуны өмнө иргэний хөдөлгөөний байгууллага, сэтгүүлч нартаа, Баттөмөрийн Энхбаяр гишүүн, Бөхчулууны Пүрэвдорж гишүүн, Баднаанямбуугийн Бат-эрдэнэ гишүүн нартаа энэ өдрийн мэнд хүргэе. Бусдад нь бол хүргэж чадахгүйнэ ээ. Хөгжлийн банк болбол баячуудад зориулсан банк, хулгайч нарт зориулсан банк, тэдний нууц амрагуудыг, хамаарал бүхий этгээдүүд, ашиг сонирхол нэгтэй тийм хүмүүсийг санхүүжүүлдэг банк.

Тэгээд ядарсан ард иргэд нь болохоор банк болон банк бус, мөнгө хүүлэгчдийн золиос болоод шөнө, өдөргүй шүүхийн шийдвэргүйгээр эд хөрөнгийг нь хурааж байхад мөн шударгаар татвар төлж байгаа аж ахуйн нэгж, жижиг дунд үйлдвэрлэгчдийг банкнууд мөнгө хүүлэгчид дээрэмдэж байхад Монголбанк яг юу хийсэн юм бэ? Би Монголбанкны нөхдүүдэд бас нэг зөвлөгөө өгье. Иргэний хуулийн 218.1 дэх хэсэгт төлбөр гүйцэтгэх хугацаа болохоос өмнө мөнгөний ханш өссөн, буурсан бол үүрэг үүсэх үеийн ханшаар тооцож төлбөрийг төлнө гэх заалт. Энэ заалтыг хэрэгжүүлж яагаад энэ баялаг бүтээгчдээ хамгаалж болдоггүй юм эрхэм хулгайч нар аа. Иргэний хуулийн 222.2 үүрэг гүйцэтгэгчийн гэм буруутайгаас болоогүй бол үүрэг гүйцэтгэгчийг хугацаа хэтрүүлсэн гэж үзэхгүй гэдэг хуулийн зүйл заалт байна. Энэ Ковидын хугацаанд энэ Хөгжлийн банкныхаа нөөцөд байгаа мөнгөнөөсөө ард иргэд, аж ахуйн нэгжийнхээ зээлүүдийг жилийн 3 хувьд яагаад шилжүүлж болоогүй юм. Ингэж байж эдийн засгийн хүндрэлээс гарч ядуурал, ажилгүйдэлтэй тэмцдэг болохоос биш та нар өөрсдөө хамаарал бүхий этгээдүүдээрээ дамжуулж хулгай хийж авсан мөнгөө ард түмэнд 12 хувь, 8 хувь, 6 хувийн хүүтэй зээлээд энэ улс яаж өнөөдөр гэрэл гэгээтэй байх юм. Тэгэхээр залуучуудынхаа аз жаргалыг хулгай хийсэн эрхэм хүндэт хулгайч нар аа. Одоо энд сууж байгаа Авлигатай тэмцэхийн дарга, Ерөнхий прокурор, хууль хяналтын

байгууллагууд энд байгаа зарим хулгайчийг уг нь гарах ёстой шүү дээ. 461-д эд нар байж байх ёстой шүү дээ.

Эд юун цай, кофе уугаад одоо нүүр нүүрээ хараад хоорондоо суурин дээрээ 360 градус эргэлдээд явж байх гэж. Тэгэхээр одоо “Ард түмний штаб”-ын тэргүүний хувьд бидний тэмцдэг зорилго бол банкны хүүг жилийн 3 хувь болгох зорилготой. Тэгэхээр Улсын Их Хурлын гишүүд бол үнэхээр азтай юм. Азтай ордонд төрчихсөн юм байна, та нар, аягүй олон лицензтэй. Тэгээд тэр лицензээ барьцаалаад Хөгжлийн банкнаас зээл аваад. Энэ хулгайг илрүүлэхэд амархан том сэтгэж чадахгүй бол ядаж жижигхэн аваад Зайсангийн амнуудыг шалгаад үз. Наад Ардын нам, Ардчилсан намын хулгайч нар хотхон барьчихсан 4 тэрбумаар зарж байна. Би та нарыг дагуулаад очъё. Зарим нэг хулгайчдынх нь найз энэ дотор сууж байна. Нөгөө хууль хяналтын байгууллага нууц, нууц гээд байдаг болохоор бас энэ хүмүүсийн ажлыг хүндэтгээд энэ хүмүүсийн нэрийг дурдахаа больё. Тэгээд одоо цаг нь болохоор Жаргалсайхан прокурор ил болох нь цаг хугацааны асуудал гэж хэлсэн учраас найдаж байна.

Сахал Эрдэнэбилэг тэргүүтэй Худалдаа хөгжлийн банк, Улаанбаатар хотын банк, Чингис хаан банк, Төрийн банк, Голомт банк, Хаан банк гээд за нэг баахан нэг банкнууд бас зээл авсан тухай ингээд яригдаад байгаа юм. Тэгэхээр өнөөдөр мөнгө хүүлэгчдийг санхүүжүүлдэг хөгжлийн бодлого байдаг юм уу? Би лав сонсоогүй. Энэ дэлхий дээр тийм юм байхгүй юм байна лээ.

Тэгэхээр та нар шударга ёсыг өөрсдөөсөө эхэл. Энэ Улсын Их Хурал одоо эрх зүйн чадамж байгаа юм уу, үгүй юм уу. Одоо энэ ном уншдаг хэдэн гишүүн байгаа юм. Би та нарт захиас хэлье. Ном уншицгаа. Нэг, хоёр, гуравхан Улсын Их Хурлын гишүүн иргэдийнхээ эрх зүйн байдлыг дээрдүүлж ажилладаг. Бусад нь бол өөрсдийнхөө эрх зүйн байдлыг хамгаалж иргэдийнхээ эрх зүйн байдлыг дордуулдаг ийм байна. Тийм учраас өнөөдөр ард түмний штабын нэн тэргүүний зорилго бол нийт одоо энэ шударгаар баялаг бүтээж байгаа аж ахуйн нэгжүүд, иргэдийнхээ зээлийг жилийн 3 хувьд шилжүүлэх ийм шаардлагыг удаа дараа та бүхэнд хүргүүлж байгаа. Ингэж байж энэ Ковидын үеийн эдийн засгийн хүндрэлээс гарах болохоос биш, та нар хоороныхоо хулгайг яриад нэг нь нэгнийгээ хамгаалаад байж болохгүй. Тэр Баагаагийн Баттөмөр гээд энэ ажлын хэсгийг ахалж байгаа нөхөр, та одоо ингээд суурин дээрээ Л.Энх-Амгаланг нэг ганц хоёр үг хэлэнгүүт нь ингээд ийм хоёр нүүртэй байхаа боль. Ажлын хэсгийн дарга юм бол ажлын хэсэг шиг бай. Би өөрт чинь анхнаас чинь итгээгүй. Ордны гадаа, манай энэ олон иргэний хөдөлгөөний сэтгүүлч нар энэ ажлын хэсгийг өргөтгөө, өргөтгөсөн бүрэлдэхүүнтэй ажиллалаа гээд хэлсэн. Одоо ингээд явж байсан Оюу толгойн ажлын хэсэг Б.Бат-Эрдэнэ гишүүн та мэдэж байгаа шүү дээ. Өргөн бүрэлдэхүүнтэй 200 гаруй хүн очиж ажилласан учраас үр дүн гарсан юм. Тэрнээс та 5 бол энийг хийж чадахгүй ээ. Би хэлчихье, та бол жижигдэнэ шүү. Тэр хулгайч нарынхаа өмнө хууль чинь бүдэг бүдгэрч байна. Энэ хууль хяналтын байгууллага ингээд ажлаа хийх боломжийг нь олгох үүднээс амжилт хүсье ээ.

### **Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн Ж.Бат-Эрдэнэ:**

За нээлттэй сайхан ярих бололцоог олгож байгаа шүү. Тэгэхдээ бас үг үсгэн дээрээ хэдүүлээ жаахан анхаарчихвал зүгээр байх, нээлттэй байхыг бол дэмжиж байгаа. За Б.Отгонтөгс Монгол Улсын Их сургуулийн Эдийн засгийн сургуулийн багш. А индэр дээр микрофон өгье.

**Монгол Улсын Их сургуулийн Эдийн засгийн сургуулийн багш  
Б.Отгонтөгс:**

Сайн байцгаана уу? Би өнөөдөр Хөдөлмөрийн үндэсний намын судалгааны хүрээлэнг төлөөлж байгаа юм. Би өөрөө их сургуулийн багш, эдийн засгийн ухааны доктор, их сургуулийн профессорын албан тушаал дээр ажилладаг эмэгтэй байна. За тэгэхээр ХҮН-ын дэргэдэх судалгааны хүрээлэн, тинктанкийн эдийн засагчид болохоор Хөгжлийн банкны энэ асуудал гарснаас хойш тодорхой хэмжээний судалгаа явуулаад, ер нь одоо цаашид яах вэ гэдэг дээр бид нар нэг зөвлөмж өгөх гэсэн юм аа. Ер нь бол Монгол Улсын Хөгжлийн банк гэдэг бол Засгийн газрын эзэмшлийн цорын ганц бодлогын банк байгаа. Банкныхан бол мэдэж байгаа. Тэгээд тусдаа өөрөө хуультай та нар мэдэж байгаа. 2011, 2017 оны хуулиар ингэж зохицуулагдаж явж байдаг аа. Тэгээд ер нь бол хөгжих явцдаа санхүүгийн зөвхөн банк төдийгүй санхүүгийн охин компаниудтай явцынхаа дунд бүр групп болж хөгжсөн ийм том байгууллага байна. Гэхдээ та нар өнөөдрийн бүтэн өдрийн хуралдаанаар юу болж, ямар шалтгаанаар 1.9 их наяд төгрөгийн чанаргүй зээлийг бий болгож, ард түмнийхээ итгэл найдварыг алдаж ийм байдалд орсныг бол мэдэж байгаа. Гэтэл одоо зарим юунууд ярьж байна. Манай ХҮН-ын судалгааны хүрээлэнгээс ямар зөвлөмж гаргаж байна вэ гэхээр энэ банкиг бол ер нь шийдэхдээ, эсвэл Засгийн газарт өрийг нь ингээд шилжүүлчихье татвар төлөгчөөр төлүүлэе, эсвэл ингээд энэ банкиг хаая гэж байна, тэгж болохгүй. Эдийн засагчдын хувьд яагаад болохгүй вэ гэхээр энэ банк бол өөрөө олон улсын хөрөнгийн зах зээлүүдээс ихээхэн хэмжээний бондуудыг Засгийн газрын баталгаатай бөгөөд сүүлийн жилд баталгаагүйгээр авч чадсан. Олон улсын мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллаж, дэлхийн санхүүгийн зах зээл дээр бонд босгож чадсан, гэрээ хэлэлцээр хийж сурч байгаа, дэлхийн санхүүгийн интегралчлалд орсон, олон улсын санхүүгийн маш сайн түүх гаргаж ирсэн банк юм. Тэгэхээр дэлхийд одоо бол дөрвөн зуун тавь орчим Хөгжлийн банк ажиллаж байна. Ер нь дэлхий дахинд сайн, муу маш олон хэмжээнийх байна. Тэгээд бол бид нарын бодож байгаагаар болохоор санал болгож байгаагаар ямар ямар зүйлийг бид нар санал болгож байна вэ гэхээр ер нь бол энэ дэлхийн Хөгжлийн банк нь Сангийн яам, Монголбанкны хэлж байсан зөвлөмжийн дагуу ер нь бол яаж байх ёстой вэ гэхээр зээлүүдийг нэгдүгээрт, эргэн төлүүлэх дээр л ерөөсөө энэ банк маш сайн ажиллах хэрэгтэй. Ирэх жилийн 2023 оны одоо тэр зүйлүүдийг бол яагаад ч дефолт болгож болохгүй. Сангийн яамны Б.Жавхлан сайдтай бүр маш санал нэг байна. Хоёрдугаарт, төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй төслүүдийг одоо төлж чадахгүй байгаа бол зээлийн үнэт цаасны хэлбэрээр ингэж арилжаалах, тэгээд тэр зээлүүдийг дахин арилжаалах, муу зээлүүдийг худалдаж авах тийм санхүүгийн хоёрдогч зах зээлүүдийг бүрдүүлэх, энийг шийдэх одоо бүр эрх зүйн болон эдийн засгийн тэр байгууллагуудыг болохоор бид нар хэрэгслүүдийг гаргаж чадах ёстой гэж үзэж байна. Гаргаж чадах байх аа гэж бодож байна. Сангийн яам, Хөгжлийн банк, Монголбанк нийлээд Санхүүгийн зохицуулах хороо, бас нийлээд.

Дараагийн зөвлөмж бол Монголбанк, Сангийн яамны удаа дараагийн зөвлөмжийг өгсний дагуу биелүүлэхгүй байгаа энэ зүйлүүдийг биелүүлэх юу байх вэ гэхээр мэргэжлийн багуудыг ажиллуулах хэрэгтэй байна. Үнэхээр мэргэжлийн баг энэ банканд дутагдаж байна. Та бүхэн харж байгаа өнөөдрийн бүтэн өдрийн туршид болоход тэр яамны үед, тэр засгийн үед тэр Ерөнхийлөгчийн үед гэж ярьж байна. Энэ банкны одоо энэ байгаа байдлаас ганцхан мэргэжлийн багууд л гаргаж чадна. Мэргэжлийн, Олон улсын, мэргэжлийн санхүүчид, ёс зүйтэй, тийм санхүүчид байж энэ банкиг одоо энэ хэцүү байдлаас гаргаж чадна гэж үзэж байна. Дараагийн асуудал яах вэ гэхээр яваандаа 5-6 жилийн дотор энэ банкиг төрийн 100 хувийн

эзэмшлээс аль болохоор багасгаад 80 хувь, төрийн эзэмшил болоод 20 хувь нь арилжааны банкууд орж ирдэг маш зөв үйл ажиллагааг нь явуулж чаддаг ийм байж чадаж байвал дараагийн 10 жилд бол урт хугацаанд бол яах вэ гэхээр “трипл эй” гэж ярьдаг AAA гэсэн тийм зэрэглэлтэй, Олон улсад маш сайн бонд босгож чаддаг, хөгжлийн том том төслүүдийг хөдөлгөж чаддаг тийм сайн нэр төртэй банк болгоод яваандаа 50, 50 ч гэдэг юм уу, Засгийн газар болон хувийн хэвшлийн банкууд, санхүүгийн байгууллагууд орсон энэ улсын хөгжлийг одоо яриад байгаа энэ Засгийн газрын Шинэ сэргэлтийн бодлого гээд байгаа энэ болгоныг санхүүжүүлж чаддаг тийм механизмтай ийм банкиг болгож чадах хэрэгтэй. Гуравдугаарт, хамгийн сүүлд яах вэ гэхээр энэ банкны гаргасан энэ зээлийн алдагдал дээр ханшийн зөрүү гэж ярьж байна. Энэ дээр мэргэжлийн хүмүүс дутсан байхгүй юу. Ерөөсөө л мэргэжлийн эдийн засагчид, санхүүчид дутсан гэсэн үг. Тэгэхээр энийг бол яах вэ гэхээр ийм багийг, ийм банкны хажууд бол судалгааны, зээлүүдийг оруулж ирэхэд нь хянаж байдаг, зээлийг өгөх үү, үгүй юу, хөгжлийн зэрэгтэй байна уу гэдгийг хийдэг судалгааны нэгжтэй болох хэрэгтэй байна. Тэгж л энэ банкиг бид нар аварч чадна.

### **Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн Ж.Бат-Эрдэнэ:**

За дараагийн оролцогч Л.Отгонтуяа Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн. А индэр.

### **Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн Л.Отгонтуяа:**

Та бүгдийн оройн амгаланг айлтгая. За өдөржин бүгдээрээ Хөгжлийн банкны асуудлаар бас сонслоо. Тэгэхлээр өнөөдрийн бидний энэ хэлэлцүүлэгт ингээд тал бүрийн оролцоог хангаад хэлэлцэх ийм боломжийг олгож байгаа Улсын Их Хурлын Тамгын газрынхандаа маш их баярлалаа. Тэгэхээр Ерөнхий хяналтын сонсголын гол зорилгыг нь бидэнд өгсөн энэ материал дээрээ биччихсэн байгаа. Улсын Их Хурал хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагавартай танилцах, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий байгууллага, түүний удирдах албан тушаалтны үйл ажиллагаанд хяналт тавих, үнэлэх зорилгоор Ерөнхий хяналтын сонсголыг хийнэ ээ. Тэгэхлээр энэ дээр өнөөдөр бол хангалттай сонслоо, тал бүрийн саналыг сонслоо. Гэхдээ эндээс одоо яг парламентын зүгээс буюу Улсын Их Хурлаас яг юуг хийх хэрэгтэй вэ гэдэг гаргалгаагаа цаашдаа одоо Түр хороо байгуулбал шинэ хуулийнхаа дагуу бүхий л хяналтын яг эцсийнхээ шийдвэрүүдийг гаргаад цаашдын гарц гаргалгаагаа гаргах нэн чухал байна аа. Тэгээд энэ дээр Тогтвортой байдлын зөвлөлийн найман гишүүдээс нэг л хүн оролцох боломжийг бидэнд олгосон. Ингээд ямар ч гэсэн Тогтвортой байдлын зөвлөлийн гол үүрэг бол төсвийн алдагдлыг зохистой хязгаарт нь буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 20 хувьд барих, мөн одоо зээлийг дотоодын нийт бүтээгдэхүүний 40 хувиас хэтрүүлэхгүй байлгах тал дээр бидний санал, дүгнэлтээ өгөх гол үүрэг маань байдаг. Ялангуяа одоо 2016 он хүртэл бий болсон 3 их наяд төгрөгийг төсөв рүү шилжүүлсэн, одоо бид нар дахиад 762.6 тэрбум төгрөгийг Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн төсвийн шинжтэй өр байдлаар магадгүй төсөв рүү шилжүүлэх ийм байдлаар, сүүлд нь Сангийн сайд маань бас тайлбар хийлээ, ингэж шилжүүлэх юм бол үнэхээр манай төсвийн байдалд том дарамт болно оо. Тэгэхлээр энийг би юу гэж хэлэх гээд байна гэхээр Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийнхээ засаглалыг одоо яг эндээс зээл авчихсан, түүнийгээ ажиллуулах тал дээр нь мэдээж гэрээ хэлэлцээр яриагаа хийнэ. Үүнээс гадна Улсын Их Хурал бол өөрөө ард иргэдээ төлөөлж, Төрийн өмчийг өмчлөгч, өмчлөгчийнхөө байр сууринаас энэ байгаад байгаа нөхцөл байдлууд яг ямар шалтгаантайгаар ийм болчихов, хууль, дүрэм журамдаа ямар өөрчлөлт хийвэл энэ дахиад гарахгүй вэ гэдэг дээрээ илүү их анхаарч, ажиллаасай, эндээсээ гаргалгаа гаргаасай гэж үзэж



байна. За мөн худалдан авалттай холбоотой гол зүйл бол Монгол Улсын Хөгжлийн банкны одоо худалдан авалтыг худалдан авах ажиллагааны хуультай, Хөгжлийн банкны үйл ажиллагаатай холбоотой худалдан авалтыг хийхдээ энэ хуулийг мөрдөхгүй гэж заасан, ингэхлээр гэрээ шууд байгуулах аргаар хийхээс өөр аргагүй байдалд орсон.

Үүнийг бол 2011 оны 02 сарын 10-нд оруулаад, 2019 оны 03 сарын 22-ны хуульд оруулсан нэмэлт өөрчлөлтөөрөө Улсын Их Хурал хүчингүй болгосон. Тэгэхлээр тэрнээс өмнө жишээлбэл, Үндэсний аудитын газар, Улсын Их Хуралд ажлаа тайлагнадаг энэ одоо хууль засаглалын гурван хэлбэрээсээ алинд нь ч хамаардаггүй хяналтын дээд байгууллага байх ёстой. Гэтэл энэ байгууллагынхаа 2019 онд өгсөн дүгнэлтээр энэ дээр бүр бүгдийг нь биччихсэн байгаа. Хөгжлийн банк бол 2012-2016 онд тооцоо судалгаагүй эх үүсвэр татаад, тэгээд мөнгөн хөрөнгийн удирдлагыг зохисгүй хэрэгжүүлснээс их хэмжээний алдагдал хүлээсэн байна аа. Мөн худалдан авалт нь болохгүй байна аа, үүнийг нь сайжруулах хэрэгтэй, хууль хяналтын байгууллагад улсад учирсан хохирлыг барагдуулах арга хэмжээг ав аа гэдэг дүгнэлт, зөвлөмжийг Улсын Их Хурлаас сонсож арга хэмжээ авах ёстой, хууль дүрэмдээ өөрчлөлт хийх ёстой байтал эдгээрийгээ сонсоогүйгээс өнөөдрийн энэ нөхцөл байдал үүсчихсэн юм биш үү? Эндээс би юу хэлэх гээд байна гэхээр бид тоглоомын дүрмээ тов тодорхой болгох ёстой. Энэ нь зөрчигдөөд байгаа юм бол түүнийгээ засах ажлыг Улсын Их Хурал маань өөрөө хийгээч ээ. Санаачлаад энэ дээрээ одоо энэ Түр хороо байгуулна уу, ажлын хэсэг байна уу, яг санал зөвлөмжөө өгөөд тэгээд тоглоомын дүрэм нь тодорхой, хууль тогтоомж нь тодорхой болох юм бол институтүүдийнхээ чадавхыг бэхжүүлээд, тэднийхээ хариуцлагыг дээшлүүлээд, тоглогчид нь хариуцлагатай байх талаасаа Улсын Их Хурал бас өөрөө хяналт тавих, бүхий л байгууллагатайгаа харилцах энэ боломж маань байгаа учраас энэ дээр илүү ажиллаач ээ гэж хүсмээр байна. Тэгэхлээр эндээсээ ямар ч гэсэн бид тодорхой шийдэл гаргах тал дээр илүү сайн санаачилгатай ажиллаасай, сая бас яг мэргэжлийн дүгнэлт гаргасан. Би бол аль нэгэн улс төрийн намын гишүүн биш, гэхдээ сая Отгонтөгс багшийн хэлсэн тэр саналуудыг бас та бүгд маань ажил хэрэг болгох талаас нь анхаарч ажиллаасай. Манай Тогтвортой байдлын зөвлөлөөс өгч байгаа дүгнэлтүүдийг, аудитын дүгнэлтийг хуульд бол тусгасан, түүнийг сонсдог шиг манай Тогтвортой байдлын зөвлөлийн өгч байгаа хараат бус дүгнэлтүүдийг бас хэрэгжүүлж ажиллаасай гэж хүсэх байна. Баярлалаа .

**Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн Ж.Бат-Эрдэнэ:**

П.Өлзийнаран Баянгол дүүргийн иргэн. А индэр дээр.

**Баянгол дүүргийн иргэн П.Өлзийнаран:**

За оройн мэнд хүргэе ээ. Өдөржингөө бүгдээрээ сууж байна. Тэгээд энэ бол улс үндэстний бүр оршин тогтноход хүртэл нөлөөлөхүйц ийм макро эдийн засгийн асуудал байж байгаа. За ингээд түрүүн бас гишүүд ярьж байна. Гол эзэд нь, гол хулгайчид нь, зохион байгуулагчид нь ерөөсөө яригдахгүй байна. Тэгээд энийг болбол тухайн үеийн анх Хөгжлийн банк байгуулагдаж байх үеийн төрийн гурван өндөрлөг гурвуулаа хийсэн шүү дээ. Хамгийн гол зохион байгуулагчид нь өнөөдөр ерөөсөө огт яригдахгүй юм. Тэгээд тэр ард түмэн, эх орноо барьцаалаад 9 тэрбум ам.долларын гадаад өр тавих хүртэл хэмжээнд очсон. Энэ 1921-ээс 90 он хүртэл Бүгд Найрамдах Монгол Ард Улс бүрэн аж үйлдвэржихэд шилжих рублиэр 10 тэрбум ам.долларын өр тавьсан байдаг. Арван тэрбум ам.доллартой тэнцэх. Гэтэл бид нар 2012-2016 оны хооронд 9 тэрбум ам.долларын өр тавьчихсан, өнөөдөр тэр

нь анхнаасаа бараг төлөгдөхгүй нь одоо энэ 1.8 их наяд төлөгдөхгүй нь тодорхой хэмжээний ийм зохион байгуулалт хийсэн байгаа байхгүй юу. Тэгээд тэр үед ч дуугарч байсан, хүн сонсдоггүй байсан. Одоо миний бие бол уул уурхайн инженер, эдийн засагч мэргэжилтэй. Тэгээд тухайн үед бол бас хэлж л байсан. Тэгээд бонд гаргах тухай Улсын Их Хурлын 52 дугаар тогтоол 2012 оны 10 дугаар сард батлагдсан байдаг.

Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, төрийн гурван өндөрлөг байгаа энэ маань үнэт цаасны талаар авах арга хэмжээг бас 12 сард гаргасан. Бондын зөвлөл 12 дугаар сарын 15-нд байгуулагдсан тухайн оныхоо. Тэгээд Бондын зөвлөл нь яадаг вэ гэхээр одоо ингэж байгаа юм, тухайн үеийн энэ бүх энэ институцийг хэн удирдах вэ гэвэл тухайн үеийн эрх баригч намын дарга Н.Алтанхуяг би түрүүчийн хурал дээр хэлсэн. Энэ хүн бүгдийг нь найруулсан. Хамгийн гол буруутан бол энэ хүн. Тэгээд энэ бүх институцээ намын бодлогоороо ч тэр, төрийн бодлогоор ч тэр уяж байгаа шүү дээ. Улсын Их Хурлаа ч базаж байгаа юм. Тэгээд Бондын зөвлөл гэж юм байгуулсан юм. Үнэндээ энэ Хөгжлийн банкны чинь зээл гаргалт бүх юмыг нь одоо Үндэсний аюулгүй байдлын зөвлөмжид биелэлтийг хангах нэрээр бондоос санхүүжих зээл зээлдэгчдийн шалгуурыг бол бондын зөвлөл нь шийдэж байсан байгаа шүү дээ. Тэгээд одоо өнөөдөр Н.Алтанхуяг гуай зарим юмнууд дээр ярьж байна лээ. Төрийн банкны удирдлага гээд нөгөө хэдэн томилсон залуучууд руугаа. Тэгээд одоо түрүүний слайд дээр Хөгжлийн банкнаас үзүүлсэн үү, хаанаас үзүүлсэн, аль захирлын үед хамгийн их чанаргүй зээл олгосон бэ гэсэн параболынх нь орой дээр Н.Алтанхуяг гишүүний, тухайн үеийн Н.Алтанхуяг Ерөнхий сайдын томилсон хүн л байж байгаа. Тэгээд энэ талаар бид нар ерөөсөө ярихгүй юм аа. Нөгөө зовлонгийн шалтгаан нь ерөөсөө олохгүй байна. Тэгээд өнөөдөр ингээд юун дээр одоо ингээд орж ирээд, ингээд тэрэнд яаж байгаанууд нь нөгөө зээлээ аваад бас зориулалтын дагуу аль болох зарцуулаад, тэгээд энэ олон санхүүгийн болон эдийн засгийн энэ сорилт бэрхшээлүүдийг туулаад, ингээд бас нэг үйлдвэрлэгч хийгээд импортыг орлох бараа бүтээгдэхүүн үйлдвэрлээд явж байгаа нөхдүүд байгаа. Нөгөө тэд нар нь гарч ирээд ингээд камерын өмнө ингээд улалзаад үнэн учраа бас хэлж байна. Нөгөө гол өр зээлээ төлөхгүй байгаа нөгөө эдийн засгийн гэмт хэрэгтнүүд ерөөсөө гарч ирэхгүй байна шүү дээ. Тэд нар бол бүр анхнаасаа, энийг шууд харахад анхнаасаа л үйлдвэрлэх чадваргүй, зээл олголтын процесс болбол эдийн засгийн арга хэрэгсэлд ерөөсөө нийцээгүй ийм нөхцөлтэй байж байгаа. Тэгээд одоо бид нар яах вэ гэвэл, түрүүн хэн гишүүн ярьж байна лээ. Энэ хуулийн гаргалгаанууд байгаа шүү дээ, энэ чинь хуулийг хүн л зохиож байгаа, тэрийг засаж болно шүү дээ. Энэ хуулийг хөөн хэлэлцэх хугацаагүй болгох хэрэгтэй, санкцыг чангатгах хэрэгтэй. Энэ санкцгүй байгаа болохоор л энэ хүмүүс бүгд хулгай хийж байгаа юм. Одоо нөгөө өмнөх хүмүүсийнхээ хулгайн хэргийн санкцыг чангатгая гэхээр дараачийнх нь хүмүүс өөрсдийгөө чангатгачих гээд байх шиг байгаа юм. Тэгээд маань бүх эрх мэдэл байгаа, одоо энийг шийдэж чадах энэ санкцуудыг чангатгаж өгөөч ээ, хөөн хэлэлцэх хугацааг нь байхгүй болгож өгөөч ээ. Энэ түрүүчийн юун дээр ч гэсэн хэлсэн. За өнөөдөр бол энэ сонсгол учраас ахиад энэ дараа нь энэний үр дүнг нь гаргах процессууд явагдах байх. Тэгээд энэ чинь бас Төрийн өмчит компаниудын тухай яригдаж байна. Бид нар 90 он гарснаас хойш энэ эдийн засгийн ач холбогдол, стратегийн ач холбогдол хоёрыг ерөөсөө ялгахаа байчихсан. Бүх юмыг эдийн засгийн ач холбогдлоор хардаг. Жишээ нь, энэ Багануурын уурхай бол угаасаа ашиггүй ажилладаг. Багануурын уурхайг ашиггүй байсан ч бид нар ажиллуулахаас өөр арга байхгүй. Дайны үед ашиггүй байсан сум үйлдвэрлэхтэй ижилхэн. Тэгээд энэ үед бол бид нар яах вэ гэхээр Багануурын уурхайд зээл олгож энэ нийслэл хотыг, энэ Монгол Улсын талыг болбол яалт ч байхгүй цахилгаан хүчээр хангана. Иймэрхүү юмнуудаа бид нар ялгаж, салгаж ойлгож ярихгүй бол бүх төрийн хэвшил

бол нэг ийм бас буруу нүдээр хараад байж болохгүй ээ. Тэгээд та бүхэнд баярлалаа. Үр дүнтэй болгохыг хүсэж байна аа.

### **Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн Ж.Бат-Эрдэнэ:**

За дараагийн оролцогч Э.Ганхөлөг хуульч, өмгөөлөгч. “В” индэр.

### **Хуульч, өмгөөлөгч Э.Ганхөлөг:**

За өнөөдрийн сонсголд оролцож байгаа нийт оролцогчдодоо оройн мэндийг хүргэе ээ. За миний хувьд бол хуульч, өмгөөлөгч Э.Ганхөлөг гэж хүн байна. Өнөөдрийн хувьд бол оролцогчийн байр сууринаас орж байгаа учраас зөвхөн санал, дүгнэлт хэлэх юм байна аа. За ингээд өнөөдөр өглөөнөөс хойш суусан. Энэ сонсголыг сонсоод нэг хоёр дүгнэлт хэлье гэж бодсон. За бараг энэ санал байж магадгүй байна. Нэгдүгээрт, өнөөдөр энэ Хөгжлийн банктай холбоотой яригдаж байгаа энэ асуудлууд бол одоо Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулийн дагуу бүгд шийдэгдэнэ гэдэгт бол эргэлзэхгүй байгаа. Манай энэ хууль шүүхийн байгууллага болбол миний хувьд улс төрийнхөө нөлөөнөөс ангид байж чадах юм бол бас голтой шийдвэр гаргадаг аа. Үнэхээрийн одоо хууль тогтоомж зөрчсөн улсууд дээр зохих шийтгэлийг нь өгөөд явдаг энэ түвшинд байгаа гэж миний хувьд боддог оо. За ингээд нэгдүгээрт, за ер нь бол өнөөдрийн энэ яригдаж байгаа Хөгжлийн банкны зээлтэй холбоотой асуудал чинь бол зээлийн гэрээ, мөн энэ зээлийн гэрээний дагуу байгуулагдсан барьцааны гэрээний асуудал байгаа юм. Тэгэхээр өнөөдөр зээлээ төлж чадаагүй бол ямар арга хэрэглэдэг вэ гэхээр үүргийн гүйцэтгэлийг барьцааны гэрээнд байгаа үүргийн гүйцэтгэлээс хангуулдаг, барьцааны гэрээнд байгаа зүйл нь харин зээлийнхээ үнийн дүнд хүрч байна уу, үгүй юу гэдэг дээр зохих үнэлгээний байгууллагууд ажиллаж үнэлгээгээ гаргадаг, за энэ үнийн дүнгээр болж байна гэж үзэх юм бол одоо барьцаалагч нь барьцааны гэрээгээ үүргээр хангадаг ийм л харилцаа байгаа. За мэдээж энэ зээлийг авахдаа болон өгөхдөө хууль тогтоомж зөрчсөн зүйл байдаг бол тэр хүмүүс нь хуулийнхаа дагуу ял шийтгэлээ үүрээд явах ийм зохицуулалттай байж байгаа. За тэгэхээр өнөөдөр энд зөвхөн энэ зээл авсан улсуудыг өнөөдөр энд одоо 20-иод байгууллага, 20-иод аж ахуйн нэгжүүд ингээд гаргаад тавих шиг боллоо. Гэхдээ харамсалтай нь ямар нэгэн хууль, шүүхийн байгууллагаар эцэслэн тогтоогоогүй зүгээр хэвлэл мэдээллийн байгууллагаар явж байгаа энэ нэрсийг ингээд биччихсэн юм шиг ийм тайлбарыг өнөөдөр бол өглөө. Энэ бол бас жоохон харамсалтай байна. За гэхдээ энэ зээлийн ард бол маш олон хүмүүсийн ажил амьдрал, маш олон аж ахуйн нэгжүүдийн бизнес, энэ нь цаашлаад манай өнөөдрийн энэ эдийн засагт маш чухал нөлөө үзүүлдэг ийм аж ахуйн нэгжүүд бол цаана нь явж байгаа. Энэ дээр маш их анхаарлаа хандуулж ажиллаач ээ гэж уриалах байна. За ингэхийн тулд яах вэ гэхээр нэгэнт одоо зээлийн гэрээний үүргийг биелүүлж чадахгүй барьцаа хөрөнгөө хангуулъя гэсэн энэ аж ахуйн нэгжүүд бол нэлээн байна аа. Ийм мэдээллүүд бол нэлээн ирсэн. За энийг одоо шийдвэрлэх субъект нь бол Хөгжлийн банк байж байгаа. Өнөөдөр энд цугласан хүмүүс, цугласан оролцогчдыг харахаар өнөөдөр энэ асуудлыг шийдэж чадах хоёрхон субъект байна л гэж би харж байгаа юм. За нэгдүгээрт бол мэдээж хууль, хяналтын байгууллагууд нь бол гэмт хэрэг хийсэн улсуудаа шүүгээд тунгаагаад гаргачихна, энэ шийдвэрээ гаргачихна. Хоёр дахь нь бол энэ зээл өнөөдөр төлөгдөх үү, төлөгдөх боломжгүй бол барьцаа хөрөнгөөр хангавал шийдэх үү гэдэг асуудлыг өнөөдөр шийдэх субъект нь Хөгжлийн банк байж байгаа. Тэгэхээр өнөөдөр Хөгжлийн банканд би өнөөдөр юу гэж уриалах гэж байна вэ гэхээр зээлээ төлж чадахгүй нөхцөл байдал үүссэн, үүнийгээ барьцаа хөрөнгөөрөө хангуулъя гэсэн нэлээн олон аж ахуй нэгжүүд байгаа юм байна. Тэгэхээр энэ барьцаа

хөрөнгийг нь хангуулах энэ асуудлыг бол түргэн, шуурхай шийдвэрлэж өгөөч ээ. Энэ дээр нэлээн хүлээгдсэн зүйл байгаа юм. Магадгүй сая шинээр ТУЗ нь томилогдохгүй байсан учраас энэ асуудлыг шийдэж чадахгүй байсан байх. Одоо ТУЗ нь томилогдсон байгаа учраас яаралтай горимоор энэ асуудлыг шийдэж өгвөл гарц нь нээгдээд энэ бусад аж ахуй нэгжүүд нь бизнесийнхээ зарчмаар цаашаа бизнесээ үргэлжлүүлээд ингээд явах ийм зохицуулалт харагдаж байна аа. Тийм учраас энэ дээр санаачилгатай ажиллаж өгөөч ээ гэж байгаа юм. За хоёрдугаарт, өнөөдөр Авлигатай тэмцэх газраас төлөөлөл ирсэн байна, удирдлага нь ирсэн байна. За өнөөдөр энэ дээр хэд хэдэн бас жаахан хариуцлагагүй мэдэгдэл гаргачихавуудаа гэж бодож байгаа юм. Бизнесийн салбар бол маш эмзэг. Зарим салбар нь болбол энэ мэдээллийн орон зай өнөөдөр маш сайн хөгжсөн сошиал хөгжсөн энэ үед бол жоохон хариуцлагагүй мэдэгдлээс болоод бизнес нь эрсдэлд орох, зогсох, гацах мөн худалдан авалт, борлуулалт нь зогсох ийм эрсдэлтэй байдлууд цаана нь үүсээд байгаа учраас энэ дээр нэг хариуцлагагүй мэдэгдэл хийсэн зүйл байгаа. Энэ дээрээ бас Авлигатай тэмцэх газрынхан маань анхаарч ажиллаач ээ. Мэдээлэл анх өгөхдөө болбол болохгүй, бүтэхгүй байгаа талаас нь мэдээллийг нь өгчихдөг, шалгаж тодруулж байх явцдаа болж бүтээд зээлээ төлөөд явж байгаа, мөн зээлээ төлөхөө илэрхийлсэн аж ахуйн нэгжүүдийнхээ нэр усыг нь зарлаад бас энэ хэвлэл мэдээллийн байгууллагаараа дамжуулаад зөв ойлголтыг нийгэмдээ өгөөч ээ. Тэгэхгүй бол үүний чинь ард эргээд эндээс орж ирсэн орлогоороо төлөх, Хөгжлийн банкны төлөх энэ төлбөр чинь гацаад байна шүү. Энэ дээр бас анхаарч үзээсэй гэж өнөөдөр энд ирсэн байгаа Авлигатай тэмцэх газрын удирдлагад санал хэлэх байна аа. За ингээд миний хэлэх хоёр санал энэ байна. Баярлалаа та бүхэндээ.

#### **Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн Ж.Бат-Эрдэнэ:**

За Б.Мөнхсоёл, ХҮН-ын төлөөлөл. А индэр дээр.

#### **Хөдөлмөрийн Үндэсний намын төлөөлөл Б.Мөнхсоёл:**

Сайн байцаана уу? Энэ эгнээнд нэрсийн хүснэгт ирээгүй учраас манай Хөдөлмөрийн Үндэсний намын Д.Гантулга бичиж чадаагүй юм. Тэгээд миний оронд үгээ хэлнэ ээ.

#### **Хөдөлмөрийн Үндэсний намын төлөөлөл Д.Гантулга:**

За манай ХҮН-д 5 минут олдож байгаа юм байна. Энэ завшааныг ашиглана. За өнөөдрийн энэ хэлэлцүүлгийг дүгнэх юм бол би энд Хөдөлмөрийн Үндэсний намыг төлөөлж ярьж байна. Хөгжлийн банкны 1.8 тэрбумын найдваргүй зээл буюу энэ хулгай үндсэндээ 60 хувийг нь 2012-2016 онд засаг барьж байсан Ардчилсан намын үед, за үлдсэн 40 хувийг нь 2016-2020 онд засаг барьж байсан Монгол ардын намын үед олгогдсон байна аа. Өөрөөр хэлбэл, энд зөвхөн найдваргүй болчихсон буюу хулгай ярьж байгаа шүү, нийт зээл биш. Өөрөөр хэлбэл, энэ эргэн төлж чадахгүй, зээлээ эргэн төлж чаддаггүй хүмүүс ямар хүмүүс зээл авдаг юм. Эрх баригчдын ойрын хүмүүс зээл авдаг. Тэгэхээр өнгөрсөн энэ хугацаанд МАН, АН ялгаагүй энэ Хөгжлийн банкнаас хулгай хийхэд оролцчихжээ, тоо баримт нь ийм байна. Ерөөсөө л маш товчхон дүгнэвэл ердөө л энэ. За тэр сахал Эрдэнэбилэг гэнэ үү, за тэр өмнөх Ерөнхийлөгч Халтмаагийн Баттулга эд нарын нэр яваад байгаа тэр “Кью Эс Си”, “Хөтөл цемент” гээд энэ хоёр компани дээр нийлээд байгаа 500 тэрбумыг чинь бүгдээрээ ярьж байна шүү дээ тэр Н.Алтанхуяг гишүүн Ерөнхий сайд байхдаа өгчихсөн. Би шууд өгчихсөн гэж хэлье. Яагаад гэвэл 2012 оны эцсээр Чингис бондын мөнгө Хөгжлийн банканд орж ирэхэд хүмүүс банканд дээр биш

фортуна Батбаяр буюу Н.Алтанхуяг даргын кабинетынх нь гадаа оочерлож байсан шүү дээ. Энэ үнэн шүү дээ. Тэгээд л өгчихсөн шүү дээ. За тэгтэл дараагийн тэр “ТОСК”-ийн зээл яригдаад байна. “ТОСК”-ийн зээл дээр анхны 222 хоёр тэрбумыг АН нь өгчихсөн байтал дараа нь мэдсээр байж төлөөгүй байхад МАН засаглаж байхад өгчихсөн л байна шүү дээ. Дахиад зуун тэрбумыг өгчихсөн байна. Ерөөсөө л бодит байдал ийм байна шүү дээ. За одоо тэгээд яах юм. Манай ХҮН намын гишүүн, Улсын Их Хурлын гишүүн Т.Доржханд ярьсан тэр дөрвөн хариуцлага гэж яриад байгаа шүү дээ. Эдийн засгийн хариуцлага, эдийн засгийн хариуцлага бол маш энгийн шүү дээ. Тэр зээл авсан хүмүүс нь хүмүүсээр нь төлүүлэе, юун тэр татвар төлөгчид вэ. Тэр иргэд чинь одоо сөхөрч байна шүү дээ. Боломжоо хулгайлаад авчихаар залуучууд нь уйлаад гадагшаа явж байна шүү дээ. Юун мөнгө байгаа юм. Мөнгө байхгүй шүү дээ. Хуулийн хариуцлага. Энэ нэр холбогдоод байгаа гишүүд үнэхээр цэвэр юм бол өөрсдөө тэр халдашгүй байдлаа больж, зогсоож байгаад шалгуул л даа, болно шүү дээ. Улс төрийн хариуцлага, улс төрийн хариуцлага гэдэг бол ердөө юу вэ гэхлээр энэ хулгайчуудыг төрөөс хол байлгамаар байна. Энэ ордноос бүүр хол байлгамаар байна. Энэ танхимд оруулмааргүй байгаа байхгүй юу. Ердөө л энэ шүү дээ. Тэгээд орж байж бүгдээрээ суучихаад л бие биеийнхээ хар, цагааныг их, бага идсэнээ яриад сууж байж болохгүй шүү дээ. Дөрөвдүгээрт, Одоо ингээд цаашдаа яах юм гэхлээр хяналт тавихаар Улсын Их Хурал руугаа Засгийн газар руугаа авчраад л сайхан удирдаад явчихвал болох юм шиг. Үгүй шүү дээ. За энд байгаа гишүүд бүгдээрээ бодоорой. Өөр өөрсөд дээрээ гишүүн болохоосоо өмнө та бүхэн ямар ажил хийж байлаа. Энэ Хөгжлийн банк гэдэг чинь мэргэжлийн ажил байхгүй юу. Мэргэжилтнүүдийн хийдэг ажил үүнийгээ бодолцмоор байна. За тэгээд эцэст нь тэмдэглэхэд Хөдөлмөрийн үндэсний нам, ХҮН нам хулгай хийхгүй ээ. Хулгай хийхгүй. Хэрвээ хэн нэгэн хулгайд холбогдох юм бол бид нар өөрсдөө шалгуулна. Тэр Д.Батлут гишүүн түрүүн ярьж байна. Манай өмнөх даргыг дурдаж байна. Шалгуул ичихгүй байгаа бол нэрийг нь өг. Бид нар эсвэл өөдөөс чинь өмнөөс чинь өгье. Өөрсдийнхөө намын хүмүүсийг шалгуулж чадахгүй байж байж одоо манай намын даргыг ч юм уу, өмнөх намын даргыг шалгуулъя гэвэл болно өгөөрэй. Нэрийг нь өгье. Би, манайхан, манай нам болбол тэр хүнийг нь аваачиж шалгуулна. За үлдсэн жоохон минутыг Удирдах зөвлөлийн гишүүн Б.Мөнхсоёлд олгоё.

#### **Хөдөлмөрийн Үндэсний намын төлөөлөл Б.Мөнхсоёл:**

За тэгье. баярлалаа. Ингээд хамт олон...

#### **Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн Ж.Бат-Эрдэнэ:**

Одоо больё, ийм замбараагүй юм гэж юу байх вэ, энэ чинь. За болоо, болоо. Хүн намаас нэрийг чинь болголоо, өглөө тэр улс төрөө хийлээ. Янз янзын юмаа ярилаа. Одоо больё. Мөнхсоёлоо ийм замбараагүй юм байж болохгүй. Болохгүй уучлаарай. Нээлттэй бүх асуудлуудыг нээлттэй ярьж байгаа шүү дээ. ХҮН намын чинь асуудлуудыг яриуллаа, улс төрийг чинь хийлгүүлээ. Тэр одоо хулгайч луйварчингууд гэж дууддаг бүх эмоцтой хүмүүсийг бүгдийг нь сайхан яриуллаа. Үнэхээр одоо хэлэх ёстой зүйлүүдээ яриуллаа. Эндээс одоо мэргэжлийн сэтгүүлчдийнхээ санаа бодлыг бас гаргууллаа. Мэргэжлийн сэтгүүлчдийн үүднээс болбол мэдээж ард иргэдийн бас бодож байгаа асууя гэсэн зүйлүүдийг нэлээд асуух шиг боллоо. Тэгээд үндсэндээ бол бид нээлттэй хийх ёстой юм. Зөвхөн Улсын Их Хурлын гишүүд яриад асуугаад ингээд дуусах биш. Харин ч одоо нээлттэйгээр та бүхний саналыг нэлээн орууллаа. Энэ одоо оролцогчдынхоо бүрэн орох, үгээ хэлэх боломж бололцоог бол хэллээ. Зарим компаниудын одоо өөрсдийгөө тайлбарлах

энэ боломж бололцоог нь олголоо. Тийм болохоор одоо хэдүүлээ хуулийнхаа дагуу дараагийнхаа зүйл рүү оръёо. За энэ Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 120.1.6-д гишүүд оролцогчдоос асуулт асууж, хариулт авсны дараа тус бүр 5 минут үг хэлэх боломж бололцоо олгож байгаа юм аа. За уучлаарай, одоо ингээд бүх юм хаагдчихлаа тийм. Тэгэхээр 5 минут Улсын Их Хурлын гишүүд одоо үг хэлээд тэгээд боломж бололцоо юу юу... энэ угаасаа хардаа Улсын Их Хурлын хүрээнд хийгдэж байгаа зүйл шүү. Нэр өгөөгүй өгөөгүй алга байна. Тэр бүх нэрээр чинь би дуудаад явчихлаа. За Улсын Их Хурлын гишүүд нэрсээ өгнө үү. За зөндөө сайхан үгийг хэлүүлээ. За дэгээ барья хэдүүлээ. За Х.Ганхуяг гишүүн.

### **УИХ-ын гишүүн Х.Ганхуяг:**

За Сайн байна уу? Энэ өдрийн мэндийг хүргэе ээ. За өнөөдөр би бас үгээ хэлчихье тэгэх үү? За өнөөдөр хэлэлцүүлэг болж байгаад бол бас талархаж хүлээж авч байгаа юм. Яагаад гэхээр бид нар бас энэ асуудлуудыг олон нийтэд нээлттэй ярилцах ёстой. Тэгээд энэ бол сүүлийн 20 жил одоо би бол бизнес хийж байсан хүн. За манай аав цэргийн хүн байдаг. За манай ээж одоо нягтлан хүн байдаг. За тэтгэвэрт гарсан байх үед нь би бизнесээ анх эхлүүлж байсан. Өнөөдрийн байдлаар манайх 250-260 тэрбум төгрөгийн татвар төлсөн байдаг юм байна. За манай компанид бол ойролцоогоор мянга гаруй залуу ажилладаг юм байна. За энэ яриад гүтгэгдээд байгаа сүүлийн хоёр жил бол гүтгүүлээ л дээ. Манай тэр бол эгчийн компани. За зөвхөн тэр компани дээр гэхэд 350 хүн ажилладаг. За тэгээд туслан гээд нийлэх юм бол бараг мянгаад хүн ажилладаг. За сүүлийн яахав авсан зээл нь бол экспортын зориулалттай зээл авсан байдаг. Тэгээд Ковидын нөхцөл байдлаас болоод манайх чинь үндсэндээ бүх боомтоо хаагаад хаячихсан. Тэгэхээр чинь экспортыг хийж чадахгүй болчихож байгаа байхгүй юу. Тэрнээсээ болоод яг сүүлийн 13 сар сул зогссон, 13 сар сул зогссон. Гэхдээ 13 сар сул зогсохдоо энэ Хөгжлийн банкныхаа хүүг бүгдийг нь төлж ирсэн байдаг юм. Ажилчдынхаа цалинг 60 хувиар бүгдийг нь төлж ирсэн байдаг. За тэгээд өнөөдрийн байдлаар тэр 33 тэрбум гээд байгаа зээлийн үндсэн төлбөрт 12.7 тэрбум төгрөг төлсөн байна. Дараа нь Мандуул захирал баталгаажуулаад хэлээд өгөөрэй. За хүүнд 9.6 тэрбум төгрөг төлсөн байна. За өнөөдрийн байдлаар 20 тэрбум төгрөгийн үлдэгдэл үлдсэн юм байна.

Манай сэтгүүлчид яалт ч үгүй эргэлзэх эрхтэй, асуух эрхтэй. Тийм ч учраас би яг энэ уржигдар байна уу энэ хэвлэлээр явж байгаа яг энэ компанийн тухай мэдээлэл одоо видео нэвтрүүлэг явж байгаа. Тэр видео нэвтрүүлгийг болохоор би Заригийн хүмүүсээр аваачиж хийлгэсэн. Тэгээд манайх хоёр төсөл дээр ажилладаг, хоёулан дээр нь аваачиж үзүүлсэн байгаа. За тэгэхээр иймэрхүү мэдээллүүд байна. За өнөөдөр Баттөмөр гишүүний хэвлэл мэдээллийн хэрэгслээр зээлдэгч улс төрийн нөлөө хамаарлын тухайд гээд 20 хүний нэр гаргасан байна аа. Тэгээд энэ дээр би бол Амартүвшин, Дамдинням хоёрыг бол хассан нь зүйтэй байх аа гэж бодож байна. Та ингэж хамаагүй тойргийнхоо дүүг бас ингэж гүтгэж болохгүй байх аа. Аа энэ дээр бол харин нэг хүн нэмэгдэх ёстой. Тэр бол та өөрөө шүү. Яагаад гэхээр та “Бэрэн групп” гэдэг компанид хувь эзэмшдэг тийм та хувьцаа эзэмшигч бол угаасаа тэр зээл авч байх мөчид зээлийн гэрээн дээр гарын үсэг зурагддаг, эсвэл хувьцаа эзэмшигчдийн хурлыг хийж байж зээл авдаг юм. Өнөөдрийн хуулиар шүү. Тийм болохоор та тэр асуудлаа өөрөө гаргаж ирж тавиад өөрөө шалгуулах хэрэгтэй шүү.

Гишүүн болоод би хоёр жил болж байна. За манай эгчийн хамаарал бүхий компани одоо манай эгчийн компани зээл авсантай холбогдуулаад өнөөдөр аягүй олон гүтгэлэг явдаг. Гэхдээ тэр зээл авч байх мөчид би гишүүн болох байтугай гишүүн болохыг одоо мөрөөдөө ч үгүй явж байсан, зүүдлээ ч үгүй явж байсан, тэр цаг үе шүү. 2019 оны 04, 05 сард манайх хүсэлтээ өгсөн байдаг. За тэрнээс өмнө

манайх 2016 онд бас лизингийн яг тоног төхөөрөмжийн зээл авч байсан байдаг, хоёр дахь удаагаа авсан байдаг. Хоёр дахь удаагаа. Тэгээд би чинь одоо 2016 оноос хойш гишүүн болно гэж төлөвлөөд явж байсан гэж хэлэх гэж байна уу, одоо юу гэж хэлэх гэж байна би ерөөсөө ойлгохгүй байгаад байгаа юм. Энэ логик яг хаана логик байгааг ерөөсөө ойлгохгүй байгаа юм. За гишүүн болсноос хойш яг энэ шалгалттай холбоотой асуудалд би бол нээлттэй хандаж байгаа. Бүх сэтгүүлчийн асуусан асуултад хариулж байгаа. Хууль хяналтын байгууллагууд шаардлагатай гэж үзвэл би дуртай цагт нь, дуудсан цагт нь очоод л бүх юмыг эхнээс нь бас яриад өгөх боломжтой. Банкан дээр бол одоо бүх тэр шалгалтын юмнууд нь сая ажлын хэсэг нь ч шалгалаа. 2020 оны 06 сард одоо сонгуульд дэвшээд явж байхад ч гэсэн шалгаж байсан. Сонгуульд дэвшихээсээ өмнө би яг нэг сарын өмнө одоо манай бага хурлаас шийдвэр гарахаар нь би бас тухайн үед бас олон нийтэд болон намын удирдлагуудад бас энэ тухай бас мэдээлж байсан. Манай хамаарал бүхий этгээд буюу манай эгч ийм Хөгжлийн банкны зээлтэй шүү, одоо худлаа гэвэл миний фэйсбүүк, пейж дээр хүртэл байгаа. Иймэрхүү л нөхцөл байдалтай байгаад байгаа юм. Эргэлзэж байгаа зүйл байвал би одоо хэзээ ч асуултад хариулахад бол бэлэн байгаа. Сая бол үндсэндээ нэг гарчихаад ороод ирэхийн хооронд л намайг хайгаад эхлэх шиг боллоо л доо. За баярлалаа.

**Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн Ж.Бат-Эрдэнэ:**

За Т.Доржханд гишүүн, Т.Доржханд гишүүн.

**Т.Доржханд-Улсын Их Хурлын гишүүн:**

За

**Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн Ж.Бат-Эрдэнэ:**

За энэ Нийтийн Сонсголын тухай хуулийн 17.4.11-ийг сануулчихъя сонсголын үйл ажиллагаанд саад учруулсан итгээдийг танхимаас гаргана гэж байгаа шүү. Та түрүүн хэлэх үгээ хэлсэн шүү дээ. Таныг хэлүүлсэн та хэлэх үгээ хэлсэн? Тийм. За хэлэх үү, Доржханд гишүүн.

**УИХ-ын гишүүн Т.Доржханд:**

За тэгэхлээр өнөөдрийн уулзалтын нэг үр дүнг дүгнэчихмээр байна аа. Тэгээд үр дүн нь юу вэ гээд, тэгэхлээр хурлын эхэнд бол тов тодорхой хэлсэн. Дөрвөн хариуцлага байна аа гээд нэгдүгээрт, хуулийн хариуцлага, хоёрдугаарт, улс төрийн хариуцлага, гуравдугаарт, ёс зүйн хариуцлага, дөрөвдүгээрт, санхүүгийн хариуцлага.

Хуулийн хариуцлага, за хуулийн төлөөллүүдээс тов тодорхой асуусан. Улсын ерөнхий прокуророос асуусан, хүрэлцэн ирсэн сайн байна. Авлигатай тэмцэх газрын даргаас асуусан, хүрэлцэн ирсэн сайн байна. Тэгэхдээ хариултууд хангалтгүй ээ. Хариултууд бол бид ийм мэдээлэл өгөх боломж байхгүй. Яагаад гэх юм бол одоо энэ байгууллагын даргын хувьд ч байлаа гэсэн тухайн хэрэг мөрдөн байцаах шатанд бол оролцох боломж байхгүй гэсэн ийм байдлаар хариу өгч байна шүү нэг. За хоёрдугаарт, цаашаага бол хариуцлага тооцно оо гэдгээ тов тодорхой хэлсэн. За тийм болохоор энэ хариуцлагыг иргэд маань, хэвлэлийн байгууллагынхан маань, энэ бас олон нийтийн байгууллага шахаж ажиллаарай. Бүгдээрээ хамтран шахаж ажиллая, үр дүнг нь харъя. Үр дүн гарна аа гэдгээ хэлсэн

шүү нэг. За хоёрдугаарт нь улс төрийн хариуцлага гээд асуусан. Та улс төрийн хариуцлага хэн тооцох юм бэ гэхлээр хоёр нам байгаа Ардын нам, Ардчилсан нам. Ардын намын дарга, Ерөнхий нарийн бичгийн дарга хоёрыг нь бол энэ хуралд хүрч ирээч ээ гэсэн ирсэнгүй. За одоо энүүгээрээ дайя. Та Ардын намын Ерөнхий нарийн бичгийн дарга нь бол тов тодорхой хэлсэн шүү. Би хариуцлага тооцно оо. Манай дүрэм ийм нээлттэй болчихсон гэдэг ээ. Одоо хариуцлагаа бүгдээрээ нэхнэ ээ, за Өнөрцэцэг сэтгүүлч, Лодой холбогдох сэтгүүлчид маань, энд байгаа хүмүүс бүгдээрээ нэхэх хэрэгтэй. Нэхэж байж улс төрийн хариуцлага тооцно шүү. Өөрөөр хэлэх юм бол холбогдох хүмүүс улс төрийн намаасаа тодорхой хугацаанд түдгэлзэж байж хуулийн байгууллагаараа шалгуулах зүйтэй. Ингэж байж цаашаагаа ард түмэнд итгэл төрнө. Ингэж цаашаагаа цэвэршинэ ээ. За харин Ардчилсан намын хувьд өнөөдөр хоёр хуваагдчихсан байна. Тэгэхдээ яах вэ, Эрдэнэ гээд тамгатай даргад нь хандаад шууд хэлчихье. Тэр хүмүүсээ өнөөдөр энд сууж байгаа Алтанхуяг гишүүний асуудал яригдаж байна. Монгол Улсын Ерөнхийлөгч асан хүний асуудал яригдаж байна. Фортуна Батбаяр гээд Хөгжлийн банкны нөхрийн асуудал бас яригдаж байна. Холбогдох зээл авсан хүмүүсийн асуудал яригдаж байна. Сахал Эрдэнэбилэг гэдэг хүний асуудал бас яригдаж байна аа. За ийм болохоор энэ хүмүүсийнхээ асуудлыг шийд. Улс төрийн хамгаалалтаа битгий үзүүл, шаардлагатай бол намаасаа түдгэлзүүл, чөлөөллөө гэж хэлмээр байгаа юм. За хоёр за гуравт нь ёс зүйн хариуцлага за Бат-эрдэнэ гишүүнээс асуусан. Ямар ч байсан ёс зүйн хариуцлага бол тооцно оо гэдгээ бол хэлсэн. За тооцох нь байна шүү. За дөрөвт нь бас санхүүгийн хариуцлага байгаа. Санхүүгийн хариуцлага дээр 762 тэрбум төгрөгийг улсын төсвөөр оруулж ирнэ ээ гэдэг ийм асуудлыг ярьсан. Энийг зөвшөөрөхгүй ээ гэдэг маш олон гишүүд хэллээ шүү. Мандуул захирал аа. Би өөрийг чинь бас Сангийн яаманд ажилд авч байсан, сайн залуу гэж бодож авч байсан, одоо энийгээ нэр төртэй хийх хэрэгтэй. Тэгээд энд ажиллаж байгаа бас удирдлагын баг Эрхэмбаатар хуульч, ямар ч байсан бас шударгаар ажиллах болов уу гэсэн хүлээлт байна. Америкийн нэгдсэн улсад сургууль төгссөн. Ямар ч байсан мэргэжлийн хувьд бол үнэ цэнэтэй, өөрөө бас ингээд итгэл үнэмшилтэй явж чадах болов уу гэсэн итгэл үнэмшил байна. Битгий итгэл алдаарай. Харин хуулийн байгууллагад найдаад за энэ хэсэг бол хуулийн байгууллага шийднэ ээ гээд тэгээд одоо яах юм бэ? гэдэг гарц, шийдэл байхгүйгээр орж ирж бас болохгүй ээ. Тэгэхээр манай ХҮН-ын эрдэм шинжилгээний тинктанк буюу хүрээлэнгээс тодорхой зөвлөмжийг албан бичгээр өгнө өө, тэрний дагуу та нар ажиллах хэрэгтэй, авахыг нь авах хэрэгтэй. За тэгээд үр дүн юу байх юм бэ гээд маш тодорхой. Өнөөдрийн сонсголоор бол асуудал шийдэгдэхгүй нь ойлгомжтой. Гэхдээ үр дүн нь бол өнөөдөр Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль батлагдсан. Энэ хуулийн дагуу бол Хянан шалгах Түр хороо байгуулна аа гээд 17 гишүүн гарын үсэг зурчихсан байгаа. 19 гишүүний тоогоор энэ маань Улсын Их Хуралд өргөн баригдах учиртай. Хоёрхон гишүүн дутуу, одоо энэ шударга ярьж байгаа гишүүд маань зурчихаач ээ, зурчих. Тэгээд байгуулъя аа. Тэгээд энэ асуудлыг дараа нэг бодитойгоор тоон мэдээлэл дээр нь үндэслээд энэ асуудлаа нухацтайгаар ярья аа. За энэ бол энэ хурлын үр дүн байх болов уу. Тэгээд ийм болохоор өнөөдрийг хүртэл бас ингээд асуудлыг босгож ирсэн, араас нь явсан энэ хэвлэл мэдээлэл, сэтгүүлчиддээ бид талархах учиртай шүү.

Хоёрдугаарт, энэ ажлын хэсгийн дүгнэлтүүд нь энэ хэвлэл мэдээллийн хэрэгслээр гарч ирж байгаа мэдээлэл дээр үндэслэсэн байж болохгүй ээ. Бид өнөөдөр эр зоригтойгоор улс төрчид нь энэ эрсдлээ үүрэх хэрэгтэй. Мөнгөтэй төгрөгтэй тийм нөхдүүдтэй үзэх гэж байгаа бол хамт хамтдаа тэмцье л дээ. Юунаасаа айдаг юм бэ? Тэгээд ийм болохоор зоригтойхон шиг энэ нөхцөлүүдээ



гаргаад ир, шаардлагатай бол би наад ажлын хэсэгт чинь оръё оо, би гарын үсэг зурчихъя аа, асуудал байхгүй. Ингэж байгаад энэ нийтээрээ энэ асуудлыг дэмжээд.

**Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн Ж.Бат-Эрдэнэ:**

За Баттөмөр гишүүнд микрофон өгье.

**УИХ-ын гишүүн, ажлын хэсгийн ахлагч Б.Баттөмөр:**

Ажлын хэсэг нэг дөчин таван хоног гэртээ ажиллаад 7000 гаруй хуудастай материал дунд ажиллалаа. Ийм 5 хуудас одоо ажлын тайлан гарч байгаа. За энэ 5 хуудсаас одоо 20 минутад багтааж ярина гэдэг бол үнэхээр төвөгтэй. Бас зарим зүйлийг дутуу ярьсан болбол уучлаарай. За нэгдсэн тайлан гарч байгаа хувьцаа эзэмшигчдийг тодорхойлсон зарим хүмүүс одоо нэлээн алергитаж байх шиг байна. Байгаа юмыг байгаагаар нь л гаргаж тавьсан. За мэргэжлийн одоо үнэлгээчдийн шинжилгээ хийлгэсэн “Ди Би Эм лизинг”-ийн компанийг тусад нь одоо тайланг нь гаргасан. 66 төсөл бүрээр нь газар дээр нь очиж үзсэн. Хуучин шалгалтууд дандаа хүний амаар хийгддэг байсан бол энэ бол газар дээр нь очиж үзээд, нотлоод мэргэжлийн үнэлгээчдээр үнэлүүлсэн ийм ажил хийсэн. За ингээд төр хяналт төр одоо Хяналт шалгалтын Түр хороо байгуулна гэвэл ихэнх ажлыг нь бид нар хийчихсэн байгаа. Тэр хүн дуудаж авчирч мэдүүлэг энэ тэр авдаг ганц нэг заалт одоо дутуу байгаа байх. Бидэнд тийм эрх бол байсангүй. За энэ анх удаагаа одоо өмнө нь хийсэн шалгалтуудыг бүгдийг нь нэгтгэж ингэж гаргаж ирж байгаа ийм онцлогтой юм аа гэдгийг хэлье. За энэ шүүхийн бус шугамаар одоо өр барагдуулах хуулийн төслийг одоо өргөн барьчихсан байгаа. За энэ дээр одоо ард нийтээр нээлттэй одоо хэлэлцэнэ. Одоо тэр фэйсбүүк, бүх утас, материалуудаараа болбол тавина. За Төлбөрийн чадваргүйжилтын тухай хууль гээд энэ Засгийн газраас бас өргөн барьж байгаа. За энэ болбол одоо бид бас Засгийн газартайгаа хамтарч ажиллаад энэ төлбөрийн чадваргүйжилтын юмыг гаргаж тавих нь зүйтэй юм аа гэдэг юмыг бол энэ шалгалтын явцад бол хийгдсэн.

Сая тэр Ганхуяг гишүүний ярьж байгаа тэр 5 хувь мувь бол “Бэрэн” компанид эзэмшдэг юм байхгүй. Энийг би хариуцлагатайгаар хэлчихье. “Бэрэн” компанид 5 хувь эзэмшдэг юм болбол би ямар ч хариуцлага хүлээхэд бэлэн. Хөрөнгийн биржийн нээлттэй хоёр дахь зах зээлийн үед би надад 5 ширхэг хувьцаа байдаг юм. Би энийг хөрөнгө орлогын мэдүүлэг дээр тэмдэглээд Авлигатай тэмцэх газар одоо бичээд өгчихсөн байгаа. Нэг нь одоо үндсэндээ 17 орчим төгрөгийн үнэтэй ингээд нэг 85 орчим төгрөгийн үнэтэй одоо таван ширхэг хувьцаа. За тэрийг нь бид нар тухайн үед нь өгч байгаа. Авах хүн байвал энэ 5 ширхэг хувьцааг болбол авч болно оо “Бэрэн” мэрэнтэй нь, надтай ямар ч холбоогүй гэдгийг би өнөөдөр хариуцлагатайгаар хэлчихье. За энэ Хөгжлийн банкны асуудлыг ингээд ярьж байх явцад, шалгаж байх явц дунд болбол олон асуудал орж ирж байна.

Энэ эрх мэдлийг дагаж одоо их олон сорилтууд тулгарч байдаг юм. Энэ манай Хөгжлийн банкны үе үеийн удирдлагууд энэ сорилтуудыг давж чадсангүй. Монголыг монголчууд өөрсдөө бид нар сүйтгэж байгаа. Өнөөдөр одоо байж байгаа байдал энэ шүү дээ. Монголын өнөөдөр бүх зүйлүүдийг ингээд ярих юм бол асар их эмгэнэлтэй юмыг хэлж болохоор байна. Ойлголт зөв бол үйлдэл зөв гэдэг. Манай Хөгжлийн банкны удирдлагууд юу хийх тэр ойлголт анхнаасаа байхгүй. Нэг тодорхой ажилд очоод л, лоббидоод баахан зээл гаргаад л, ингээд одоо эцэст нь ийм дүр зураг гарч байна шүү дээ. Гэм хийсэн хүнээс одоо зөвийг хайгаад хэрэггүй ээ гэдэг үг байдаг.

Үнэхээр яг энэ зөв болчихож гэдэг юм их маруухан байгаа. Энийг одоо өнөөдөр хэлэх нь зүйтэй гэж бодож байгаа юм аа.

За Хөгжлийн банкиг тойрсон асуудлыг зөвхөн нэг өнцгөөс харж хэрэггүй, олон өнцгөөс харах ёстой. Энэ цементийн үйлдвэрийн төслүүд байна. Одоо сүүлийн үед бол дандаа цутгамал байшин барьдаг болчихсон, цемент бол үнэхээр Монголд хэрэгтэй. Тэр Ховдын цементийн үйлдвэр гээд байж байгаа. Үнэхээр баруун аймагт бол үнэхээр одоо чухал шаардлагатай төсөл эхэлсэн, явж байгаа. Энэ “Эрэл групп”-ийн тэр үйлдвэр байна, энэ бол одоо энэ Улаанбаатар хотыг утаанаас салгах үнэхээр одоо маш чухал төсөл энд явж байгаа юм гэх мэтээр. Тэр одоо надтай холбож яриад байгаа, тэр “Бэрэн групп”-ийн гээд байгаа Бэрэнгийн гангийн үйлдвэр Монголд ширэм үйлдвэрлэчихсэн байна. Түүхий төмрийн хүдрээс ширэм үйлдвэрлэчихсэн. Энэний дараагийн үе шат нь бол тэр ган энэ тэр үйлдвэрлэх ийм үе шат нь явна шүү дээ. Ийм учраас эдгээр төслүүдийг бол Монголын төрөөс дэмжиж, төр засаг, тэр компаниудтай хамтарч ажиллаж ингэж ажиллах шаардлагатай гэдгийг одоо хэлэхийг бодож байгаа юм. Цөөн хэдэн олигархууд биш ард түмэн, төрд үйлчилдэг банк байх ёстой гэж ингэж үзэж байгаа юм. За энэ Түр хороо байгуулагдаад энэ талаар тодорхой судалгаа хийж, тодорхой ажиллана аа гэдэгт итгэж байгаа. Аливаа асуудлыг одоо өөрчлөхийн тулд дүрмийг нь өөрчил гэж үг байдаг. За бид бол Улсын Их Хурал бол энэ дээр Хөгжлийн банкны хуулийг өөрчлөх шаардлагатай. Энэ хуульд юу гэхээр Засгийн газрын оролцоог, Засгийн газрын хяналтыг, Засгийн газар өөрсдөө одоо ямар төсөл санхүүжүүлэхээ Хөгжлийн банканд хэлж, хамтарч ажиллахгүй бол Хөгжлийн банк дангаараа, Монгол Улсын хөгжлийн бүх төслүүдийг санхүүжүүлнэ гэж бол байхгүй. Ийм байдалтай байгаа энэ зүйлийг би өнөөдөр хэлэхийг ...

#### **Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн Ж.Бат-Эрдэнэ:**

За тэнд нэг хүн бүр орон нутгаас ирсэн гээд гараа өргөөд байна. За энэ хүнийг л авчихъя хэдүүлээ, тэгээд больё тэгэх үү. За ганцхан энийг л авчихъя. За яах вэ, энийг сонсчихъё, тэгээд больё. В индэр.

#### **“Ганхүдэр орд” ХХК-ийн гүйцэтгэх захирал Р.Эрдэнэбаяр:**

За сайн байцаана уу? Та бүхний энэ үдшийн амгаланг айлтгая аа. За өглөөнөөс хойш бас энэ сонсголд ингээд суулаа. За миний хувьд намайг Эрдэнэбаяр гэдэг. Дархан-Уул аймагт “Ганхүдэр орд” гээд төмрийн хүдрийн баяжуулах үйлдвэрийн гүйцэтгэх захирал хүн байна. Энэхүү Хөгжлийн банкнаас 2017 онд манай компани 5 тэрбум төгрөгийн төслийн зээл авсан. Төсөл маань амжилттай хэрэгжээд бид үйлдвэрээ барьсан. За манай үйлдвэр ямар үйлдвэр вэ гэх юм бол 2012 он анх үүсгэн байгуулагдсан. За анх байгуулахдаа төмрийн хүдрийг нойтон соронзон аргаар баяжуулах ийм чиглэлээр байгуулагдаад 5 жил үйл ажиллагаа амжилттай явуулаад компанийнхаа орлогоор тодорхой хэмжээний бизнесийнхээ ашгаар энэхүү төмрийн хүдрийн дараагийн шатны үйлдвэр болох хорголжин баяжлуулах үйлдвэрийг барьж эхэлсэн. За ингээд суурийн бүх суурийн ажлыг хийж байх явцдаа 2017 онд Хөгжлийн банканд хүсэлт тавьж төслөө танилцуулсны үндсэн дээр одоо хангалттай барьцаа хөрөнгө, манай нийт барьцаа хөрөнгийг бол арван хэдэн тэрбумаар үнэлэгдээд, түүний тавь хүрэхгүй хувьд нь одоо энэ төслийн зээлийг олгосон юм байдаг юм аа. Тэгээд бид нар энэ төслөө бол амжилттай хэрэгжүүлээд 2017 онд үйлдвэрээ бариад 2019 онд бол үйлдвэрээ бүрэн хүчин чадлаар нь ашиглалтад оруулсан. За анх үйлдвэр барихад бол одоо 60 хүний ажлын байрыг бол бий болгоно оо гэсэн ийм зорилготой байсан. Гэсэн хэдий боловч

бид нар төслийн хөрөнгө оруулалтыг гадаад, дотоодын зах зээл дээр өөрийн компанийн үйл ажиллагааныхаа ашгаар бас нэмэгдүүлээд, ажлын байрны тоог 4 дахин нэмэгдүүлсэн, үйлдвэрийн хүчин чадлыг 3 дахин нэмэгдүүлсэн. Одоо манай компани амжилттай үйл ажиллагаа явуулж ирсэн. Сүүлийн хоёр жил та бүхэн мэдэж байгаа, энд байгаа бүх бизнес эрхлэгчид ярьж байна. Дэлхий нийтээр Ковид-19 цар тахал үнэхээр том хүчин зүйл нөлөөлсөн. Энэнээс болоод тодорхой хэмжээний бид нар бас үйл ажиллагаа доголдоход хүрч байсан. Яагаад гэвэл манай компани Монгол Улсад байхгүй хамгийн анхны одоо анхдагч төмрийн хүдрийн хорголжин баяжмал үйлдвэрлэдэг ийм компани байгаа. Боловсон хүчний хомсдолд орж, хорголжин бүтээгдэхүүн маань доголдох чанар, технологийн бас алдаа дутагдал гаргах, тэр маань үнэгүйдэх тиймэрхүү юм бол байсан хэдий боловч бид нар одоо 100 хувь дотоодын ажиллах боловсон хүчнээ өөрсдөө бэлтгэж сургасаар энэхүү үйлдвэрээ одоо амжилттай явуулж ирсэн.

Гэсэн хэдий ч одоо бид нарт маш том хоёр томоохон хүчин зүйл байгаа. Энэ маань юу вэ гэх юм бол одоо нэгдүгээрт, төмөр зам тээвэр, ложистикийн асуудал байгаа юм. Манай үйлдвэр бол өдөрт түүхий хүдрээр одоо 1800 тонн хүдэр үйлдвэрлэх ийм хүчин чадалтай. За үүгээрээ бол нойтон соронзон аргаар баяжмал үйлдвэрлээд 67 хувийн агуулгатай баяжмал үйлдвэрлээд Монгол Улсад одоо байхгүй. Одоо энэ “Болд төмөр Ерөө гол” компанийнхан хийх гэж байгаа зарим Хятадын хөрөнгө оруулалттай компани хийсэн хэдий ч одоо ашиглалтад оруулж чадаагүй байгаа энэ үйлдвэрүүдийг л манай компани хоёрын хоёр ийм үйлдвэр барьчихсан байгаа. Эхний нэгдүгээр үйлдвэр нь бол одоо яах аргагүй энэ Хөгжлийн банкны төслөөр хийсэн. Хоёрдугаар үйлдвэр нь бол тэрнээс хоёр дахин илүү том хүчин чадалтай ийм үйлдвэр бид нар барьж, амжилттай одоо ч гэсэн үйл ажиллагаа явуулж байгаа. Манай компаниас 60 хүнийг ажлын байраар хангасан бол 280 хүн болчихсон байна, манай бүтэц, орон тоо ийм амжилттай ингээд явж байгаа. За сая ярилаа, тэгээд бид нар үйлдвэрийнхээ үндсэн түүхий эдүүдийг Дархан, Сэлэнгийн бүс нутгаас Төмөртэйн уурхай, Төмөр толгойн уурхайнуудаас татдаг. За Төмөртэйн уурхайг та бүхэн мэдэж байгаа, төмөр замаар тээвэр ложистикоо хийдэг, тэндээс автомашинаар тээвэрлэхийг хориглодог. За ингээд бид нар түүхий эдээ татах нөхцөл боломж байхгүйгээс үйлдвэр маань ингээд доголдох, тасалдах ийм нөхцөл байдал байнга үүсэж байдаг. За тэгээд дараа нь яах вэ гэхээр арай чүү гэж татаж авлаа, тэгээд буцаагаад нөгөө л үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ экспортод гаргая гэхэд манай бүтээгдэхүүн 100 хувь Хятад Ард Улс руу экспортод гардаг ийм бүтээгдэхүүн байгаа юм. Монгол Улсад баялаг бүтээж байгаа, уул уурхайн нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаа ийм компани. Гэтэл бас өнөөдрийг хүртэл тээвэр байхгүй. 2021 оны 11 дүгээр сарын 28-наас хойш нам зогссон үйлдвэр маань. Ажилчиддаа сул зогсолтын цалин өгөөд ингээд байж байгаа. Тэгээд иймэрхүү хүндрэлтэй асуудлууд байгаа.

Дараагийн нэг асуудал нь юу вэ гэх юм бол АМНАТ-ын төлбөр байгаа. Манайх уул уурхайн ашиглалтын лицензгүй, боловсруулах үйлдвэр. Тэгэхээр өнөөдөр Монгол Улсын Ерөнхий сайд Шинэ сэргэлтийн бодлого гэж гаргасан. Тэрний хамгийн том асуудал нь Монгол Улсын төсвийг бүрдүүлж байгаа уул уурхайн бүтээгдэхүүн байгаа. Бид нар уул уурхайн бүтээгдэхүүнээ одоо 30 жил түүхийгээр нь урагшаа Хятад Ард Улс руу асар хямдхан үнээр ажлын байр Монгол Улсад бий болохгүй, Хятадад гадаад улсад ажлын байр бий болгох ийм бодлогоор одоо тэнд зөөсөөр ирсэн. Өнөөдрийг хүртэл тавхан хувиа боловсруулж байна. Бид нар тавхан хувиа боловсруулж байгаа, 95 хувиа түүхийгээр нь бид нар гаргаж байгаа. Тэгэхээр бид нар яах ёстой вэ гэхээр энэ АМНАТ-ын асуудал яаж байна гэхээр ашиглалтын лицензгүй, боловсруулах үйлдвэр эрхэлж байгаа манайх шиг компаниудад энэ

АМНАТ нь маш өндөр дарамт болж байгаа юм аа. Өнөөдөр бид нар 3.4 тэрбум төгрөгийн АМНАТ-ын өр төлбөртэй байгаа. Хэрвээ бид нар энэ АМНАТ 2019 оны 04 сард бий болсон. АМНАТ байгаагүй байсан бол бид нар энийгээ төлөх ийм боломжтой байсан гэдэг ийм дүр зураг бас ажиглагдаж байгаа юм аа.

За тэгээд л би хэллээ сая 2021 оны 11 сараас хойш бүтээгдэхүүн маань үйлдвэрлээд экспортод гарч чадаагүй. Одоо манай үйлдвэрийн гаалийн хяналтын талбай дээр гэх юм бол нойтон баяжмал 8,000 тонн, хорголжин баяжмал 10,000 тонн байгаа Хөгжлийн банкныхан бүгд мэдэж байгаа. Бид нар Хөгжлийн банканд одоо ийм бараа бүтээгдэхүүн байна, энийг экспортлохын бол өр төлбөрөө ингээд төлнө өө, барагдуулна аа гэдэг юмыг бол удаа дараа хэлээд бас мөн одоо энэ үйл ажиллагаа явуулж байх төсөл хэрэгжүүлэх явцдаа ч гэсэн одоо бидний хувьд ийм ийм хүндрэлтэй асуудал байна, тээвэр ложистикийн асуудал байна, АМНАТ-ын асуудал байна, боловсон хүчний асуудал байна, Ковидын асуудал байна ингээд бүгдийг нь танилцуулж байсан. Бүгд дээр нь албан бичгээр явуулж байсан. Мөн одоо хамтарч ажиллая аа, бид нарт вагон олоод өгөөч ээ, төмөр замын тээвэр олоод өгөөч ээ, тэгэх юм бол бид нар бүтээгдэхүүнийг экспортод гаргаад орлогынхоо одоо 70 хувийг нь ч юм уу одоо ингээд шууд зээлийнхээ өр төлбөрт өгье өө гэдгээ бол ингээд хэлээд яриад явж байсан байгаа юм аа.

За дараагийнх нь нэг юу бол одоо манай мэдээллийн зөрүүтэй байдал, ойлголтын зөрүүтэй байдлаас болоод манай компанийг одоо.

#### **Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн Ж.Бат-Эрдэнэ:**

За Б.Энхбаяр гишүүн.

#### **УИХ-ын гишүүн Б.Энхбаяр:**

За Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн дагуу Улсын Их Хурал энэ хуулийн дагуу анхны хяналтын ерөнхий сонсголоо хийлээ. За ингээд өндөрлөж байгаа биш, энэ бол эхлэл болно оо. За тийм ч учраас Улсын Их Хурал дээр Түр хороо байгуулж ажиллахыг дэмжиж миний бие гарын үсэг зурсан байгаа. Түр хороо байгуулагдах байх. За Түр хороо бол энд өнөөдөр хэлэлцэгдсэн болон хэлэлцэгдээгүй байгаа, удахгүй илрэх, удахгүй ачигдах олон хүний асуудал, олон авлига, хулгайн асуудлыг хуулийн байгууллагатай хамтарч, дэмжлэг үзүүлж эцэслэн шийднэ ээ, эцэслэн шийднэ. Улсын Их Хурлын гишүүддээ хандаж хэлэхэд бидэнд бол нэлээн тийм түүхэн хариуцлага ирж байна аа. Хэрвээ бид энэ хулгай, луйврын асуудал дээр өмнөх 6, 7 жилийнх шиг мэдсэн ч мэдээгүй царайлж, хүний өөрийн гээд ингэж явах юм бол энэ Монгол Улсын цаашдын хувь заяа, бидний ирээдүй, үр хүүхдийн минь хувь заяа яадаг бол доо. Өнөөдөр манай олон иргэд, залуучууд гадагшаа гарахыг л хүсдэг болсон байна. Эх орноосоо зугтана гэдэг бол сайхан зүйл биш л дээ. Ийм хулгайчтай улсаас бүгд л зугтахыг хүсэж таарах байх. Хулгай хийгээд байгаа хүмүүс энэ улс орнуудыг харж байхад бүгд өөрсдөө хөрөнгөө гаргаад, үр хүүхдүүдээ гадагш нь гаргахад бэлдээд зугтахад бэлэн л болчихсон юм байна лээ. Эхнээсээ Ерөнхий сайд нь хаана байгаа нь мэдэгдэхгүй, эх орноосоо урваад гадаадад дүрвэчихсэн явж байгаа. Тэр хүн одоо ирэх хэрэгтэй.

За хэрвээ энэ асуудлыг Улсын Их Хурал манлайлж асуудал ярихгүй бол цаашдаа ард түмэн бослого, тэмцлийн хэлбэрт мэдээж орох байх. Өнгөт хувьсгал ч болж мэднэ. Тэгээд манайх нэг хүний засаглалтай ч болох байх, дарангуйлагч ийм засаглалтай болох байх. Нэг хүнийг бол том улсууд бол хап гээд л бариад авчихна.

Ингээд ер нь төртэй, төргүй нь мэдэгдэхгүй ийм байдал руу явна аа. Монгол Улсын парламент бол манай улсын тусгаар тогтнол, эрх чөлөө, ардчиллын баталгаа. Би үүнд итгэлтэй байдаг. Ямар ч тохиолдолд парламент бол бидний үнэ цэн. Өнөөдөр Хөгжлийн банкны асуудлыг улс төржөөд байна уу, яагаад байна вэ, бид бүтэн өдөр тойроод сонсож байгаа нь ард түмэндээ энэ хулгай, луйвар ийм юм болжээ гэдгийг парламент л илчилж нээлттэй хэлэлцдэг юм. Тийм учраас ямар ч тохиолдолд бид энэ бүгдээрээ хэлэлцдэг, олон талаас нь шүүдэг ийм засаглалынхаа үнэ цэнийг бол бодож байх ёстой. Бүгдийг нь муухай харагдуулж байгаад цаашдаа нэг хүний засаглал руу явуулах манай улсын төртэй, юутай хийтэй нь атгандаа атгах ийм санаархал, ийм хүч ойрхон байгаа шүү. Ийм сонирхолтой этгээдүүд ч байна. Тийм учраас том зургаараа бол бид одоо улс орныхоо, энэ тусгаар тогтнолын үнэ цэнийг ирээдүй хойчоо бодож бүгд тэмцэх ёстой. Энэ дээр хуулийн байгууллагынхан гол ачааг үүрнэ ээ. Гол ачааг үүрнэ шүү. Та хэд дээр бол би бол одоо их олон юм яримааргүй байна. Түр хороо байгуулагдаад ярих боломж гарах байх. Тодорхой тодорхой хэргүүд дээр. Одоо жишээлбэл тэр Ууганбаяр гээд “Нью яармаг”-ийн Женкогийн зөвлөх байсан хүн нэг гаргачихсан л сурагтай байна лээ. Хэнийг нь ч хориод, хэнийг нь ч гаргадаг юм. Их итгэл байгаа шүү, би бол итгэхийг хүсэж байгаа. Тэгээд харъя. Харъя.

### **Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн Ж.Бат-Эрдэнэ:**

За Х.Булгантуяа гишүүн үгээ хэлье.

### **УИХ-ын гишүүн Х.Булгантуяа:**

Бид нар өнөөдөр энэ асуудлаар нэг их улс төржих гэж юм ярьсангүй л дээ яг үнэнийг хэлэхэд. Анх удаа өнөөдөр энэ ажлын хэсгийн мэдээллийг сонсож байна бид нар, одоо Улсын Их Хурлын гишүүд ч гэсэн.

45 хоног ажлын хэсэг ажилласан юм байна. Хөгжлийн банкн дээр, дээрээс нь нэмээд бараг 2, 3 яамны хэмжээтэй хүмүүс ажиллаж байгаа. Мэргэжлийн хүмүүс ажиллаад, мэргэжлийн ажлын хэсэг ажиллаад Монголбанкнаас, Үндэсний Аудитын газраас, Сангийн яамнаас тэгээд нэг өчнөөн хүмүүс ажиллаад ажилласан тайлангаа тавих ёстой. Бид асуух ёстой. Иргэд олон нийт та бүхэн маань ч гэсэн сая асуух шиг боллоо. 1.8 их наяд гэдэг бол маш их мөнгө. Сая Ковидын үед энэ хатуу хөл хорионы үед өрх болгонд 300 мянган төгрөг тараалаа. Тэр бол 1 их наяд төгрөг байсан. 1.8 их наядаар өрх болгонд 500 мянган төгрөг тараах мөнгө. Сая бүх иргэдийн ахмадуудын тэтгэврийг нэмлээ, тэрэн дээр 600 гаруй тэрбум төгрөг нэмж шаардагдсан. Та бүхний ахмадуудын тэтгэврийг 3 дахин нэмэх ийм хэмжээний мөнгө. 200 хүүхдийн цэцэрлэг 3 тэрбум төгрөг байгаа. Улсын хэмжээнд 600 цэцэрлэг барих мөнгө. Сонгинохайрхан дүүрэгт баригдсан Япон, Солонгост байдаг шиг 200 ортой эмнэлгийг 13 эмнэлэг барих хэмжээний мөнгө. Ийм их хэмжээний мөнгийг өнөөдөр ингээд чанаргүй үрчихсэн гээд одоо ингэчихээд дараа нь тэрүүгээр одоо улс төр хийнэ ч гэж одоо юу байх вэ дээ. Үнэнийг хэлэхэд бүх улс төрчдөд л иргэд яг өнөөдөр бол энэ цаг үед бүгдээрээ үзээд сууж байгаа хүн болгон л бухимдаж байгаа. Тэндээс нэг их одоо би ч нэг сайхан нэртэй, бид нар ч бүгдээрээ сайхан нэртэй гарна гэж бол байхгүй байх. Төрд ажиллаж байгаа хүмүүсийг нь хянаж шалгахгүй юугаа хийж байсан юм, энэ хүмүүст хариуцлага тооцохгүй юугаа хийж байсан юм гэж л харж байгаа байх яг үнэнийг хэлэхэд.

Тэгэхдээ одоо ард түмэн минь, иргэд олон нийт та бүхэн маань энэ бүгдийн үнэн зөвийг бас өөрсдөө тунгаан бодоорой. Одоо ингээд энэ том бүлэглэлүүдтэй

чинь үзэхээр урдаас бүхэл бүтэн одоо хэчнээн зуун тэрбумаар аваад идчихсэн хүмүүс бол нэг үүнийг дарахын төлөө 500 сая төгрөг, тэрбум төгрөг хаях бол юу ч биш байдаг юм шиг байна лээ. Сошиалаар бүхэл бүтэн хүмүүсийг агнах аян явуулдаг юм байна лээ. Янз янзын худлаа үнэн мэдээлэл явуулаад л, би эх оронч, би илүү их эх оронч гээд л. Иргэдийнхээ ирээдүйг хулгайлдаг эх оронч гэж бол байдаггүй юм аа. Иргэдээсээ 13 эмнэлгийн мөнгийг хулгайлдаг эх оронч гэж бол байдаггүй юм аа. 600 цэцэрлэгийн мөнгийг хулгайлдаг эх оронч гэж бол байдаггүй юм аа. Хэн нь хулгай хийгээд өнөөдөр иргэдээ өрөнд оруулчихаад, эх орныхоо нэр хүндийг дэлхийд өнөөдөр ингээд муухайгаар зарлуулаад сууж байна гэдгээ эрх биш харж байгаа байх аа. Өнөөдрийн хийж байгаа мэдээллүүдийг олон улсын байгууллагууд хараад л сууж байгаа байх. Олон улсын банк, санхүүгийн байгууллагууд эд нарын байж байгаа царайг дээ гээд дүгнээд л сууж байгаа байх. Хэн нь илүү хулгай хийсэн бэ гэдгээ ингээд хэлэлцээд эцсийн эцэст сууж байна даа гээд л дүгнэж байгаа байх аа.

Энэ бүгдийг эхлүүлсэн хүн нь өөрөө тэгээд аймаар энхийн цагаан тагтаа шиг юм яриад. Би одоо тэр Мөнхбат гэдэг залууг би огт мэдэхгүй энэ тэр гээд. Тухайн үедээ одоо би санаж байна. Одоо манай намын бүлгийн гишүүд би одоо тэр үед гишүүн ч байсангүй. Тэгэхэд Мөнхбат аа, миний дүү чи одоо ингэж байгаад энэ ах нарынхаа үүрэг даалгаврыг “За” гэж биелүүлж байгаад миний дүү шоронд явчихав даа гэж би хэлж байсныг санаж байна. Одоо яг л тийм л юм болж байх шиг байна. Тэр өнөөдөр өмгөөлөгч нь бас хэлж байна. Тэгэхдээ сая зарим нэг зүйлүүдийг бол дутуу л ярилаа. Н.Алтанхуяг гишүүн өөрөө 2013 онд Засгийн газрын тогтоол гаргаад энэ Бүгд Найрамдах Солонгос Улсын Хөгжлийн банк, удирдлагын баг, манай Хөгжлийн банк хооронд байгуулсан гэрээг цуцлаад тэр солонгосуудыг нь хөөж гаргасан юм билээ. Солонгосын Хөгжлийн банкнаас тэр солонгосын удирдлагын багийг ажиллах бүх зардлыг нь дааж байсан юм байна лээ, цалин хангамжийг нь. Та нар хэрэггүй ээ, бид нар өөрсдөө удирдана аа гэж хэлээд, тэгээд энэ бүх зүйлийн үүд хаалгыг нээж байсан. 2011 оны 179 дүгээр Монгол Улсын Засгийн газрын тогтоол байгаа. Манай эрэн сурвалжлах энэ сэтгүүлчид, иргэний нийгмийн байгууллагууд та бүхэн өөрсдөө шалгаарай legalinfo дээр байна лээ. 179 дүгээр тогтоолоор сая энэ яриад байсан ажлын хэсгийг байгуулсан, Бондын ажлын хэсэг гэдгийг. Ямар төслүүдэд зээл өгөх вэ, ямар шалгуураар өгөх юм, бид нар хянана, бид нар шалгана гэдэг ийм ажлын хэсгийг байгуулсан. Ингээд үнэнийг хэлэхэд бараг тэндээс нь шалгаруулаад, тэгээд Мөнхбат гэдэг залуу нь тэр зээлийг нь одоо өгч байсан юм шиг байгаа юм захирал нь. Тэгээд эцсийн эцэст ингээд өчнөөн хүмүүсийг яг энэ хоморголсон энэ бүх юуг эхлэлийг нь өнөөдөр тавьчихаад ингээд энхийн цагаан багтаа шиг байж болохгүй ээ. Тэгээд өнөөдөр одоо ингээд шүүмжлээд ярьсан бид хэд маргаашаас авахуулаад сошиалаар нэлээн гөвүүлэх биз бодвол. Тэрэн дээр тэгэхдээ нэг их айж эмээгээд байх зүйл алга аа.

Тэгээд хууль хяналтын байгууллага та бүхэн маань энийг үнэн зөвийг нь гаргаарай. Улсын Их Хурлын гишүүд бид нар, тэгэхдээ бүрэн эрх одоо энэ хууль хяналтын байгууллагад нөлөөлөөд байх эрх бол байхгүй шүү дээ. Та бүхэн шийд шийд гээд байх юм. Энд очсоны дараа энд мэдээлэл ч өгөхгүй байгаа биз дээ. Мэдээлэх ёсгүй. Энэ бол одоо улс төрчид та нарт нөлөөлж болохгүй гээд ингээд. Нөлөөлж болохгүй, хуулиараа болохгүй юм чинь бид нар болохгүй шүү дээ. Харин та нар тэгвэл тэрнийхээ дагуу шүүх шийдвэрийг нь одоо гаргаад яваарай. Тэгээд энэ хэдэн аж ахуйн нэгжүүдээ одоо яах юм тэр шийдвэрээ л тэр Түр хороон дээр Хөгжлийн банк, ажлын хэсэг нь орж ирж танилцуулах нь зүйтэй байх аа.

## **Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн Ж.Бат-Эрдэнэ:**

За М.Оюунчимэг гишүүн.

### **УИХ-ын гишүүн М.Оюунчимэг:**

Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийг санаачлаад энийг батлах нь зайлшгүй хэрэгтэй, цаг алдаж болохгүй гэж явсан гишүүдийн нэг би байна л даа. Тэгээд өнөөдөр яг энэ хуулийн хүрээнд анхны нээлттэй сонсголыг Хөгжлийн банкн дээр хийж байна. Тэгээд энд бол манай хэвлэл мэдээллийнхэн бол маш гол үүрэгтэй оролцсон. Тийм учраас би хэвлэл мэдээллийнхэндээ бол үнэхээр талархаж байна. Хэвлэл дээр гарсан нүцгэн мэдээг тэрэн дээр гарсан учраас баримт гэдэг юм уу, эсвэл нэг нэгийгээ одоо буруу аргаар ашиглах юм уу тийм зүйл бол бас байж болохгүй учраас би бас ажлын хэсгийг хариуцлагатай хандаж, Улсын Их Хурлын гишүүн, хяналт шалгалт хийж байгаа хүмүүс харин тэр үнэхээр энэ нөлөөтэй, нөлөөгүй байна уу гэдгийг шударгаар гаргаж ирээд тавих ёстой шүү. Нэгдүгээрт энийг хэлье ээ.

Хоёрт нь би нэг зүйлд үнэхээр харамсаад байна л даа. Өнөөдөр ингээд л ярьж байхад дандаа нэг залуучуудын маань л хөөрхий нэр гараад л гарын үсэг зурсан, гардаж гүйцэтгэсэн дандаа залуучууд, тэд нар тэгээд хохироод үлдэж байна. Нөгөө жинхэнэ цаана байгаа хүнд гарууд, том эздийн тухай яриа ч алга. Тэгээд тэр шүүх хяналтын байгууллага дээр ч тэр нь бараг очдоггүй юм уу, одоо яадаг юм бүү мэд. Одоо тэр хэд маань буруутан болоод, ингээд залуучууд явна, дараа дараагийн дүрүүд гаргаж ирнэ. Дахиад тэд нар хохироод, жинхэнэ нөгөө нэг үүр идээ нь байгаад л байна. Тэгэхээр Хөгжлийн банкаар энэ зогсоосой л гэж би бодож байна л даа. Нэг хэсэг залуучууд маань ингэж том гаруудын золиос болоод явдаг. Нөгөө нэг хэсэг нь ажилгүй, орлогогүй болоод гадагшаа явах юм уу, ингээд өнөөдөр амьдрал нь хэцүү, архинд ороод байж болохгүй. Энэ байдлыг үнэхээр бид өнөөдөр засахгүй л бол улс орон хөгжихөд хэцүү. Тэгээд өнөөдөр гадаад геополитикийн нөхцөл байдал ямар байгаа билээ. Сая бас манай гишүүдийн хэлдэг үнэн л дээ. Яг одоо бид нар энийг ингээд л ярина, маргаашаас эхлээд зохион байгуулалттайгаар зарим нэгийг нь намнах ажлууд ч эхэлдэг. Амыг нь барих, дуугай болгосон гэдэг ажиллагаа ч явдаг. Тийм учраас түрүүн Б.Энхбаяр гишүүний хэлдэг, түрүүн Х.Булгантуяа гишүүн сая бас хэлж байна. Бид нар бол үнэхээр энд одоо зогсож болохгүй л дээ. Энэ бол эхлэл нь.

Сая одоо манай намын хүнийг ярьж байвал өөрийнхөө намын хүмүүс ичээрэй гээд л Шинэ намын дарга нь тэгж ярьж байж бас болохгүй л дээ. Харин ч одоо Ардын намын тэр хүмүүс, Ардчилсан намын тэр нь, ХҮН-аас холбогдсон бол тэр нь гээд бүгдээрээ нийлээд энийг өөрчилье гээд явж байх ёстой л доо. Тэгэхгүй бол хүний өөрийн юм яриад л, ёстой ичээрэй гэж ярих биш. Бид өнөөдөр энэ чуулганы танхимаас, Улсын Их Хурлын энэ танхимаас энэ асуудлыг хамтдаа шийдээд ядахдаа Хөгжлийн банкн дээр за энэний ард нээрээ болохгүй юм байна гэдэг ядахдаа тийм дохиог өгье л дөө. Өнөөдөр харин хууль хүчний байгууллагын удирдлагууд маань бүгд ингээд одоо болтол ингээд сууж байгаад талархаж байна. Энэ хүмүүс маань бүгдийг нь сонсож байгаа байх, бас хаана юу байна, хэний ард ямар нь байна гэдэг мэдээллүүд ч гэсэн ил гарч байгаа байх. Тийм учраас энэ дээр бол бид нар үнэхээр нэгдээд ажиллаж байж л үр дүнд хүрнэ. Тэрнээс нэг хоёроороо бол намнуулаад, гүтгүүлээд, нэр төрөө гутаагаад дуусна. Ийм битгий болоосой гэж бодож байна.

Би тэгээд Эрдэнэбат гуайд, таныг би бол хүндэлдэг юм, мундаг бизнесмен байсан хүн та. Та сая цар тахлаас болж үйлдвэр зогссон гэлээ. Би бас танд яг ингээд итгээд 2016-2020 онд та манай Чингэлтэй дүүргийн яг тэр гэр хороолол дээр дахин төлөвлөлт хийнэ гээд зээл аваад орсон. Та тэр үед төр дэд бүтцийг нь тавиад өгөөч гэхлээр нь би жишээ нь Улсын Их Хурлын гишүүний төсөв батлах үед ёстой үхэн хатан хөөцөлдөж байж, яам, Тамгын газруудтайгаа нийлж байж тэгээд гадаадын зээл, тусламж гээд 60 тэрбум төгрөгийн дулаан, хүйтэн, халуун усны шугамыг тавиад өгсөн. Дараа нь та шугам тарьсны дараа хүмүүсийг дуудсанаа үгүй ээ, дахиад зээл өгөөдөхөөч, төр өмнөөс нь хийгээдэхээч гэсэн. Тэрийг чинь төрөөс хийгээд л байсан байх, тухайн үед бас туслаад л яваад байсан тэр үед. Одоо та цар тахал гээд ярьж байгаа байхгүй юу. Бас бизнесменүүд дотроо хариуцлагатай байх хэрэгтэй байна зарим нь. Тэрнээс би таныг өөр юмаар гүтгээгүй, худлаа хэлээгүй. Тэнд ард түмэн нүдээ ширгэтэл ингээд хараад байж байна шүү дээ. Энэ газрыг авчихсан, одоо нөгөө тэр нь шүүхдээд, та нар Төр засгийнхан худлаа яриад байна, гэр хорооллын дахин төлөвлөлт гэж яриад найм, тав, зургаан жил боллоо гээд хохироод байж байна шүү дээ. Тийм учраас энд нэр дурдаж ярьсан шүү, тэрнээс элдэв асуудал байхгүй. Харин та ажлаа хий. Түрүүний хэлдэг шиг нээрээ эсвэл тэр таны зээл авсан, одоо та төлж чадахгүй байгаа, үйлдвэрлэлээ явуулж чадахгүй байгаа шалтгаанаа энд хэлээд Хөгжлийн банкны анхны тэр кейсийг нь гаргаад ир л дээ. Тэгвэл бид нар таныг бас хамгаалаад шаардлагатай хуулийг нь гаргая, хаа хаанаа шударга байя аа л гэж хэлье. Тэрнээс бие биеэ хуурсаар байгаад одоо бүгдээрээ мэддэг болчихлоо шүү дээ. Тэгэхдээ ер нь ичихгүй тэгж худлаа яриад байж болохгүй л дээ. Тэнд хүмүүс харж байгаа. Бид өмнөх дөрвөн жил тэр ядахдаа тэгвэл иргэдийн маань газрыг чөлөөлөөд өгчихөөч дээ та. Шүүх дээр ингээд худлаа ялаад л яваад байна шүү дээ. Гэтэл шударга бус юм тэнд байгаад байна шүү дээ. Тэгээд өөр компанид нь, чаддаг компанид нь өгөөд, харин энэ Хөгжлийн банкны өр төлбөрөө өөр аргаар хий гэж би танаас гуймаар байна. Ерөөсөө өөр асуудал байхгүй.

Тэгээд энэ Хөгжлийн банктэй холбоотой асуудлуудыг бүгдээрээ нэг талд нь гараад одоо яг ард түмэнд зөв ойлголт өгөх хэрэгтэй. Ингэхийгээд өнгөрч болохгүй, эсвэл сенсаацлаад, улс төржөөд өнгөрч болохгүй. Бие бие рүүгээ хараад бас шударга хандъя. Түрүүний Отгон сэтгүүлч бас хэлж байгаа нь үнэн. Бие биеэсээ шударга хандаад айхгүй байя. Дарга маань ч гэсэн энэ дээр зөв хариулт өгөөд явах хэрэгтэй.

### **Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн Ж.Бат-Эрдэнэ:**

За Бат-Эрдэнэ гишүүн.

### **УИХ-ын гишүүн Б.Бат-Эрдэнэ:**

За өнөөдрийн одоо энэ хуулийн хүрээнд анх удаа нээлттэй сонсгол бас зохих үр дүнгээ өгч байгаа гэж ингэж бодож байгаа. За тэгээд Улсын Их Хурлаас байгуулагдсан ажлын хэсэг бол энэ өргөтгөсөн нэлээн өргөн бүрэлдэхүүнтэй ажилласан. За түрүүн ажлын хэсгийн гишүүн Ц.Даваасүрэн гишүүн бас тодорхой дүгнэлт өгч байна лээ. Би дотоод сүлжээгээр харсан. Энэ дэд ажлын хэсэгт орж ажилласан энэ мэргэжлийн хүмүүс дандаа төрийн албан хаагчид хүмүүс байгаа. Энэ хүмүүс бол гаргасан дүгнэлт, энэ ажилласан судалгаа, энэ ажил дээрээ бол хариуцлага хүлээнэ шүү гэдгийг маш тодорхой хэлж байна лээ. Тийм учраас бол манай энэ ажлын хэсэг ялангуяа ажлын дэд хэсэгт ажилласан салбар бүрийн мэргэжлийн хүмүүс одоо энэ хариуцлагаа хүлээх ёстой гэдгийг би бас дахиж хэлье.



За тэгээд энэ манай ажлын хэсэг бол нэг онцлогтой, хэд хэдэн зүйлүүдийг хийсэн. За тэрийг бол та бүхэн мэдэж байгаа. Яг зээлдэгч тус бүрээр нь материалтай нь танилцсан. Тэгэхдээ яг баримт бичиг дээрээ тулгуурлаад. Яг бид нарт одоо хуулийн эрх хэмжээнд олдож байгаа тэр хүрээндээ бол сайн ажилласан.

Нөгөө нэг юм нь бол яг зээл, хэрэгжиж байгаа төсөл бүрээр бодитой газар дээр нь үзсэн, үнэлгээ хийлгэсэн. Энэ зээл авахдаа шалгуур нөхцөлүүдийг хангаж уу, үгүй юу гэдгийг тодорхой шалгасан. Энэ манай ажлын дэд хэсгийн гаргасан энэ шалгалт байгаа, хувийн хэвшлийн нийт 27 зээлдэгчид хуульд заасан шаардлага хангаагүй байхад зээл олгосон гээд. Тэгээд энд “Хөтөл”, “Кью Эс Си”, “Эрэл групп”, “НВЦ”, “Монгол драй милк”, “Вестерн холд”, “Монгол мах экспо” гээд ингээд “Сонгоулд” гэх мэтчилэнгээр “МБҮ трейд” энэ тэр гээд ингээд 27 аж ахуйн нэгж байж байгаа юм. Тэгэхээр би түрүүн Сангийн сайдаас асуусан. Надад яг цаасаар материалаар нь энэ аж ахуйн нэгжүүдийн энэ зөрчилтэй холбоотой материалыг ирүүлнэ ээ гэж ингэж хэлсэн байгаа юм. Тэгэхээр аль аль талдаа бид нар бол хариуцлагатай ажиллах ёстой.

Нөгөө талын одоо манай ажлын хэсгийн нэг хийсэн зүйл бол энэ одоо харин энэ Хөгжлийн банкны зээлдэгчийн харилцан хамаарлын схем танилцуулгыг энд гаргасан. Энэ бол одоо хуулийн байгууллагын хэмжээнд бол хийж чадахгүй шүү дээ. Гэхдээ өөрсдийнхөө одоо байгаа бололцооны хэмжээнд бол энэ Хөгжлийн банк, Улсын бүртгэлийн газар, бусад одоо холбогдох байгууллагуудтай материал дээр тулгуурлаж байж энэ харилцан хамаарлынх нь схемийг гаргаж ирсэн. Энэ дээрээ тулгуурлаад манай ажлын хэсгээс тэр 22 аж ахуйн нэгжийн харилцан хамаарлыг гаргаж, өнөөдөр бол ажлын хэсгийн ахлагч танилцуулж байгаа. Энд ямар нэгэн байдлаар эмзэглэх зүйл байхгүй ээ. Энд бол одоо манай Улсын Их Хурлын гишүүд бол эмзэглэх асуудал огт байхгүй. Харин одоо шуурхай энийгээ хууль хяналтын байгууллагаар шалгуулаад нэг мөр нэг талд нь гаргах ёстой. Энэ манай ажлын хэсгийн хүрээнд ажиллаж байгаа энэ хүрээ бол энэ Хөгжлийн банкнаас авсан нийтдээ 3.2 тэрбум, нийт 66 компанийн 70 зээлийн, тэгээд тэрний 40 компанийн 40 зээлдэгчийн зээл бол чанаргүй зээлийн ангилалд орчихсон. 1.8 их наяд төгрөгийн чанаргүй зээлийн асуудал ярьж байгаа шүү дээ. Энэ 1.8 их наяд төгрөгийн төр, ард түмнийг хохиролгүй болгох эцсийн зорилго бол энд чиглэж байгаа байхгүй юу. Тийм учраас тэр 40 аж ахуйн нэгжийн чинь жагсаалтад орчихсон байж байгаа учраас Улсын Их Хурлын гишүүд ээ та бүхний хамааралтай энэ аж ахуйн нэгжүүдийг чинь гаргахаас өөр арга байхгүй. Ийм зүйл шүү. Энийг одоо хэлэх ёстой.

За ингээд ажлын хэсэг үндсэндээ бид үүргээ гүйцэтгэсэн. Өнөөдөр ингээд сонсгол хийгээд холбогдох Байнгын хороогоор дамжаад Улсын Их Хуралд танилцуулагдаад өнөөдөр одоо энэ Хяналт шалгалтын хууль батлагдсантай холбоотой Түр хороо байгуулах, цаашдаа энэ Түр хороон дээрээ ажил асуудлыг аваад явах энэ ажил бол цаашдаа ингээд үргэлжлээд явах нь ээ. Тийм учраас бид нарын нийтээрээ тавьж байгаа өнөөдрийн энэ одоо нээлттэй сонсголд оролцож байгаа хэвлэл мэдээллийн байгууллагууд, энэ аж ахуйн нэгжүүд, төрийн бус байгууллагууд бид бүгдээрээ хамтдаа одоо ард иргэдээ төлөөлж тавьж байгаа эцсийн зорилго бол төр, ард түмнийг хохиролгүй болгох, энэ чанаргүй, муу зээлийн ангилалд орсон энэ 1.8 их наяд төгрөгийг төлүүлж барагдуулах энэ том зорилтын төлөө л бид ажиллах ёстой л гэж ингэж бодож байгаа юм.

## **Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн Ж.Бат-Эрдэнэ:**

За баярлалаа. За тэр нэг залуу одоо бүр гараа гар нь чиллээ, гараа өргөөд байх шиг байна. Алив, гараад ир дээ. В индэр дээр. За тэгээд хэдүүлээ оролцогчдынхоо бүрэн санааг ингээд хангая даа.

## **“Кью Эс Си” ХХК-ийн гүйцэтгэх захирал Э.Шижир:**

За хурал даргалагчдаа баярлалаа, үг хэлэх бололцоо олгосонд. За ингээд би одоо сая тайлан шалгалтууд дээр дурдагдаад байгаа аягүй их дурдагдсан “Кью Эс Си” гэж компанийн гүйцэтгэх захирал Шижир гэж хүн байна аа. За “Кью Эс Си” компани бол 2010 оноос хойш яг уул уурхайн металлургийн цогцолбор гэдэг төслийг бол төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хэрэгжүүлж эхлээд маш олон одоо хорь гаруй төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлээд ажиллаж байна. За тэгээд анх бол яг “Кью Эс Си” компани бол Дарханы төмөрлөгийн үйлдвэрийг концессын гэрээгээр эзэмшиж байгаа ийм компани. За тэгэхлээр нөгөө нэг энэ дээр яг яагаад ингээд анх ингээд энэ Дарханы төмөрлөгийн үйлдвэртэй ажиллаж байсан юм бэ гэхээр ер нь бол Дарханы төмөрлөгийн үйлдвэрийг бол түүхэндээ хоёр удаа хувьчилна гэдэг Улсын Их Хурлын тогтоол гарч байсан юм байна лээ. Гэхдээ “Кью Эс Си” компани бол зөвхөн концессын гэрээгээр, Дарханы төмөрлөгийн үйлдвэр бол төрдөө хэвээрээ байгаа. Зөвхөн бид нар уул уурхайн металлургийн цогцолбор, Монгол Улсыгаа ган үйлдвэрлэгч улс болгоё гэсэн ийм төсөл, хөтөлбөрүүдийг эхнээс нь авахуулаад шат дараалалтайгаар хэрэгжүүлээд явж байна. Энэ төслийн хүрээнд бид нар одоо 20, 30 гучин төслүүдийг хэрэгжүүлсэн. Энэ олон төслүүдийн нэг нь одоо дэд бүтцийн болох “Хандгайт-Төмөртэйн” төмөр замын төсөл байсан. За энэ төсөл нь бол 2014 оны 03 дугаар сараас эхэлж байсан. Бид нар Хөгжлийн банкнаас 2014 оны 11 дүгээр сард зээл авч энэ төсөлд бол зарцуулж байсан. Энэ төсөл нь бол хамгийн анх одоо зээл авахад 130 тэрбум төгрөг байсан. За 130 тэрбум төгрөгөөс бол бид нар яг одоогийн байдлаар бол нийтдээ 89 тэрбум төгрөг төлчихсөн байгаа. Одоо зээлийн үлдэгдэл маань бол 192 тэрбум төгрөг байгаа. Тэгэхлээр энэ дунд нь юу болсон байгааг бол та бүхэн сая өнөөдрийн яригдсан юмнууд дээр бол бас тодорхой харагдаж байгаа байх аа. За зээл нь өөрөө бас яагаад ингээд муудчихсан юм бэ гэдэг асуудлыг бас ярья. 2014 онд авсан зээл бид нар 2018 оныг хүртэл ямар ч зөрчилгүйгээр саяын хэлсэн дүнгээр одоо зээлийг хэвийн төлөлттэй явж байсан. За тэгээд 2018 оны 01 дүгээр сард болохоор Засгийн газрын 2018 оны 7 дугаар тогтоолоор манай Хөгжлийн банканд дээр байж байгаа зээлийг Засгийн газар өөртөө шилжүүлээд авчихсан юм. Өөрөөр хэлбэл Хөгжлийн банканд ингээд төлөх ёстой юм уу, эсвэл Засгийн газарт төлөх ёстой юм уу гэдэг нь тодорхойгүй болж ирсэн.

Тэгэхээр “Кью Эс Си” компани яасан бэ гэхээр 2018 онд яг тэр тогтоол гарсных нь дараахан нь бид нар энэ зээлээ Хөгжлийн банкандаа үргэлжлүүлэн төлмөөр байна аа гэж бид нар шүүхэд хандсан. Өөрөөр хэлбэл бид Хөгжлийн банк нь ингээд одоо төлөхгүй ээ гээд одоо засаг руу манай энэ зээлийг шилжүүлээд авчихсных нь дараа нь бид нар шүүхэд нэхэмжлэл гаргаад энэ хугацаанд болохоор бас Хөгжлийн банк өөрөө бол бас энэ шүүхийн процесст бол оролцоогүй. Юу, яадаг байсан бэ гэхээр танайх зээл, нөгөө нэг шүүхийн процесс чинь юу болж байна аа, танайх одоо манайд төлөхөөр байна уу? Засагт төлөхөөр болчихсон уу? Юу болж байна аа гэсэн. Бид нар шүүхийн процесс хийгээд явж байна аа гэдэг тайлбарыг тухайн үед Хөгжлийн банкныхан бид нараас асуугаад бид нар бол энэ шүүхийн процессыг тайлбарлаж хэлж өгдөг байсан. За тэгээд энэ шүүхээр бид нар ялагдаад Хөгжлийн банкандаа биш, тэр шүүхийн шийдвэр бол Засгийн газартаа төлөх ёстой

гэдэг одоо шийдвэр хэвээрээ үлдсэн юм аа. За ингээд 2020 онд бол бас Хөгжлийн банк биш, Улсын ерөнхий прокурор шүүхэд өгснөөр бол шүүхийн процесс хэрэгжээд явсан. За тэгээд энэ хугацаанд бол одоо сая энэ оны 01 дүгээр сард одоо Хөгжлийн банканд зээлээ төлөх ёстой гэдэг шийдвэр гарсан. Ингээд бид нар энэ зээлийн асуудлыг яаж шийдвэрлэх вэ гэдэг талаар бол ярилцаад явах байх аа. Гэхдээ эргээд Засгийн газарт шилжчихсэн гэдэг байгаа тэр Засгийн газрын тогтоол нь хэвээрээ байгаа. Бид нарын зүгээс бол Монгол Улсын Хөгжлийн банктайгаа хуваарь гаргаад үргэлжлүүлээд төлөөд явахад бэлэн байгаа. Мөн Засгийн газарт шилжүүлсэн тэр хувилбараар ч гэсэн шийдээд явах бас боломжтой шүү гэдэг бид нар тэр одоо өөрсдийнхөө санал юмнуудыг бол албан ёсоор бас хүргүүлчихсэн байгаа. За ийм юмыг хэлэх гэсэн юм.

Тэгээд дээрээс нь бид нар энэ төслийнхөө хүрээнд бид нарыг Худалдаа, хөгжлийн банктай их холбож яриад байдаг. Манай төсөл дээр өөрөө Худалдаа, хөгжлийн банк нь өөрөө энэ уул уурхайн металлургийн цогцолбор төслийн хамтран санхүүжүүлэгч одоо гэж орж ирсэн. Тэгэхээр нийт төсөл дээр хийгдсэн нийт санхүүжилтийн бид нарын зарцуулсан санхүүжилтийн 66 хувь нь Худалдаа, хөгжлийн банкнаас, зөвхөн 14 хувь нь Хөгжлийн банкнаас, за ингээд 20 гаруй хувь нь бол бид нар гадаадын зээлийн санхүүжилтийн байгууллагуудыг ашиглаж энэ төслөө бол амжилттай хэрэгжүүлээд явж байгаа. За баярлалаа.

#### **Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн Ж.Бат-Эрдэнэ:**

За цаг яг 21.00 цаг болж байна. Бид өнөөдөр есөн цагаас эхэлсэн. Сонсгол ингээд 12 цаг үргэлжлээд одоо өндөрлөж байна. За ингээд Монгол Улсын Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж, шалгалт хийсэн талаар холбогдох эрх бүхий байгууллагуудын тайлан, мэдээлэлтэй танилцах Ерөнхий хяналтын сонсгол энэ хүрээд ингээд өндөрлөж байна. За юуны өмнө бид нарт сонсголын хүрээнд танилцуулга хийсэн ажлын хэсгийнхэндээ баярлалаа. Б.Баттөмөр гишүүндээ, Б.Бат-Эрдэнэ гишүүн, С.Чинзориг гишүүн, Ц.Даваасүрэн гишүүн, Б.Пүрэвдорж гишүүн та бүхэн маань бол бас нэлээдгүй том хэмжээний дүгнэлтийг бол гаргаж ирсэн.

Нэлээн шүүмжлэл байх шиг байна. Бид одоо өнөөдөр нэгдүгээрт бол материалуудаа та бүхэнд тараагаагүй нэг алдаа гарах шиг боллоо. За энэ сонсгол маань бол анхны сонсгол шүү дээ. Тэгээд материалаа тараагаагүй, тэрнээс болоод бас нэлээн бухимдал, илтгэлийг бол тэр бүр бас сонсож дүгнэлт хийж чадаагүй байх нэг ийм зүйл гарсан байж болох юм аа. Түүнээс биш яг ингээд доторхыг нь ингээд хараад байхад бол үнэхээр бас урьд өмнө нь хараагүй, сонсоогүй янз янзын зүйлүүд гарч ирж байна.

Дээрээс нь та бүхэн маань бод. Сая хорин хэдэн улс төрчийнхөө нэрийг хүртэл дурдлаа шүү дээ. Энэ чинь одоо өнөөдөр бид нарын хувьд бол үнэхээр ажлын хэсэг маань бол одоо ардчиллын хэлбэрийг бол гүн сонгосон, дотоод нөөц бололцоогоо гаргасан, өөрөө өөрсдөдөө бол шаардлага тавьсан, хариуцлага үүрсэн ийм хэлбэр бол өнөөдөр харагдлаа гэж үзэж байна шүү дээ. Зарим одоо шүүмжлэгчид гарч ирж байх шиг байна. Та бүхэн маань одоо хоорондоо бие биедээ бол шаардлага тавьж чадахгүй, нэг л хуйвалдсан тийм зүйл өнөөдрийн хуралдаан боллоо гээд ганц нэгэн хүний үг, үсэг гарч байх шиг байгаа юм. Энэ чинь өнөөдөр Монгол Улсын Их Хурал асуудлыг бол өөртөө татаж хэдэн гишүүн өөрсдөө одоо энэ өнөөдрийн сонсголыг санаачилж, за тэгээд ажлын хэсэг, Улсын Их Хурлын даргаас ажлын хэсэг гарч, Байнгын хороон дээр энэхүү сонсголыг гаргах одоо шийдвэр буюу

одоо дэгүүдийг гаргаж ингээд үндсэндээ бол Улсын Их Хурал энэ Улсын Их Хурлын хяналт шалгалтын хуулийнхаа дагуу анхныхаа сонсголыг бид нар хийж байгаа юм аа. Энэ бол нэг том алхам юм гэж харж байгаа юм.

Тэгээд энэний дараа бол одоо өнөөдөр бид нарын гаргасан, та бүхний ярьсан саналууд, та бүхний гарсан илтгэлүүд энэ бүх зүйлүүдийг бид нар нэгтгээд Байнгын хороондоо өгнө. Байнгын хороо бол тэндээ Байнгын хороонд, одоо өөрөөр хэлбэл танилцуулна, энэ тайлангаа бол танилцуулна, ийм ийм хурлууд боллоо, ийм байгууллагууд оролцоо, ийм илтгэлүүд гарлаа гээд. Илтгэлүүдээ шүүмжлэлүүдийнх нь хамтаар, хэлсэн үгтэй нь хамтаар энэ аж ахуйн нэгжүүдийн өөрсдийнх нь гаргасан саналууд, тэр хүндрэлтэй байсан нөхцөл байдлууд, тэгээд дээрээс нь одоо ямар ямар компаниуд ямархуу зээлүүд авсан юм, тэнд нь ямар алдаа дутагдал гарсан юм. Зарим нь одоо хууль бусаар авсан ч байдаг юм уу, одоо тэр банкны дүрэм, журмыг зөрчсөн, магадгүй зүгээр энэ банкныхны өөрсдийн хайнга хандсан асуудлууд гээд бүх зүйлүүдийг бид нар нэгтгэсэн ийм байдлаар бол тайлангуудыг нь өгнө өө. Та бүхний тайлан дээр нэмж одоо энд хүмүүсээс гарсан одоо дүгнэлт, саналуудыг бол бүх видео, аудиоогоор нь одоо нэгтгээд Байнгын хороондоо гаргана. За Байнгын хороо бол цаашаагаа тодорхой хэмжээний саналыг боловсруулаад Улсын Их Хуралд өргөн барина. Ингээд энэ бол түрүүн Б.Энхбаяр гишүүн хэллээ шүү дээ. Сонсгол бол хамгийн эхний зүйл нь юм аа. Хамгийн эхлэл нь юм шүү. Энэ бол Улсын Их Хурал өөр дээрээ татаж авч асуудлыг хэлэлцэж байгаа. Өөрөөр хэлбэл одоо нийтийн эрх ашгийг хөндсөн энэ асуудлаар сонсгол хийж, энэ асуудлыг бол тодорхой байгууллагуудад нь үүрэг даалгавар өгч шийдэх ийм шийдлийг бол гаргах анхны алхам юм. За ингээд Улсын Их Хурал дээр бол гарна. Улсын Их Хурал дээр та бүхэн маань ажлын хэсгийнхээ танилцуулгыг хийнэ шүү дээ. За дээрээс нь Байнгын хорооноос асуудлууд орж ирнэ. За тэгээд одоо хууль хяналтын байгууллагуудыг татан оролцуулна. Тэд нар дээр түрүүн хэлсэнчлэн тодорхой хэмжээний хариуцлагууд, тодорхой хэмжээний үүрэг даалгавар, тодорхой хэмжээний одоо анхаарлын төвд байх бүхий л асуудлуудаа хамтран ажиллах, хууль хяналтын байгууллагатай хууль эрх зүйн хүрээнд хамтран ажиллах бүх боломж бололцоо маань ямар байна. Тэгээд дараа дараагийн асуудлууд бол яригдаад явах байх. Өөрөөр хэлбэл одоо Нийтийн сонсголын хүрээнд хийсэн ажлууд маань цааш цаашдаа бол үр дүнд хүрэх талын асуудлыг Улсын Их Хурал одоо үндсэндээ ингээд татаж авсан гэдгийг бол та бүхэндээ хэлэхийг хүсэж байгаа юм аа.

За ингээд миний хувьд бол Улсын Их Хурлын гишүүнийхээ хувьд бас тодруулж хэлэхэд зээлтэй холбоотой асуудлууд, хариуцлага алдсан асуудлууд нэлээдгүй байна. За миний хувьд Зам тээвэр, барилга хот байгуулалтын Төрийн нарийн бичгийн даргаар ажиллаж байх үед бол Хөгжлийн банктэй нэлээн харьцах, за тухайн үеийн барилгажуулах асуудлууд, за тэгээд 100 мянган айлын орон сууц, авто замтай холбоотой асуудлууд гээд бүтээн байгуулалтын Шинэ бүтээн байгуулалт гэсэн том хөтөлбөрийг хэрэгжүүлэх тал дээр бол нэлээдгүй анхаарал тавьж ажиллаж байсан. За тэр үед бол 2011 он шүү дээ. 2011, 2012 оны үед бол Хөгжлийн банкн дээр түрүүний миний дурдсан Солонгос захиралтай баг байсан. За бид бүтээн байгуулалт хийхийн тулд барилга, хот байгуулалттай холбоотой компаниудыг дэмжээч ээ, 100 мянган айлын орон сууцад хөрөнгө оруулалт оруулах хэрэгтэй байна, олон хөрөнгө оруулалт хийж барилга байшин барих, өөрөөр хэлбэл утаагаа арилгах ийм зайлшгүй шаардлага байна аа, тийм болохоор одоо зээл өгч, хөрөнгө оруулалт хийгээч ээ гэж саналуудыг тавьж байсан. Улаанбаатар хотыг бүх аймгийнхаа төвтэй холбох авто замын хүрээнд бол том авто замын сүлжээ байгуулах, энэ хүрээнд олон аж ахуйн нэгжүүдэд бол концессын хүрээнд дэмжлэг

үзүүлээч гэсэн ийм саналуудыг тавьж байсан. Тэгэхэд Хөгжлийн банкны баг бол үнэндээ судалж үзье гээд судалж үзээд энэ бол үнэхээр буцаж эргэлтэд ордоггүй буюу орлого олохгүй ийм хэмжээний төсөл, хөтөлбөр байна аа. Тийм болохоор бид бол энийг санхүүжүүлж чадахгүй ээ гэсэн ийм хариултыг хэлээд явж байсан. Би бол тухайн үедээ хэдийгээр ажил хариуцаж байсан хүн хүндрэлтэй байсан хэдий ч тухайн үед бол бас тодорхой хэмжээний үнэлгээ өгч байсан. Үнэхээр одоо энэ баг бол банкныхаа хэмжээнд бол тодорхой хэмжээнд дүгнэлт, шалгалт хийгээд тэгээд болох, болохгүйг нь ингэж дүгнэдэг зарчмынхаа дагуу явж байгаа банк юм байна аа гэсэн ийм дүгнэлтэд л хүрч байсан. За тэрнээс хойш бол юу болсныг өнөөдөр бид хэд одоо өчнөөн харлаа, сонслоо. Мэдээж одоо хариуцлагын хүрээнд бол алдагдсан зүйлүүд, зарчмын хувьд алдагдсан зүйлүүд, хууль хяналтын хүрээнд одоо янз янзын хуулийн өөрчлөлтүүд, за түүнийг ашигласан, янз янзын хулгай хийсэн, одоо хууль бусаар, зориулалтын бусаар зээл авсан гэх мэт зөндөө зүйлүүд гарч ирлээ. Тэгээд одоо өнөөдөр бид энийг одоо эндээс болоод тодорхой шийдвэр биш, энэ дээр бол хамгийн гол нь энэ бүх зүйлүүдийг бид бүхэн сонсож, ард иргэддээ мэдэх эрхийг нь нээж байгаа, ард иргэддээ төрийн энэ үйл ажиллагаанд оролцох боломжийг нь нээж байгаа нь бол хамгийн чухал байгаа юм аа гэдгийг та бүхэндээ хэлье ээ.

За ингээд зав зайгаа гаргаад оролцож ирсэн нийт сонсголд оролцсон төрийн болон төрийн бус байгууллагууд, ард иргэд та бүхэндээ бас талархал илэрхийлье. Анхны сонсголд та бүхэн маань идэвхтэй оролцож, бүхий л санаа оноогоо гаргаж ард, иргэддээ бүх л талаас нь мэдээллүүдийг өглөө гэж үзэж байна. Тэгээд та бүхэндээ талархсанаа илэрхийлье. Ингээд анхны хяналтын сонсгол маань өндөрлөж байна. Баярлалаа та бүхэндээ.

Ерөнхий хяналтын сонсгол 21.10 цагт өндөрлөв.

--oOo--